Legum servi esse debemus, ut Liberi esse possimus

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААА, ОНОЛ, ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

ЭНЭ ДУГААРТ:

- Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн тухайд өгүүлэх нь
- Германы сонгодог философич Гегелийн эрх зүйн үзэл санаа
- Монгол Улсын хөрөнгө, орлогын мэдүүлгийн тогтолцоо, тулгамдсан асуудал
- Иргэний хэргийн шүүхийн шийдвэр, түүнд тавигдах шаардлага
- Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаанд шүүмжлэлтэй хандах нь
- Хүчин төгөлдөр бус гэрээнээс үүсэх үр дагавар
- Мэдээллийн эрх чөлөө
- Монгол Улсын нотариатын хөгжил, цаашдын чиг хандлага
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг Монгол Улсын шүүхийн шинжилгээний байгууллагын бодлого, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхийн ач холбогдол
- Мал хулгайлах гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, хийх дүгнэлт, тулгамдсан асуудал

2009
№2 (25)

ШИНЭ НОМ



Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Монголын төр, эрх зүйн түүхийн судалгааны төв, Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн эрх зүйн судалгааны төв, Гадаад харилцааны яам, Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төв хамтран гаргасан "Олон улсын Үндсэн хуулийн оршил" ном хэвлэгдэн гарлаа.

1924 оны Анхдугаар Үндсэн хуулийг боловсруулах явцад гадаад улсуудын Үндсэн хуулиудыг орчуулан судалж байсан тод жишээ нь энэхүү ном даруй мөн. Анхдугаар Үндсэн хуулийг боловсруулах явцад гадаад орнуудын Үндсэн хуулийг хөрвүүлэхдээ цуглуулсан баримт бичгүүдээ нэгтгэж "Олон улсын Үндсэн хуулийн оршил" хэмээн нэрлэж нэг багц судалгаа болгожээ. Бид номоо энэ нэрээр нэрлэж "Анхдугаар Үндсэн хуулийн судалгааны эх сурвалж" гэсэн давхар гарчиг оноов.



Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын нотариатчдын танхимаас хамтран гэрээнд оролцогчдын хүрээ жил ирэх тусам өсөж байгааг харгалзан хуульчид, бизнес эрхлэгчдийн ажлын хэрэгцээнд зориулан өчүүхэн ч атугай тус нэмэр болох үүднээс "Гэрээ (үлгэрчилсэн загвар)" номонд нэмэлт, өөрчлөлт оруулан гурав дахь удаагаа бэлтгэн гаргаж байна. Уг номонд хуульчид, бизнес эрхлэгчдэд нэн тэргүүнд хэрэгцээтэй, байнга ашиглагддаг шинэ төрлийн гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн үзэл баримтлал, зарчим, агуулгын хүрээнд шинээр боловсруулан оруулсан юм.



Бүгд Найрамдах Хятад Ард Улсад зорчиж байгаа, түүнчлэн удаан хугацаагаар сурч, амьдарч байгаа Монгол Улсын иргэд, бизнес эрхлэгчдэд эрх зүйн мэдлэг олгох, эрхээ хамгаалахад дэмжлэг үзүүлэх, мөн их, дээд сургуулийн багш, судлаач, оюутан нарын сургалт, судалгааны ажилд зориулан БНХАУ-ын зарим хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хамт Монгол хэлнээ хөрвүүлэн цуврал болгон нийтэлж байна. Эдгээр хуулийг БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны Ардын хэвлэх хорооноос монгол бичгээр хэвлэсэн албан ёсны хуулийн эмхтгэлээс хятад болон англи хэл дээрхи хувьтай тулган хөрвүүлэхдээ тухайн харилцаанд оролцогч Танд дөхөм болох үг хэллэг, нэр томьёог өөрчлөлгүйгээр буулгасан бөгөөд уншиж ойлгоход хүндрэлтэй зарим үгийг хавсралтад тайлбарлан бичлээ.

ЭНЭ ДУГААРТ:

Хууль зүйн албаны 100 жилийн ойд

Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн тухайд өгүүлэх нь
/ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор **О.Батсайхан**/...4-6

Төрийн байгуулалтын хууль тогтоомж

Германы сонгодог философич Гегелийн эрх зүйн үзэл санаа
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн доктор **Х.Сэлэнгэ**/.....7-9

Эрх зүй нийгмийн үзэгдэл мөн
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн доктор **Р.Уранбилэг**/.....10-12

Эрх зүйт ёсыг төгөлдөржүүлэх нь хөгжлийн тулгуур багана мөн. (Эрх зүйн шинэтгэлийн зорилт)
/ХЗҮХ-ийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрхлэгч, докторант **Р.Мухийт**/.....13-20

Монгол Улсын хөрөнгө, орлогын мэдүүлгийн тогтолцоо, тулгамдсан асуудал
/Голомт банкны хууль зүйн зөвлөх **П.Өнөрмаа**/.....21-24

Иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбогдох зарим асуудал
/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр **Б.Одонгэрэл**/ 25-28

Бараа импортлох гаалийн тариф, түүний хөнгөлөлт
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант **В.Оюумаа**/.....29-32

Шүүх эрх мэдэл

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр, түүнд тавигдах шаардлага
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант **Д.Хуяг**/.....33-38

Мэтгэлцээнба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш, докторант **Ж.Эрхэсхулан**/.....39-42

Хэн дор эрх байна, түүн дор хилэнц бий
/Өвөрхангай аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч **П.Соёл-Эрдэнэ**/.....43-44

Иргэний хууль тогтоомж

Өмчлөх эрх ба өмчийн мөн чанарын асуудалд
/"Законы России" сэтгүүлээс орчуулсан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Олон Улсын эрх зүйн секторын эрхлэгч, докторант **М.Мөнхбат**, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан **Д.Тамир**/ 45-51

Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаанд шүүмжлэлтэй хандах нь
/Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн профессор, хууль зүйн доктор **Б.Уранцэцэг**/ 52-54

Хөдөлмөрийн эрх зүй дэх хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдлын зохицуулалт
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, докторант **С.Болормаа**/.....55-58

Хүчин төгөлдөр бус гэрээнээс үүсэх үр дагавар
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант **Ц.Давхарбаяр**/ 59-62

Хөдөлмөрийн харилцаа ба түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал
/ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэн, бизнесийн эрх зүйн тэнхмийн багш **Г.Жаргал**/.....63-65

Мэдээллийн эрх чөлөө
/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан **Б.Солонго**/.....66-69

Монгол Улсын нотариатын хөгжил, цаашдын чиг хандлага
/Сүхбаатар дүүргийн нотариатч **Р.Онончимэг**/.....70-73

Хүүхэд хөдөлмөрлөх ёстой юу?
/Хуульч **Д.Солонго**/.....74-76

Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

АНУ-ын эрүүгийн процесс дахь хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /II хэсэг/
/Сүхбаатар дүүргийн шүүгч, докторант **Ч.Хосбаяр**/ 77-80

ХБНГУ дахь концернийн эрх зүйн зохицуулалт, онцлог
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш, докторант **Э.Байгал**/.....81-83

Криминологи

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг Монгол Улсын шүүхийн шинжилгээний байгууллагын бодлого, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхийн ач холбогдол
/Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн лабораторийн тасгийн дарга, биологийн ухааны доктор **С.Ганболд**/.....84-86

Орчин үеийн зарим төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл
/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан **Г.Оюунболд**/.....87-91

Мал хулгайлах гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, хийх дүгнэлт, тулгамдсан асуудал
/Төв аймгийн шүүхийн шүүгч **Д.Гансүх**/.....92-96

Компьютерийн гэмт хэрэг
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант **Ц.Хүрэл-Очир**/.....97-98

CONTENT:

The 100th anniversary of the Justice service

On the Mongolian Ancient Law "Zarligaar Togtooson Huuli Zuiliin Bichig"
/O.Batsaikhan, Ph.D, Institute of International Studies, The Mongolian Academy of Sciences.....4-6

State organization legislation

The Concept of Law Developed by German Classic Philosopher G.W.F.Hegel
/**Kh.Selenge**, Ph.D, Lecturer of School of Law, National University of Mongolia/.....7-9

Law as a Social Phenomenon
/**R.Uranbileg**, Ph.D, Lecturer of School of Law, National University of Mongolia/.....10-12

Strengthening the Rule of Law as one Pillar of Development. (The Objective of Legal Reform)
/**R.Muhiit**, candidate Ph.D, Head of Administrative and Humanitanian law sector, National Legal Institute/.....13-20

Pressing issues concerning on assets and income statement in Mongolia
/**P.Unurmaa**, Legal adviser of Golomt bank/.....21-24

Some Issues Related to Citizen's Registrations and Movement
/**B.Odongerel**, LLM, Researcher of Criminal Law and Criminology Research sector, National Legal Institute/.....25-28

Customs Tarriffs and Facilities on Import Goods
/**V.Oyumaa**, Senior Lecturer of School of Law, National University of Mongolia/.....29-32

Judicial power

Court Judgement in Civil Cases and the Legal Requirement
/**D.Huyag**, candidate Ph.D, Senior Lecturer, School of Law, National University of Mongolia/.....33-38

Adversarial Process in Criminal Procedure
/**J.Erkheshulan**, Lecturer of Criminal law department, School of Law, National University of Mongolia/.....39-42

Who Has Have a Right, Also Has a Sin
/**P.Soyol-erdene**, Judge of Administrative court, Uvurkhangai aimag/.....43-44

Civil legislation

Ownership and the Nature of Property
/**Translated by M.Munkhbat**, Head of International law sector, National Legal Institute, **D.Tamir**, Assistant Researcher of Civil and economic law sector, National legal Institute/.....45-51

A Critical Note on Labour Relations involving public servant
/**B.Urantsetseg**, Ph.D, Academy of Public Management/.....52-54

The Legal Regulations of Occupational Safety in Labour Law
/**S.Bolormaa**, candidate Ph.D, Lecturer of Civil law department, School of Law, National University of Mongolia/.....55-58

Consequences of a Void Contract
/**Ts.Davkharbayar**, candidate Ph.D, Senior Lecturer of Civil law department, School of Law, National University of Mongolia,/.....59-62

Labour Relations and Certian Issues of Legal Regulations
/**G.Jargal**, Lecturer of Civil and business law department, "Otgontenger" University/.....63-65

Freedom of Information
/**B.Solongo**, Researcher of Civil and economic law sector, National Legal Institute/.....66-69

Development and Future Trends on Notary in Mongolia
/**R.Ononchimeg**, Notary of Sukhbaatar district/.....70-73

Should Children Be Allowed to Work?
/**D.Solongo**, Lawyer/.....74-76

International law, comparative law

Adjudication by Plea in the U.S.A
/**Ch.Khosbayar**, Judge of Sukhbaatar district court/.....77-80

Legal Regulations of Cartels in F.R.G
/**E.Baigal**, candidate Ph.D, Lecturer of International law department, School of Law, National University of Mongolia/.....81-83

Criminology

The Importance of Developing Scientific Research as an Primary Policy and Activity Issues of National Institute of Forensic Investigation
/**S.Ganbold**, Ph.D, Head of laboratory of National Institute of Forensic Investigation/.....84-86

The Causes of Certain Crimes in Modern Times
/**G.Oyunbold**, Researcher of Criminal law and Criminology Research sector, National Legal Institute/.....87-91

The Causes of Theft of Livestock
/**D.Gansukh**, Judge of Tuv aimag court/.....92-96

Computer Crime
/**Ts.Hurel-Ochir**, candidate Ph.D, Senior Lecturer, School of Law, National University of Mongolia/.....97-98

СОНИН, СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Сонин, сэтгүүлийн зөвлөлийн дарга **Академич Ж.Амарсанаа**

ГИШҮҮД:

Л.Баасан - Хууль зүйн шинжлэх ухааны доктор, "Отгонтэнгэр" Их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал

Г.Банзрагч - Хууль зүйн доктор

Ц.Батцэрэн - Нийслэлийн шүүхийн шүүгч

Ж.Бямбаа - Хууль зүйн доктор, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч

Л.Бямбаа - Хууль зүйн доктор, Улсын дээд шүүхийн шүүгч

Н.Гантулга - Хууль зүйн доктор, Цагдаагийн академийн дэд захирал

Д.Даваа-Очир - Хууль зүйн доктор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Тогтоол гүйцэтгэх газрын дарга, хурандаа

И.Дашням - Хууль зүйн шинжлэх ухааны доктор

Д.Зүмбэрэллхам - Хууль зүйн доктор, Төрийн албаны зөвлөлийн дарга

Т.Мэндсайхан - Хууль зүйн доктор, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн эрхлэгч

Ц.Сарантуяа - Хууль зүйн шинжлэх ухаан доктор, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш

С.Сүхбаатар - Хууль зүйн доктор, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч

Б.Цэрэнбалтав - Улсын ерөнхий прокурорын орлогч

С.Цэрэндорж - Хууль зүйн доктор, Монголын өмгөөлөгчдийн холбооны дэд ерөнхийлөгч

Б.Чимид - Ардын багш, гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор

Ч. Энхбаатар - Хууль зүйн шинжлэх ухааны доктор, Удирдлагын академийн Ерөнхий эрдмийн тэнхимийн эрхлэгч

ДУГААРЫГ ЭРХЭЛСЭН:

С.Алтантуяа - Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга

Эрхлэн гаргагч: **Хууль зүйн үндэсний хүрээлэн**

Редакцийн хаяг: **Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай-7**

Утас: **315736** *Факс*: **315736**

Вэб сайт: **www.legalcenter.mn**

И-мэйл: **magazine_info@legalcenter.mn**

Улсын бүртгэлийн дугаар: 279

ЗАРЛИГААР ТОГТООСОН МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙЛИЙН БИЧГИЙН ТУХАЙД ӨГҮҮЛЭХ НЬ

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн,
Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор О.Батсайхан

1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр "Халхын таван аймгийн хаад, чуулганы дарга, жанжин, олон засаг ноёд, хутагт хувилгаад, шанзодва, да лам нар язгууртан тушаалтан тайж түшмэд бүрнээ Их Хүрээнд хуралдан" Монгол Улсын тулгар төрийг нээн, тусгай улс байгуулж, Наймдугаар Богд Жавзандамба хутагтыг Улсын эзэн хаанд өргөмжлөн, Эрдэнийн их сууринд суулгаж, шашин төрийн бүрэн эрхийг хослон бариулж, улсын нэрийг Монгол, оны цолыг Олноо өргөгдсөн гэж нэрийдэж, Их Хүрээг улсын төв нийслэл болгон, Дотоод, Гадаад, Цэрэг, Сан, Шүүх таван яамтай Засгийн газрыг байгуулсан"[1] хэмээн түүхнээ бичжээ. Иймхүү 1911 онд Монгол Улс сэргэн мандсаны 100 жилийн ой 2011 онд болно. Эл өдрийг монголчууд 2007 оноос эхлэн Монгол Улсын Их Хурлаас баталсан хуулийн дагуу "Үндэсний эрх чөлөөний өдөр" болгон тэмдэглэж буй бөгөөд 2011 онд Монголын үндэсний хувьсгалын 100 жилийн ойг улс орон даяар тэмдэглэх тухай Ерөнхийлөгчийн зарлиг нэгэнтээ гарсан билээ.

1911 онд байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын анхны таван яамны нэг бол Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яам байв. Тус яамны анхны сайдаар Манжаас анх түрүүн засгийн эрх авсан зүргаан хүний нэг буюу Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууны засаг ноён Мижиддоржийн ахмад хөвгүүн Намсрай ван ажилдаж байв.[2]

Тус яамнаас Богдын Зарлигаар хийсэн томоохон ажлуудын нэг нь Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг билээ. Энэхүү хууль зүйлийн бичиг хэрхэн бүтсэн хийгээд уг эх нь эдүгээ хаана хадгалагдаж буй тухайд товч өгүүлье.

1911 оны Монголын үндэсний хувьсгалын дараа Монгол улс өөрийн гэсэн нийгмийн амьдралыг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ болсон хуультай болохоор шийдэж, энэ зорилгоор Засгийн газар хууль зүйн эмхтгэл бичиг зохиох тусгай комисс байгуулжээ.

1915 оны Бүгд ерөнхийлөн захирах яамны бичгийг үзэх аваас хууль зохиох комисст Богдын зарлигаар дараах хүмүүсийг оруулж, хууль зүйлийн бичиг зохиох ажлын чигэлийг өгсөн байна. Үүнд: "олон яамнаас тусгайлан сайд түшмэл жич хэрэг өнгөрүүлсэн гүн нарыг томилон гаргаж Шүүх таслах яамнаа хуралдуулан хуучин хууль зүйлийн бичиг хараг байцаан хянан үзүүл" гээд "эртний Богд хүний ёс дэлхий дахины дүрэм одоо бидний улсын шашин суртал тэнгэр газрын амьсгал хүн иргэний зан журам их төлөвийн байдал дор

1. Монгол Улсын автономи хэмээх өөртөө эзэрхэн засах эрхт засгийн үеийн үнэнхүү явдал чухам байдал, чухал учрыг тэмдэглэсэн товч өгүүлэл хэмээх түүх бичиг УБ., 1992 он, 9 дэх тал.

2. **Гүн Намсрай**

Намсрай 1876 оны улаан хулгана жилд Мижиддоржийн ууган хүү болж төрсөн байна. 1892 оноос Засгийн тэргүүн зэрэг тайж залгамжилж, 1894 онд насанд хүрсэн тул засгийн тамгыг хүлээн авч, хэрэг шийтгэн харьяат хошууны олон гайж, ардыг захирах болжээ.Намсрайд 1894 онд нэгэн нэмсэн зэргэ олгосон бол 1895 оны 3 сараас харьяат чуулганы даргын газраас тус аймгийн Орос зүгийн харуулыг түр захируулсан бол мөн оныхоо зунаас Хүрээний сайдын газраас гүүнийг бүр захируулан суулгасан байна.Хойт хилийг таван жил захиран суусаны дараагаар 1900 оны 4 дүгээр сараас хошууны хэргээ эрхлэхийн зэрэгцээ Түшээт хан аймгийн сэргийлэн боловсруулах цэргийн түр захирч байв. Мөн оны өвлөөс түүнийг Хүрээний сайдын газраас Зүүн хоёр аймгийн (*Түшээт, Сэцэн*) харуулыг бүгд захиран, мөн хошууны хэргийг хавсран шийтгэж таван жил болсон ба 1906 оноос Жавзандамба хутагтын Сангийн хэргийг гурван жил захирчээ. 1910 онд Гадаад Монголын төрийг засах яндлын яамнаас Намсрайд хүрэвтэр өнгийн жолоо шагнан олгож байжээ. 1911 оны 12 дугаар сарын 29-нд Богд Жавзандамба хутагт Монгол Улсын хаан ширээнээ суугаад гаргасан хишиг тараах зарлигтаа тулгар төрийг байгуулахад үнэн санаагаар чармайн зүтгэсэн учир Мижиддоржийн Намсрайд үе улиран Эрдэнэ цол, төрийн жүн ван, улбар шар жолоо шагнаж, шадар сайд, Бүгд захирах сайд, Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайдын тушаалд тохоон тавьж гурван нүдний тогосын отго, саран цацаг бүхий ногон тэрэг олгожээ[4].

1913 онд түүнд гурван нэмсэн зэргэ, хоёр тэмдэглэсэн зэргэ олгуулж байжээ. 1915 онд Намсрай бие өвчтэй учир Шадар сайд, Бүгд захирах сайд, Шүүх таслах яамны тэргүүн сайдын тушаалаас чөлөө гуйсанд, Богд хааны зарлигаар Шадар сайдыг хэвээр зүтгүүлж, буслыг гуйсан ёсоор болгожээ. Шүүх таслах яамнаа таван жил эндэлгүй зүтгэсэн учир чин ван Намсрайд 1919 оны 7 дугаар сарын 30-ны өдөр Зарлигаар үе улиран хошой чин вангийн хэргэм шагнан олгожээ. Түүний тухай "Эрдэнэ ван Намсрай бол эрдэм бичиггүй, урьд Чин улсын үед Жавзандамба хутагтын сангийн хэрэг эрхлэх гүнгээр томилогдож, Хүрээнд сууж, Шавь яамны хэрэгт оролцож байхдаа Богдод шадарлаж нүүр талтай болсны дээр мөн Манж улсаас тусгаарлах хэрэгт оролцсон учир, иймхүү Шүүх яамны тэргүүн сайдад сонгогджээ"[2] хэмээн Навааннамжид авгай бичсэн байна.

нийлүүлэн залруулан засах нэмэж зохиох хасаж гаргахыг нь зүйл анги зохион бичүүлж тухай дор улсын хоёр хурал (Дээд, Доод хурал-О.Б) дор үзүүлж шавь боол боловсортол хянан нийлэлцүүлж зүйл дараалан шар дэвтэр үйлдэж" Богд гэгээнээ айлтган "тогтоолгон удаа бүр хураангуйлан дэвтэр товхиж нийтэд тараан явуулж журамлан дагаж шийтгүүлвээс зохихын тул эл зүйлийн хэрэг дор Шадар сайд Эрдэнэ жонон бэйс Ширнэндамдин, Бүгд ерөнхийлөн захирах яамны дэд сайд бэйсийн зэрэг улсад туслагч гүн Магсаржав, шадар сайд Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны дэд сайд засаг хошой дархан чин ван Пунцагцэрэн, Гадаадын хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны орлосон дэд сайд гүнгийн зэргэ Бавуудорж, Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны дэд сайд бэйсийн зэргэ улсын түшээ гүн Сонондорж, Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яамны туслан шийтгэлцэх дэд сайд гүнгийн зэргэ бодлогот баатар Цэнд, Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны дэд сайд засаг төрийн дайчин жонон жун ван Цогбадрах, Шашин төрд туслах сайдын яамны эрхэлж зөвлөх сайд нягт билигт чин зоригт хичээнгүй эетэй да лам Цэрэндэндэв, дэс түшмэл итгэмжтэй түшээ гүн Цогт Очир, дэс түшмэл захирагч тэргүүн зэрэг тайж Авирмэд, дэс түшмэл захирагч тайж Санжмятав, дэс түшмэл дэд зэрэг тайж Төртогтох, дэс түшмэл зайсан дэд зэргэ Жамьян, дэс түшмэл дэд зэргэ Туваанжав, эх зохиогч түшмэл дэд зэргэ зайсан Магсаржав хурц түшээ гүнгийн зэргэ Хайсан нарыг томилон гаргаж эрхлэн зохиолгохоор" тогтоосон байна.

Ийнхүү хууль зохиох комисс томилохын зэрэгцээ тэдний ажиллах нөхцөл зэргийг хүртэл сайтар бодолцон: "энэхүү хууль зүйлийг зохиох сайд түшмэдийн суух гэр байшин ба бийр цаас бичиг хараа зүйлийг Сангийн яам лугаа зөвлөлдөж бэлтгүүлэх", "өөр өөрийн яамнаас томилон гаргасан нэр бүхий сайд түшмэдэд уламжлан зарлан гүйцэтгэж, нээн явуулах тухайд уг хэрэг дор өчүүхэн саад үгүй болгон бэлтгүүлэх"-ийг даалгасан нь бас харагдана.

Уг хууль зохиох комисст Монголын бүх аймгуудад тухайлбал, Баруун хязгаарын сайдууд дөрвөн аймгийн чуулганы дарга, жанжин, Нийслэл Хүрээний эрдэнэ шанзодва, Хөвсгөл нуурын урианхайн гүн, Хиагтын хоёр этгээд харуулыг захирах дарга гүн нараас "өөр өөрийн аймаг шавь ба жич урианхай харуулын газраас тус газар орон дор эрх үгүй хууль зүйл дор оруулан хэлэлцэж тогтоовоос зохих чухал хэрэг зүйл буй аваас нарийвчлан тодорхойлж данс үйлдэж" ирүүлэхийг үүрэг болгосноос гадна "өөр өөрийн харьяат аймаг чуулган шавиас энэ мэт зүйл ба хууль ёс хуучин удаа дор нэвтэрхий хэрэг өнгөрүүлсэн нэн ихээхэн тушаалын хүн нижгээдийг томилж элдэв учрыг ухуулан бичиг зүйлийг авуулан өртөө улаагаар мордуулж энэ он долоон сарын арван тавны дотор Нийслэл Хүрээний газраа илгээн ирүүлж уг хэргийг хамт зөвлөн шийтгэлцэхэд өчүүхэн саад үгүй болгосугай" хэмээн зарлиг буулгажээ.

Хууль зохиох тухай Богдын зарлигаас үзвэл Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийг Засгийн газрын комисс болон Монгол Улсын бүхий л аймгуудын төлөөлөл, хууль, хэрэг зүйлийн талаар мэдлэг бүхий хүмүүсийг өргөнөөр хамруулан оролцуулж бүтээсэн нь илт буй.

Тэрхүү хууль зохиох комисс ямар ямар хууль харааг гол болгон баримталсан тухай өгүүлэхдээ "энх цагийн олон улсын сайн хуулийг мөрдөн шийтгэж үүрд хоцроовоос зохихын тулд" урьд эрдэмтний номлосон Дайчин улсын бүгд хууль зэрэг олон хууль зүйлийн бичгийг орчуулж үзсэн хэмээжээ. Үүнд, Дайчин улсын бүгд хууль бичиг нэгэн зуун дэвтэр, Хууль зүйлийн бичиг 180 дэвтэр басхүү цэргийн яамнаас шилжүүлэн ирсэн цэргийн журганы хэргийн хууль ял хэлэлцэх хууль бүгд 69 дэвтэр, Шүүх яамнаас шилжүүлэн ирсэн Шүүх цаазны бичиг 47 дэвтэр, энэ бүгд гурван зуун жаран зургаан дэвтэр цөм манж үсгийг монголоор орчуулж нийлүүлсэн байна. 360 дэвтэр хууль болон хууль холбогдох материалыг монголчилсон гэжээ бодоход багагүй ажил өрнүүлсэн нь ойлгомжтой болов уу.

Зарлигийн дагуу "Монгол хуулийг гол болгож хөнгөнийг нь хүндэтгэн шүүх цаазнаас авахыг авч дутагдахыг нь нэмэн нөхөн оруулж хурдан түргэн гүйцэтгэн" зохиож, Улсын Хурлаар хянан хэлэлцүүлж, "монголчуудын угаас бүхий суртал ёсыг Богдын ач дор ойр албан хааж нүд үзсэн, чих сонссон, эрх биш журамлан хэрэглэвээс зохихыг нь магадлан шүүмжилж тохиолдуулан зохиож", "элдэв хэргийг тодорхойлох сургаал- соёлыг" бүрнээ багтаасан бөлөхөө хууль зохиох комиссынхон тайландаа дурджээ.

Эдүгээ цагийн хууль зохиогч, тогтоогч эрхэмүүдэд сургамжтай үгс ч тэдний тайланд нэг бус байгаагаас заримыг дурьдвал, "эхээс адаг дор хүртэл", "ер нэгэн хүний төдий ээрхэж санааны дураар авчихсан үгүй", "нэгэн хүний төдий гадуур дагаж, дотуур санаа үлдээсэн үгүй", "цөм нэгэн санаа нэгэн хүний гар хуруу мэт эвсэлдэн чармайж хичээнгүйлэн зүтгэж" энэхүү хууль зүйлийн бичиг 65 дэвтэрийг 1918 онд дуусан Богдод өргөн барьсан байна. Энэхүү хууль зүйлийн бичиг нь Монгол Улсын засаг захиргааны бүтэц, төрийн байгуулалтын зохион байгуулалт, түшмэл хүний эрхэмлэх ёсон, иргэний болон эрүүгийн хууль гээд нийгмийн бүхий л талын харилцааг зохицуулсан Үндсэн хуулийн шинжтэй иж бүрэн хууль билээ. Социализмын үед энэхүү хууль зүйлийн бичгийг Манжийн үеийн хуулийн хуулбар хэмээн тоодоггүй

байсан бол эдүгээ ч уг хууль зүйлийн бичгийн агуулгыг сайтар нягталсан нь үгүй шиг байна. Молхи судлаачийн бодоход энэхүү Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг бол Монгол Үндэстэн тусгаар улс болон оршиж буйг илтгэн харуулсан олон зүйл заалттайн дээр өмнөх үеийн хуулиудаас дэвшилттэй болсон болов уу гэж бодогоо нуух юун.

1918 онд уг комисс ажлаа дуусгаж 65 дэвтрээс бүрдсэн олон хууль зүйн шинэ эмхтгэл бичгийг маш нууц байдлаар хэвлэж эхэлсэн ажээ. "Монголын төрийн хуулийг зөвхөн учир мэдэх тохоогдсон хүмүүс уншиж болох төрийн нууц гэж үздэг. Манай экспедицийг Өргөөд байх хугацаанд зөвхөн эхний найман дэвтэр нь хэвлэгдээд байсан үлдсэн 56 дэвтрийг хэвлэж амжсан эсэхийг би мэдэхгүй байна"[3] хэмээн Майский өгүүлсэн байдаг.

Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичгийг зохиосон тухай Магсар хурц өгүүлэхдээ: "улс нийтийн засаг захиргааны хэргийг явуулсан үндэс нь их төлөв Чин улсын хуулийг иш татаж хааяа монгол газар орны суртал дор нийлүүлэн засаж зохиосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг бүгд жаран таван дэвтрийг Богд хаан танаа тухай бүр үзүүлэн айлтгаж цөм зарлигаар тогтоон баталж хүчин төгөлдөр болон хэвлэж төгсгөсөн боловч хараахан нийтэлж завдаагүй дор автономит Монгол засгийг устгах дор хүрсэн болох учир эдүгээ уг хууль зүйлийн дэвтрүүдийг тус улсын судар бичгийн хүрээлэн дор олж хадгалсан"[4] хэмээжээ. Эндээс үзвэл, Хууль зүйлийн бичгийг бүгд 65 дэвтрийг зохиож дуусгаад хэвлэж арай дуусаагүй байсан бололтой. Харин Ардын засгийн жилүүдэд Судар бичгийн хүрээлэнд хадгалж байсан эхүүд нь эдүгээ бидэнд уламжлагдан иржээ.

"Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг" 65 дэвтэрийг Монгол Улсын хаан Жавзандамбын зарлигаар төр, шашны зүтгэлтэн эрдэм мэдлэг төгс ухаант мэргэд урьд урьдын хууль цаазад тулгуурлан 1913 оны сүүлчээс 1918 оны эх хүртэлх хугацаанд боловсруулж, Улсын доод, дээд хурлаар нягтлуулж шүүлгэсний дараа зохих засвар, өөрчлөлт, нэмэлт үйлдэж, Улсын эзэн хаанаар батлуулсан байна. Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийг анх 65 дэвтрээр боловсруулж, нилээддийг нь хорголжин бараар хэвлэсэн ба нэг хэсэг нь гар бичмэлээрээ хадгалагдсаар эдүгээ хүрчээ. Энэхүү 65 дэвтэрийн 58 дэвтэр нь эдүгээ Монгол Улсын Үндэсний төв архив, Үндэсний төв номын санд хадгалагдаж байна. Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг нь дотоод, гадаадынханы сонирхлыг ихээр татаж байсан нь тухайн үеийн түүх бичлэгээс тод харагдана. Тухайлбал, Японы Мицуй Буссан пүүсийн төлөөлөгч Оошима Киёша 1917-1920 оны хоорондоо Монголд хэд хэдэн удаа ирэхдээ энэхүү 65 дэвтэр Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийг авч, улмаар япон хэлнээ хөрвүүлэн "Хүрээнд очсон тухай илтгэлдээ" хавсаргажээ. Японы монгол хэлтэй Оошима сан тэдгээр 65 дэвтэр Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичгийг Монголоос авч, Японд ирсэн нь лав тодорхой мэдэгдэж буй билээ. Ингэхдээ ямар ч гэсэн 65 дэвтэр бүгдийг авчирсан нь мэдэгдэж байна. Энэ нь нэг талаас ямар ч гэсэн Монголчууд Хууль зүйлийн бичгийн 65 дэвтрийг бүтнээр нь зохиосон нь лавтайг нотолж буй билээ. Гэхдээ харин бүгдийг хэвлүүлж чадсан эсэхийг тодруулж чадаагүй болов ч Японы пүүсийн төлөөний түшмэл Оошима уг Хууль зүйлийн бичгийн жинхэнэ гар бичмэл эхийг авчирсан гэх баталгаа үгүй билээ. Гэхдээ тухайн үед Монголчуудаас төрийн холбогдолтой баримт бичгүүдийг гадаадын хүмүүс амархан олж авч чадаж байсан бололтой байгаа юм. Энд нэгэн жишээ татахад бидний мэдэх Майский 1918 онд Монголд экспедицийн ажлаар ирсэн бөгөөд тэгэхдээ Монголын хүн ам, малын тооллогын материалыг бүрэн авч чадсан тухай "ийм амархан бүтэж" авна чадна хэмээн бодож байгаагүй тухайгаа дурдсан байдаг билээ. Тиймээс Оошима сан ч гэсэн тухайн үед монголчууд хятадуудаас тодорхой хэмжээнд нуущалж хэвлэж байсан Хууль зүйлийн бичгийг олж авсан нь тодорхой юм. Оошима бээр Монголоос авчирсан Хууль зүйлийн бичиг 65 дэвтэр бүгдийг япон хэлнээ 1922 он гэхэд хөрвүүлж чадсан байдаг. Тиймээс энэхүү япон хэл дээр буй 65 дэвтэр уг эхийг бид ямар ч байсан одоо байгаа бүрэн эх болгон одоохондоо барьж буй.

Үүнийг Шинжлэх Ухааны Академийн Олон Улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан О.Батсайхан миний бие Японд судалгаа хийх явцдаа олж, Монгол хэлээр хараахан олдоогүй ХЗБ-ийн 7 дэвтэрийг хуулбарлан 2005 онд авчирч, Үндэсний архив, номын санд тус бүр нэг хувь өгсөн билээ. Ийнхүү бид монгол хэл дээр буй 58 дэвтэр, япон хэл дээр буй 7 дэвтэр бүгд 65 дэвтэр Хууль зүйлийн бичиггэй болоод байгаа билээ.

Эзэн Чингис хааны Их Засаг хуулиас эдүгээ үеийн мөрдөгдөж буй хууль хүртэлх монголчуудын оюуны санааны өв болсон цааз эрхэмжийн эмхтгэл 20 ботийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн хийж байгаа билээ. Энэхүү эмхтгэлийн 5 дугаар боть болох "Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг"-ийг хэвлэхэд бэлтгээд байна.

3. Майский, "Орчин үеийн Монгол". УБ., 2001 он, 331 дэх тал.
4. Н.Магсаржав, "Монгол Улсын шинэ түүх". УБ., 1994 он, 65 дахь тал.

ГЕРМАНЫ СОНГОДОГ ФИЛОСОФИЧ ГЕГЕЛИЙН ЭРХ ЗҮЙН ҮЗЭЛ САНАА

Түлхүүр үг: эрх зүйн үзэл санаа, чөлөөт хүсэл зориг, эрх чөлөө, эрх зүй, хууль, позитив эрх

Товч утга: Германы сонгодог философич Гегелийн эрх зүй, түүний үзэл санаанд хандах онол-арга зүйн асуудал нь өнөөгийн хууль зүйн шинжлэх ухаанд тодорхой байр суурь эзэлсээр байна. Иймд орчин үеийн эрх зүйн сэтгэлгээний онол–арга зүйн үндэс болсон Гегелийн эрх зүйн үзэл санаа, түүний онол–арга зүйн асуудлыг И.Кантын эрх зүйн философитой харьцуулан гаргаж тавьлаа.

Гегель нь хүн төрөлхтний сэтгэлгээний агуу их сэтгэгч билээ. Гегелийн үзэл санаа нь эрх зүйн сэтгэлгээний хөгжилд онол–арга зүйн их хувь нэмэр оруулсан юм.

Эрх зүйг судлах арга зүйн асуудлыг авч үзвэл: И.Кант нь хүний зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээний (категорический императив) үүднээс эрх зүйг байх ёстой зүйлийн хүрээнд авч үздэг бол харин Гегель эрх зүйг байгаа зүйлийн хүрээнд авч үздэгээрээ ялгаатай. "Ийм байх ёстой", "тийм байх ёстой" гэдэг бол хоосон утопи санаа, бодит зүйл биш учир байгаа бодит эрх зүйг судлан, түүний мөн чанарт хүрэхийг эрмэлзэх ёстой хэмээн шүүмжилж байв. Нөгөө талаар, шинжлэх ухааны зорилго нь ертөнцийг өөрчлөх бус, харин байгаа бодит зүйлийг танин мэдэж, түүнд хүрэх явдал гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухаан нь танин мэдэхүйн зорилготой байна.

Байгалийн хууль бол хүний хүсэл зоригоос хамааралгүй абсолют хууль байдаг тул хүмүүс

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн доктор Х.Сэлэнгэ

байгалийн хуульд зайлшгүйн үүднээс захирагддаг. Харин позитив хууль нь абсолют хууль биш. Хүмүүс позитив хуульд зайлшгүйн үүднээс захирагдлаггүй тул хүн бүр эрх зүйн актыг өөр өөрийн эрх зүйн ойлголттой нийцүүлэх шаардлага тавьдаг байна. Иймд Гегель эрх зүйд байгаа болон байх ёстой зүйлийн хүрээнд зөрчил байна хэмээн үзэж, хамгийн "зохистой", "зөв" эрх зүйг илрүүлэхийг эрмэлзжээ.

Гегель "зохистой", "зөв" эрх зүйг танин мэдэхийн тулд юуны өмнө эрх зүйн "зохистой", "зөв санаа"-г танин мэдэх ёстой хэмээн үзэж, эрх зүйн санааны тухай асуудлыг авч үзсэн. Үнэн санаа гэдэг нь тухайн юмсын ойлголт. Зөв сэтгэхүй бол зөв танин мэдэхүй, зөв мэдлэг. Иймд танин мэдэхүй шинжлэх ухааны байх ёстой хэмээн үзсэн юм.

Дээрхи арга зүйн үүднээс Гегелийн эрх зүйн философи нь чөлөөт хүсэл зоригийг танин мэдэхээс эхэлдэг. Өөрөөр хэлбэл, эрх зүйн үндсийг материаллаг харилцаа бус, оюун санааны үндэстэй хэмээн үзсэн байна.

Чөлөөт хүсэл зориг нь И.Кантынхаар хүний ухамсарын факт, практик оюун санааны нотлогдохгүй үнэн байдаг аж. Өөрөөр хэлбэл, И.Кантынхаар чөлөөт хүсэл зориг оршин буйг нотлох буюу няцаах боломжгүй юм. Иймд чөлөөт хүсэл зориг оршин буйд итгэх нь чухал байна. Харин Гегель чөлөөт хүсэл зоригийг эрх зүйн санааг хэрэгжүүлэх зайлшгүй арга хэрэгсэл[1] гэж үзсэн. Чөлөөт хүсэл зориг нь Гегелийн хувьд оюун санааны нотлогдохгүй үнэн, түүнд итгэх зүйл биш, харин туйлын оюун санааны хөгжлийн хамгийн чухал хэсэг нь юм.

Гегелийн чөлөөт хүсэл зоригийн ойлголт нь сэтгэхүй, хүсэл зоригийн өвөрмөц ойлголттой шууд холбоотой. И.Кант сэтгэхүй, хүсэл зоригийг ялгаж, онолын болон практик оюун ухаан, танин мэдэхүй ба хүний үйл ажиллагаа нь хоорондоо ялгаатай хэмээн үзсэн. Харин Гегель сэтгэхүй, хүсэл зоригийг нэгдмэлээр авч үзсэнээрээ И.Кантаас ялгаатай юм. Гегель үзэхдээ: "Хүсэл зориг бол сэтгэхүйн хамгийн ойрын үнэн". "Хүсэл зориг-бодит ахуйд өөрийгөө хувиргасан сэтгэхүй". "Сэтгэхүйгүй хүсэл зориг гэж үгүй" гэжээ. Иймд хүнийг нэг талаас хүсэл зоригтой, нөгөө талаас сэтгэх чадвартай хэмээн үзэж болохгүй. Сэтгэхүй, хүсэл зоригийн ялгаа нь гагцхүү онол, практикийн хоорондын ялгаа юм. Учир нь, хүсэл зориг бол сэтгэхүйн онцгой арга гэж үзжээ.[2]

Гегелийн сэтгэхүй, хүсэл зоригийн нэгдлээс чөлөөт хүсэл

1.А.А.Пионтковский. "Учение Гегеля о праве и государстве". М, 1993 г., С.93.
2.Г.В.Гегель. "Философия права". М, 1990 г., С.32-33.

зоригийн ойлголт урган гардаг байна. Эрх чөлөө бол хүсэл зоригийн үндсэн шинж, түүний мөн чанар. Хүсэл зоригийг эрх чөлөөнөөс салгаж, чөлөөт бус хүсэл зоригийн тухай ярьж болохгүй юм.

.Гегелийн чөлөөт хүсэл зоригийг ойлгож танин мэдэхийн тулд хүсэл зоригийг танин мэдэх хөгжлийн үйл явцыг авч үзэх ёстой. Хүсэл зориг нь хөгжлийн гурван үе шатыг дамжин хөгждөг гэж Гегель үзсэн[3].

1. Төрөлхийн хүсэл зориг. Энэ үе шатанд хүсэл зоригийн чөлөөт байдал нь зөвхөн өөрөө л эрх чөлөөтэй байдаг. Энэ бол эрх чөлөөний боломж. Ийм хүсэл зориг хүүхдэд байдаг бөгөөд түүнд эрх чөлөөтэй, ухаалаг хүн болох боломж бий. Гагцхүү хүүхэд энэхүү эрх чөлөөг мэддэггүй, мөн ухамсарладаггүй байна. Ийм хүсэл зориг бол хэлбэр, агуулгын хувьд чөлөөт бус юм;

2. Дур зорго. Дур зорго нь өөртөө л эрх чөлөөтэй байдаг тул жинхэнэ эрх чөлөө биш юм. Энэ бол формаль эрх чөлөө. Дур зоргын үед хүсэл зоригийн чөлөөт байдал нь хэлбэрийн хувьд л байхаас, агуулгын хувьд чөлөөт бус байна. И.Кант дур зоргыг чөлөөт хүсэл зориг хэмээн төсөөлсөн. Харин Гегель дур зорго, чөлөөт хүсэл зоригийг ялгаж, дур зоргод хүсэл зоригийн чөлөөт байдлын агуулга, хэлбэр нь хоорондоо зөрчилдөг гэж үзсэн. Хүн жинхэнэ эрх чөлөө, чөлөөт хүсэл зоригтой байгаа үед дур зоргоор бус, ёс суртахуунаар өөрийгөө удирдаж, үйл ажиллагаа явуулан, хуульд хамсартайгаар захирагдаж байдаг байна. Гегель дур зорго, чөлөөт хүсэл зоригийн ялгааг зураачийн ажлаар жишээлж авч үзсэн. "Хэрвээ зураач төгс бүтээл бүтээсэн бол ямар бүтээл байх ёстой тийм л бүтээлийг бүтээсэн гэсэн үг. Энэ үед зураачийн онцгой, өвөрмөц бие даасан байдал үгүй болно. Энэхүү бүтээлд түүний мөн чанар илрэхгүй. Иймд зураачийн ажил хэдий чинээ бүтэмжгүй байна, түүний бүтээлээс өвөрмөц онцлог, дур зорго илрэх болно"[4] гэжээ;

3. Чөлөөт хүсэл зориг. Энэ үед хүсэл зоригийн чөлөөт байдал нь өөрөө өөртөө эрх чөлөөтэй байх бөгөөд агуулга, хэлбэрийн ялгаа байхгүй болно. Энэ бол чөлөөт хүсэл зоригийг танин мэдэх 3 дахь шат. Хүсэл зориг нь хэлбэр, агуулгын хувьд эрх чөлөөтэй юм. Эндээс л Гегелийн хүсэл зориг нь сэтгэхүйн онцгой арга, бодит ахуйд өөрийгөө хувиргасан сэтгэхүй болохыг олж харж болно.

Иймд Гегелийн үзлээр жинхэнэ чөлөөт хүсэл зориг нь ухаалаг, зохистой хүсэл зориг байна. Өөрөөр хэлбэл, чөлөөт хүсэл зориг бол ухамсарт хүсэл зориг буюу эрх чөлөөний илрэл юм. Харин жинхэнэ эрх чөлөө бол ухамсарласан зайлшгүй байдал. Ёс суртахуунтай хүн өөрийн үйл ажиллагааны агуулгыг ухамсарлах тусмаа хохирол бага учруулдаг байна. Жинхэнэ эрх чөлөө бол зайлшгүй байдлыг ухамсарлан танин мэдэх явдал. Иймд эрх чөлөө нь дур зорго бус. Хүн чөлөөт байдлаа ухамсарлах нь зайлшгүй чухал бөгөөд энэ нь чөлөөт хүсэл зоригийн илрэл аж .Гегелийн үзлээр оюун ухааныг ухамсартайгаар зорилгоо болгосон чөлөөт байдал л жинхэнэ чөлөөт байдал болдог. Эрх чөлөө нь танигдсан зайлшгүй байдал тул танин мэдэхүйн хэрээр өсөн нэмэгдэж байдаг байна. Иймд хүн орчин тойрны юмс үзэгдэл, байгаль, нийгмийг таньж мэдэх тусам эрх чөлөөтэй болж байна гэсэн үг. Хэрвээ жам ёсны эрхийн онолоор хүн төрөлхөөсөө байгалиас заяагдсан эрх, эрх чөлөөгөө зайлшгүй эдлэх ёстой гэж сургадаг бол, Гегель байгалаас заяасан эрх гэж үгүй, харин хүн гадаад ахуйгаа зөв ухаалгаар таниж мэдсэн, оюун ухаан руу тэмүүлэх бие хүн л жинхэнэ эрх, эрх чөлөөгөө олж авна гэж үзсэн.

Ийнхүү Гегель нь эрх чөлөө, зайлшгүй байдлын харилцан хамаарлыг зөв тодорхойлсон бөгөөд Гегелийн эрх чөлөөний философи нь орчин үеийн эрх чөлөөний сэтгэлгээний нэг гол үндсэн чиг хандлагыг тодорхойлсоор байна.

Гегель "эрх зүйг-чөлөөт хүсэл зоригийн бодит ахуй"[5] гэж тодорхойлжээ. Түүний эрх зүйн ойлголтыг танин мэдэхийн тулд эрх зүйн танин мэдэхүйн хөгжлийн процессыг авч үзэх шаардлагатай юм. Гегель эрх зүйг танин мэдэх хөгжлийн процессыг түүхэн бус, танин мэдэхүйн логик процесс хэмээн үзэж, гурван үе шатанд хуваасан байна. Үүнд:

1. Хийсвэр эрх-чөлөөт хүсэл зоригийн гадаад бодит ахуй. Энэ бол бие хүний хүсэл зоригийн гадаад бие даасан хэлбэр. Иймд хийсвэр эрхийн хүрээнд хүмүүсийн харилцааны объектив тал илэрдэг. Хийсвэр эрхийн үндсэн ойлголт нь бие хүний ойлголт. Гегель хийсвэр эрхийн хүрээнд бие хүний эрх чөлөөний илрэл болох өмчлөх эрх, гэрээ, гэмт хэрэг, ялын асуудлыг авч үзсэн;

2. Зан суртахуун-чөлөөт хүсэл зоригийн дотоод бодит ахуй. Иймд зан суртахуунд хүмүүсийн харилцааны субъектив тал илэрдэг тул хүний үйлдэл, түүний үр дагавар, санаа сэдэл, гэм буруугийн асуудлыг авч үзсэн;

3. Ёс суртахуун-чөлөөт хүсэл

3.Гегель. "Философия прав". М, 1990 г., С.37-44.
4.Гегель. "Философия права". М, 1990 г., С.45.
5.Гегель. "Философия права". М, 1990 г., С.53.

зоригийн гадаад, дотоод бодит ахуйн нэгдэл. Иймд ёс суртахууны шатанд хүмүүсийн харилцааны субъектив, объектив тал нэгдмэлээр илрэнэ хэмээн үзэж иргэний нийгэм, төрийн асуудлыг авч үзжээ.

Ёс суртахууны эхний шат нь гэр бүл, хоёр дахь шат нь иргэний нийгэм, гурав дахь шат нь төр болно. Гегель ёс суртахууны ертөнцийг жинхэнэ эрх чөлөөний биелэл хэмээн үзэж, хүн төрд нэгдэж, иргэний эрх, үүргээ ухамсарлан, хуульд ухамсартайгаар захирагдаж байгаа энэ үед жинхэнэ эрх чөлөө хэрэгжинэ гэжээ.

Нийгэм дэх чөлөөт байдал бол хэсэг бүлэг хүмүүсийн дур зоргоороо авирлахыг даван туулах явдал. Хүмүүсийн хүсэл зоригийн нийгэм дэх хязгаарлал нь гагцхүү эрх зүйгээр зохицуулагдаж, эрх зүйн хэм хэмжээгээр илрэн гарч, эрх зүйн харилцааны хүрээнд л хэрэгжиж байдаг.

Дээрхээс үндэслэн эрх зүйн ойлголт нь Гегелийн эрх зүйн философид дараах утгаар илэрдэг болно[6]. Үүнд:[7]

1. Эрх зүй-эрх чөлөөний санаа. Эрх зүйг танин мэдэхүйн хөгжлийн эхний шатанд эрх чөлөөний санаа бий болдог. Энэ үед эрх чөлөө, эрх зүйн ойлголт нь нэг утгатай байна;

2. Эрх зүй-эрх чөлөөний хэлбэр. Эрх чөлөөний санаа нь өөрөө, өөрийгөө мэдэрч ухаарч эхэлсэн явцад эрхийн санаа нь эрх чөлөөнөөсөө салаад тодорхой хэлбэрт орж, өмчлөх эрх, гэрээ, гэмт хэрэг, ял шаардах эрхээр илэрнэ;

3. Эрх зүй-хууль (позитив эрх). Эрх зүйн санаа нь энэ үе шатанд хууль тогтоомжийн тодорхой хэлбэрт ордог байна. Гегель эрх зүй, хуулийг ялгах үзэл санааны явцдаа тэдгээрийг сөргүүлэн тавихгүй байхыг эрмэлзэж, позитив эрхийг эрх зүйг танин мэдэх тодорхой үе шат хэмээн үзэж байсан боловч, хууль тогтоох явцад эрх зүй нь агуулгаасаа гажих тохиолдол байдгийг хүлээн зөвшөөрч байсан. Энэ үндсэнд хууль нь эрх зүйн илрэн гарах хэлбэр юм. Иймд эрх зүйн агуулгаас гажсан хууль бол эрх зүй биш[8] хэмээн үзсэн. Гегелийн хэлсэнчлэн нийгмийн амьдралд хүний эрхийг үгүйсгэж, эрх зүйн агуулгаасаа гажсан хууль нилээдгүй гарч байсныг эрх зүйн өнгөрсөн түүх гэрчилнэ. Тухайлбал, хүний эрх чөлөөний илрэн гарах анхдагч хэлбэр болох өмчлөх эрхийг үгүйсгэсэн хуулиудыг социалист чиг баримжаагаар хөгжиж байсан улс орнууд гаргаж байсан. Мөн 1992 оны Монгол Улсын Үндсэн Хуульд хүний эрхийг баталгаажуулсан болов, 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас батлагдсан "Улс төрийн намын тухай" хуульд хүний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийн үзэл бодлын үүднээс эвлэлдэн нэгдэх, сонгох, сонгогдох эрхүүдийг ноцтой зөрчсөн "Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан, түүнчлэн нам нэрээ өөрчлөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглоно" (6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг), "Нам үүсэн байгуулагдаж, Улсын дээд шүүхэд бүртгүүлснээс хойш 18 сарын дараа Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож болно" (8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг) гэсэн заалтууд орсон байсан нь Үндсэн Хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1/01 тогтоолоор хүчингүй болсон юм. Иймд эрх зүй, хуулийг ялгаж, хууль эрх зүйн шинжийг агуулсан эсэхэд хариулт өгөх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, эрх зүйт болон эрх зүйн бус хуулийг ялган зааглах шаардлагатай байна.

Гегелийн эрх зүйн ойлголт И.Кантынхаас ялгаатай. И.Кантын үзлээр "эрх зүй бол хүний зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээний дагуу нэг субъектын дур зорго, нөгөө субъектын дур зорготой зэрэгцэн орших бүх нөхцөл" юм. Энэхүү ойлголтын үндэс нь бие хүний чөлөөт хүсэл зориг буюу дур зорго (И.Кант) байна. Харин Гегелийн эрх зүйн ойлголтын үндэс нь тодорхой субъектын хүсэл зориг бус, бүх нийтийн хүсэл зориг байдгаараа ялгаатай болно. Субъектын хүсэл зоригоор дамжин бүх нийтийн хүсэл зориг илэрнэ гэж үзсэн юм. Гегелийн үзэл санааны онцлог нь эрх зүйн мөн чанар, ойлголт нь нэг субъектын хүсэл зориг, ашиг сонирхолоос хамаарахгүй, хамаагүй дээгүүр байна хэмээн үзсэнд оршино. Ийнхүү Гегель эрх зүйг философийн категорийн агуулга, хэлбэрийн үүднээс авч үзэхдээ индивидуаль аргаар хандсангүй.

Орчин үед Гегелийн эрх зүйн ойлголт, түүнд хандах онол-арга зүйн асуудлыг үгүйсгэн шүүмжилсэн хандлага ажиглагдахгүй байна. Гегелийн эрх зүйн ойлголт, түүнийг танин мэдэх арга зүйн асуудал нь эрх зүйн сэтгэлгээний хүрээнд онол–арга зүйн ач холбогдолтой хэвээр байна.

6."История политических и правовых учений". Под. Ред. В.С. Нерсесянца. М, 1988 г., С.340-341.
7. Ю.В.Тихонравов. "Основы философии права". М, 1997 г., С.455.

ЭРХ ЗҮЙ НИЙГМИЙН ҮЗЭГДЭЛ МӨН

Эрх зүйн социологид эрх зүйн үзэгдлийг судлах судалгааг янз бүрийн арга замаар гүйцэтгэж болно. Тэдгээрийн нэг нь асуулт хариултын аргаар хүн амын зарим хэсгийн дунд эрх зүйд хандах хандлагын талаар мэдээлэл авах явдал юм. Яагаад асуулт хариултын арга гэж? Яагаад гэвэл эрх зүй бол хүмүүсийн бодол, санаанд байдаг зүйлүүдийн нэг. Хүн амын зарим давхаргуудад эрх зүй хэрхэн яаж төсөөлөгддөгийг харъя. Хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудад эрх зүй нь зайлшгүй судлах шаардлагатай хичээлүүдийн нийлбэр бөгөөд түүнийг судлах зорилго, утга учир нь мэргэжлийн хууль зүйн дээд боловсрол эзэмшихэд байгаа гэдгээр төсөөлөгдөнө. Эрх зүйн үнэт зүйлсийн талаар лекц уншиж буй багш, эрх зүйчдэд эрх зүй, эрх зүйн практик, хууль тогтоомж нь хууль зүйн шинжлэх ухааны судлагдахуун болох талаасаа, тэдний үйл ажиллагааны зорилго нь эрх зүйн мэдлэгийг ирээдүйн хуульчдад дамжуулах тэднийг практик ажилд бэлтгэхэд байна.

Өмгөөлөгчийн хувьд эрх зүй үйлчлүүлэгчийнхээ эрх, ашгийг хамгаалах арга, хэрэгсэл гэж ойлгогдоно. Шүүгчийн хувьд эрх зүй бол алив хэрэг, маргааныг шийдвэрлэх механизм болдог. Улс төрчдөд эрх зүй улс төрийн тогтоомын нэг хэлбэр мэт төсөөлөгдөж болох юм. Зарим арилжаа наймаа эрхлэгч эрх зүйг үйл ажиллагаагаа шударга үнэнч, үр ашигтай, хариуцлагатай явуулах хууль гэж төсөөлж байхад зарим нь эрх зүйг төвөгшөөж, болж өгвөл түүний алдаан дээр

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн доктор Р.Уранбилэг

ашиг, орлогоо нэмэгдүүлэхийг эрмэлзэнэ.

Ихэнхи жирийн иргэдийн хувьд эрх зүйд хэрхэн хандах нь тодорхой нөхцөл байдалд эрх зүй түүнд тус болж байсан уу? үгүй юу гэдгээр тодорхойлогддог.

Харин хуулиар ял авсан хүмүүсийн хувьд эрх зүйн шударга ёсны талаар өөрийн үзэл, бодолтой болсон нь ойлгомжтой.

Эрх зүйг чухал үзэгдэл талаас судлах эрх зүйн социологийн судалгаа шинжилгээний зорилго өөр байдаг. Өөрөөр хэлбэл, эрх зүйг нийгмийн үзэгдлийн хувьд түүний нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх чиг үүрэг нийгмийн бусад үзэгдлүүдтэй холбоо хэлхээнд нь тайлбарлаж, ойлгоход оршино.

Эрх зүй нийгмийн үзэгдэл болох тухай хэд хэдэн чухал шинжийг авч үзье.

1. Эрх зүй нийгмийн хөгжил, үйл ажиллагааны хэрэгцээг илэрхийлэгч үйл явц, үр дүн мөн. Эрх зүйн социологийн шинжилгээний хувьд эрх зүйг жам ёсны нийгмийн тогтоц гэж ойлгох нь чухал юм.

Эрх зүй нийгмийн харилцан үйл ажиллагааны явцад бий болсон гэдэг утгаараа жам ёсных болдог (эрх зүй судлаачид "жам ёсны"-гэсэн ойлголтыг янз бүрээр тайлбарладаг). Нэг үгээр хэлбэл, зохиомол бус, "жинхэнэ үнэн", "анхдагч"[1] нийгэм - эдийн засгийн харилцааны үр дүн бол эрх зүй гэсэн үг.

Мөн эрх зүйн жам ёсны үүслийг хүний хэл ярианы хөгжилтэй адилтган үзэх явдал бий. Хэл яриа яаж үүссэн бэ? Хүмүүсийн сайн дурын харилцааны үр дүнд хэл яриа төлөвшсөн гэж үздэг. Хүмүүст амьдрахын тулд хоорондоо бараа таваар солилцох, үзэл бодол, мэдээллээ солилцохыг эрмэлзэх, аль эсвэл зүгээр л хов жив ярих, сонссоноо бие биедээ хүргэхийн тулд хэл яриа зайлшгүй хэрэгтэй болжээ. Ийнхүү хүмүүсийн харилцааны үндсэн дээр бий болсон үг хэллэгүүд өргөн хүрээтэй болж тархсанаар тэдгээрийн ач холбогдол утга санаа толь бичигт[2] бэхжигдэн үлддэг байна.

Үүнээс үзвэл эрх зүйн социологийн үзэл бодлын зүгээс эрх зүй нь нийгмийн онцгой үзэгдэл мөн. Эрх зүйд хууль тогтоохоос өмнөх үеийн, хууль тогтоох үеийн нийгмийн нийгэм-улс төрийн амьдралын[3] шаардлага, шинж, бодит зүй тогтлын нэгдэл илэрч байдаг.

Харин социологич эрх зүйг нийгмийн үзэгдлийн хувьд позитив эрх зүйтэй хамт авч үздэг. ОХУ-ын эрх зүй судлалын томоохон эрдэмтдийн нэг Р.З.Лившиц: "Позитив эрх зүй эхний ээлжинд нийгмийн харилцааг зохицуулж буй хэм хэмжээнүүдийн нийлбэр юм". Позитив эрх зүй бол үргэлж

1. В.С.Нерсесянц. "Право-математика свободы". М, 1996 г., С.20.
2. М.Фридман. "Капитализм и свобода. Фридман и Хайек о свободе". Минск, 1990 г., С.49.
3. В.С.Нерсесянц. "Право-математика свободы". М, 1996 г., С.20.

нийтийн засаглалын үр дүн байдаг. Позитив эрх зүйд төрөөс зөвшөөрсөн тогтоосон бичмэл хэм хэмжээ, түүгээр зохицуулагдаж буй нийгмийн харилцаанууд бөөгнөрч байдаг. Позитив эрх зүй-жинхэнэ эрх зүй. Судлаачдын болон эрх зүйг хэрэглэгчдийн өмнө ноуны урьд эрх зүй-позитив эрх зүй байдаг. Эрх зүйн мөн чанар позитив эрх зүйгээс ангид төсөөлөгдөх бололцоогүй[4]" гэж бичсэн байна;

2. Эрх зүй нийгмийн тогтолцооны хэв маяг, үнэт зүйлтэй холбоотой.

Энд зарчмын хувьд нийгмийн зохион байгуулалт, нийгмийн зохицуулалтын 2 зохистой хэв шинжийн талаар ярьж болох юм. Өөрөөр хэлбэл:

а) нийгмийн хүн төвтэй тогтолцоо;

б) нийгмийн нийгэм төвтэй тогтолцооны талаар яригдах тухай.

Хүн төвтэй нийгмийн баримжааны утга учир зорилго нь хүн, хүний эрх чөлөө болно. Хүн төвтэй нийгмийн хөгжлийн түүхийн эхний үед (Эртний Грек) уг нийгмийн "загвар" нийгмийн бүх гишүүдэд тархаж байсангүй.

Хүний нийгмийн соёл иргэншлийн хөгжлийн дараа дараагийн өөрчлөлт нь хүний эрх чөлөөнд тодорхой хэлбэрээр ач холбогдол өгч байсантай холбоотой. Шинэ үеэс эхлэн хүний эрх, эрх чөлөөг хуулиар бэхжүүлж, түүнийг зөрчвөл нийгмийн байгуулал, үнэт зүйлд халдсан явдал гэж үздэг болов. Нийгэм төвтэй нийгмийн баримжаанд хүн-хувь хүний хувьд эрх чөлөөгүй, бие даасан бус, харин хүнийг нийгмийн зорилгыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл гэж баримжаалдаг.

Эрх зүй ба нийгмийн тогтолцооны хэв маяг харилцан уялдаатай. Нийгэм төвтэй соёл иргэншлийн эхний үеүүдэд (овог аймгаар хамтран амьдрах) явцад нэг хэм хэмжээ үйлчилж байв. Өөрөөр хэлбэл, хамтын аж амьдралыг маш чанга хатуу дүрэмлэн зохицуулах нийгэм төвтэй хэм хэмжээ байжээ. Грек-Римийн соёл иргэншил эдгээр хэм хэмжээг эхэндээ баримталж байсан. Нэг хэм хэмжээ нэг талаас ёс суртахуун, чөлөөт сэтгэлгээ, шашны төлөвшлийн явцад, нөгөө талаас хувийн өмч, хүний эрх чөлөөг хуулиар бэхжүүлсэн эрх зүйн хэм хэмжээний үүслийн үр дүнд задран унажээ. Христианы соёл иргэншлийн үүсэл нь Грек-Римийн хүн төвтэй нийгмийн баримжааг сэргээж, хүний жам ёсны[5] эрхийн үзэл бий болоход ихээхэн нөлөөлжээ. Мөн хүн төвтэй эрх зүйн загварын үүсэл хөгжилд Христианы Европд гарсан сүм хийдийн эрх чөлөөний төлөөх "папская" (григорианская) хувьсгал чухал үүрэг гүйцэтгэсэн. Үүний үр дүнд дүрэм, журам, жаягийн эрх зүйн хөгжил тавигдсан гэж зарим судлаачид[6] үзсэн байна.

Үүнээс үзвэл эрх зүй нийгмийн чухал үзэгдэл болохын хувьд нийгмийн үнэт зүйлсийн тогтолцоо, нийгмийн харилцааны шинжээр нөхцөлддөг байна;

3. Эрх зүйн социологид эрх зүйг хүмүүс, нийгмийн хэсэг, бүлгийн ашиг сонирхлоор дамжуулж судалдаг. Энэ тохиолдолд уг асуудлыг судалж буй судлаачийн өмнө хүмүүс эрх зүйг сонирхдог уу? Хэрэв сонирхдог бол яагаад эрх зүйг сонирхдог вэ? гэсэн асуултууд тавигдах байх.Хүний хувийн амжилтыг нийгмийн үнэт зүйлсийн нэг гэж шүтэх болсон өрнөдийн орнуудад ажиглагдаж буй хүнийг хувийн амжилт, үр бүтээл олохын төлөө баримжаатай амьтан гэж үзэх үзэл нь бодит байдалд үндэслэжээ. Үүний тулд хүнээс хүсэл, зориг, шургуу хөдөлмөр, авъяас, чадвар, амжилтыг шаардана. Амжилт бол түүний "хувийн болон нийгмийн чадал чинээний" нийгмийн үзүүлэлт юм. Амьдралд оршин байх эсэх нь мөн чанартаа чинээлэг байхыг хэлж байгаа юм. Хүний ашиг сонирхол үүнтэй холбоотойгоор амжилт олохын төлөө, хөрөнгө чинээтэй хүн болохын төлөө хүсэлд хөтлөгдөнө.

Тэгэхээр бидний өмнө "хүн-амжилт" гэсэн загварыг хийсвэрээр бий болгож болох юм. "Хүн-амжилт" бүхий л хүч бололцоогоо ашиг хонжоонд зориулахаар эрмэлзэнэ. Энэ бол өрчин үеийн нийгэм дэх хүмүүсийн зан үйлийн түгээмэл шинж. Бүгд амжилт руу гэмүүлдэг ч нөөц бололцоо хязгаарлагдмал байдаг. Өрсөлдөөн зохих журмаар явагдаж болох тэр үед өрсөлдөөний талбарт хамгийн овсгоо, самбаатай (хамгийн зөв хүн) нь ялах болно. Эсрэг тохиолдолд эрх ямбын эрх мэдэл аль эсвэл төрийн засаглалын эрх[7] ялна. Харин хувиа хичээсэн бэртэгчин зантай хүмүүсийн хувьд амжилт олох хувийн хүсэл сонирхлоо хэрэгжүүлэхийн тулд авъяас, шургуу хөдөлмөрөөс гадна өөр ямар нэг зүйл хэрэгтэй болдог. Уг чанартаа түүнд дураар авирлах юм уу эрх мэдэл эсвэл эрх зүйг сонгохоос өөр сонголт байхгүй. Хувийн ашиг хонжооныхоо төлөө санаа тавигч хувь хүмүүс яалт ч үгүй эрх зүйг сонирхож эхэлнэ. "Ашиг сонирхол-хонжоо-эрх зүй" бол харилцан уялдаатай, харилцан хамааралтай тогтолцоо. Хувиа хичээгчдийн эрх зүйг сонирхох

4. Р.З.Лившиц. "О противоречивой двуединой природе права. Подготовка и принятие законов в правовом государстве". М, 1998 г., С.284.

5. А.П.Семитко. "Развитие правовой культуры как правовой прогресс". Екатеринбург, 1996 г., С.23-25.

6. Г.Дж.Берман. "Западная традиция права: эпоха формирования". М, 1998 г., С.61-258.

7. С.С.Алексеев. "Философия права". М, 1998 г., С.64, 78.

сонирхол нь нийгэмд амжилт олоход адилхан боломж олгохуйц тогтонги, тогтвортой нийгмийн харилцааны хэлбэрийг бий болгохын төлөө байдаг хувийн хүсэл сонирхлоор илэрч байдаг юм. Харин бодит амьдрал бол энэ зөв, энэ буруу, энэ нь болно, болохгүй, үүнийг хийж болно, үүнийг хориглосон гэсэн сайхан үг хэлэхдээ биш. Яагаад гэвэл нийгмийн харилцааны субъектүүдийн эрх зүйг сонирхох байдал хууль тогтоомжийн, процессийн ба эрх зүйг хэрэглэх баталгааны хүрээ рүү хандаж байдаг юм.Эрх зүйг сонирхох сонирхол юуг харуулж байна вэ? гэвэл эрх зүй хүний амжилт олох хүчин чармайлтыг хууль зүйн хэлбэрт оруулж, улмаар түүнийг амьдралд хэрэгжүүлэх эрх зүйн баталгаг бий болгож өгч байна;

4. Эрх зүй нийгмийн харилцаанд орж буй субъектүүдийн хэрэгцээний үндсэн дээр бий болж, нийгмийн амьдралыг тодорхойлогч, зохицуулагч "бие даасан" нийгмийн хүч болж байна.

Эрх зүй хүмүүсийн амьдрал дахь зан үйлийн тогтолцооны баримжааг өөрчилж байна. Германы социологич Г.Зиммель "Тэдний хүсэл, сонирхол одоо ... хэрэгжиж байна. Яагаад гэвэл түүнийг эрх зүй өдөөж, дэмжиж байдаг: fiat justicia, pereat mundus[8] (хэрэв ертөнц сөнөхөд хүрвэл хууль зүй бүтнээр үлдэг)" гэж бичсэн байна. Үүнээс үзвэл эрх зүйн дагуух зан үйл нийгмийн амьдралын зорилгод үндэслэдэг;

5. Эрх зүй нийгмийн харилцан үйл ажиллагааны явцад бий болж чиг үүргээ гүйцэтгэдэг. Аль ч нийгмийн байгуулал нийгмийн тогтолцоо болохын хувьд харилцан үйл ажиллагаанд оролцож буй хувь хүмүүсээс тогтож байдаг[9].

Хувь хүмүүс нийгмийн гишүүний хувьд бие биетэйгээ харилцан үйл ажиллагаа, үйлдэл хийх замаар харилцаанд орж байдаг. Тэдний харилцааны ялгагдах шинж нь хэм хэмжээний байх явдал юм. Зах зээлийн харилцаанд эрэлт, хэрэгцээний харьцаа бодитойгоор тогтоогдож байдаг шиг нийгмийн ба эрх зүйн хэм хэмжээ бодитой бүрэлдэн төлөвшдөг. Хувь хүмүүсийн харилцан үйл ажиллагаа хэм хэмжээгээр журамлагдсан байдаг бол эрх зүй чиг үүргээрээ тэдний нийгмийн харилцан үйл ажиллагаатай холбоотой.

Нийгмийн хүн төвтэй загварын тэргүүлэх үнэт зүйл нь хүн, хүний эрх, эрх чөлөө байдаг. Ийм учраас эрх зүй хэм хэмжээний, бүх нийтээр заавал дагаж биелүүлэх, эрх зүйн үйлчлэлийг хангахын[10] тулд төрийн албадлагыг хэрэглэх зэрэг шинжүүдийг агуулж байдгаараа хувь хүний амьдралын үйл ажиллагаа, эрх чөлөөг хангахад зориулагдсан байна. Товчоор, эрх зүй нийгмийн эрх чөлөөний хэлбэр, арга юм.

Эрх зүй нийгмийн харилцан үйл ажиллагааны янз бүрийн төрөлд нийгмийн чиг үүрэг гүйцэтгэж үйлчилж байдаг. Жишээлбэл:

а) Хүний эрх, эрх чөлөөг хангахад;

б) Нийгмийн хэсэг, бүлэг, хувь хүмүүсийн хамтын болон хувийн ашиг сонирхлыг нийгмийн зөвшилд хүргэхэд;

в) Байгалийн ба нийгмийн нөөц бололцоо (эд баялаг–засаглал–нэр төр, алдар хүнд) хязгаарлагдмал нөхцөлд нийгмийн зөрөлдөөний эх үүсвэр, түүнд хүрэх тэгш бус байдлыг арилгахад;

г) Иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан эрх зүйт төр, иргэний нийгмийн институтүүдийг төлөвшүүлэхэд эрх зүй үйлчилнэ.

Харин бид эрх зүйг туйлын хүслэн болгосон нийгмийн бүтцийг ямар нэг хэмжээгээр санал болгохыг хүсэхгүй. Энэ бол гүвэгтэй асуудал. Хувь хүн нийгмийн боломж, эрх чөлөөгөө чухам яаж ашиглах, эдлэх тухай эрх зүй хэлдэггүй. Хүн өөрийн асуудлаа бие дааж өөрөө шийддэг. Тэгээд ч эрх зүй хүнийг шударга, үнэнч, ёс суртахуунтай, хүнлэг болгон хүмүүжүүлэх гэж оролдсоор байдаг. Энэ бол ёс суртахууны, шашны хүрээний үнэт зүйл юм. Эрх зүй мөн нийгмийн тэгш байдлыг хавтгайруулан тэгшитгэх, амжилтыг тэгшлэн тогтоох арга хэрэгсэл болохгүй. Үүний зэрэгцээгээр нийгэмд хуулийг тойрон гарахыг эрмэлздэг иргэд, байгууллага, төрийн албан хаагчид үргэлж байсаар байсан, байх ч болно. Ийм тохиолдолд эрх зүй нийгмийн байгууллыг тогтвортой байлгах үүднээс эрх зүйн дэг журмыг хадгалах хүчний нөөцөө гаргахад хүрдэг.Ийм арга хэмжээг нийгмийн харилцаанд авах явдал нь нийгмийн зөрчил, зөрөлдөөнийг шийдвэрлэх эрх зүйн механизм болдог. Хүний нийгмийн соёл иргэншлийн түүхэнд үүнээс өөр нийгмийн механизм төлөвшиж бий болоогүй бөгөөд ингэх ч боломжгүй. Эрх зүйн хэлбэрт хучигдсан нийгмийн харилцаа хүмүүст өөрийн чадавхи, нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаж хувийн амжилт, нийгмийн хөгжилд хүрэх нөхцөл бололцоог бий болгодог. Эрх зүй хүмүүсийг тэгшитгэдэггүй, албан тушаал ахих, эд баялаг, засаглалд хүрэхэд саад болдоггүй. Гэсэн ч зарим хүмүүс, бүлгийн эрх мэдэл, ямбаа хуулиас хэтрүүлэх гэсэн хүсэл, эрмэлзэл, оролдлогод саад болдог.

8. Г. Зиммель. "Пример чистой или формальной социологии. Избранное". М, 1996 г., Т.2. С.487-488.
9. Нийгмийн энэ төсөөлөл хийсэн бөгөөд нийгмийн тогтолцоог хялбаршуулсан загвар.
10. Л.И.Спиридонов. "Теория государства и права". М, 1996 г., С.88-97.

ЭРХ ЗҮЙТ ЁСЫГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛЭХ НЬ ХӨГЖЛИЙН ТУЛГУУР БАГАНА МӨН. (ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ЗОРИЛТ)

Эрх зүйт ёс хэмээх ойлголт юуг илэрхийлдэг ба Монгол Улсын эрх зүйн шинжлэх ухаанд хэрхэн авч үздэг байсан талаар

Монгол Улсын эрх зүйн шинжлэх ухаанд "эрх зүйт ёс" хэмээх нэр томъёо хэрэглэгдэх болсон нь тун саяхных (2000 оноос хойш) бөгөөд түүний агуулга, мөн чанарын талаар эрс тэс зөрөөтэй тайлбар хараахан гарахгүй байгаа юм. Гэхдээ энэ нь эрх зүйн үзэгдэл болохынх нь хувьд өмнө огт сонсоогүй, хэрэглэж байгаагүй нэр томъёо биш бөгөөд уламжлалт байдлаар бид түүнийг "эрх зүйт төр" гэж нэрлэж[1] байжээ. "Эрх зүйт төр" хэмээх нэр томъёог шинжлэх ухааны агуулгад төдийлэн нийцдэггүй талаар зарим судлаачид өгүүлэх болсон байна. Жишээлбэл, Х.Тэмүүжин "Бид ихэнхдээ Эрх зүйт

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрхлэгч, докторант Р.Мухийт

ёсыг хэрэглэж буй эрх зүйт төр гэх нэр томъёоносоо шалтгаалаад төрийн загвар, түүний хөгжлийн нэг гүвшин гэж ойлгодог. Гэтэл энэ ойлголт нь Германы Rechtsstaat болон Англи-америкийн Rule of law гэх ойлголттой дуйцэх (Р.М) ба Rechtsstaat болон Rule of law гэх ойлголтуудын хооронд зарчмын үндсэн гол ялгаа байхгүй. Товчоор хэлбэл Rechtsstaat гэх ойлголт нь төрийн гэхээсээ хууль, эрх зүйн асуудал болон хувирсан[2] бөгөөд Rule of law-ын талаархи хамгийн сайн концепци бол Rechtsstaat-ын концепци гэж хэлэгдэх хүртлээ ойртон нэгдэж чадсан байна"[3] гэжээ.

Тэгэхлээр судлаачид Германы Rechtsstaat болон Англи-америкийн Rule of law гэх ойлголтууд хоорондоо дуйцэхүйц гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Харин Rechtsstaat буюу эрх зүйт төр гэсэн энэхүү ойлголт нь төрийн шинж чанартай холбоотой эсэх талаар зарим зөрүүтэй үзэл бодол байгаа нь харагдаж байна.

1.Эрх зүйт ёс англи. Rule of law; ор. Господство права //С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2008 он, 620 дахь тал/;

Rule of law гэсэн ойлголтыг монгол хэлнээ "эрх зүйт төр" хэмээн орчуулж хэрэглэж байна. //Н.Лүндэндорж. Төрийн онол. Сурах бичиг. УБ., 2005 он, 222 дахь тал/;

Англи хэл дээрхи хууль зүйн зохиол бүтээлд энэ нэр томъёо (Rechtsstaat Р.М) хэрэглэгддэггүй бөгөөд харин түүнтэй эн тэнцүү утга бүхий нэр томъёо нь "эрх зүйн удирдлага" /правление права-rule of law/ юм //Н.Жалбажав, Д.Отгонтуяа. Эрх зүйн философи. УБ., 1998 он, 219 дэх тал/;

Эрх зүйт төр гэж монгол хэлнээ, Германаар der Rechtsstaat гэж нэрлэдэг. Үүнийг англи хэлний хууль зүйн үгсийн санд rule of law гэж томъёолсон байдаг //Ц.Сарантуяа. Төрийн онол. УБ, 1998 он., 136 дахь тал/ гэж тус тус үзжээ.

Гэхдээ Rule of law-г "эрх зүйт төр" гэдэг утгаар биш эрх зүйт төрийн үндсэн зарчим (Н.Гантулга. Төр, эрх зүйн ерөнхий онол. УБ., 1998 он, 192 дахь тал), эрх зүйт төрийн тусгаар тогтнолд хамаарах ойлголт (Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол. УБ., 2004 он, 391 дэх тал), англи хэлтэн улсуудын хууль зүй судлалын эл ухагдахуун нь эх газрын эрх зүйн бүл дэх эрх зүй тэргүүлэх байр суурьтай байна хэмээх төсөөлөлтэй нэлээд хэмжээгээр дуйцэнэ (С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2008 он, 620 дахь тал) гэж үзсэн нь ч бий.

2. Харин доктор, профессор Н.Лүндэндорж "Rechtsstaat" гэсэн ойлголт нь төрийн тодорхой шинж чанарыг зааж байдаг талаар дурдсан байдаг бөгөөд "Rule of law" нь "төр" гэсэн ойлголттой тодийлөн холбоогүй буюу тийм утгыг агуулаагүй байсан юм (Н.Лүндэндорж. Төрийн онол. Сурах бичиг. УБ., 2005 он, 222 дахь тал), академич С.Нарангэрэл Эрх зүйт төр англи. Rule of law state; ор. Правовое государство - Үндсэн хуулийн эрх зүйд төрийн Үндсэн хуулийн эрх зүйн статусын тодорхойлолт юм (С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2008 он, 621 дэх тал) гэжээ.

"Эрх зүйт төр" гэдэг ойлголтыг төртэй илүү холбож үзсэн үзэл санаа ихээхэн байдгийг Н.Гантулга. Төр, эрх зүйн ерөнхий онол. УБ., 1998 он, 193 дахь тал, Ц.Сарантуяа. Төрийн онол. УБ., 1998 он, 138 дахь тал, Д.Лүндээжанцан, Н.Жалбажав, Д.Отгонтуяа. Эрх зүйн философи. УБ., 1998 он, 238-239 дэх тал, Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол. УБ., 2004 он, 394 дэх талаас үзэж болно.

3. Х.Тэмүүжин. Эрх зүйт ёс: онол, үзэл баримтлал //Өмгөөлөгч: онол практик, мэдээ, мэдээллийн сар тутмын сэтгүүл. 2006 он, №1. 26-27 дахь тал.

Эрх зүйт ёс гэсэн нэр томъёо сүүлийн үеийн эрх зүйн бүтээлүүдэд дурдагдах болжээ. Жишээбэл: Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008 он, 173 дахь тал; Ж.Амарсанаа. Ардчилсан эрх зүйт ёс. УБ., 2009 он; Үндсэн хууль ба эрх зүйт ёс (Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний уралдаанд шалгарсан илтгэлийн эмхтгэл). УБ., 2009 он, зэрэг бүтээлийг үзнэ үү.

Эрх зүйт ёс нь социалист эрх зүйтэй мөн чанарын хувьд харшилах (энэ талаар хойно өгүүлэх болно) учир 1992 оны ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдах хүртэл үндсэндээ Монгол Улсын эрх зүйн шинжлэх ухааны эргэлтэд орох бололцоогүй байжээ гэж үзэх бүрэн үндэстэй болж байна. Гэхдээ ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны дараа энэ ойлголтыг бид "эрх зүйт төр" хэмээх онолын ойлголтоор илэрхийлж байсныг өлгөө "эрх зүйт ёс" хэмээх нэр томъёог хэрэглэх нь зүйтэй гэх үзэл санаа бий болжээ.

Эндээс:

• 1992 оны ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдах хүртэл Rule of law=Rechtsstaat=Ойлголт байгаагүй;

• Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны дараа Rule of law=Rechtsstaat=Эрх зүйт төр;

• Өнөөдөр зарим судлаачдын үзэж, санал болгож байгаагаар Rule of law=Rechtsstaat=Эрх зүйт ёс болон шинжлэх ухааны нэр томъёоны хувьд хувьсан өөрчлөгдөх үйл явц явагдаж байна гэсэн дүгнэлт хийж болно.

Эрх зүйт ёсны агуулга, мөн чанарын тухайд

Эх газрын эрх зүйн тогтолцоонд буюу Монгол Улсад

Доктор, профессор Н.Лүндэндорж "эрх, хууль, төр гэсэн гурван ойлголт салшгүй нэгдэлтэй, бас ялгаатай. Эдгээрийн хамгийн зохистой хослолыг бүрдүүлсэн төрийг эрх зүйт төр гэдэг. Хууль дээдлэдэг төр бүрийг эрх зүйт гэхгүй, харин эрх зүйт хуулийг дээдэлдэг төрийг тэгж хэлдэг ...Тэгэхлээр, эрх зүйт төрийн суурь зарчим бол дур зоргын хууль биш **эрх зүйт хууль ноёрхох** явдал мөн. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын тулд эрх зүйт хуулийг дээдэлдэг төр ёсны мөн чанарыг эрх зүйт төр гэсэн ойлголтоор гэмдэглэдэг. Нөгөө талаас эрх зүйт төр бол төр, иргэний нийгэм хоёр эрх зүйт хуулийн үндсэн дээр харьцангуй тэнцвэртэй орших арга мөн"[4] гээд эрх зүйт төр нь эрх зүйт хуулийн үндсэн дээр:

• Төрийн эрх мэдлийг хуваарилах;

• Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас улс төрийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ хууль ёсыг чанллан сахих;

• Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах;

• Үндсэн хуульт ёсыг хэрэгжүүлэх;

• Эрүүгийн хууль тогтоомжийг буцаан хэрэглэхийг хориглох;

• Эрх зүйн хамгаалалт, хяналтыг тогтоох гэсэн үндсэн элементтэй[5].

Харин эрх зүйт төр нь:

• Эрх зүйт хууль, ялангуяа Үндсэн хууль үнэнхүү дээдлэгдэх

• Хүний эрх, эрх чөлөөний баталгаат найдвартай хангах

• Төрийн эрх мэдлийн хуваарилалт

• Хараат бус шүүх төлөвшсөн байх

• Төр хийгээд иргэн харилцан хариуцлага хүлээх гэсэн үндсэн шинжтэй[6] гэж үзсэн байна.

Англи-америкийн эрх зүйн тогтолцоонд:

Английн Стаффордшир Их Сургуулийн доктор Найжель

4. Н.Лүндэндорж. "Төрийн онол". Сурах бичиг. УБ., 2005 он, 219-224 дэх тал.
5. Н.Лүндэндорж. "Төрийн онол". Сурах бичиг. УБ., 2005он, 231 дэх тал.
Харин доктор Ц.Сарантуяа эрх зүйт төр нь:
• Эрх мэдлийг хуваарилах зарчим;
• Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангах;
• Төрийн байгууллагууд гагцхүү эрх хэмжээнийхээ хүрээнд ажиллах;
• Эрх зүйн баталгаат байдал;
• Хууль дээдлэх зарчим гэсэн элементтэй гэжээ. //Ц.Сарантуяа. "Төрийн онол". УБ., 1998 он, 140 дэх тал.
6. Н.Лүндэндорж. "Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага". УБ., 2002 он, 105-109 дэх тал.
Эрх зүйт төрийн шинжийг судлаачид дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:
• Хууль дээдлэх ёс;
• Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн хүндэтгэж, түүнийг эдийн засаг, улс төр, хууль, эрх зүйн баталгаагаар найдвартай хангах;
• Төр улс-бие хүн хоёрын хоорондын харилцаг уян хатан, бие биеийн өмнө харилцан үүрэг хүлээсэн, аль алины нь ашиг сонирхолыг адил харгалзан зөв хосолсон байхаар тогтоох;
• Төрийн эрх мэдлийг хуваарилах;
• Шүүх хараат бус байж, зөвхөн хуульд захирагдах; //Д.Лүндээжанцан, Н.Жалбажав, Д.Отгонтуяа. "Эрх зүйн философи". УБ., 1998 он, 239-253 дахь талыг үзнэ үү.
• Захиргааны байгууллагаас явуулж буй үйл ажиллагаа тус бүр хууль зүйн үндэслэлтэй, хуулиар зөвшөөрөгдсөн байх;
• Хууль дээдлэх; //Ц.Сарантуяа. "Төрийн онол". УБ., 1998 он, 138 дахь тал.
• Нийгмийн амьдралын бүх хүрээнд хууль ноёрхоно;
• Хувь хүний эрхийг хангаж хөгжүүлэх; //Т.Одонхүү. "Эрх зүйн философи". УБ., 1999, 106-107 дахь тал.
Үүнээс гадна зарим судлаачид эрх зүйт төр нь ард түмний бүрэн эрхт байдал, Үндсэн хуулийн байгуулал бүхий төртэй холбогдуулан төрийн зүгээс хүний эрх ба эрх чөлөөг зөрчихгүй байх, Үндсэн хууль болон бусад хуулийг дээдлэх, эрх мэдлийг хуваарилах, эрх мэдлийн хариуцлагын институт нь эрх зүйт төрийн зохион байгуулалтын үндэс болох, шүүх хараат бус байх (С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Нэмж засварласан хоёрдахь хэвлэл. УБ., 2008 он, 621 дэх тал), хууль дээдлэх, иргэд ба хүн эрх зүйн найдвартай хамгаалалтад байх, хууль, эрх зүй нэгдэлтэй байх, төрийн засаглалын янз бүрийн салбаруудын үйл ажиллагааг хязгаарлах ((Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол. УБ., 2004 он, 391-394 дэх тал), эсхүл хууль дээдлэх, төр, иргэн харилцан үүрэг хүлээх, засаглалын эрх мэдлийг хуваарилах, ардчилсан ёсыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг хангах (Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2000 он, 74 дэх тал) зэрэг үндсэн зарчмуудаар биелэлээ

Ашфорд эрх зүйт ёсны агуулгыг:

• Хүний бус, хуулийн засаг;

• Хуулийн өмнө эрх тэгш байх;

• Ерөнхий болон хийсвэр хууль;

• Шударга ёсны түгээмэл зарчим;

• Хараат бус шүүх;

• Үндсэн хуульт ёс ба хязгаарлагдмал засаг зэрэг зарчмуудаар илэрхийлсэн[7] бөгөөд эрх зүйт ёсны зорилго бол хувь хүнийг хамгаалах явдал юм. Эрх зүйт ёсноос өөр юу ч чөлөөт нийгмийг чөлөөт бус нийгмээс тийм сайн ялгаж өгч чадахгүй. Хуулийн засаг ба дур зоргын засгийн ялгаа нь хүрэх газраа очихын тулд хаагуур явахыг заасан замын тэмдэг ба хаагуур, хэзээ аялахыг зааж, чөлөөтэй шилжих эрхийг хязгаарласан төрийн заавар хоёрын ялгаатай адил[8] гэжээ.

Эндээс үзэхэд ижил утга санаа бүхий ойлголтууд эрх зүйт ёсны үндсэн шинж, зарчим, элемент гэх мэтээр өөр өөр байдлаар ангилагдан оршиж байгаа бөгөөд нэгтгэн дүгнэхэд зарим талаар хүндрэлтэй мэт харагдаж байна.

Энэ талаар МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш М.Батсуурь, Ч.Өнөрбаяр нар "өнөө үед эрх зүйт ёсны идеалийг агуулгын болон хэлбэрийн талаас нь тодорхойлдог бөгөөд эрх зүйт ёсны хэлбэрийн идеалийн тухайд маргадаггүй боловч энэ нь эрх зүйт ёсны мөн чанарыг төдийлөн нээж чаддаггүй. Учир нь хуульт төрд ч гэсэн хэлбэрийн шаардлагууд байдаг. Харин эрх зүйт ёсны агуулгын идеал нь түүнийг хуульт төрөөс салгахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ агуулгын идеал дээр маргаан байдаг боловч дараахь гурван зарчим дээр санал зөрдөггүй" гээд үүнд:

• Үндсэн эрхийг хамгаалах;

• Эрх мэдэл хуваарилах;

• Үндсэн хуулийг дээдлэх гэсэн гурван зарчмыг" нэрлэжээ.

Эрх зүйт ёсыг төгөлдөржүүлэх нь хөгжлийн тулгуур багана болох нь

Дээр дурдсанчлан эрх зүйт ёс нь хүн төрөлхтний агуу их ололтуудын нэг бөгөөд үнэт зүйл нь мөн. Энэ үүднээсээ эрх зүйт ёсыг амьдралд жинхэнэ утгаар нь нэвтрүүлэх, хөгжүүлэх, түүнийг төгөлдөржүүлэх явдал нь хүний эрх, эрх чөлөөг найдвартай хамгаалж, иргэний нийгэм болон төр тэнцвэртэй байх нөхцлийг бүрдүүлэх бөгөөд төрийн үйл ажиллагаа эрх зүйд үндэслэгдэж ингэснээр иргэн, хуулийн этгээд хэн боловч хуулийн дагуу чөлөөт зах зээлийн эдийн засагт шударгаар, тэгш өрсөлдөх боломжийг бүрдүүлнэ.

Ийм эрүүл хөрс бүрдсэн тохиолдолд улс орон хөгжих нь зүй ёсны асуудал юм. Ер нь улс орны хөгжил бол төр нь баян, эрх мэдэлтэй ард түмэн нь ядуу буурай, эрхээ хязгаарлуулсан байх явдал биш билээ. Харин ч эсрэгээрээ ард түмэн нь баян, эрх, эрх чөлөөгөө эдлэх бололцоогоор хангагдсан, төр нь энэхүү боломжийг бүх этгээдэд тэгш байдлаар олгодог байх ёстой.

Эндээс улс орны хөгжил бол төрийн хөгжил биш, харин эцсийн дүндээ хүний хөгжил юм гэсэн санаа гарч байна. Хүний хөгжил нь иргэний нийгмийг хөгжүүлнэ. Иргэний нийгмийн хөгжил нь төрийг өөрийг нь ч бас хөгжүүлнэ. Эдгээр нь нийлбэрээрээ улс орны хөгжлийг өөд нь татна.

Иймээс хувь хүнийг хамгаалах, хүнийг хөгжүүлэх явдал бол эрх зүйт ёсны гол зорилго бөгөөд энэ утгаараа эрх зүйт ёсыг төгөлдөржүүлэх нь хөгжлийн тулгуур багана мөн гэж үзэж байна.

Эрх зүйт ёсыг төгөлдөржүүлэх үйл явц нь эрх зүйн шинэтгэлийн зорилтуудтай холбоотой болох нь

Эрх зүйт ёсыг төгөлдөржүүлнэ гэдэг нь эрх зүйт ёсыг амьдралд жинхэнэ утгаар нь нэвтрүүлэх, хөгжүүлэх, сайжруулж, боловсронгуй болгох явдлаар илэрнэ. Энэхүү үйл явц нь эрх зүйн тогтолцоог сайжруулж, боловсронгуй болгох явдлаар буюу **эрх зүйн шинэтгэлээр** дамжиж явагдана. Иймээс Монгол Улсад явагдсан эрх зүйн шинэтгэлийн галаар товч дурдъя.

Монгол Улс 1990-ээд он хүртэл төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай, улс төрийн тоталитари дэглэмд оршиж байсан. Харин 1980-аад оны эцсээс ардчилсан хөдөлгөөн өрнөсний дүнд 1990 оны 3 дугаар сараас тоталитари дэглэмийг халж улс төрийн ардчилсан дэглэм тогтоон, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц алгуурхан эхэлсэн.

Үүнээс өмнө монголчууд гурван Үндсэн хуулийг (1924, 1940, 1960 оны) дагаж мөрдсөн түүхтэй бөгөөд эдгээр гурван Үндсэн хууль нь бүтэц зохиомжийн болон зарим зүйл нь агуулгын ялгаатай боловч тодорхойлсон зорилго, төрнийгмийн байгууллын үндсэн зарчмуудын хувьд нэгэн адил социалист маягийн Үндсэн хууль байсан.

Харин 1990 онд монголд ардчилсан хувьсгал өрнөсөн ба үүгээр захиргаадлын дэглэмийг халж улс оронд ардчилсан дэглэм

олдог гэж үздэг байна.

7. Найжель Ашфорд. "Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд" (гарын авлага). УБ., 2007 он, 94-100 дахь талаас эдгээр зарчмуудын талаар дэлгэрүүлэн үзнэ үү.

АНУ-ын орчин үеийн номлолд эрх зүйт ёсыг хэрхэн авч үздэг талаар С.Нарангэрэл. "Эрх зүйн эх толь бичиг". Нэмж засварласан хоёрдахь хэвлэл. УБ., 2008 он, 620 дахь талаас харьцуулан үзнэ үү.

8.Найжель Ашфорд. "Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд" (гарын авлага). УБ., 2007 он, 100 дахь тал.

9.М.Батсуурь, Ч.Өнөрбаяр. Эрх зүйт ёсны үүднээс Үндсэн хуулийг авч үзэх нь. Үндсэн хууль ба эрх зүйт ёс (Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний ураллаанд шалгарсан илтгэлийн эмхтгэл). УБ., 2009 он, 10-15 дахь талаас эдгээр зарчмуудын талаар дэлгэрүүлэн үзнэ үү.

тогтоох цоо шинэ бодлогыг хэрэгжүүлэхийн тулд өмнөх Үндсэн хуулиар (1960 оны) бэхжүүлсэн хуучин тогтолцоог нэн даруй өөрчлөх, улмаар шинэтгэх зорилт тавигдаж байв.

1990 оны 3 дугаар сарын 21-ний өдөр нэг намын дангаар ноёрхлыг халж, олон ургалч ёс, улс төрийн эрх чөлөөг тунхагласан зарчмын өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулав. Энэ нь улс төр, эрх зүйн шинэ харилцааны эхлэл болов. 1990 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Ардын Их Хурлын 11 дэх удаагийн сонгуулийн чуулган "БНМАУ-ын төрийн эрх барих дээд байгууллагын бүтцийг шинэчлэх тухай" хэлэлцсэн бөгөөд 1990 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг баталсан бөгөөд энэ нь шилжилтийн чанартай Үндсэн хуульчилсан хууль[10] байв. Нэмэлтийн хууль нь мөн чанарын хувьд өөр байсан учир 1960 оны Үндсэн хуулийн бүлэг бус харин бие даасан хууль бөгөөд Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй үйлчилж, түүхэн үүргээ гүйцэтгэжээ.

БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль нь үзэл санааны хувьд ч, үр дүнгийн хувьд ч түүхэн ач холбогдолтой байсан[11].

Энэ бүхнийг түшиглэн 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр БНМАУ-ын Ардын Их Хурал Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хуулийг баталсан.

Монгол Улсын шинэ Үндсэн хуульд хүний эрхийн асуудлыг зөвхөн Монгол Улсын иргэдийн нэг хэсгийн эрх, эрх чөлөөгөөр хязгаарлаагүй, харин бүх иргэнээ хамааруулж бас тэднээс гадна тус улсад байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг оролцуулан нийт "Хүний эрх, эрх чөлөө" гэсэн өргөн хүрээнд анх удаа дэвшүүлэн (Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг) тодорхойлсон[12]. Өмнөх буюу 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудад хүн амын нэг хэсгийн эрхийг анги давхраа болон бусад байдлаар ялгаварлан хассан байлаа.

Мөн Үндсэн хуулиар төрийн байгууллын шинэ тогтолцоог бий болгосон. Ингэхдээ төрийн эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлж, нэг нам хяналтгүйгээр хэрэгжүүлж байсныг эрх мэдлийн гурван салаанд хуваарилж хяналт тэнцэлтэй болгохыг зорьсон.

Энэ бүх тогтолцоо Үндсэн хууль баталмагц тэр даруй бий болоогүй нь ойлгомжтой бөгөөд 1992 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хууль буюу БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай хуулийг БНМАУ-ын Ардын Их Хурал баталсан ба түүнд заасны дагуу зарим хуулиудыг яаралтай шинээр боловсруулах, зарим нэмэлт, өөрчлөлт оруулах зорилт тавьжээ.

Эрх зүйн шинэтгэлийг өдгөө өргөн, явцуу хоёр утгаар ойлгож байна. Энэ нь эрх зүйн тогтолцоог мөн ийм хоёр утгаар гайлбарладагтай, бас практикийн ач холбогдлоор нь авч үздэгтэй шууд холбоотой.

Эрх зүйн тогтолцоог хууль тогтоомж, эрх зүйн бусад хэм хэмжээ, түүнийг үзэх үзэл, хандах, хэрэглэх практик зэрэг олон хүчин зүйлийн нийлбэр цогц гэсэн өргөн утгаар нэг тайлбарладаг. Эсвэл эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц гэсэн явцуу утгаар бас тодорхойлдог. Юутай ч эрх зүйн хэм хэмжээг шинэтгэн тогтоож, зөв ойлгож, үр нөлөөтэй хэрэгжүүлдэг болгох нь нийгмийн бодит хэрэгцээ мөн. Хэрэгцээг дүүрэн харгалзах нь илүү үр дүнд хүргэдэг билээ[13].

Юуны түрүүнд төрийн байгуулламын шинэтгэлийг хийж, төрийн болон нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллагуудыг шинэчлэн зохион байгуулах ажлын хүрээнд Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай, Засгийн газрын тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон сонгуулийн багц хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн байна. 1993 онд батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар шүүхийн тогтолцоог өөрчилж, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгааг бий болгож, түүний эрх зүйн шинэ орчинг бүрдүүлэх суурийг тавьсан юм.

1992-1997 оны хугацаанд эдийн засгийн харилцааг зохицуулахад шаардлагатай хууль тогтоомжийн шинэтгэл эрчимтэй хийгдсэн ба үүнийг эрдэмтэн судлаачид хууль тогтоомжийн шинэтгэлийн өрнөлтийн үе гэж тодорхойлсон байдаг. 1963 оны Иргэний хуулийг бүхэлд 1994 онд шинэчлэн найруулж, улмаар түүнд холбогдох хуулиудыг шинэчлэн боловсруулсан. "Татварын багц хууль", "Гаалийн тухай", "Гаалийн тарифийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", "Орон сууц хувьчлах тухай", "Дундын өмчлөлийн орон сууцны тухай", "Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай", "Газрын тухай", Газрын төлбөрийн тухай", "Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай", "Дампуурлын тухай", "Хоршооны тухай", "Нөхөрлөл, компанийн тухай", "Үнэт цаасны тухай", "Төв банкны тухай", "Банкны тухай", "Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр, тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай",

10. Б.Чимид. "Үндсэн хуулийн мэдлэг". УБ., 2008 он, 38 дахь тал.

11. Энэ талаар Б.Чимид. "Үндсэн хуулийн мэдлэг". УБ., 2008 он, 440-441 дэх талаас дэлгэрүүлэн үзнэ үү.

12. Б.Чимид. "Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл" /хоёрдугаар дэвтэр/. УБ, 2004 он., 15 дахь тал.

13. Б.Чимид. "Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал". УБ., 2004 он, 197 дахь тал.

"Валютын зохицуулалтын тухай" "Зохиогчийн эрхийн тухай", "Патентийн тухай", "Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай", "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай", "Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай", "Нотариатын тухай", "Аудитын тухай" зэрэг зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулахад хэрэгцээтэй олон хуулийг боловсруулж, зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан ажээ.

Ийнхүү төрийн байгуулал, батлан хамгаалах, гадаад харилцаа, төсөв, татвар, гааль, эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн хамгаалал, газар, байгаль орчин, аж ахуйн үйл ажиллагаа, дэд бүтэц зэрэг нийгмийн гол чухал харилцааг зохицуулсан 180 гаруй хуулийг 1998 он хүртэлх хугацаанд батлан гаргаж[14], тэдгээрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авчээ. Эдгээр арга хэмжээний үр дүнд Үндсэн хуульд нэр заагдсан хуулиуд батлагдан гарч, өмнө гарсан хууль, байгуулагдсан олон улсын гэрээг Үндсэн хуульд нийцүүлэн өөрчлөх ажил үндсэндээ хийгдсэн байна.

Улсын Их Хурал 1992-1996 оны хооронд 10 удаагийн чуулганаар 369 хууль, 374 тогтоолыг баталжээ[15]. Харин 1996 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс 1998 оны 1 сар 16-ны өдөр хүртэл хугацаанд 66 хууль шинээр баталж, 111 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 11 хуулийг хүчингүй болгож, 38 олон улын гэрээг соёрхон баталсан байна.

1997 оны эцсийн байдлаар Монгол Улсад 180 хууль шинээр батлагдан гарч, олон талт 126 олон улсын гэрээ, хоёр талт 758[16] олон улсын гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байв. Хэдийгээр шинэ Үндсэн хууль, түүний үзэл баримтлалд нийцсэн ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийн эрх зүйн үндэс бүрэлдэж эхэлсэн боловч эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нийгэмд шинээр үүсч буй харилцааг хуульчлан зохицуулах, тэдгээрийг олон улсын жишиг, загварт нийцүүлэх, хуулийг дээдлэх, хүндэтгэн хэрэгжүүлэх нийгмийн ухамсрыг төлөвшүүлэх шаардлага хэвээр байв. Иймээс эрх зүйн шинэтгэлийн зорилго, зарчим, арга зүйн үндсийг нарийвчлан тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, төлөвлөгөөг тогтоон батлах зорилгоор Эрх зүйн шинэтгэлийн Хөтөлбөрийг 1998 онд боловсруулсан байна. Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор Хөтөлбөрийг батлаж, уг Хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөөний биелэлтэд байнга хяналт тавьж, биелэлтийн явцыг жил бүр гарган Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулж байхыг Хууль зүйн байнгын хороонд даалгасан байна. Үүний дагуу Улсын Их Хурлын 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 18 дугаар тогтоолоор "Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр", "Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл", "Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г тус тус баталжээ.

Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх) нь эрх зүйн шинэтгэлийн зорилго, зарчим, арга зүйн үндсийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх 7 үндсэн чиглэлийн[17] нийт 56 зорилтот арга хэмжээг төлөвлөсөн байна. "Эрх зүйн шинэтгэлийн зорилго нь тус улсад хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилгыг биелүүлэх үүднээс Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санааны дагуу төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчин бүрдүүлэхэд оршино" гэжээ. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох Үндсэн чиглэлд 2000 он хүртэл буюу 2

14. "Монголын эрх зүйн шинэтгэл-8 жил" илтгэл болон зөвлөмжүүдийн эмхтгэл. УБ., 2003 он, 86 дахь тал

15. Ж.Төгсжаргал, "Монгол Улсын Их Хурлын архивын хөмрөг үүсгэгчийн түүх", УБ., 2002 он, 67, 82 дахь тал.

16. Гадаад хэргийн яамнаас авсан нийт 1044 хоёр талт гэрээний жагсаалтаас гаргав.

17. Энэхүү 7 үндсэн чиглэлд:

- "Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хангах эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх";
- "Эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох";
- "Хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах";
- "Төрийн байгууллын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох";
- "Эрх зүйн шинэтгэлийн орчин бүрдүүлэх";
- "Хууль зүйн мэргэжлийн боловсон хүчний сургалтын тогтолцоог боловсронгуй болгох";
- "Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх" гэсэн үндсэн чиглэл хамаарна.

Гэхдээ Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид эрх зүйн шинэтгэлийн таван үндсэн чиглэл баримтлах талаар өгүүлсэн байдаг. Үүнд : хууль тогтоомжийг шинэтгэх; хууль тогтоох, хуулийн гүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагааг шинэтгэх; хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх; хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх; нийгэмд эрх зүйн шинэ ухамсар төлөвшүүлэх зэрэг нь хамаарна. //Б.Чимид. Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эргэгтэй асуудал. Хоёрдугаар дэвтэр. УБ., 2008 он, 14-16 дахь тал.

жилийн дотор 1)хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах, 2)элийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, 3)төрийн байгуулалтын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, 4)нийгмийн салбарын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох талаар 69 хуулийг шинээр буюу шинэчлэн боловсруулах, 49 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар зорилт тавьсан ба Улсын Их Хурлаас уг үндсэн чиглэлийг 2001, 2005 онд тус тус дөрвөн жилээр бодож шинэчлэн баталжээ.

Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 16 төрлийн арга хэмжээ тусгажээ.[18]

Улсын Их Хурлын 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 33 дугаар тогтоолоор "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг баталсан ба уг хөтөлбөрийн 6 дугаар хэсгийн 3-т "эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл шинэчлэх Үндсэн чиглэлийг боловсруулан Улсын Их Хуралд оруулж батлуулах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах"-ыг заасан. Улсын Их Хурлын 2001 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн "Үндсэн чиглэл батлах тухай" 44 дүгээр тогтоолоор "Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл"-ийг баталсан бөгөөд үүгээр нийгмийн бодлого, эдийн засгийн бодлого, бүс нутаг, хөдөөгийн бодлого, байгаль орчны бодлого, батлан хамгаалах, гадаад бодлого, засаглалын хямралыг арилгах, дэг журмыг бэхжүүлэх бодлого[19] гэсэн 6 үндсэн чиглэлд 150 гаруй хуулийн төсөл, 7 тогтоолын төслийг боловсруулж батлан гаргахаар төлөвлөсөн юм.

Улсын Их Хурлаас 2005 онд "Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл"-ийг баталсан ба энэ Үндсэн чиглэлд төрийн байгуулалтын, нийгмийн бодлогын, эдийн засаг-санхүүгийн бодлогын, хот байгуулалт, бүс нутаг, хөдөөгийн бодлогын, байгаль орчны бодлогын, аюулгүй байдал, гадаад бодлогын, хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах гэсэн нийт 7 чиглэлээр 134 хуулийн төсөл, мөн 20 тогтоолын төсөл боловсруулахаар тусгагдсан байна.

Үүнээс төрийн байгууллагуудын шинэтгэлийн хүрээнд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чирэгдэл дамжлага багатай бүтэц бий болгох, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдуулан эдгээр байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиудыг бүхэлд нь 2002 онд өөрчиллөө. Энэ хүрээнд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Прокурорын байгууллагын тухай, Өмгөөллийн тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай зэрэг хуулийг дурдсан онд баталсан юм.

Газрын шинэтгэлийг эрчимжүүлэх, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, газар өмчлөх, эзэмших, ашиглах явдлыг шинэ түвшинд гаргах зорилгоор Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудыг 2002 онд батлан гаргасан байна.

Санхүү, төсөв, удирдлагын иж бүрэн тогтолцоог бий болгож байгаа Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг 2003 оноос мөрдөж эхлээд байна.

Захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, иргэний гаргасан гомдлын дагуу иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг арилгуулах, тэдний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх зорилго, эрх бүхий шүүх байгуулах, түүний үйл ажиллагааг зохицуулсан хууль гаргах шаардлагын үүднээс Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулийг 2002 онд Улсын Их Хурлаас баталж, захиргааны шүүн таслах ажлаар төрөлжсөн шүүх нь 2004 оны 6 дугаар сараас ажиллаж эхэлсэн юм.

Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан судалгааны дүнгээс үзэхэд 2000-2004 онд Засгийн газраас хууль санаачлах бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, шинэчилсэн найруулгыг батлуулах, гэрээ соёрхон батлуулах, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, эрх олгох тухай зэрэг нийт 556 хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьснаас 539-ийг нь баталсан байна[20].

2004-2007 онд татварын багц хууль, ашигт малтмалын хууль, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай зэрэг хууль батлагдан гарчээ.

Эрх зүйн шинэтгэлийн ололтыг гоогоор илэрхийлбэл, 1990 оноос өмнө нийгмийн зарим харилцааг 50-иад хуулиар зохицуулж байсан бол өнөөдөр (2007 оны 10 дугаар 01-ний байдлаар) нийгмийн олон талт харилцааг 360 гаруй бие даасан салбар хуулиар зохицуулж байна.

Монгол Улс 14 олон улсын байгууллагын гишүүн бөгөөд бүс нутгийн түвшинд 2 олон улсын байгууллагын үйл ажиллагаанд ажиглагч орноор оролцож байна. Манай улсын хувьд өнөөдөр хоёр

18. Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан. УБ., 2008 он, 5 дахь тал.
19. Улсын Их Хурлын 2001 оны 44 дугаар тогтоолын хавсралт.
20. Д.Баянбилэг. "Эрх зүйн шинэтгэлийн үйл явц ба хүний эрх". //"Хууль дээдлэх ёс". 2006 он., №2. 17-19 дэх тал.

талт 208 олон улсын гэрээ, олон талт 1044 олон улсын гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна.

Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэд 2007 онд ХЗДХЯ-наас санаачлан хийсэн мониторингийн дүнгээр Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийн ихэнхихэсэг биелэсэн байна.

Улсын Их Хурлын 2001 оны 44 дүгээр тогтоолоор баталсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийн ихэнхи хэсэг биелэсэн байна.

Улсын Их Хурлын 2005 оны 26 тогтоолоор баталсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийн зарим хэсэг биелэсэн байна гэвч ер нь Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр нь ихэнхи зорилтот арга хэмжээний хувьд үндсэндээ хэрэгжсэн гэсэн үнэлгээ өгсөн ба зөвхөн "Эрх зүйн шинэтгэлийн орчинг бүрдүүлэх" үндсэн чиглэлд тусгагдсан зарим арга хэмжээ хангалттай хэрэгжээгүй байна гэж үзсэн.

Гэхдээ энэ мониторингийн дүнгээс Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр үндсэндээ хэрэгжиж, эрх зүйн шинэтгэлийн зорилт хууль тогтоомжийн түвшинд биелэгдсэн. Үүний үр дүнд өнөөдрийн байдлаар Үндсэн хууль, түүний үзэл баримтлалд нийцсэн ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийн эрх зүйн үндэс бүрэлдсэн. Харин хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх талаархи нийгмийн эрх зүйн ухамсарыг бүрдүүлэх зорилт зохих хэмжээнд хангагдсангүй гэж үзэж болно.

Харин манай улсын эрдэмтэн судлаачид энэ талаар "сүүлийн жилүүдийн үр дүнгээс үзвэл хууль тогтоомж боловсронгуй болгох ажил их төлөв нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах хэвшмэл байдалд орсон байна"[21] гэж үзэх болжээ. Учир нь эрх зүйн шинэтгэлийг зөвхөн хууль тогтоомжийг шинэчлэх хүрээнд хэт явцууруулж үзэх нь буруу юм. Ингэснээр эрх зүйт ёсыг жинхэнэ утгаар нь амьдралд нэвтрүүлж, улмаар төгөлдөржүүлэх үйл явцад ахиц гарахгүй.

Угтаа бол Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг Монгол Улсын Хөгжлийн болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг иш үндэс болгон жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн Үндэсн чиглэлд тусгах замаар тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэх ёстой. Гэвч Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор тодорхой арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн Үндсэн чиглэлд тусгаж байсан тохиолдол байхгүй байна. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос Хөтөлбөр батлагдсанаас хойш уг Хөтөлбөрийн биелэлтийг үнэлж дүгнэх, биелэлтийн явцыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулах тулгайлсан арга хэмжээ авч байгаагүй бөгөөд Үндсэн чиглэлийн биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Байнгын хороодын дарга нар, Тамгын газарт даалган үүрэг болгосон байна. Харин Улсын Их Хурал, Байнгын хорооны мэдээллийн санд холбогдох арга хэмжээний талаар мэдээлэл алга байна.

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого гэсэн баримт бичиг батлан гаргасан. Үүнд Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүнг 2007-2015 онд Мянганы хөгжлийн зорилтыг хангах, эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх, 2016-2021 онд мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих хоёр үе шаттай хамтатган авч үзсэн байдаг. Энэ "Цогц бодлого"-ын 3.2-т Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод **Монгол Улсын Үндсэн хуулийг баримтлах** гэсэн үнэт зүйлийг эрхэмлэн дээдлэхээр тусгасан. Улмаар Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг дор дурдсан зургаан тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ гэсний дотор улс төрийн ардчилсан тогтолцоог боловсронгуй болгож, авлига, хүнд суртлаас ангид, ил тод, хариуцлагатай, шударга тогтолцоог бүрдүүлэх асуудал багтсан байна.

Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэд 2007 онд ХЗДХЯ-наас санаачлан мониторинг хийсэн. Эндээс дараах дүгнэлтийг хийсэн:

1. 1998 оны Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр хууль тогтоомжийн түвшинд үндсэндээ хэрэгжсэн учраас тус хөтөлбөрийг хааж, дараагийн үе шатны хууль зүйн бодлогын талаархи шинэ хөтөлбөрийг боловсруулан УИХ-ын тогтоолоор батлуулах. Ингэхдээ "Мянганы хөгжлийн зорилтуудад тулгуурласан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-той уялдуулах;

2. Хууль зүйн бодлогын шинэ хөтөлбөр (баримт бичиг)-т дараах зорилтыг тусгайлан тусгавал зохимжтой байна:

• Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй бүх хуулийн агуулга, эх бичвэр, хууль зүйн нэр томьёог дахин хянан нягталж, сайжруулах арга хэмжээг тодорхой үе шат төлөвлөгөөтэйгээр ойрын 4 жилд авч хэрэгжүүлэх;

• Хууль, нийтээр дагаж мөрдөх журам агуулсан эрх зүйн хэмжээний актын төслийг

21. Б.Чимид. "Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал". Хоёрдугаар дэвтэр. УБ., 2008 он, 26-29 дэх тал.

боловсруулах, хянах, батлах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, хуулийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага, төсөл боловсруулах арга ажиллагааг шинэчлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгадаг болох;

• Хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах Засгийн газрын (Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь заалтын 1), төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах Ерөнхий сайдын (Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх заалт) үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих болон хууль сахиулах байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог дахин хянаж өөрчлөх;

• Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагын чадавхи, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн мэргэжил, сахилга, ёс зүйн шалгуур болон ажлын байр, хангамжийн стандартыг шинэчлэн тогтоож мөрдүүлэх;

• Хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх нийгмийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

• Хууль болон хуулийн хэрэгжилт, хууль хэрэгжүүлэх байгуулагын үйл ажиллагаанд урьдчилан болон явцад нь хяналт шинжилгээ (мониторинг), үнэлгээ тасралтгүй хийж байх, ийм чиг үүрэг бүхий бүтцийг (мониторингийн институт) бий болгож бэхжүүлэх[22].

Дүгнэлт

Дээр дурдсан мониторингийн дүгнэлтээс гарсан саналыг хэрэгжүүлэхдээ агуулгын болон хэлбэрийн талыг нь харгалзан үзэх нь зүйтэй. Учир нь, зөвхөн хэлбэрийн хувьд хэрэгжүүлбэл энэ нь эрх зүйт ёсны агуулгыг бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй бөгөөд ингэснээр агуулгагүй хоосон хэлбэрдэлт болно. Харин хуулийн төслийг боловсруулж батлахдаа байх ёстой зүйл буюу зүй ёсонд нийцүүлэх, ухаалаг зарчмыг баримтлах, түүнийг эрх бүхий албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд хэн боловч ягштал дагаж мөрдөх нь агуулгын хувьд амилуулж буй явдал мөн. Эрх зүйн шинэтгэлийг ингэж байх ёстой зүйл буюу зүй ёсонд агуулгын болон хэлбэрийн хувьд нийцүүлэх алхам бүр эрх зүйт ёсыг төгөлдөржүүлэх алхам болох бөгөөд эрх зүйт ёсыг төгөлдөржүүлэх нь хөгжлийн тулгуур багана болох юм.

Түүнчлэн эрх зүйт ёсыг төгөлдөржүүлэх явдал бол Үндсэн хуулийг ягштал баримтлахаас эхлэх ёстой. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийг 2000 онд өөрчилсөн явдлыг Үндсэн хууль судлаачид өнөөдөр ч хууль бус бөгөөд эрх мэдлийн хуваарилалтын зарчмыг алдагдуулсан гэж үзсээр байгаа. Мөн Улсын Их Хурлын зарим үйл ажиллагаа Үндсэн хуулийг үгүйсгэх (Улсын Их Хурлын гишүүний гангараг өргөхгүй байх гэх мэтээр) байдлаар явагддаг. Ард иргэдийн дунд хууль тогтоох үйлчилдэггүй гэсэн үзэл бодол давамгайлж эрх зүйг үгүйсгэх үзэл газар авч байгаа зэрэг үзэгдлүүд Монгол Улсад эрх зүйт ёсыг төгөлдөржүүлэх үйл явцад ихээхэн саад тотгор болж байгаа нь гарцаагүй юм. Иймд эдгээр сөрөг хүчин зүйлийг засах талаар иргэний нийгэм болоод засаг төрөөс хамтын хүчин чармайлт гаргах нь зүйтэй байна.

☙ ☙ ☙

"ҮНДСЭН ХУУЛЬТ ЁС БА ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО" СЭДЭВТ ОЛОН УЛСЫН СИМПОЗИУМЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн, Улсын Их Хурлын Тамгын газар, Ханнс-Зайделийн сан, Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургууль хамтран **"Үндсэн хуульт ёс ба үндэсний эрх зүйн тогтолцоо"** сэдэвт олон улсын симпозиумыг 2009 оны 6 дугаар сарын 19-нд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 304 тоот хурлын танхимд зохион байгуулаа.

Хурлыг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, Монгол Улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, академич С.Нарангэрэл нээснээр эхэлсэн ба Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Ханнс-Зайделийн сангийн Тэргүүн захирал, доктор П. Виттерауф, ХБНГУ-ын Элчин сайдын яамны зөвлөх, доктор М. Фройденберг нар мэндчилгээ дэвшүүлсэн юм.

Уг симпозиумд "Хууль дээдлэх ёсыг хангахад шударга шүүхийн шийдвэрлэгч үүрэг" сэдвээр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ардын багш, гавъяат хуульч, доктор, профессор Б.Чимид, "Эрүүгийн эрх зүйн тогтолцоонд тавигдах Үндсэн хуулийн шаардлага" сэдвээр ХБНГУ-ын Людвиг Максимилианы нэрэмжит Мюнхений их сургуулийн Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Эрх зүйн философи, Эрх зүйн мэдээлэл зүйн хүрээлэнгийн доктор, профессор Б.Шюнеманн, "Хууль зүйн боловсролын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал" сэдвээр МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, УИХ-ын даргын зөвлөх, Монгол Улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, академич С.Нарангэрэл нар илтгэл тавиж хэлэлцүүлсэн бол үдээс хойших хуралдаанд "Үндсэн хуульт ёс ба Оросын Холбооны Улсын эрх зүйн тогтолцоо" сэдвээр ОХУ-ын Буриадын их сургуулийн Үндсэн хуулийн ба олон улсын эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор Юлий Григорьевич Хамнуев, "Японы эрх зүйн соёл" сэдвээр Япон Улсын Нагояагийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Уэчи Ичиро, "Хууль бүтээх урлаг орчин цагийн чухаг асуудал" сэдвээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн захирал, гавъяат хуульч, академич Ж. Амарсанаа илтгэл тавиж хэлэлцүүлээ.

www.legalinfo.mn сайтаас

22. Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан. УБ., 2008 он. 451-452 дахь тал.

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ТОГТОЛЦОО, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

1. Хөрөнгө орлогын мэдүүлгийн ойлголт, төрөл

Дэлхийн бусад оронд Хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХОМ)-ийг авлига, хууль бусаар баяжих явдлаас сэргийлэх, ашиг сонирхлын зөрчил (АСЗ)-ийг шийдвэрлэх зорилгоор албан хаагчаас санхүүгийн байдлаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдүүлэх, түүнд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд зөвлөгөө өгөх\авах, гарч болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, урт хугацааны хэрэгсэл гэж үздэг. Нөгөө талаар төрийн албан хаагчийн ХОМ-ийг гаргуулан авч бүртгэх, хянах, шалгах, мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажилд дүн шинжилгээ хийх, ХОМ-ийн талаар (хууль тогтоомж болон хэрэгжилт) нийтэд мэдээлэх үйл ажиллагаануудын нийлбэр цогц юм.

Мэдүүлгийг улс бүрт харилцан адилгүй өөрөөр нэрлэдэг. Жишээлбэл "Санхүүгийн байдлын мэдүүлэг"[1], "Орлого, хөрөнгийн мэдүүлэг"[2], "Эдийн засгийн ашиг сонирхлын мэдүүлэг"[3], "Ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг"[4] Канадад "Хөрөнгө, өр авлага болон давхар ажил

Голомт банкны хууль зүйн зөвлөх П.Өнөрмаа

эрхлэлтийн мэдээлэл" гэж тус тус нэрлэдэг.

Манай улсын хувьд мэдүүлэг дор дурьдсан төрөлтэй. Үүнд:

1. Ажилд орсон даруй гаргах мэдүүлэг;
2. Сонгуульд нэр дэвшигчийн мэдүүлэг;
3. Жил бүрийн мэдүүлэг.

Польш, Перу улсад:[5]

1. Ажилд орохын өмнө гаргах мэдүүлэг;
2. Ажиллаж байх хугацаандаа гаргах буюу жил бүрийн мэдүүлэг;
3. Төрийн албанаас гарсны дараах мэдүүлэг.

АНУ-д:

1. Ажилд орсон даруй гаргах мэдүүлэг;
2. Сонгуульд нэр дэвшигчийн мэдүүлэг;
3. Жил бүрийн мэдүүлэг;

Ажлаас гарсны дараах мэдүүлэг гэсэн төрлүүд байдаг.

Мөн мэдүүлгийг нийтэд нээлттэй, хаалттай гэж хуваж болно. Ихэнх улс оронд албан хаагч ажилд орохдоо болон жил бүр мэдүүлэг гаргадаг. Харин хяналт тавих тогтолцоо, механизм бүрдсэн үед ажлаас гарсны дараах мэдүүлгийг авч хяналт тавьдаг. Манай улсад энэ механизм хараахан бүрдээгүй байна.

2. Эрх зүйн зохицуулалт

ХОМ-ийн асуудлыг тусгайлан авч үзсэн олон улсын хэм хэмжээнүүд бол НҮБ-ын Авлигын Эсрэг Конвенц, Америкийн холбооны Авлигын эсрэг конвенц[6]-ууд юм. 2005 онд Монгол Улс НҮБ-ын Авлигын Эсрэг Конвенцид нэгдэн орсноор уг баримт бичгийг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх үүрэг хүлээсэн. Конвенцийн 8 дугаар зүйлийн 2-т зааснаар "Оролцогч Улс бүр төрийн үүргийг зөв, эрхэм бөгөөд зохистой байдлаар биелүүлэх ёс зүйн хэм хэмжээ буюу стандартыг өөрийн байгууллагын болон эрх зүйн тогтолцооны хүрээнд хэрэглэхийг эрмэлзэнэ" гэж заасан. Мөн зүйлийн 5-д зааснаар "Оролцогч Улс бүр өөрийн дотоодын хууль тогтоомжийн тулгуур зарчимд нийцүүлэн шаардлагатай

1. Financial disclosure form
2. Income, asset disclosure
3. Statement of economic interest
4. Conflict of Interest disclosure
5. Declarations of Income and Assets; Polish instruments assessment, www.wap.edu.pl
6. Keith E. Henderson, Asset, Income Disclosure for Judges: A Summary Overview and Checklist, Washington College of Law

тохиолдолд төрийн албан тушаалтан өөрийнх нь чиг үүргийн хувьд ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурхи үйл ажиллагаа, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалт, эд хөрөнгө, чинээлэг бэлэг буюу давуу талыг холбогдох байгууллагад тайлагнаж байх систем болон арга хэмжээг тогтоохыг эрмэлзэнэ" гэж заасан. Энэ заалтыг (олон улсын өмнө хүлээсэн үүргийг) хэрэгжүүлэх үүднээс ХОМ-ийн тогтолцоог бүрдүүлж эхэлсэн билээ.

2006 онд Авлигын эсрэг хууль (АЭХ) батлагдан гарч, АТГ байгуулагдаж, АЭХ-ийн 3 дугаар бүлэгт "Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах" заалтыг хэрэгжүүлэх болсноор ХОМ-ийн тогтолцооны эрх зүй, менежментийн үндсийг бүрдүүлжээ. Түүнчлэн Монгол Улсын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрт[7]:

- Авлига үүсэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцлийг тусгайлан судалж[8], санал дүгнэлт гаргах;
- Төрийн өндөр албан тушаалтны болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинээр буюу шинэчлэн баталж, тэдгээрийн хэрэгжилтэнд хяналт тавих иж бүрэн тогтолцоог бий болгох;
- Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, түүнд хяналт тавих механизмыг улам боловсронгуй болгох шаардлагатай гэжээ.

"Авлигагүй нийгэм-тогтвортой хөгжлийн гарц" Үндэсний бага хурлын урианлгад: "Төрийн албан тушаалтны ил тод, шударга байдлын нотолгоо болох хөрөнгө, орлогын мэдүүлгээ хуульд заасан цаг тухайд нь үнэн зөвөөр гаргаж хэвших"-ийг төрийн албан хаагчдад урианлсан байдаг.[9]

3. Тулгамдсан асуудал

2006 оны 3 дугаар сард авсан судалгаагаар иргэдийн 75 хувь нь "Авлига ихэссэн" гэж хариулж байсан бол өдгөө ийнхүү үзэх хүний тоо 62 хувь болж буурчээ.[10] Авлига буурч байгаад олон нийт итгэх болсон нь сайшаалтай хэрэг бөгөөд үүнд ХОМ-ийн тогтолцооны гүйцэтгэх үүрэг нөлөөлсөн гэж үзэх үндэслэлтэй. Улсын хэмжээнд 2007 оны байдлаар нийт 47285 мэдүүлэг гаргагдаас 46768 буюу 98,9 хувь нь хуулийн хугацаандаа ХОМ-ээ мэдүүлж, 184 буюу 0.39 хувь нь хугацаа хожимдуулж мэдүүлж, 333 буюу 0.7 хувь нь ХОМ-ээ мэдүүлээгүй байна.[11] Хэдийгээр ХОМ-ийн бүрдүүлэлтийн байдал сайн байгаа ч ХОМ-ийн талаарх хууль тогтоомжид сайжруулах шаардлагатай зүйл олон байна. Үүнд:

Бусад оронд Эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-ууд ХОМ-ийг шалгасны дараа АСЗ-өөс сэргийлэх, зохицуулах[12] талаар зөвлөгөө, заавар, анхааруулга өгдөг байна. Ингэхгүйгээс ХОМ-ийн ач холбогдол буурч, архивт хадгалагдах цаас болж хувирах эрсдэлтэй байна. Улсын Их Хурлыаас баталсан "Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх хадгалах журам"[13]-д мэдүүлгийн агуулгыг годорхойлсон байдлаас харахад "Хууль бусаар баяжих" явдлыг илрүүлэхэд голлон анхаарсан мэт санагдаж байна;

Одоогийн ХОМ-ийн маягт агуулгын хувьд хэт ерөнхий бөгөөд АСЗ-ийг илрүүлэхэд ашиглах мэдээллийг өгч чадахгүй байна. Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчид хориглох үйл ажиллагааны тухай заалтыг[14] хэрхэн биелүүлж байгааг шалгах боломжтой дутмаг юм;

Мэдүүлгээс тухайн жилд болж өнгөрсөн зарим нэг ач холбогдол бүхий үйл явдлыг мэдэх боломжгүй байна. Уг нь мэдүүлэг тухайн жилд болсон ач холбогдол бүхий бүх үйл явдал, өөрчлөлтийг хамрах хэрэгтэй байна. Жишээлбэл: Төрийн байгууллагад бараа нийлүүлж, үйлчилгээ үзүүлэх гэрээ хэлцэлд оролцсон эсэх- Одоогийн мэдүүлгээс гагцхүү үйл ажиллагааны орлого хэсгээс мөнгөний дүн л харагддаг. Харин хэнтэй ямар гэрээ байгуулсан нь тэр бүр тодорхой харагдахгүй. Ө.х орлогын дүн бус харин ямар замаар уг орлогыг олсон нь АСЗ-ийг шийдвэрлэхэд илүү чухал мэдээлэл юм;

Гадаад, дотоодод бусдын зардлаар эмчлүүлсэн байдал, хүүхдийн сургалтын төлбөрийг төлсөн зэрэг томоохон

7. Монгол Улсын Их Хурлын 2002 оны 41-р тогтоолоор батлагдсан, www.legalinfo.mn хаягаар үзнэ үү.
8. Ашиг сонирхлын зөрчил нь авлига төдийгүй бусад олон гэмт хэрэгтэй нягт холбоотой.
9. Үндэсний бага хурлын илтгэлийн хураангуй, 2007 он, 70 дахь тал.
10. "Хахууль өгөхгүй гэж хэлэх иргэд олширчээ", АНУ-ын Азийн сангаас үндэсний хэмжээнд явуулж буй авлигын түвшин тогтоох зургаа дахь удаагийн судалгаа, 2008 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр.
11. АТГ-ХШДШХ, "Төрийн албан хаагчдын 2007 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, яиц байдлын талаарх мэдээ", 2008 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр.
12. АСЗ-өөс урьдчилан сэргийлэх, түүнийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт манайд үгүйлэгдэж байна.
13. Улсын Их Хурлын тогтоол, 9 дүгээр тогтоолын хавсралт, 2007 он.
14. Төрийн албаны тухай хууль 15.1 дүгээр зүйл Гэхдээ энэ заалт гагцхүү төрийн захиргааны болон тусгай албан тушаалтанд хамаардаг.

хэмжээний зардлын тухай мэдээлэл[15], эх сурвалжийг илрүүлэх бололцоог одоогийн маягт олгохгүй байна;

"Nepotism" – хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан тушаалтантай гэр бүл, төрөл, садангийн хүн нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахыг хориглоно.[16] Энэ хязгаарлалтын хэрэгжилтийг ХОМ-ээс мэдэх боломжгүй юм. Филипинн улсад төрийн албанд ажилладаг төрөл, садны тухай мэдүүлэгт бичих ёстой байдаг;[17]

Хуульд ХОМ-ийг албан хаагч өөрөө гаргана гэж заасан байтал түүнийг нотлох хамгийн гол зүйл буюу гарын үсэг зурах хэсгийг маягтад тусгаагүй байна;

Мэдүүлгийг шалгахад гардаг хүндрэл: Мэдүүлэг гаргагчдийн гэр бүлийн гишүүн, харилцагч байгууллага, бусад этгээдээс шаардлагатай мэдээллийг авах хэрэгтэй болдог. Мэдүүлэг гаргагчаас бусад этгээд мэдүүлэг өгөх үүрэггүй байдаг. Мөн мэдүүлгийг шалгах аргыг тодорхойлохдоо эхний ээлжид мэдүүлэг гаргагчийн амьдралын бодит байдлыг зөв тогтооход чиглэх хэрэгтэй.[18] Мэдүүлэг гаргагч нь өөрийнх нь эд хөрөнгийг хариуцаж байгаа банк, санхүүгийн бусад байгуулагаас мэдүүлгийг шалгахтай холбогдуулан мэдээлэл авах эрхийг олгох, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг эдлэхгүй байвал зохино. Түүнчлэн хөрөнгийн болон эрхийн бүртгэлийн байгууллагад тавигдаг шаардлага бол тухайн хөрөнгө, эрхийг гагцхүү түүний үр шимийг (шууд) хүртдэг этгээдийн нэрээр бүртгэх явдал юм.[19] Мэдүүлгийг шалгах боломжгүй тохиолдолд мэдүүлгийн ач холбогдол эрс буурдаг болохыг сайтар анхаарах хэрэгтэй;

Хуульд зааснаар ХОМ-ийг хуульд тусгайлан нэрлэн зааснаас бусад тохиолдолд албан хаагчийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан бүртгэж, хадгалах үүрэгтэй.[20] Харин практикт эдгээр албан тушаалтнууд бус тэдгээрийн удирдлага дор ажилладаг тамгын газрын мэргэжилтэн, хуульч, хүний нөөцийн ажилтан нар[21] мэдүүлгийг бүртгэж, хадгалдаг. Эндээс харахад "Эрх бүхий албан тушаалтан" гэдэг нэр томъёог эргэн харах хэрэгтэй байна. Учир нь ХОМ-ийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох материалыг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй ЭБАТ-ыг 100000-150000 төгрөгөөр торгох эрх зүйн үндэслэл бий[22]. Албан хаагчийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанг торгох уу[23] уг ажлыг гардан хийж байгаа ажилтанг торгох уу? Эсхүл бүр хамтад нь торгох уу?;

АЭХ-д мэдүүлгийг "хянах", "хянан шалгах", "шалгах" гэсэн нэр томъёонуудын зааг ялгааг төдийлөн сайн тусгаагүй байгааг анхаарах хэрэгтэй;

Зарим байгууллагын удирдлагууд ХОМ-ийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажилд бага зэрэг "Хойрго" хандаж, гагцхүү ЭБАТ ба АТГ-ын ажил мэт хандах хандлага ажиглагдаж байна.

4. Санал зөвлөмж "One size fits all remedy – no"

Мэдүүлгийн бүрдүүлэлт, хадгалалтын талаар:

Байгуулллагуудын туслалцаатайгаар судалгаа явуулж мэдүүлэг гаргах шаардлагагүй ямар албан тушаал байгааг тогтоож, үндэслэлийн хамт хууль тогтоогчид өргөн барьж мэдүүлэг гаргах этгээдийн тоо, хүрээг багасгах; (Практикт эсрэгээр, 2008 онд Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор төрийн үйлчилгээний зарим албан тушаалыг төрийн захиргааны болгон тул мэдүүлэг гаргагчдын тоо 5000[24] гаруйгаар нэмэгдсэн байна.);

Одоогийн ХОМ нь бүтэц болон агуулгын хувьд төгс боловсрогдож амжаагүй байгаа тул (түүнчлэн мэдүүлэг бөглөх тухай зөвлөмж) мэдүүлэг бүрийн хамт санал асуулга илгээж, мэдүүлэг гаргагчаас мэдүүлэгтэй холбоотой асуудлаар санал, шүүмжлэл, зөвлөмж авах хэрэгтэй. Магадгүй мэдүүлэг гаргагч бүр энэ асуулгыг бөглөж

15. OECD, Ani-Corruption Toolkit, version 4, November, 2002., P.117.
16. Төрийн албаны тухай хуулийн 16.2.3 дугаар зүйл.
17. Pelagio S. Apostol, The Experience of Asset Declaration in the Philippines, Office of the Ombudsman, 2007 он.
18. Anti-Corruption Tool kit, CICP-15, Volume one, 2002, P.118.
19. Нийтийн эрх зүйд мөрддөг.
20. Авлигын эсрэг хуулийн 11.1.5 дугаар зүйл.
21. ХОМ-ийг бүртгэх, хадгалах, хянах үүргийг үндсэн ажил үүрэгт хавсаргах байдлаар хийж байгаа нь ХОМ-ийн хууль тогтоомжийн бодит хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байгааг анхаарах хэрэгтэй. 22.Авлигийн эсрэг хуулийн 13.7 дугаар зүйл.
23. Судалгааны ажлыг хийх явцад энэ зөрчилтэй байдал Цагдаагийн байгууллагад гарч байгаа нь ажиглагдсан.
24. "Төрийн албан хаагчдын 2007 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, явц байдлын талаарх мэдээ" ХШДШХ, АТГ, 2008 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр.

ирүүлэхгүй байж болно. Гэхдээ тэднээс ирүүлсэн тодорхой хэмжээний мэдээллийг цаашид ХОМ-ийн үйл ажиллагаг сайжруулахад ашиглах, дүн шинжилгээ хийхэд ашиглах боломжтой юм;

Бусад орны жишгийг дагаж, ЭБАТ-ууд ХОМ-ийг шалгасны дараа АСЗ-өөс сэргийлэх, зохицуулах талаар зөвлөгөө, заавар, анхааруулга өгдөг байх хэрэгтэй. Ингэхгүйгээс ХОМ-ийн ач холбогдол буурч байна;

Эх сурвалж бол хамгийн гол аргумент эх үүсвэр, (хэзээ, хэрхэн, хэнээс, ямар томоохон эд хөрөнгө) хөрөнгийг хүлээж аваад бусдад шилжүүлсэн, зарсан тухай мэдээллийг авах боломж бүрдүүлэх;

ХОМ-ийг хянах, шалгах үйл ажиллагаануудын зааг ялгааг тодорхойлж, ЭБАТ-ны эрх хэмжээг тодорхой болгох хэрэгтэй. Terms such as "verify" and "investigate" need to be carefully defined in the law.[25];

АТГ-аас гаргасан "ХОМ гаргагчид өгөх зөвлөмж"-ийг дахин боловсруулах, бусад хууль тогтоомжийн заалттай уялдуулах, энэ зөвлөмжийг жил бүр шинэчилж байх[26];

АСЗ үүсгэж болох албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалт, эд хөрөнгө, чинээлэг бэлэг буюу давуу талыг холбогдох байгууллагад тайлагнаж байх систем болон арга хэмжээг тогтооход АТГ гол үүрэг гүйцэтгэнэ.[27] Гэтэл энэ бүхэл бүтэн системийг гагцхүү ХОМ-ийн системийг байгуулснаар бүрдүүлнэ гэж үзвэл өрөөсгөл ойлголт болно. ХОМ, түүний систем нь албан тушаалтыг АСЗ-өөс сэргийлэх, зохицуулах үйл ажиллагаа-системийн нэг л хэрэгсэл (эсхүл дэд систем) юм. Иймд ХОМ-ийг АСЗ-тэй тэмцэхэд үр дүнтэй хэрэгсэл болгох талаас нь анхаарах хэрэгтэй байна;

Зарим хэсгийг нэмж оруулах нь зүйтэй. Жишээлбэл: бусад байгууллага, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний тухай (АСЗ үүсгэж болохыг тогтооход ашиглах);

Мэдүүлгийн нэг хувийг хадгалах тухай сануулах хэсгийг маягтад оруулах.

Мэдүүлгийг хянах шалгах талаар:

ЭБАТ-уудаас мэдүүлгийг хуульд заасан журмын дагуу бүрэн хянах ажлыг хэвшүүлэх;

Мэдүүлэг бүрийг бус авлигад өртөх магадлал өндөр салбарт ажилладаг, хөрөнгө, орлого нь эрс нэмэгдсэн этгээдийн мэдүүлгийг шалгахад голлон анхаарах.

Мэдүүлгийг нийтэд мэдээлэх талаар:

АТГ-ын веб сайт дээр ХОМ-ийн талаар асуулт, хариулт булан нээх;

Мэдүүлгийн аль хэсгийг нийтэд харуулах, нуущлах талаар ЭБАТ-уудад нэгдмэл ойлголт өгөх-сургалт явуулах, заавар боловсруулах;

Мэдүүлгийн аль хэсгийг нийтэд харуулж болохгүй талаар ЭБАТ-уудад бичгээр нэгдсэн зааварчилгаа өгөх.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн дүн шинжилгээний талаар:

Дүн шинжилгээ хийх ажлыг автоматчлах боломжийг эрэлхийлэх;

Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаар:

Мэдүүлгийг санаатай худал мэдүүлсэн нь авлига, хууль бусаар баяжих үйлдлээ нуух зорилготой байсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэрэгтэй.

25. Richard E. Messick, Regulating COI: International experience with asset declaration and disclosure, http://www.acrc.org.ua/articles_doc/ua/Regulating_Conflict_of_Interest_International_Experience_2007.pdf 2008/11/03.

26. Гэр бүлийн гишүүн гэж хэнийг хэлэх, хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод босго үнэ тогтоох, их хэмжээний өөрчлөлт зэрэг тодруулан тайлбарлах шаардлагатай зүйл олон байна.

27. НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 8.5 дугаар зүйл, 2003 он.

ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБОГДОХ ЗАРИМ АСУУДАЛ

Манай оронд иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг хийх механизмыг сайжруулах, иргэдэд хүндрэл, чирэгдэл учруулахгүйгээр шилжилт, хөдөлгөөн хийх талаархи эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Ялангуяа иргэний бүртгэлийн үйл ажиллагааны зарчмыг Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлтэй уялдуулж хүүхдийн эрхийг эн тэргүүнд хангах, хамгаалах, мөн иргэний бүртгэлийг төрийн үйлчилгээтэй уялдуулах, олон нийтийн оролцоог төгөлдөршүүлэх зэрэг нь зарчмын чухал асуудал болоод байна.

Үүнтэй холбогдуулан Иргэний бүртгэлийн тухай Монгол Улсын 1999 оны хуулийн зорилтыг хэрэгжүүлэх, түүний зүйл, заалтыг илүү боловсронгуй болгох хэрэгтэй төдийгүй зарим эрх зүйн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, шилжилт хөдөлгөөний үед хүүхдийн бүртгэлийн асуудлыг баталгаажуулах, тодорхой үндэслэл, журмын дагуу (хэрэв тухайн иргэн тодорхой орон нутагт шилжин ирсэн буюу оршин сууж байгаа, тодорхой эд хөрөнгөтэй болсон, эсхүл ажил, хөдөлмөр эрхэлж байгаа гэх мэт) эцэг, эх, хүүхдийн бүртгэлтэй холбоотой баримт бичгийг иргэний бүртгэлийн байгууллагууд хоорондоо харилцан шуурхай солилцдог журамд шилжих нь зүйтэй.



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторыш эрдэм шинжилгээний ажилтан, магистр Б.Одонгэрэл

Ийнхүү иргэдийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нөхцөл байдал ямар байгаа талаар нийслэлийн хэмжээнд болон хөдөө орон нутагт судалгаа хийж үзсэн юм. Судалгааны ажлын хүрээнд иргэний шилжилт хөдөлгөөн нийслэлийн хэмжээнд хэрхэн хийгдэж байгаатай танилцаж, Нийслэлийн эмэгтэйчүүдийн холбоо, СХД-ийн 20 дугаар хорооны 9 дүгээр хэсэг (Эмээлт), ЧД-ийн 12 дугаар хорооны 5 дугаар хорооны Булаг, БЗД-ийн 5 дугаар хорооны Монелийн задгай зэрэг газраар явж нийт 80 орчим өрх, айлаас анкетийн болон ярилцлагын аргаар судалгаа авсан. Судалгааны дүнгээс үзэхэд иргэдийн шилжилт хөдөлгөөнөө шинэчлэн бүртгүүлээгүй шалтгаан нь орон нутгаас шилжин ирэхдээ хасалтаа хийлгээгүйгээс болж шилжиж ирсэн нутаг дэвсгэрийн нэгжид бүртгүүлэх боломжгүй болдог, мөн тухайн иргэний бүртгэлийн байгууллагын шилжилт хөдөлгөөн хариуцсан ажилтнуудын хүнд суртал, харилцааны соёлгүй байдал, ямар нэгэн шалтаг, шалтгаанаар торгох буюу олон удаа нааш цааш явуулж чирэгдүүлэх явдал маш их тохиолддог хэмээн хариулж байв.

Шилжилт хөдөлгөөн хийлгээгүй шалтгааныг зургаар харуулбал, *(Зураг 1-ээс үзнэ үү).*

Үүнээс гадна мөнгө, санхүүгийн асуудлаас болж тухайн орон нутагтаа буцаж очиж шилжүүлэг хийлгэх замын зардал байхгүй зэрэг бэрхшээл тулгардаг байна. Түүнчлэн зарим нэг иргэдийн хариулснаар хөдөө, орон нутгаас төлбөртэйгээр хасалт хийлгэсэн байтал шинээр бүртгэл хийж байгаа байгууллага нь мөн л төлбөртэйгээр бүртгэж байна гэжээ. Мөн иргэний бүртгэлийн байгууллагын шилжилт хөдөлгөөн хариуцсан ажилтны харилцааны соёл, үйл ажиллагаа нь олон шат дамжлагатай, өндөр төлбөртэй үйлчилдэг зэрэг нь тэдний иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ нь хангалтгүй гэсэн үнэлгээг хийхэд хүргэж байна.

Шилжилт хөдөлгөөн хийлгэх явцад орон нутгаас нийслэл хот руу хасалт хийлгэх болон Улаанбаатар хотод ирээд бүртгүүлэх шатанд аль алинд нь чирэгдэл учирдаг гэж судалгаанд оролцогчдын 59 хувь нь үзжээ. Мөн судалгаанд оролцогчдын 38 хувь нь шилжилт хөдөлгөөнийг заавал өөрийн биеэр явалгүйгээр орчин үеийн мэдээллийн хэрэгслийг ашиглан интернэт, онлайнаар хийвэл илүү чирэгдэлгүй, шуурхай байж чадна

Зураг 1



гэж хариулсан байна.

Мөн насанд хүрээгүй хүүхдийг бүртгэлгүй гэдэг үндэслэлээр төрөл бүрийн нийгмийн үйлчилгээнд хамруулахгүй байгаа нь Хүүхдийн эрхийн НҮБ-ын конвенци болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн заалтыг ноцтой зөрчиж байгаа явдал юм. Тухайлбал Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны "Эмээлт" хэмээх газар нийт 215 өрх айл, 1100 гаруй хүн оршин сууж байна. Гэтэл Эмээлтийн задгайд байх айлууд ямар нэг бүртгэл, шилжилт хөдөлгөөн хийлгээгүй төдийгүй шилжилт үүний улмаас хүүхдийн мөнгөө орон нутаг руугаа захиж авах, хүүхдүүд сургуульд сурах болон бусад нийгмийн халамжийн үйлчилгээг авах боломжгүй байсан нь бидний судалгаагаар харагдаж байв.

Хөдөө орон нутагт шилжилт хөдөлгөөн хийгдэж буй байдлыг тодорхойлох хүрээнд Хэнтий аймаг, Орхон, Дархан-Уул аймаг болон Нийслэлийн Багануур дүүрэгт иргэний шилжилт хөдөлгөөнийг хэрхэн хийж байгаа үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийв.

Хэнтий аймгийн хэмжээнд 2007 онд өөр аймаг, хотод бүрмөсөн шилжиж явсан (ХААТР 24) 372 иргэн, өөр аймаг, хотоос бүрмөсөн шилжиж ирсэн (ХААТР 23) 179, аймаг, хот дотор бүрмөсөн шилжсэн (ХААТР 22) 98 иргэн, хаягийн хөдөлгөөн хийлгэсэн 437 иргэн байв. *(Зураг 2-оос үзнэ үү)*

Хэнтий аймгийн Засаг даргын 2003 оны 180 дугаар захирамжийн дагуу шилжин явахад ХААТР 24 маягтыг 5000 төгрөг, ХААТР 23 маягтыг бүртгэл, үйлчилгээний хамт 3000 төгрөг, ХААТР 22 маягтыг 300 төгрөг гэж тус тус үнэлэн тогтоосон журмын дагуу иргэдээс уг мөнгийг авдаг юм байна.

Хэнтий аймгаас Улаанбаатар болон бусад аймаг руу шилжилт хөдөлгөөн хийхдээ дараахь дараалал бүхий ажиллагаа хийдэг байна.

• Багийн Засаг даргаас тойрох хуудас авч зуруулаад түүнийгээ багийн Засаг даргын тодорхойлолттой хамт Хэрлэн сумын иргэний бүртгэлийн

Зураг 2



ажилтан дээр очиж хасалт хийлгүүлнэ;

• Тэндээсээ аймгийн иргэний бүртгэлийн албанд очиж "ХААТР 24" маягт бөглүүлж уг албанаас хасалтаа хийлгүүлнэ.(ХААТР маягтны үнэ 5000);

• Харин Улаанбаатар хот болон бусад аймгаас Хэнтий аймагт шилжин ирсэн иргэн нь;

• Тухайн оршин байсан газраас хасалт хийлгэж, "В" хуудсаа үзүүлээд 23 маягтыг 3000 төгрөгөөр авч тэр 23 дугаар маягтныхаа "В" талыг багийнхаа Засаг даргад аваачиж үзүүлээд бүртгүүлнэ;

• Маягтны "А" талыг ИБМУТ-д хүргүүлж, "Б" талыг нь Хэнтий аймгийн иргэний бүртгэлийн албаны архивт хадгалдаг байна.

Хөдөө орон нутагт судалгаа хийх явцад бид шилжүүлэгчгүй иргэдийн талаар мөн тусгайлан судалсан. Тухайлбал, Багануур дүүрэгт оршин сууж байгаа шилжүүлэгчгүй иргэдийн байдлыг судалж авч үзэхэд дараахь байдалтай тоон мэдээ гарсан. Хэнтий аймгаас 24, Баян-Өлгий аймгаас 2, Говь-Алтай аймгаас 1, Дорнод аймгаас 2, Дорноговь аймгаас 6, Дундговь аймгаас 2, Орхоноос 1, Сүхбаатараас 1, Сэлэнгээс 1, Ховд аймгаас 2, Төв аймгаас 18 иргэн шилжилт хөдөлгөөнөө хийлгэсэгүй хаягийн дагуу бус оршин сууж байсан байна. Мөн доорх 62 иргэнээс насанд хүрээгүй хүүхэд 4 байв.

Хөдөө, орон нутгийн иргэний бүртгэл, мэдээллийн албаны ажилтнуудаас иргэдийн шилжилт хөдөлгөөнийг хийх явцад үүсч байгаа хүндрэл бэрхшээлийн талаар ярилцлагын аргаар судалгаа авсан бөгөөд тэд иргэдийн иргэний бүртгэлийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх явцад дараахь хүндрэл, бэрхшээл учирдаг гэж ярьсан болно:

• Тойрох хуудас зуруулдаг явдал байсаар байна. Зарим аймгуудын хувьд тойрох хуудас зуруулах ажиллагаа байсаар байгаа нь иргэдэд ихээхэн чирэгдлийг учруулдаг. Тухайлбал, Дархан-Уул аймагт тойрох хуудас зуруулахгүйгээр банкнаас годорхойлолт авдаг байсан ба иргэдийг чирэгдүүлэхгүй гэсэн үүднээс больсон байна. Ер нь Иргэний бүртгэлийн тухай хууль, болон шилжилт хөдөлгөөнийг хийх журамд тойрох хуудас зуруулна гэсэн заалт байдаггүй. Гэтэл зарим аймагт тойрох хуудас зуруулдаг практик байгааг зогсоох нь зүйтэй гэж шүүмжилж байв;

• Гадаадад гарсан иргэдийн хувьд бүртгэл байдаггүй гэсэн нэг асуудал байна. Ялангуяа гадаадад гарч буй насанд хүрээгүй хүүхдүүдийн асуудлыг анхаарах;

• Насанд хүрээгүй хүүхдүүдийн хувьд эцэг, эхээ дагаж их шилждэг. Дангаар нь 16 нас хүрээд шилжүүлдэг. Заримдаа иргэний бүртгэлийн ажилтнуудын болон эцэг, эхийн хариуцлагагүй байдлаас болж хүүхэд дангаараа үлдсэн байдаг. Энэ тохиолдолд хуулийн дагуу дангаар нь шилжүүлж болохгүй насанд хүрээгүй хүүхдийг хэрхэн шилжилт хөдөлгөөнийг хийх талаар нэлээд асуудалтай болдог;

• Иргэд шилжиж ирээд 30 хоногийн дотор бүртгүүлэх ёстой гэж хуульд заасан байдаг боловч хэрвээ бүртгүүлээгүй бол хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт байдаггүй. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаар хариуцлага хүлээлгэдэггүй;

• Дүүргүүд хоорондоо 22 дугаар маягтаар шилжүүлдэг боловч Багануур дүүрэгт 24 дүгээр маягтаар шилжүүлдэг. Үүнийг зарим хорооны дарга нар мэдэхгүйгээс болж 22 дугаар маягтаар шилжүүлсэн байдаг. Гэтэл Багануур дүүргийн иргэний бүртгэлийн албаныхан авах ёстой маягтаар нь шилжүүлэн авах ёстой тул тийм маягттай ирсэн хүмүүсийг буцаадаг. Үүнээс болж иргэдэд ирэх буцах зардал гарах үүний улмаас бусад байдлаар бэрхшээл учирдаг. Иймд хаанаас хаашаа шилжихэд ямар маягтаар шилжүүлэх вэ гэдгийг годорхой болгон журамлаж өгөх;

• Гэр бүлийн гишүүд амьдралын шаардлагаар өөр өөр газар амьдрах

шаардлагатай болдог. Тухайлбал, эхнэр нь Багануур дүүрэгт хүүхдүүдтэйгээ шилжин ирж (хүүхдүүдээ сургуульд сургахын тулд) амьдардаг. Нөхөр нь Төв аймгийн Мөнгөнморьт суманд мал маллан амьдардаг. Тэндээ хашаа саравч хатгаад өмчлөх гэхээр танайх Багануурт шилжсэн. Эхнэр, хүүхдүүд чинь шилжсэн тул чамд газар өмчлүүлэх боломжгүй гэдэг. Энэ талаар эрх зүйн зохицуулалт байх шаардлагатай.

• Иргэний бүртгэлийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой бичиг цаасны ажил маш их байдаг. Цахимжуулсан системд шилжүүлбэл иргэний бүртгэлийн ажилтнуудад болон иргэдэд аль алинд нь ихээхэн хялбар үйлчилгээтэй болно. Жишээлбэл, шилжилт хийлгэсэн иргэдийг хүлээн аваад цээж зураг бүхий журнал хөтөлдөг, тэгээд МАЯГТ 1 гэсэн хуудсыг мөн зурагжуулан бүх хувийн байдлыг нь бичээд архивт хадгалдаг. Тэгээд ХААТР 24 маягтны "Б" талыг "А" талтай адилхан бөглөж бичээд мөн архивт хадгалдаг. Ийм олон ажиллагааг явуулах нь зардал төсвийн хувьд ч хүндрэлтэй нь ойлгомжтой юм.

• Мөн насанд хүрээгүй хүүхдүүдийн хувьд тохиолддог нэг асуудал байна. Аав нь хорих ангид ял эдэлж байгаа, ээж нь багад нь хаяад явсан, одоо хаана байгаа нь мэдэгддэггүй, хүүхэд нь хэн нэгэн хамаатан садныхаа гэрт амьдарч байгаад 16 нас хүрээд иргэний үнэмлэх авахаар орж ирдэг. Иргэний үнэмлэхийг зөвхөн эцэг, эхийнх нь оршин суугаа харъяалалын дагуу өгнө гэж заасан байдаг. Гэтэл эцэг, эхийнх нь харъяалал гэж хэлэх, мэдэгдэх юм байхгүй болсон байдаг. Тэгээд тухайн хүүхдэд иргэний үнэмлэхийг Багануур дүүргээс өгөх боломжгүй болчихдог. Энэ тохиолдолд яах ёстойг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт байдаггүйг анхаарах нь зүйтэй юм.

Бид энэхүү судалгаагаар иргэний бүртгэлийн шилжилт хөдөлгөөнтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, түүнтэй холбоотой зарим хууль зүйн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, төсөл боловсруулах зорилт тавьсан бөгөөд энэ зорилго маань иргэдийн шилжилт, хөдөлгөөнийг чирэгдэлгүй болгох боломжийг бүрдүүлэх давхар зорилт агуулж байгаа юм. Хуулийн нэр томъёонд "Иргэний бүртгэл" гэдгийг "иргэний эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болгохтой холбогдох хуульд заасан үйл ажиллагааг хэлнэ" гэж томъёолсныг хуулийн бусад зүйл, заалтад нарийвчлан зааж өгөх нь зүйтэй. Дахин тэмдэглэхэд иргэний бүртгэл нь иргэний эрхийг хангах галаар ямар үүрэг хүлээх талаар тодорхойгүй өөрөөр хэлбэл, иргэний бүртгэлийг явуулж буй төрийн үйлчилгээ нь иргэний эрхийг хэрхэн хангах, хамгаалах галаар ямар уялдаа холбоотой байх нь бүрхэг байна. Ялангуяа шилжих хөдөлгөөний үед иргэний эрхийг хэрхэн хангах, эрхийн хэрэгжилтэд хэн хяналт тавих, хэн мэдээлэх гэх зэрэг асуудал байсаар байна. Хэрэв иргэн хүний эрх нь зөрчигдсөн нөхцөл байдал үүсэх, хүүхэд бүртгэлгүй байх явдал илрэх юм бол, тэрхүү зөрчигдсөн эрхийг илрүүлсэн байгууллага, ажилтан иргэний бүртгэлийн байгууллагад мэдэгддэг, бүртгэлийн алба нь бүртгэлтэй болгохыг анхаардаг, эрх нь зөрчигдсөн нөхцөл байдал илрээд байвал холбогдох байгууллагад нь бүртгэлийн алба мэдэгддэг, тэр дундаа хүнд нөхцөлд байгаа хүүхдийн асуудлыг хамтад нь шийддэг байх тогтолцоо бий болгох нь зүйтэй байна.

Иргэний бүртгэлийн шилжилт хөдөлгөөнтэй холбогдох харилцаанд үүсч байгаа бэрхшээлтэй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар Нийслэлийн болон хөдөө орон нутгийн иргэдээс болон иргэний бүртгэлийн ажилтнуудаас авсан анкетын судалгааны дүнг

ДҮГНЭН ҮЗВЭЛ:

1. Иргэний бүртгэлийн үйлчилгээг явуулахдаа өөр өөр үнэ, тарифыг тогтоосон байгаа нь харагдаж байна. Тухайлбал, Нийслэлийн иргэний бүртгэлийн албаны даргын захирамжаар тогтоосон үнэ дүүргүүдийн хэмжээнд үйлчилдэг бол аймгуудын хувьд Засаг даргын захирамжаар үйлчилгээний үнийг тогтоодог байна[1]. Түүнчлэн тэдгээр нь өөр өөр үнэтэй байхаас гадна зарим аймгуудад иргэний бүртгэлийн маягтыг хэтрүүлэн үнэлдэг нь иргэдийг иргэний бүртгэлийн үйлчилгээнд хамрах боломжийг хомсдуулахаас гадна шилжилт хөдөлгөөнөө хийлгэхгүй байх нэг гол шалтгаан болж байна. Тухайлбал, Нийслэлийн иргэний бүртгэлийн албанаас иргэний үнэмлэхийн ард наадаг хаягийн наалт 2000 төгрөг болгон тогтоосноос иргэд дүүрэг хооронд шилжсэн шилжилтийн хаягын өөрчлөлтийг хийлгэдэггүй байх нь харагдаж байна. Мөн "ХААТР 24" маягтыг зарим аймаг 1500 төгрөг, зарим нь 5000 төгрөг гэх мэт дур зоргоороо үнэлдэг байна. Иймд Иргэний бүртгэлийн тухай хуульд маягтын нэгдсэн үнэ, тарифыг ямар байгууллага тогтоох талаар хуульчилж өгөх нь зүйтэй байна.

2. Гадаадад сурахаар болон ажиллахаар гарсан хүмүүсийн шилжилт хөдөлгөөнийг яах ёстой вэ гэсэн бүрхэг асуудал байна. Хуульд энэхүү асуудлыг зохцуулсан зохицуулалт байхгүй байна. Жишээлбэл, гадаадад ажиллаж байгаа хүүхэддээ газар авъя гэдэг ч юм уу янз бүрийн асуудалтай орж ирдэг. Гэтэл гадаадад амьдарч буй хүмүүсийг шилжилт хийсэн гэж үзэх үү эсвэл түр шилжилт хийсэн гээд хүн амын тооллогод автоматаар тоолж байх уу гэсэн асуудал бүрэн төгс шийдвэрлэгддэггүй байгаа. Тухайлбал, гадаадад 5 жил амьдарсан хүмүүс орон нутгийн жил бүрийн тооллогод бүртгэгддэггүй тул хасагдчихсан хаана ч бүртгэлгүй болсон байдаг. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын иргэний бүртгэлд бүртгэлгүй болсон байдаг. Тэд эх орондоо эргэж ирээд би хасагдсан байна, бүртгэлгүй болсон байна гэх мэт

1. Хэнтий аймгийн Засаг даргын захирамж болон Нийслэлийн иргэний бүртгэлийн албаны даргын захирамжийг судалгаанд дурдсан.

гомдол гаргадаг. Иймд гадаадад ажиллахаар болон сурахаар явсан иргэдийг, мөн түүнчлэн тэдэнтэй хамт гарч явсан насанд хүрээгүй хүүхдүүдийн асуудлыг нэг мөр цэгцтэй бүртгэж байх системийг бүрдүүлэх шаардлагатай байна.

3. Иргэд тухайн оршин суув байсан газраасаа хасалт хийлгэх үед тойрох хуудас зуруулсаар байгаа тогтолцоог халах нь зүйтэй байна. Нийслэлийн хэмжээнд энэ үйл ажиллагааг хэдийн халсан нь судалгааны дүнд гарч ирсэн нь сайшаалтай хэдий ч зарим аймгуудад тойрох хуудас гэгчийг зуруулсаар байна. Тухайлбал, Хэнтий аймгийн иргэн М нь Нийслэлийн Баганаур дүүрэгт шилжин явахын тулд Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Шүүхийн шийдвэр биелүүлэх алба, Хаан банк, "Дулааны станц" ХК (борлуулалт) гэх мэт нийт 17 газраар орж тойрох хуудаст гарын үсэг зуруулсан нь тухайн иргэнд ихээхэн чирэгдэл учруулж байгааг харж болно. Гэтэл Иргэний бүртгэлийн тухай хуульд тойрох хуудас зуруулах тухай ямар ч заалт байдаггүй боловч бас хориглосон заалт байдаггүй нь эдгээр аймгуудын хувьд зуруулсаар байх нөхцөлийг нь бүрдүүлдэг байна.

4. Цахим иргэний бүртгэл, үнэмлэхийг Монгол Улсад нэвтрүүлэх эдийн засгийн боломж хомс байгаа хэдий ч цахимжуулсан системд шилжүүлэх нь чухал асуудлын нэг байсаар байгааг анхаарахгүй өнгөрч болохгүй юм. Мөн цахим бүртгэлд оруулахаас гадна иргэд, олон нийтийн ерөлцөө, идэвхийг сайжруулах, ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, бүртгэл нь чирэгдэл багатай, жинхэнэ утгаараа үйлчилгээ байх гэх зэрэг хандлага, зохицуулалтыг төгөлдөршүүлэх юм бол иргэний бүртгэлийн тогтолцоо аажмаар сайжрах боломж байна.

5. Насанд хүрээгүй хүүхдүүдэд ихээхэн тохиолддог нэг зүйл бол 16 нас хүрсэн мөртлөө иргэний үнэмлэхээ аваагүй байх явдал юм. Нас нь хэтрээд 2, 3 жил болсон байдаг. Иргэний үнэмлэхээ авах гэвч очихоор 8 дугаар анги төгссөн монтаж шаардсан. Гэтэл сүүлийн үед хүмүүс монтаж хуурамчаар хийлгэх, хүний нэр дээр хуурамч иргэний үнэмлэх гаргуулах гэх мэт зөрчлүүд нэлээд их гарч байна. Тиймээс эцэг, эхээс батлан даалт авч байж 16 нас хүрсэн иргэнд иргэний үнэмлэх олгож байна. Насанд хүрээд иргэний үнэмлэхээ авах боломж байсан бол нэн ядуу айлын хүүхдийг ч Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, иргэний гэр бүлийн байдлын баримт бичиг олгох, эзэмших, хадгалах, шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмыг зөрчсөн гэсэн үндэслэлээр Захиргааны хариуцлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу 40.000 хүртэл төгрөгөөр торгоно гэдэг. Энэ тохиолдолд иргэд торгууль төлөх боломжгүй учраас иргэний үнэмлэхээ авахгүй явсаар 21 насанд хүрсэн иргэн бидний судалгааны явцад тохиолдсон. Иймд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд "...анх удаа зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол..." гэж хөнгөрүүлэх нөхцөл байдлыг оруулан, дээрх тохиолдолд төлөх торгуулийн хэмжээг багасган өгөх зохицуулалттай болгох нь зүйтэй болов уу.

6. 16 насанд хүрээгүй хүүхдийг дангаар шилжүүлж болохгүй гэсэн заалт Иргэний бүртгэлийн тухай хуульд байдаг. Гэтэл насанд хүрээгүй хүн шилч ілт хөдөлгөөн хийгдэх явцад шилжилт нь хийгдэхгүй орхигдсон байдаг. Энэ нь эцэг, эхийн болон магадгүй иргэний бүртгэлийн ажилтны хайхрамжгүй байдалтай холбоотой ба өөрөөр хэлбэл эцэг, эх нь өөрсөдтэйгээ хүүхдээ цуг шилжүүлэхгүй орхисон байдаг. Энэ нь эцэг эхийн хувьд санаатай болон санамсаргүй байдлын аль алин нь байдаг боловч харин иргэний бүртгэлийн ажилтнууд цуг шилжих хүүхэд байгаа эсэхийг нь лавлаагүй хайхрамжгүй хандсан байдаг нь харагдаж байна. Энэ тохиолдолд 16 насанд хүрээгүй хүүхдийг дангаар нь шилжүүлж боллогүй учраас дараа нь хүүхдийг шилжүүлэх боломжгүй болдог. Ийм асуудал практик дээр нэлээд гардаг, гэвч мөн л шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт байдаггүй бөгөөд иргэний бүртгэлийн зөрчилтэй асуудлын нэг болсоор байна.

7. "Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам"-ын 3.3.8-д "тухайн засаг захиргааны нэгжид шилжин ирээд тодорхой хаягаар суурьшсан, шилжүүлгээ албан ёсоор хийлгээгүй, өөрийн биеэр очих санхүүгийн боломжгүй энэхүү журмын 2.4-т заасан шилжин суурьшихыг түр хойшлуулах үндэслэлгүй иргэний хувийн хэргийг тухайн иргэний хүсэлтийг үндэслэн оршин суув байгаа газрын иргэний бүртгэлийн байгууллагын албан ёсны хүсэлтээр шилжүүлж өгнө." гэсэн тодорхой заалт байдаг. Хэдийгээр ихэнх аймгуудад шилжилт хөдөлгөөний хасалт хийлгэхэд заавал өөрийн биеэр байхыг шаардахгүй байгаа боловч хасалтаа хийлгээгүйн улмаас шинэ хаяггаа бүртгүүлж чадахгүй байгаа иргэд нийслэл хотод ихээхэн байгаа нь судалгааны явцад тогтоогдсон. Иргэний үнэмлэх болон хорооны Засаг даргын тодорхойлолттой байхад хасалт хийж байгаа боловч үүнийг иргэд тэр бүр мэдэхгүйгээс болж оршин суугаа газраа бүртгүүлэхгүй байна гэж иргэний бүртгэлийн ажилтнууд өгүүлж байна. Гэсэн хэдий ч дээрх журмын заалтын хэрэгжилт муу, хувийн хэргийг нь шилжүүлэх хүсэлт гаргаад 3 сар болсон байхад ч хариу ирэхгүй байна гэдгийг иргэд ярьж байв. Иймд дээрх журмын заалтыг Иргэний бүртгэлийн тухай хуульд оруулж өгөхөөс гадна энэхүү заалтын хэрэгжилтэд иргэний бүртгэлийн байгууллага дор бүрнээ хяналт тавьж анхаараан ажиллавал иргэдээ хүндэтгэсэн төдийгүй тэдний цаг, мөнгийг хэмнэсэн алхам болох байна.

БАРАА ИМПОРТЛОХ ГААЛИЙН ТАРИФ, ТҮҮНИЙ ХӨНГӨЛӨЛТ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант В.Оюумаа

1. Гаалийн тарифийн тухай ойлголт

Гаалийн тариф гэдэг нь өргөн утгаараа хуулиар батлагдсан журмын дагуу төрийн байгууллагаас явуулж буй эдийн засгийн гадаад үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдсэн зохион байгуулалт, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээний нэгдсэн сүлжээ юм. Явцуу утгаараа бол гаалийн татварын хувь хэмжээг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн (БТКУС) ангилалын дагуу эмхтгэн тогтоосон сүлжээг хэлнэ. БТКУС нь олон улсын хэмжээнд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн барааны ангилал бөгөөд бараа, гаалийн татварын ялгавартай тариф, түүнээс чөлөөлөгдөх барааны нэрсийн жагсаалтаас гадна барааны шинж чанарыг харгалзсан ангиллын системийг хөгжүүлэхдээ тодорхой нэрийн барааны ялгавартай татвар тогтоох асуудлыг агуулсан гаалийн тарифийн салшгүй нэг хэсэг нь юм. Гаалийн тарифийн бодлогын асуудлыг Монгол улсын Гаалийн тарифийн тухай хууль, мөн гааль тарифийн зарчим, хэм хэмжээ, зохион байгуулалтыг тал талаас нь тодорхойлон тогтоосон олон улсын хэд хэдэн гэрээ, хэлэлцээр, конвенцоор зохицуулдаг.

Гаалийн тариф нь эх орныхоо үйлдвэрлэлийг гадаадын өрсөлдөөнөөс хамгаалах, эх орныхоо болон гадаад орнуудын үйлдвэрлэлүүдийн хооронд уралдан хөгжих нөхцөл бүрдүүлэх, эх орныхоо бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үүрэгтэй.

Гаалийн тарифийн тухай хуульд гаалийн татварын хувь хэмжээг тогтоох зарчим, гаалийн үнийг тодорхойлох, гаалийн татвар ногдуулах, барагдуулахад дагаж мөрдөх журмаас гадна зарим нэг хязгаарлалтыг тогтоосон байдаг. Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны гаалийн тарифийн дагуу гаалийн үнийг үндэслэн тооцсон гаалийн татвар ногдуулна. Гаалийн татварын үндсэн зорилго нь:

- Гадаадаас бараа оруулах тогтолцоог оновчтой болгох;
- Барааны экспорт, импортын болон валютын орлого, зарлагын зохистой тэнцвэрийг дэмжих;
- Барааны үйлдвэрлэлт болон хэрэглээний бүтцийг боловсронгуй болгож, шинэчлэх нөхцлийг бүрдүүлэх;
- Улс орны эдийн засгийг гадаадын өрсөлдөөний нэн тааламжгүй нөлөөллөөс хамгаалах зэрэгт чиглэнэ.

Гаалийн татварын хувь хэмжээг гаалийн хилээр бараг нэвтрүүлж буй ямар ч этгээд өөрчлөх эрхгүй. Гадаадаас оруулж буй импортын барааны татварыг хуулиар тогтоодог бөгөөд уг татварын хувь хэмжээ нь тогтмол өөрчлөгдөж байдаг уян хатан асуудал юм. Гаалийн тариф нь ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй хувь хэмжээнээс бүрдэнэ[1].

Татварын хувь, хэмжээний дээд түвшинг Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д элсэхдээ тухайн орны хүлээсэн үүрэг амлалтын жагсаалтад тогтоож, тэр нь Дэлхийн худалдааны байгууллагын үндсэн зарчим болох үндэсний нэн тааламжтай нөхцөл, үндэсний нөхцлөөр дамжин бусад гишүүн орны өмнө хүлээсэн заавал биелүүлэх үүрэг болядог. Монгол улс ДХБ-ын гишүүн орнуудтай гаалийн тарифийн хувь, хэмжээг 0-75 гэсэн ялгавартай байхаар тогтоосон нь дотоодын зах зээлийг хамгаалах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, төлбөрийн тэнцэлийг хангах зэрэг худалдааны бодлогыг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Монгол улсад үндэсний тааламжтай нөхцөл олгодог улсын гарал үүсэлтэй барааND гаалийн тарифийн нэн тааламжтай хувь, хэмжээг хэрэглэж болох бөгөөд Монгол улсад тарифийн хөнгөлөлт үзүүлдэг улсын гарал үүсэлтэй барааND гаалийн тарифийн хөнгөлөлттэй хувь, хэмжээг хэрэглэнэ. Үүнээс бусад улсын гарал үүсэлтэй барааND гаалийн тарифийн өндөр хувь, хэмжээг хэрэглэнэ. Гаалийн тарифийн ердийн хувь хэмжээ нь гаалийн тарифийн нэн тааламжтай хувь хэмжээнээс хоёр дахин их байна. Монгол улсаас гаргаж болох экспортын барааны нэрсийн жагсаалт, эдгээр барааНаас авах татвар болон эдийн засгийн гадаад худалдааны зориулалтын тарифийн бус арга хэмжээг Засгийн газрын шийдвэрээр тогтоодог.[2]

1. Гаалийн тарифийн тухай хууль. 1996 он.
2. Ш.Цогтоо, "Гаалийн эрх зүй". УБ., 2003 он.

2. Гаалтийн тарифийн хөнгөлөлтүүд

Тарифийн хөнгөлөлтүүд гэдэг нь харилцан зохицсон нөхцөл буюу нэг талын саналаар гаалийн хилээр нэвтэрч буй барааны хөнгөлөлт үзүүлэх, ингэж хөнгөлөлт үзүүлэхдээ урьчилан төлсөн албан татварыг буцааж олгох, чөлөөлөх, татварын хэмжээг багасгах хэлбэр юм[3]. Гаалийн нутаг дэвсгэрт оруулж буй бараа урьд нь гаалийн хяналтын дор орж гарч байсан бол гаалийн горимын дагуу тарифийн хөнгөлөлт эдлэнэ. Засгийн газрын хоорондын хэлэлцээрийн дагуу гадаад улсад үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж гаргахад тарифийн хөнгөлөлт эдэлнэ. Мөн зохих хууль тогтоомжийн дагуу улсын экспортод гаргах зарим барааны хөнгөлөлт үзүүлнэ. Гаалийн нутаг дэвсгэрээр гарч буй бараа нь хамтарсан үйлдвэрийн дүрмийн санд шилжүүлэх бараа, мөн тэдгээр үйлдвэрийн зарим төрлийн барааг оруулж ирэх тохиолдолд засгийн газар хоорондын хэлэлцээр хууль зүйн дагуу бүрэн эрх өгсөн барааны хөнгөлөлт эдлүүлнэ.

Татвараас чөлөөлөгдөх объектүүд: Олон улсын хооронд зорчигчийн тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл, мөн хэвийн ажиллагаат хангахад зориулагдсан материал, түлш, уур ус, цахилгаан байж болно. Гаалийн нутаг дэвсгэрт оруулж гаргаж буй бараа нь гадаад улсын төлөөлөгчдийн газрын албаны болон хувийн хэрэгцээнд зориулагдсан бараа байх бөгөөд олон улсын гэрээ хэлэлцээр, хууль тогтоомжоор зохицуулагдана. Гадаад улсын валют, үнэт цаасыг мөн хамааруулна. Гаалийн нутаг дэвсгэрт оруулж, гаргаж буй хүмүүнлэг, буцалтгүй тусламжийн барааг чөлөөлнө.

Тарифын хөнгөлөлтийн ерөнхий систем буюу GSP

Дэлхийн худалдааны байгууллагаас худалдааг тааламжтай болгох гэсэн үйл ажиллагаануудын нэг нь тарифийн хөнгөлөлтийн ерөнхий систем юм. Энэхүү хөгжил буурай орнуудыг хөгжүүлэх зорилгоор (хөгжингүй орнуудад тариф бууруулахгүйгээр) худалдааны тарифыг бууруулж буй систем юм. Өөрөөр хэлбэл ДХБ-аас хүлээн зөвшөөрснөөр хөгжингүй гишүүн улсууд буурангуй болоод хөгжиж буй орнуудын эдийн засаг, худалдааны хөгжлийг дэмжих зорилгоор импортын барааны тарифт хөнгөлөлт үзүүлж байгаа явдал юм.

GSP-ын бүтэц зохион байгуулалт:

- GSP эдлэх улсуудын шалгуур үзүүлэлт:
  - Буурангуйт, үгүй бол хөгжиж буй орон байх;
  - Конвенцэд нэгдэн орсон, түүнийг амжилттай хэрэгжүүлж байх;
  - Дараалалсан 3 жилийн үзүүлэлтээр Дэлхийн Банкны өндөр орлоготой орны тоонд ороогүй г.м.
- GSP буюу хөнгөлөлт үзүүлэх барааны жагсаалт;
- GSP буюу хөнгөлөлт үзүүлэх улсуудын жагсаалт;
- GSP буюу хөнгөлөлт үзүүлэх хувь хэмжээ:
  - ҮНТН буюу тодорхой хэмжээгээр зааж өгсөн хөнгөлөлт;
  - Тариф бүрэн чөлөөлөх;
  - Тодорхой бараан дээр тариф чөлөөлөх;
  - Шалгуур үзүүлэлтээс хамаарч тариф чөлөөлөх;
- Барааны гарал үүслийн дүрэм.

АНУ-ын GSP хэмээх хөтөлбөр нь хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн хөгжлийг дэмжиж Америкийн үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн сонголтыг өсөн нэмэгдүүлэх зорилготой юм. GSP хөтөлбөрийг 1976 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн албан ёсоор нэвтрүүлж эхэлсэн бөгөөд хамгийн сүүлд хөтөлбөрийг 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хэрэгжүүлэхээр баталсан. Одоогоор Монгол улсыг оролцуулан 136 улс орон энэхүү хөнгөлөлтийг эдэлж 3400 төрлийн бараа бүтээгдэхүүнээ гаалийн импортын татвараас чөлөөлүүлэхэд байгаа билээ. АНУ руу экспортлож байгаа Монголд үйлдвэрлэсэн зарим нэг тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг гаалийн татваргүйгээр нэвтрүүлж 3-7% тарифийн хэмнэлт эдэлдэг.

GSP хөтөлбөрт тавигдах шаардлага (АНУ):

АНУ-ын ТХЕС-ийн хөтөлбөрт багтахын тулд дараах шаардлагыг хангана:

- Улс нь албан ёсоор тодорхойлогдсон хөгжиж буй болоод буурангуй орон байх;
- Улс нь хөтөлбөрт оролцох зохистой нөхцөл бүрдсэн байх;
- Хөтөлбөрт заах гарал үүсэлийн дүрмийг баримтлах.

АНУ-ын ТХЕС-ийн хөтөлбөрт хамрагдсан улсуудын 40-өөд улс орон нь буурангуй хөгжилтэй улс орон гэж үздэг ба хөгжиж буй орныг бодвол илүү өргөн хүрээний хөнгөлөлт буюу олон төрлийн барааны илүү хөнгөлөлт эдэлдэг.

GSP-Европын Холбоо(ЕХ)

Хамтын нийгэмлэгийн худалдааны нэгдсэн бодлогын зорилтуудтай харилцан уялдах, ялангуяа хөгжиж буй орнуудад ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжихэд чиглэнэ. Хамгийн анх Европын нийгэмлэг нь 10 жилийн хугацаатайгаар 1971-1981 оны хооронд улс орнуудад хөнгөлөлт үзүүлж эхэлсэн. ЕХ-ны тарифын хөнгөлөлтийн системийн хүрээнд дэлхийн хөгжиж буй 178 орны бараа, бүтээгдэхүүн ЕХ-ны зах зээлд хөнгөлөлтэй татвартайгаар буюу татваргүй нэвтэрч байна. Мөн ЕХ нь нэн буурай хөгжилтэй 49 орны бараг бүх бараа бүтээгдэхүүнийг татваргүй нэвтрүүлж байна.

Европын холбооноос дараах хөнгөлөлтийг үзүүлдэг байна:

3. Ж.Жавзандулам, "Гаалийн эрх зүй". УБ., 2005 он.

• **Ерөнхий хөнгөлөлт**– жагсаалтад заасан хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүнээс бусад мэдрэмтгий бус бараа, бүтээгдэхүүнийг Гаалийн нэмэгдмэл тарифын татвараас чөлөөлөх, тодорхой нэр төрлийн бараанд нэмэгдмэл тарифын татварыг 3,5 пунктээр буруулна;

• **Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшуулалын зохицуулалт (GSP+)**–жагсаалтад заасан бүх бараа, бүтээгдэхүүнийг үнийн дүнд ноогдуулах Гаалийн нэгдмэл тарифын татвараас чөлөөлнө;

• **Нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай зохицуулалт**.

Сайн засаглал, тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн ЕХ-ны худалдааны тусгай хөнгөлөлт "GSP+" нь монголын экспортын бараа, бүтээгдэхүүнийг татваргүйгээр буюу хөнгөлөлттэй татвартайгаар ЕХ-ны зах зээлд нийлүүлэх боломж юм

Монгол Улс 2005 оны 7 дугаар сарын 1-нээс ЕХ-ны Худалдааны тусгай хөнгөлөлт "GSP+"-д хамрагдсанаар 7200 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн, түүний дотор манай экспортын гол бүтээгдэхүүнд тооцогддог бүх төрлийн оёмол, сүлжмэл хувцас, эдлэлийг ЕХ-ны нэгдсэн зах зээлд гаалийн татваргүй гаргах болсон

GSP+ тавигдах шаардлага

Монгол Улсын бараа, бүтээгдэхүүн ЕХ-ны "GSP+" хөнгөлөлтөд хамрагдахын тулд дараах шаардлагыг биелүүлэх ёстой:

• ЕХ-ны ХЕС-ийн Гарал үүслийн дүрмийн дагуу тухайн бүтээгдэхүүн Монгол Улсаас гаралтай байх ёстой. (Гарал үүслийг тодорхойлохдоо зөвхөн ЕХ-ны Гаалийн хууль, холбогдох бусад хуульд заасан гарал үүслийн тухай заалтуудыг баримтлана);

• Тухайн бүтээгдэхүүнийг Монгол Улсаас ЕХ руу шууд тээвэрлэсэн байна;

• Хүчин төгөлдөр гарал үүслийн баримт бичиг бүрдүүлэх ёстой.

ЕХ-ны "GSP+" хөнгөлөлтийн хүрээнд дараах 3 төрлийн баримт бичгийг бүрдүүлнэ:

• Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас олгодог Гарал үүслийн гэрчилгээ;

• ХЕС-д хамрагдах бага өртөг бүхий экспортод хэрэглэдэг нэхэмжлэлийн мэдүүлэг (The Invoice Declaration);

• Тээврийн баримт бичиг (The Movement Certificate EUR1).

GSP+ хөнгөлөлтийн ач холбогдол:

• Тарифыг тэглэх буюу бууруулснаар бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар нэмэгдэнэ;

• Экспортын зах зээл өргөжинө;

• Экспортын чадавхи сайжирна;

• Хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлт нэмэгдэнэ;

• Экспортыг хөхүүлэн дэмжихэд чухал түлхэц болно;

• Бизнес эрхлэгч аж ахуй нэгж, ажиллагчдын хувьд эдийн засгийн үр ашиг өснө.

2003 оны GSP-ийн хүрээнд эдлэсэн хөнгөлөлт дунджаар 163, 000 ам. доллар хүрч нийт экспортын 2.4 % -ийг эзэлсэн байна. 2004 онд 2003 оныхтой харьцуулахад оёмол болон ноолууран бүтээгдэхүүнийг ХБНГУ, Их Британид гаргасан экспортын өсөлтөөс хамааран 2 дахин их бөгөөд 309, 000 ам. долларт хүрчээ. GSP+ нь "Сенситив" бүтээгдэхүүний жагсаалтад Монголын хамгийн их хэмжээгээр экспортлодог оёмол бүтээгдэхүүнийг оруулсан тул манай улсын экспортын хэмжээ өсөхөд чухал нөлөөтэй болсон. 2003 онд GSP+ -ээр эдлэх хөнгөлөлтөөр 800, 000 ам. доллар буюу 12%-ийн ашиггүй худалдаа хийх тооцоо гарч байна. 2004 оны хувьд энэ 1.4 сая ам. доллар хүрж байна. GSP болон GSP+ -ийн Монголд ашиггүй гол хөнгөлөлт нь ЕХ-нд гаргах экспортын 90%-ийг эзэлж байгаагаараа оёмол бүтээгдэхүүнд оногдож байгаа юм.

Европын Холбооны "GSP+" хөнгөлөлтийн системд Монгол улс 2005 оны 7дугаар сараас хамрагдаж эхэлсэн бөгөөд уг хөнгөлөлтөд цаашид үргэлжлүүлэн хамрагдах төлөвлөгөөтэй байна. Энэ хөнгөлөлтөд хамрагдсанаар 7200 нэр төрлийн бараа гаалийн татваргүй, квотгүй Европын зах зээлд нийлүүлэгдэх эрхтэй болно. Энэ хөнгөлөлтөд эхний ээлжинд 2006-2008 оны хооронд, улмаар 2015 он хүртэл хамрагдах юм. Европын Холбооны хөнгөлөлтийн системийн нөхцлийг ашиглах талаар бизнес эрхлэгчдийн дунд семинар, уулзалт зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан. Энэхүү боломжийг ашиглахын тулд манай үйлдвэр, компани, аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүнийхээ чанарыг ЕХ-ны стандартын шаардлагад нийцүүлж, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх хэрэгтэй юм.

3. Бараа импорлохтой холбоотой зарим статистик тоо баримтууд

Монгол Улсын гадаад худалдааны зарим статистик тоо баримт[4]:

• Импортоор нийт 1336.4 сая ам.долларын бараа, түүхий эд оруулсан нь 2005 оны мөн үеэс 290.9 сая ам.доллараар буюу 27.8 хувиар өсчээ;

• Импортын өөрчлөлтийг БТКУС-ын барааны хэсгээр авч үзвэл мал, амьтны болон ургамлын гаралтай өөх тос, нэхмэл бүтээгдэхүүн зэрэг 3 хэсгийн үнийн дүн 0.09-8.3 сая ам.доллараар бууруч, бусад барааны 18 хэсгийн үнийн дүн 0.02-112.2 сая ам.доллараар тус тус нэмэгджээ. Эрдэс бүтээгдэхүүн 112.2 сая ам.доллараар буюу 38.3 хувиар, авто, агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 24.1 сая ам.доллар буюу 23.4 хувиар, химийн болон химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн 20.0 сая ам.доллар буюу 43.7 хувиар, целлюлоз цаас картон 33.9 сая ам.доллар буюу 91.4

4. Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл. 2006 оны 11 дүгээр сарын байдлаар

хувиар тус тус өссөн нь имдортын өсөлтөнд голлон нөлөөлсөн байна.

• Импортоор нийлүүлсэн барааны 82.0 хувийг вальютын төлбөргэй худалдаа, 1.1 хувийг гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа, 2.7 хувийг гадаадын тусламжийн бараа, 9.8 хувийг гадаадын хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, 3.9 хувийг гадаадын захиалагчийн материал, эд зүйлс эзэлж байна;

• Мөн доорх Графикуудуудаас зарим статистик тоо баримтуудыг харж болно.

Зохиогч сэтгүүлийн дараагийн дугаарт энэхүү сэдвийн үргэлжлэл Гаалийн тарифийн тухай шинэ хуулийн төслийн талаар болон Дэлхийн худалдааны байгууллагад авсан үүрэг, амлалт, түүний хэрэгжилтийн талаар толилуулах болно.

Импортын барааны бүтэц (орноор)



Импортын барааны бүтэц
(уялдуулсан системийн барааны хэсгээр)



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХУРЭЭЛЭН www.mj.gov.mn

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант Д.Хуяг

Нэг. Шүүхийн шийдвэрийн ойлголт, мөн чанар

Анхан шатны журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц болон эцэст эрх зүйн ач холбогдол бүхий хэд хэдэн баримт бичиг гаргах бөгөөд энэ нь шүүх эрх мэдлээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн хэлбэр юм. Эдгээр баримт бичгийг гаргах эрх бүхий субъект, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь олон чиглэл, онцлогийг шалгуур болгон шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийдвэр, магадлал, шийтгэвэр гэсэн төрөлд хуваах болох ба мөн чанарын хувьд эдгээр нь эрх зүйн тодорхой маргааныг магадлан шийдвэрлэсэн эсвэл хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой процессийн асуудлыг зохицуулсан шинжтэй байна.

Шүүхийн шийдвэр нь хэрэг маргааны талаар дүгнэлт бүхий шийдлийг агуулсан эрх зүйн баримт бичиг юм. ХБНГУ-ын иргэний процессийн эрх зүйн зохиол бүтээлд иргэний хэргийн "Шүүхийн тогтоол гэдэгт хуулиар тогтоогдсон тодорхой тохиолдлын эрх зүйн үр дагаврын илэрхийлэл юм"[1] гэсэн бол мөн зарим хуульчид "Шүүхийн тогтоол гэдэг нь хэргийн нөхцөл байдлыг тогтоож, түүнд объектив эрхийн хэм хэмжээг хэрэглэж байгаа сэтгэн бодох үйл ажиллагааны үр дүн гэж үзсэн байна"[2].

Шүүхийн шийдвэр бол Монгол Улсын төрийн, тэр дундаа шүүх засаглалын эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын акт мөн. Шийдвэрийг төрийн статус бүхий аливаа байгууллага бус, зөвхөн шүүх гаргах бөгөөд энэ нь ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн заалтаас урган гарч байгаа юм. Түүнчлэн шийдвэрийг төрийн баталсан хуулийн дагуу, түүний хүрээнд гаргах бөгөөд шүүх эрх мэдлийг Үндсэн хуулиар эрх нь олгогдсон төрийн байгууллага хэрэгжүүлдэг учраас шийдвэрийг Монгол Улсын нэрийн өмнөөс гаргадаг. Нөгөө талаар шийдвэр нь төрийн бодлого, зориг санааг илэрхийлэхийн зэрэгцээ төрийн албадлагын механизмыг хэрэгжүүлэх эрх зүйн хэлбэр болдог. Иймд шийдвэр нь:

- Ерөнхий утгаараа нэг удаагийн үйлчлэлтэй;
- Төрийн хүсэл зоригийг илэрхийлсэн эрх бүхий байгууллагын баримт бичгийн хэлбэртэй ;
- Хууль зүйн нэгдмэл үйл ажиллагааны эцсийн бүтээгдэхүүн хэсэг болдогийн хувьд тодорхой хууль зүйн үр дагавар үүсгэдэг;
- Эрх зүйн хэм хэмжээний зохицуулалтаар тодорхой хүрээний этгээдүүдийн зан үйлийн зохих хэмжээ, хязгаарыг тодорхойлдог;
- Тодорхой хэрэг, маргааны талаархи хууль хэрэглээний үр дүнг хэлбэршүүлсэн;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд тавигдсан шаардлагад нийцсэн;
- Төрийн албадлагыг амьдралд хэрэгжүүлэх арга хэрэгсэл мөн.

Шүүхийн шийдвэр нь зөрчигдсөн буюу маргаантай эрхийг сэргээх, түүнийг зохих ёсоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон нийт иргэдэд хүмүүжлийн үр нөлөө үзүүлэх зорилготой болно

Шийдвэр нь онолын талаас материаллаг эрх зүйн ба процессийн эрх зүйн харилцааг агуулж байдаг. Энэ нь иргэн, хуулийн этгээдийн хуулиар тогтоож хамгаалагдсан эдийн ба эдийн бус баялаггай холбоотой эрх нь зөрчигдсөн нь материаллаг эрх зүйн, харин тэрхүү зөрчлийг шүүх хянан үзэж эцсийн шийдвэр гаргаж байгаа нь процессийн эрх зүйн харилцааг давхар илэрхийлдэг.

Хоёр. Шүүхийн шийдвэрт тавигдах шаардлага

Иргэний процессийн эрх зүйн зохиол бүтээлүүдэд шүүхийн шийдвэр нь дараах зургаан шаардлагуудыг хангасан байх ёстой гэж үзжээ.

1. Хууль ёсны байх;
2. Үндэслэл бүхий байх;
3. Бүрэн дүүрэн байх;
4. Тодорхой байх;

1. Rosenberg /Schwab/ Gottwald.ZiviljrozeB.1993. S.307.
2. Furtner.Das Urteil in ZiviljrozeB.4.Aufl.1978.
3. Ц.Амарсайхан нар. "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар", УБ., 2008 он, 304 дэх тал.
4. Д.Баярсайхан. "Эрх зүйн онол".УБ., 1996 он, 56-57 дахь тал.

5. Шийдвэр бислэх ажиллагаа нь ямар нэг нөхцөл, болзолгүй байх.;

6. Хуульд заасан хэлбэрийг хангаж байх.

Шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх гэсэн шаардлагуудыг үндсэн бөгөөд гол шаардлага гэж үзэж болох ба шийдвэр бүрэн дүүрэн байх,тодорхой байх, шийдвэр биелэх ажиллагаа нь ямар нэг нөхцөл, болзолгүй байх,хуульд заасан хэлбэрийг хангаж байх гэсэн шаардлагуудыг шүүхийн шийдвэрт тавигдах бусад шаардлага гэж ангилж болох юм гэж үзнэ.

Эдгээр шаардлагуудыг тодруулан авч үзье.

Шүүхийн шийдвэр нь төрийн хуулийг амьдралд хэрэгжүүлэх эрх зүйн акт учраас ИХШХШ тухай хуульд заасан тодорхой шаардлагыг хангасан байх ёстой ба ИХШХШ тухай хуулийн 116 дугаар зүйлийн 2-т шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна гэжээ.

1. Шүүхийн шийдвэр хууль ёсны байх.

Хуульч Ц.Амарсайхан "Хэрэг, маргааны талаар материаллаг болон процессийн эрх зүйн хэм хэмжээг тэдгээрийн агуулга, зорилгод нийцүүлэн, шүүхээс оновчтой, зөв хэрэглэсэн тохиолдолд шүүхийн шийдвэрийн хууль ёсны байх шаардлага хангагдана"[5] гэж тодорхойлолт өгсөн нь уг ойлголтын гол шинжийг тусгажээ. Шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр бусад хууль, Монгол Улсын соёрхон баталж, нэгдэн орсон олон улсын гэрээг хэрэглэхээс гадна Үндсэн хуульд харшлахгүй бол олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэж болно. Шүүх Үндсэн хуульд нийцээгүй хууль, олон улсын гэрээг хэрэглэхгүй бөгөөд хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл ИХШХШ тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т заасан журмын дагуу саналаа Дээд шүүхэд гаргаж шийдвэрлүүлнэ. Тухайн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол шүүх төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ. Хэрэв тийм хууль байхгүй бол шүүх Үндсэн хуулийн агуулга, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн маргааныг шийдвэрлэнэ.

Шүүхийн шийдвэр хууль ёсны байх гэдэг ойлголтыг схемчлэн авч үзвэл:



Энэхүү схемээс үзэхэд шүүх материаллаг болон процессийн хуулийн бүх шаардлагад нийцүүлэн, хуулийн дагуу гаргасан шийдвэрийг хууль ёсны шийдвэр гэж тодорхойлж болох юм.

Гэтэл шүүхийн практикт хууль ёсны болсон гэж үзэх боломжгүй шийдвэр, магадлал гарсаар байна. Жишээ нь: "Б.У" компанийн нэхэмжлэлтэй "Э.С.С.Э" компанийн хууль бусаар барьсан барилгыг буулгуулах тухай хэрэгт (Чингэлтэй дүүргийн шүүхийн 2005 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 987 тоот шийдвэр, Нийслэлийн шүүхийн 2005 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 608 тоот магадлал, Дээд шүүхийн Иргэний хэргийн ганхимийн 2006 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 152 тоот тогтоолтой хэрэг) Чингэлтэй дүүргийн шүүх гаргасан шийдвэртээ нэхэмжлэлийг хүлээн авсан он, сар, өдрийг бичээгүй учраас шүүх нэхэмжлэлийг хуульд заасан хугацаанд шийдсэн эсэхийг мэдэх боломжгүй болгож, бодит байдлаар уг хэргийг хуульд заасан хугацааг үндэслэлгүйгээр хэтрүүлж шийдсэн байна. Мөн дээрх хэрэгт Чингэлтэй дүүргийн шүүх, хариуцагч нь нэхэмжлэгчийн өмчлөлд байгаа байрны нэг цонхыг таглаж хууль бусаар барилга барьсан байхад уг шүүх Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1.1 , Газрын тухай хуулийн 32.1, 34 дүгээр зүйлийн 1 дэхь хэсгийн заалтуудыг хэрэглэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, хариуцагчийн хууль бусаар барьсан барилгыг бүхэлд нь буулгах тухай шийдвэр гаргах ёстой байхад Чингэлтэй дүүргийн шүүх эдгээр зүйлүүдийг хэрэглээгүйн зэрэгцээ, хэрэглэх ёсгүй Иргэний хуулийн 135 дугаар зүйлийн заалтыг хэрэглэж нэхэмжлэлийн зарим хэсгийг хангах тухай хууль бус шийдвэр гаргаж байжээ.

Мөн Өлзий-76 СӨХ-ийн нэхэмжлэлтэй Д-д холбогдох хэргийг (Чингэлтэй дүүргийн шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 363 дугаар шийдвэр, Нийслэлийн шүүхийн 2006 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 439 дүгээр магадлал, Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимийн 2006 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 650 тоот тогтоолтой) Нийслэлийн шүүх давж заалдах шатаар хянахдаа талуудын хооронд түрээсгийн гэрээтэй холбоотой маргаан гарсан байхад шүүх эд хөрөнгө хөлслөх гэрээний заалтыг баримтлан маргааныг шийдвэрлэж байжээ

2. Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх.

Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх гэдэг нэр томъёог бид

5. С.Нарангэрэл, "Эрх зүйн эх толь бичиг". УБ., 2007 он, 555 дахь тал.

"хууль зүйн факт" гэсэн нэр томъёотой холбон авч үзэж болох ба доктор Д.Баярсайхан "Эрх зүйн онол"[6] номондоо "Факт" гэдэг нь "учрал","тохиолдол" гэсэн утгатай үг гээд "эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчлөн, дуусгавар болгоход чиглэсэн нөхцөл байдлыг хууль зүйн факт гэнэ" гээд хууль зүйн фактыг хүсэл зоригийн шинжээр нь үйл явдал, үйл хөдлөл гэж хоёр ангилсан байна.

Академич С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" номондоо' "факт" гэдэг үгийг "үйл баримт" гэж орчуулсан ба үүнийг бид шүүхийн шийдвэр үйл баримтын талаас тогтоогдсон байх гэдэг утгаар ойлгож байна.

Шүүхийн шийдвэр зөвхөн бодит нөхцөл байдалд үндэслэсэн байх ёстой. Энэ нь шүүхийн шийдвэр ИХШХШ тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан нотлох баримтад тулгуурлана гэсэн ойлголт юм.

Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байхын тулд шүүх дараах хоёр үе шатны ажиллагааг хуулийн дагуу хийх нь зүйтэй гэж үзнэ. Үүнд:

А. Нотлох баримтыг хууль заасан шаардлагад нийцүүлэн цуглуулсан, бүрдүүлсэн байх;

Б. Шүүх цугларсан нотлох баримтанд хууль зүйн үүднээс үнэн зөв үнэлэлт, дүгнэлт өгсөн байх.

Нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу цуглуулж бүрдүүлэх, түүнд хууль зүйн үүднээс үнэн зөв үнэлэлт, дүгнэлт өгсөнөөр шийдвэр бодитой буюу үндэслэл бүхий байх болно.

А. Нотлох баримтыг хуульд заасан шаардлагад нийцүүлэн цуглуулсан, бүрдүүлсэн байх

Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий бодитой байхын тулд зохигчоос шүүхэд гаргаж байгаа ба зохигчийн хүсэлтээр шүүхээс бүрдүүлсэн нотлох баримтууд нь дараах дөрвөн шаардлагыг хангах нь зүйтэй гэж үзнэ. Үүнд:

Нэгдүгээрт. Тухайн хэрэгт ач холбогдолтой буюу хамааралтай байх;

Хоёрдугаарт. Хуульд заасан журмын дагуу олж авсан, гаргуулсан буюу бүрдүүлсэн байх;

Гуравдугаарт. Хэргийн материалд авагдсан байх;

Дөрөвдүгээрт. Шүүх хурлаар хэлэлцэгдэж судлан шинжлэгдсэн байх.

I. Нотлох баримтыг тухайн хэрэгт ач холбогдолтой буюу хамааралтай байх гэдэг нь нотлох баримтыг агуулгын хувьд авч үзэж байгаа ойлголт юм. Шүүхийн шийдвэрийн үндэслэл болж байгаа нотлох баримтууд нь тухайн хэрэгт хамааралтай байх гэдэг нь нэхэмжлэлийн шаардлага болон түүнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хариуцагчийн татгалзлалыг тогтооход ач холбогдолтой бөгөөд шалтгаант холбоотой байх шинжийг илэрхийлнэ. ИХШХШ тухай хуульд дээрх нотлох баримтыг "хамааралтай", "ач холбогдолтой" гэсэн хоёр үгээр бичсэн боловч үгтаа "ач холбогдолтой" гэсэн ойлголт нь "хамааралтай" гэсэн ойлголтын агуулгыг тодорхойлж байна;

II. Хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтууд нь ИХШХШ тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасны дагуу хуулиар зөвшөөрөгдсөн арга хэрэгсэл, хэлбэрээр гаргасан, цугларсан, бүрдсэн тохиолдолд шүүхийн шийдвэрийн үндэслэл болох боломжтой. Хуулиар зөвшөөрөгдөөгүй арга хэрэгслэлээр олж авсан, хуульд заасан хэлбэрээр бэхжүүлэгдээгүй, гэрчлэгдээгүй баримтыг шүүх нотлох баримт гэж үзэж шийдвэрийн үндэслэл болгож болохгүй.

Юуны өмнө шүүгч зохигчоос шүүхэд гарган өгч байгаа нотлох баримт нь хуурамч эсэхийг анхаарч шалгаж байх ёстой. Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх нь баримт, үйл явдлыг зохиомлоор бий болгох, гуйвуулан гажуудуулах, дүрс, хэлбэр, онгө зүсийг өөрчлөх, бичиг баримтын агуулга, тоо, үг үсгийг өөрчлөх зэргээр бодит үнэн байдлыг эсрэг талаас нь буюу ор үндэсгүй зүйлийг бий болгож, нотлох байдалд оруулахыг ойлгоно.

Мөн шүүхэд хууль бус аргаар бүрдүүлсэн нотлох баримт гарган өгч байгаа эсэхийг шүүгч анхаарах ёстой. Нотлох баримтыг хууль бус аргаар цуглуулах гэдэг нь иргэний хэргийн зохигч, гуравдагч этгээд нь өөрт байхгүй байгаа нотлох баримтаа эрж олох, түүнийг цуглуулах эрхтэй боловч хуулиар хориглосон арга хэрэглэж болохгүй. Тухайлбал, бусдыг айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэх замаар бичиг захидал, гэрээ баримт үйлдүүлэх, хууль бусаар утас чагнах, дүрс, бичлэг хийх хэрэгсэл тавих зэргээр нотлох баримтыг бүрдүүлэх ажиллагаа явуулж болохгүй.

Хэргийн оролцогч нэхэмжлэлийн шаардлага ба уг шаардлагаас татгалзах нотлох баримтыг гаргах, цуглуулахдаа хуульд заасан журмын дагуу гүйцэтгэх ёстой. Хэрэв хуульд заасан журмыг зөрчвөл тэдгээрээс гаргасан нотлох баримтыг шүүх үнэлэхгүй, түүнийг авч хэлэлцэхгүй. Ингэснээр уг баримтууд нотлох чадвараа алдаж, шүүхийн шийдвэрийн үндэслэл болдоггүй. Нотлох баримтыг гаргах, цуглуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн гэдэгт гэрчээс мэдүүлэг авахдаа хууль сануулаагүй, гарын үсэг зуруулаагүй болон гэрчээр мэдүүлэг авах эрхгүй этгээд асуусан, гэрчээр өөрөөр нь тодорхойлолт бичүүлж авсан, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа явуулахдаа хуулиар тогтоосон журам зөрчсөн, хөндлөнгийн хоёр гэрч, хэргийн оролцогчдыг оролцуулаагүй, тэмдэглэл хөтлөөгүй, тэд нараар тэмдэглэлд гарын үсэг зуруулаагүй, бичмэл нотлох баримтын хуулбарыг нотариатаар гэрчлүүлээгүй, шинжээчийн дүгнэлт гаргах эрхгүй

6. Т.Мөнхжаргал, Л.Баасан, Д.Хуяг нар. "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй (Ерөнхий анги)". УБ., 2008 он, 92 дахь тал.

этгээд (шүүхээс томилогдоогүй буюу тухайн төрлийн мэдлэггүй этгээд)–ээр дүгнэлт гаргуулсан, "справка" гэх мэт хуульд заагаагүй хэлбэрийн бичиг баримт бүрдүүлсэн зэргийг ойлгоно;

III. Шүүгч хавтаст хэргийн материалд авгдаагүй нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгож болохгүй. ИХШХШ тухай хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зохигч, гуравдагч этгээд тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзалын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй гэж заасны дагуу нэхэмжлэгч, гуравдагч этгээд, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь нэхэмжлэлийн шаардлага ба үндэслэлийг батласан, хариуцагчийн татгалзлалыг үгүйсгэсэн нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх, хариуцагч, гуравдагч этгээд, түүний төлөөлөгч буюу өмгөлөгч нь татгалзал гаргах болсон үндэслэл, түүнийгээ нотлож байгаа баримтуудыг шүүхэд гаргаж өгөх үүрэгтэй байна. Мөн зохигч өөрсдөө олж авах буюу шүүхэд гаргаж өгөх боломжгүй нотлох баримт болох төр, байгууллага, хувь хүний нуущтай холбоотой, өөр улс, орон нутагт байгаа, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа, шинжилгээ хийлгэх, гэрчийн мэдүүлэг авах зэрэг ажиллагааг зохигч шүүхэд хүсэлт гаргаж хийлгэх боломжтой;

IY. Шүүх хавтаст хэргийн материалд цугларсан нотлох баримт болох зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, бичмэл ба эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг зэрэг нотлох баримтыг зохигчийн хүсэлтээр шүүх хуралдааны явцад магадлан шинжлэн судалсны үндэсэн дээр тэдгээрийн үнэн зөв бодитой эсэхийг тогтооно. Шүүх хүрлаар шинжлэн судлагдсан дээрх нотлох баримтууд нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болно.

Б. Шүүх цугларсан нотлох баримтад хууль зүйн үүднээс үнэн зөв үнэлэлт, дүгнэлт өгсөн байх.

Шүүх хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтыг судлан шинжилсэний үндсэнд үнэлэх ажиллагаг хийнэ.

ИХШХШ тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэхь хэсэгт "Шүүх хэргийн оролцогчийн гаргасан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлийн үндсэн дээр үнэлнэ." гэж заасан ба шүүхэд цугларсан нотлох баримтуудын нотолгооны шинж, зориулалтыг шүүх хууль зүйн талаас нь үнэлэлт, дүгнэлт хийх ойуун санааны бүтээлч хандлагыг нотлох баримтыг үнэлэх гэнэ. Нотлох баримтыг үнэлэх ажиллагаа нь шүүхийн нотолгооны бусад үе шатуудыг хэрэгжүүлсэний эцэст явгдах, шүүгчдийн мэдлэг, боловсрол, дадлага, арга зүйтэй холбоотой үйл ажиллагаа юм[6]. Хэргийн оролцогч өөрийн шаардлага, татгалзлалын үндэслэлийг шүүхийн өмнө нотлох үүрэгтэй ба тэд өөрийн ашиг сонирхолд нийцсэн нотлох баримтыг шүүхэд гаргаж өгдөг учир шүүх хэргийн оролцогчийн гаргаж өгсөн аливаа тайлбар, үндэслэл, нотлох баримтад эргэлзэх эрхтэй, тэдгээрийг бодитойгоор үнэлсэний эцэст зөв шийдлийг гаргах үүрэгтэй байна.

Дээр дурдсанаас үндэслэн шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх гэдэг ойлголтыг нотлох баримтыг үнэлэх ажиллагаатай холбогдуулан схемчлэн авч үзвэл:

Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх;



Шүүхийн шийдвэрт хэргийн талаар хийсэн дүгнэлт нь хэргийн жинхэнэ (бодит) нөхцөл байдалтай тохирч байх;

Шүүхээс хэрэгт хууль зүйн ач холбогдол бүхий нөхцөл байдлыг зөв тогтоосон байх;

Шүүхийн дүгнэлтэд онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад алийг нь авч шүүхийн шийдвэрийн үндэслэл болгож, бусдыг нь үгүйсгэсэн тухай үндэслэлийг заасан байх.

Гэтэл шүүхийн практикт нотлох баримтыг үнэлэх ажиллагаатай холбоотой хууль зүйн үндэслэлгүй шийдвэр гарах тохиолдол байна. Тухайлбал: Бидний дээр жишээ болгон авсан "Б.У" компанийн нэхэмжлэлтэй "Э.С.С.Э" компанийн хууль бусаар барьсан барилгыг буулгуулах тухай хэрэгт хариуцагч "Э.С.С.Э" компани нь Газрын тухай хуулийн 21.5.3, 23.3.7, 34.1-д заасан газар эзэмших эрхийг (барилга барих) Засаг дарга шийдвэр (захирамж) гаргаж олгох, уг захирамжийн үндэсэн дээр газар эзэмших эрхийг гэрчилгээ авч дараа нь газар эзэмших тухай Газрын албатай гэрээ хийж газар эзэмших тухай заасан байхад хариуцагч газар эзэмших (барилга барих) захирамж, газар эзэмших эрхийн гэрчилгээ аваагүй зөвхөн газрын албатай газар эзэмших тухай гэрээ хийсэн байсан ба уг гэрээ нь Газрын тухай хуулийг зөрчиж хийгдсэн байхад уг гэрээг Чингэлтэй дүүргийн шүүх хууль ёсны нотлох баримт гэж үзэж хариуцагчийн хууль бусаар барьсан барилгын зөвхөн зарим хэсгийг буулгах тухай

хууль зүйн үндэслэлгүй шийдвэр гаргаж нотлох баримтыг үнэлэх ажиллагаанд алдаа гаргаж байжээ.

Шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн талаар академич С.Нарангэрэл " Аливаа хэрэг маргааныг хуулийн дагуу, шудрагаар шийдвэрлэх, хуулийг зөв хэрэглэх, тайлбарлахад шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэгээг маш тодорхой болгох асуудал нэн чухал ач холбогдолтой юм. Бидний хийсэн хэсэгчилсэн судалгааны дүн нийт шүүхүүд таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлалдаа хууль хэрэглэсэн үндэслэгээгээ тодорхой, оновчтой, үндэслэлтэй илэрхийлэхгүй байх явдал нийтлэг болсоныг харуулав"7 гэж дүгнэсэн нь онцгой ач холбогдолтой юм.

3. Шийдвэр бүрэн дүүрэн байх

Шүүхийн шийдвэр нь хэргийн талуудын гаргасан нэхэмжлэл, тайлбар, шаардлагад хариу өгсөн байх ёстой. Энэ нь шүүх нэхэмжлэлийн хэд хэдэн шаардлага, сөрөг нэхэмжлэл, бусад этгээдийн гаргасан хүсэлт тайлбарт дурдсан асуудлыг бүх талаас нь шийдвэрлэж ач холбогдол бүхий аливаа асуудлыг шийдвэрлэхгүй орхигдуулж болохгүй гэсэн үг юм. Шүүх, бусдын эрүүл мэндэд хууль бусаар гэм хор учруулсан тохиолдолд нэхэмжлэгч гаргуулахыг хүссэн бүх төлбөрийн асуудлыг бүрэн хэмжээгээр шийдэх ёстой. Энэ нь хохирогчийн хөдөлмөрийн чадвараа алдаснаас дутуу авсан цалин хөлс, эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдон гарсан эмчилгээний зардал, асарч сувилах, нэмэгдэл хоол өгөх, хиймэл эрхтэн хийлгэх, сувилалын газар сувилуулах зэрэг зайлшгүй бүх зардлыг нэхэмжлэгчид гаргуулан өгөх тухай асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Гэтэл энэ шаардлага хангагдаагүй шийдвэр гарсаар байна. Тухайлбал: Э-ийн нэхэмжлэлтэй Хас банкинд холбогдох (Увс аймаг дахь сум дундын шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 201 тот шийдвэртэй, Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимийн 2007 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 201 тоот тогтоолтой) хэргийг Увс аймгийн сум дундын шүүх шийдэхдээ нэхэмжлэгч Э зээлийн гэрээг цуцалж, зээлийн хүүг зогсоож өгөхийг хүссэн, түүнчлэн зээлийн төлбөрийг фургон машинаар төлүүлж өгөх тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байхад шүүх уг нэхэмжлэлийн шаардлага болох банкны барьцаанд байгаа фургон машины асуудлыг шийдвэрлэхгүй орхигдуулж байжээ.

4. Шийдвэр тодорхой байх

Энэ нь шүүхээс маргаантай асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн нь ойлгомжтой, хариуцагч этгээдийн хүлээх үүрэг нарийн тогтоогдсон байх гэсэн шаардлага юм.

Шийдвэр тодорхой байх нь түүний тогтвортой байх, зөрчигдсөн эрхийг сэргээх, шийдвэрийг биелүүлэх чухал нөхцөл болох ач холбогдолтой байна. Жишээ нь: дээр дурдсан "Б.У" компаний нэхэмжлэлтэй "Э.С.С.Э" компаний хууль бусаар барьсан барилгыг буулгуулах тухай хэрэгт хэргийг шийдсэн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгч 987 тоот шийдвэрийнхээ үндэслэх хэсэгт "нэхэмжлэгчийн цонхыг таглаж барьсан... харалдаа хэсгийг буулгах нь зүйтэй" гэж дүгнэсэн атлаа шийдвэрийнхээ тогтоох хэсэгт цонхыг тагласан..."харалдаа хэсгийн өрлөгийг буулгах-ыг" хариуцагчид даалгаж, хариуцагчид хоёр өөр үүргийг хүлээлгэж шийдвэрийн үндэслэх ба тогтоох хэсэг зөрчилдөж, шийдвэр биелүүлэх ажиллагаанд хүндрэл учруулж байжээ.

5. Шийдвэр биелэх ажиллагаа нь ямар нэг нөхцөл, болзолгүй байх

Шүүх шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг ямар нэгэн нөхцөл байдал бий болох эсхүл болохгүй байхаас хамааралтай байхаар зааж болохгүй. Тухайлбал хариуцагчийг орон сууцнаас албадан гаргуулахаар шүүхийн шийдвэрт заахдаа тухайн хариуцагч өөр нэгэн орон сууцанд орох боломжтой болсон тохиолдолд дээрх шийдвэрийг биелүүлнэ гэж заахгүй. Мөн шүүх хариуцагчаас ямар нэгэн эд хөрөнгө гаргуулж нэхэмжлэгчид олгохоор шийдвэрт заахдаа нэхэмжлэгчийн зүгээс ямар нэгэн хариу үйлдэл хийсний дараа уг эд хөрөнгийг гаргуулна гэж шийдвэрт зааж болохгүй.

6. Шийдвэр хуульд заасан хэлбэрийг хангаж байх

Шийдвэр нь хуульд заасан бүрдүүлбэр болох удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсэгтэй байж ИХШХШ тухай хуульд заасан хэлбэрийг хангана. Энэ нь тогтоосон журмын дагуу бичгээр үйлдсэн, хэрэг шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн, өөрсдөө шийдвэрийг төлөвлөсөн, алдаа мадаггүй, хуульд заасан агуулгыг бүрэн багтаасан, шүүгчид гарын үсэг зурж, тамга дарах зэргээр албан ёсны баримт бичиг болгосон байна. Гэтэл энэ шаардлагыг хангаагүй шийдвэр гарсаар байна.

Жишээ нь: М-ийн нэхэмжлэлтэй О -д холбогдох (Төв аймаг дахь сум дундын 2-р шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 180-р шийдвэртэй, Дээд шүүхийн Иргэний хэргийн ганхимийн 2007 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 33 тоот тогтоолтой) хэрэгт шүүгч ИХШХШ тухай хуулийн 118 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шийдвэр удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгээс бүрдэнэ гэсэн заалтыг зөрчиж анхан шатны шүүхийн шийдвэр нь удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгээс бүрдсэн бөгөөд үндэслэх хэсгийг тодорхойлох хэсэгт бичиж хууль зөрчиж байжээ.

Дүгнэлт, санал

1. ИХШХШТХуулийн 168 дугаар зүйлд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлүүдийг заахдаа зөвхөн материаллаг эрх зүйн ба процессын

7. С.Нарангэрэл. "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо". УБ., 2001 он, 124-125 дахь тал.

хуулийн заалтуудыг дурдсан байх ба энэ зүйлд шүүхийн шийдвэрийг хэргийн нотлох баримтаар "тухайн хэргийн үйл баримт" тогтоогдсон эсэх талаас нь, шүүхийн шийдвэр үндэслэл бүхий болсон эсэх талаас нь буюу шүүхийн шийдвэр ямар тохиолдолд үндэслэлгүй болсон гэж үзэж шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох тухай заалтуудыг орхигдуулсан байх тул уг хуульд нэмж тусгах.

2. Шүүхийн шийдвэр өөрчлөгдөж, хүчингүй болж байгаа нэг шалтгаан нь ИХШХШ тухай хууль боловсронгуй бус, тухайлбал мөн хуулийн 116 дугаар зүйлийн 2-т заасан шүүхийн шийдвэр "хууль ёсны" бөгөөд "үндэслэл бүхий байх" гэсэн нэр томъёонуудыг тодруулан заагаагүйтэй холбоотой гэж үзэж байна. Иймд ИХШХШ гухай хуульд "материаллаг болон процессын хуулийн бүх шаардлагад нийцүүлэн, хуулийн дагуу гаргасан шийдвэрийг хууль ёсны шийдвэр гэнэ", "Шүүхэд хэргийн оролцогчдоос гаргасан ба шүүхээс бүрдүүлсэн нотлох баримт нь хуулийн шаардлага хангасан, түүнд хууль зүйн үүднээс үнэн зөв үнэлэлт, дүгнэлт өгсөн шийдвэрийг үндэслэл бүхий шийдвэр гэнэ" гэх зэргээр тодорхойлолт өгч улмаар дээрх хоёр ойлголтыг уг хуульд дэлгэрүүлэн заажөгөх.

3. Иргэний хэрэгт анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхээс гаргах шүүхийн тогтоолын үлгэрчилсэн загварыг боловсруулан гаргах.

4. Шүүхийн шийдвэр боловсруулах, гаргах ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ХБНГУ-ын хуулийн сургуулиудын жишээгээр манай их, дээд сургуулиудад тухайлан "шүүхийн шийдвэр гаргах" сэдэвт хичээл оруулах асуудлыг судлаж үзэх.

ТАНЫ ХӨТӨЧ

ХУУЛЬ ЗҮЙН 1982 ЛАВЛАХ

Хууль зүйн лавлах 1982 дугаар дараах чиглэлээр лавлагаа өгнө

1. Иргэд төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол хэрхэн гаргах талаар;
2. Хэргийн харьяаллын талаар;
3. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн актын талаар;
4. Газар болон бусад үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар;
5. Гэр бүл, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлаар;
6. Нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудлаар;
7. Компани, нөхөрлөл, хоршоо байгуулах, өөрчлөн байгуулах чиглэлээр;
8. Банк болон банк бус санхүүгийн байгууллага, хөдөлмөж, зээлийн хоршоо талаар;
9. Гэрээний эрх зүйн чиглэлээр;
10. Иргэний бүртгэл, мэдээлэлтэй холбоотой асуудлаар;
11. Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны хариуцлагын тухай хуультай холбоотой асуудлаар;
12. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар;
13. Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын асуудлаар;
14. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн талаар;
15. Татвар болон гаалийн хууль тогтоомжтой холбоотой асуудлаар;
16. Төрийн байгууллагуудын утас, хаяг, байршлын талаар;
17. Шүүхийн утас, хаяг, байршлын талаар;
18. Хууль зүйн үндэсний төвийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар;
19. Өмгөөллийн туслалцаа хэрхэн авч болох талаар болон МӨХ-ны өмгөөлөгчдийн утас, хаяг, байршлын талаар;
20. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйл ажиллагаа явуулж байгаа нотариатчдын талаар лавлагаа өгөх гэх мэт.

МЭТГЭЛЦЭЭН БА ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА

Эрүүгийн байцаах шийтгэх ажиллагааны зорилт нь хэргийн талаарх бодит үнэнийг илрүүлэх, гэм буруутай эсэхийг тогтоох тухай асуудал юм. Үүн ухааны үүднээс "...Үнэний асуудлууд дахь шүүгч нь оюун ухаан түүнд хүрэх арга нь танин мэдэхүйн шүүмжлэлт рационалист зарчим болох"-ыг тодорхойлдог. Энэхүү зарчмыг үндэслэгч К.Попперийн боловсруулсан мэтгэлцээний онол арга зүйн үндэс нь верификац (нотлох)-ийн зарчмын эсрэг Фальсификац (няцаах)-ийн зарчмыг сөргүүлэн тавьжээ. Фальсификацийн зарчмын үүднээс хандвал шинжлэх ухааны аливаа үндэслэлийг нотолсноос няцаасан нь танин мэдэхүйн илүү хөдөлгөөнгүй бөгөөд ашиггүй үр дүн өгдөг[1]. Энэ нь мэтгэлцээн явуулах арга хэлбэрийг тодорхойлсон хэрэг юм. Мэтгэлцээн нь хүмүүсийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх харилцан байр сууриа тодорхойлох, өрсөлдөгчийн байр суурийг хүндэтгэх хүмүүсийн харилцааны хамгийн ардчилсан хэлбэр.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны түүхэн хэв маяг, тухайлбал, хувийн нэхэмжлэлд үндэслэсэн, эрэн сурвалжлах, яллах хэв маяг верификацийн зарчмаар явагддаг байсан нь ажиглагддаг. Хувийн нэхэмжлэлд үндэслэсэн хэв маяг нь мөрдөн мөшгөх ажиллагааг зөвхөн хохирогч өөрийн эрхийг хамгаалах, сэргээхийн тулд үүсгэдэг байсан бөгөөд яллах баримтаа өөрөө цуглуулж яллагдагчийг шүүхэд өөрөө авчирдаг. Ийнхүү хувийн нэхэмжлэлд үндэслэсэн байцаан шийтгэх ажиллагаанд хувь хүний яллагаа зонхилж өргөсөн тангараг, тулаан, мэтгэлцэх үг зэргээс

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш, докторант Ж.Эрхэсхулан

бүрдэж, тулаанд ялагч нь зөвлөг байснаас үзвэл бас ч мэтгэлцээний зарим нэг шинжүүд байсан боловч "хүчтэйн өмнө хүчгүй нь буруутай" зарчим үйлчилж байсан нь тухайн үеийн нийгмийн хандлагыг илэрхийлж байсан ажээ. Хувь хүний яллагааны хэв маяг нь үндсэндээ "цусан өшөө" авах хэлбэрийг төрүүлж, өөгшүүлэх нэн тохиромжтой хэв маяг байлаа.

Ийнхүү цусан өшөө авах явдал нь хувь хүн төдийгүй гэр бүл, хэсэг бүлгүүд, улмаар овог аймгийн хоорондын тэмцэл болж, нийгмийг хамарсан шинжтэй болж ирсэн явдал нь төр оролцох зайлшгүй зүй тогтлыг бий болгов. Чухам энэ үеэс төр байцаан шийтгэх ажиллагааны идэвхитэй оролцогч төдийгүй, голлох субъект болж бүхнийг гартаа атгасан нь "...төр өөртөө яллан шийтгэх үйл ажиллагааг төвлөрүүлснээр ЭБШ ажиллагааны хувийн нэхэмжлэлд үндэслэсэн хэв маягийг үгүйсгэж, гэмт этгээдийг эрэн сурвалжилж илрүүлэх үүргийг төр хүлээсэн нийтийн шинжтэй ЭБШ ажиллагааны хэв маяг бүрдэж эхэлсэн"[2] байна. Дурьдаж буй хэв маягийг шүүмжлэлт рационализмын онолын үүднээс авч үзвэл: нэгэнт тогтсон тодорхой онол буюу үзэл бодол, биднийхээр "төрийн яллагаа"-г баримтаар нотлох идэвхитэй үйл ажиллагааг явуулж, гагцхүү энэ байдалд тохирохгүй үйл явдал гэж хэзээд байж болохгүй гэж үзээд, шүүгдэгчийн гэм бурууг тулган хүлээлгэх, улмаар шүүгдэгч гэм бурууг хүлээсэн эсэхийг голлон анхаардаг байсан нь верификацийн **зөвхөн нотлох** хандлагатай төстэй бөгөөд шүүгдэгч ямар ч эрхгүй, яллагчтай мэтгэлцэх боломжгүйгээс гадна яллагч, өмгөөлөгч, шүүгчийн үүргийг зөвхөн төр гүйцэтгэдэг байснаар тайлбарлагдана. Үүнээс үзвэл хувийн нэхэмжлэлд үндэслэсэн болон эрэн сурвалжлах байцаан шийтгэх ажиллагааны хэв маягууд, нэн ялангуяа эрэн сурвалжлах хэв маягт неопозитивизмын верификацийн зарчим сонгодог хэлбэрээрээ хэрэгжиж байв гэсэн дүгнэлтэнд хүргэж байна. 19 дүгээр зууны хоёрдугаар хагасаас 20 дугаар зууны туршид шинжлэх ухаан, нийгмийн сэтгэлгээнд эргэлтийн шинжтэй томоохон дэвшил гарч "...нийгэмд зайлшгүй шалтгаалцал хийгээд зүй тогтол ноёрхох[3] буюу аливаа үзэгдлийн хооронд бодит холбоо хамаарал байна. Энэхүү бодит холбоо хамаарлыг шинжлэх нь үзэгдлийн зүй тогтлыг илрүүлэхэд тусална" гэсэн диалектик хандлага хүчтэй болов. Нийгмийг хамарсан энэхүү хандлага ч байцаан шийтгэх ажиллагаанд нөлөөлсний нэг илрэл нь төр хэдийгээр ЭБШ ажиллагаанд бүрэн ноёрхох системийг бүрдүүлж төрийн яллагаа байцаан шийтгэх ажиллагааны хөдөлгөгч хүч болж байсан хэдий ч, яллагаа нь зөвхөн бодит баримтад тулгуурлах тухай

1. "Философи", 2001 он., 116 дахь тал.
2. Ж.Бямбаа, Г.Баясгалан. "Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд", УБ., 1998 он, 36 дахь тал.
3. "Философи", 2001 он, 111 дэх тал.

шинэ онол[4] гарч ирэв. Үүнээс улбаалаад яллагдагч тал ч өөрийгөө цагаатгах бодит баримтыг гаргаж тавих боломжтой болсон явдал нь асуудлыг зөвхөн нэг талаас нотлох, шийдэх боломжгүйд хүргэсэн аж. Чухам энэ үеэс л эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд шудрага, ардчилсан онол сэтгэлгээ бүрэлдэж, орчин үеийн сонгодог **мэтгэлцэх** хэв маягийн үндэс тавигдсан гэж болно. Ийнхүү байцаан шийтгэх ажиллагаанд дан ганц яллагаа нотолгооны асуудлаас гадна, эсрэг талын хариу няцаалтын үйл ажиллагааг шүүх шийдвэр гаргах үйл явцдаа харгалзан үзэх болсон нь байцаан шийтгэх ажиллагаанд "хувьсгал" болсон гэхэд хилсдэхгүй. Шүүмжлэлт рационализмыг үндэслэгч К.Попперийн үзсэнээр мэдлэгийн хөгжил "өсөлт" нь нэг таамаглал нөгөөгөөр солигдон, хуучин онол таамаглал няцаагдах замаар шинэ онол таамаглалаар солигддог[5], үүний фальсификацийн зарчим гэх бөгөөд шинэ зоримог онол таамаглал нь хатуу ширүүн шүүмжлэлийн дунд шүүн хэлэлцэгдэж, олон онолын байнгын өрсөлдөөн дундаас хамгийн шилдэг нь шалгарч байх учиртай. Ийнхүү үзэл бодлыг уралдуулж түүний дундаас шилдэг сайныг шалгаруулах тухай үзэл санаа нь шүүмжлэлт рационализм бүюу орчин үеийн **мэтгэлцээний үндэс** нь болно. Асуудалд тодорхой үзэл санаа (таамаглал, шийдэл) дэвшүүлснээр мэтгэлцээний хүрээг тодорхойлж, талууд шийдлээ нотлогоо ба няцаалтаар жишээ баримттайгаар тавьж бусдыг итгүүлэн үнэмшүүлэх замаар олонхийн санал авахыг эрхэм зорилгоо болгодог. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны яллах хэв маяг нь зарим тохиолдолд мэтгэлцээний хэлбэр, шинжийг агуулдаг хэдий ч энэхүү хэв маягт мэтгэлцээн нь төгс сонгодог хэлбэрээр хэрэгжих эсэх нь өнөөг хүртэл эргэлзээтэй бөгөөд онолын маргаантай юм. Өнөөгийн хандлагаар "Харилцан бие биеэсээ хараат бус, өөрсдийн эрх ашиг сонирхолыг хамгаалан, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд тэнцүү эрх эдэлж, шүүн таслах ажиллагаанд оролцож буй яллах болон өмгөөлөх талууд, тэдгээрт холбогдох оролцогчдын үйл ажиллагаанд хэргийг бүх талаас нь бүрэн дүүрэн, бодитой судлан үзэж, шударгаар, гадны ямар нэгэн нөлөөнд авталгүй шийдвэрлэж чадах шүүх, төвлөх байр суурь эзэлж байхыг мэтгэлцэх зарчим"[6] хэмээн ойлгож байна. Мэтгэлцэх хэв маягт яллагч нь шүүгдэгчийн гэм бурууг нотлох үүргийг, нөгөө талаас өмгөөлөгч нь хөнгөрүүлэх, цагаатгах бүюу гэм бурууг нотлох, шүүх нь хөндлөнгийн байр суурьнаас талуудын баримттай нотолгоо, няцаалтыг нь үнэлэн үзэж бодитой үндэслэлтэйд нь тулгуурлан шийдвэр гаргаж буй нь шүүмжлэлт рационализмын фальсификаци (няцаах, үгүйсгэх)-ын зарчим үйлчилж байна гэж үзэх үндэстэй юм. Тодруулбал, эрүүгийн хэргийн байцаан шийтгэх ажиллагааны өвөрмөц онцлогоос хамаарч яллах баримтыг нотлох, цагаатгах баримтыг няцаах үүргийг улсын яллагч, яллах баримтыг няцаах, цагаатгах баримтыг нотлох үүргийг өмөөлөгч хүлээж мэтгэлцээнд зөвхөн хоёр тал (яллах, өмгөөлөх) оролцдог гэж үзэж болно. Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлд "Шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулах"-аар тогтоосныг онцгой анхаарч жинхэнэ утга агуулгаар нь ойлгож хэрэглэх нь чухал. Уг хуулийн заалт нь мэтгэлцээний субъектүүд болох яллах өмгөөлөх талуудын эрх хэмжээнээс гадна шүүхийн гүйцэтгэх үүргийг нэгдмэлээр тодорхойлж байдгаараа зарчмын ач холбогдолтой бөгөөд эрдэмтэн судлаачдын бүтээл, төрийн албаны баримт бичигт "Мэтгэлцэх зарчим" хэмээн нэгэнт нэршжээ. Яллах тал болох прокурор нь сонсгосон ялыг нотлох үүрэгтэй болох талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17.2, яллах баримтыг нотлох үүрэгтэй болохыг мөн хуулийн 261.2 дугаар зүйлд тус тус зааж, шүүх хуралдааны үед прокурорын чиг үүргийг 239 дугаар зүйлд "...шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцох, нотлох баримтыг шинжлэн судлах, ял оногдуулахад баримтлах эрүүгийн хуулийн талаар дүгнэлт гаргах..." гэж тодорхойлжээ.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад гэмт хэрэг үйлдсэн нь баримтаар хангалттай нотлогдож байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч яллагдагчаар гатаж, ял сонсгоно. Иймд хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчийн сонсгосон ялыг прокурор үндэслэлтэй гэж үзвэл нотлох үүрэг хүлээх бөгөөд уг үүрэг нь яллах дүгнэлтээр илрэн гарна. Өөрөөр хэлбэл, сонсгосон ял нотлогдсон гэж үзвэл яллах дүгнэлт бичигдэх учиртай. Яллагдагчаар татсан тогтоол, прокурорын яллах дүгнэлт нь үйлдсэн хэргийн байдал, санаа зорилго, учруулсан хохирол хэрхэн тогтоогдож байгаа, гэмт хэрэг Эрүүгийн хуулийн ямар зүйл ангид тохирох, бусад ямар байдал тогтоогдсоныг эрх бүхий этгээдээс хуульд заасан журмын дагуу үйлдсэн баримт бичиг болно. Эдгээр баримт бичгийн агуулга нь зөвхөн гэмт хэргийн ул мөр болох хэрэгт цугалсан баримтад үндэслэгдэж, хуульд заасан шаардлагыг хангасан байдгаараа эрүүгийн хэргийн яллах нотлох баримтыг бүрдүүлнэ. Ийнхүү бүрдсэн яллах нотлох баримтыг шүүхийн өмнө прокурор эргэлзээгүй нотолж гэмээнэ шүүхэд мэтгэлцэх улсын яллагчийн гүйцэтгэх үүрэг тодорхойлогдох учиртай. Үүнээс үзвэл сонсгосон ялыг нотлох асуудал нь прокурорын хяналтын шатанд хэлбэршиж, харин яллах баримтыг нотлох үүрэг нь шүүхийн шатанд тодруулбал, шүүх хуралдааны мэтгэлцээний зүйл болдог ажээ. Иймээс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дугаар зүйлийн 239.4-т

4. Ж.Бямбаа, Г.Баяргалан. "Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд", УБ., 1998 он, 37 дахь тал.
5. The Philosophy of Karl Popper. Vol-1. La Salle, 1974.
6. "Шүүгчийн ном", УБ., 1999 он, 43 дахь тал.

заасан прокурорын эрх хэмжээ бол сонсгосон ялыг нотлохоос татгалзаж буй биш яллах баримтыг нотлохоос татгалзаж байгаа хэрэг болно. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн зорилго бол хэргийн бодит үнэнийг илрүүлэхэд чиглэгддэг. Иймд хэргийн нөхцөл байдлыг бүх талаас нь авч үзэх, танин мэдэхийг аяндаа шаарддаг. Сонсгосон ялыг нотолсон асуудал нь яллах дүгнэлт бичигдсэн хавтаст хэргийн хүрээний л асуудал. Гэтэл шүүхийн шатанд, шүүхийн мэтгэлцээний үед шинэ үндэслэгээ, нөхцөл байдал, нотлох баримт гарч ирэхийг үгүйсгэх аргагүй. Энэ тохиолдолд хэргийн бодит үнэнийг бүх талаас нь авч үзэх шалгуурын үүднээс прокурор яллах баримтыг нотлох үүргээсээ татгалзах тэр ч бүү хэл прокурорын шатанд сонсгосон ялыг нотолсон (яллах дүгнэлт) үзэл бодлоосоо ухрах, түүнийгээ буруу болохыг ч зөвшөөрдөг байх нь ёс зүйтэй юм. Учир нь хэргийн үнэн учрыг олох, гэм буруугүй хэнийг ч гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангах нь гэмт хэргийг мөрдөх, илрүүлэхээсээ илүүтэй тэргүүний асуудал бөгөөд дан ганц прокурорын байгууллагын төдийгүй эрх бүхий төрийн бусад байгууллагуудын үйл ажиллагааны нэгдмэл зорилго болно.

Өмгөөлөгч нь үйлчлүүлэгч этгээдийн эрх ашиг сонирхолыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлэх замаар өмгөөлөх чиг үүрэг хэрэгжинэ. Үйлчлүүлэгчийн эрх ашиг сонирхлыг хамгаалах хэлбэр нь шүүх хуралдаанд оролцох, хүсэлт гомдол гаргах арга хэрэгслээр хамгийн тод илрэнэ. Байцаан шийтгэх хойшлуулшгүй ажиллагаа явуулж буй эсхүл сэжигтнээр тооцогдсон үеэс эхлэн хэрэгт өмгөөлөгч оролцдог. Өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх нь чухам энэ үеэс хэрэгжинэ. Тодруулбал: хэргийн холбогдогчтой ганцаарчлан уулзах, зөвлөгөө өгөх, иргэн, хуулийн этгээдээс хэрэгг ач холбогдол бүхий тайлбар баримт бичиг, тодорхойлолт гаргуулж хөнгөрүүлэх болон цагаатгах баримт мэдээлэл гаргах, шалгуулах, хэрэгт нотлох баримтаар тусгуулах, байцаалтын ажиллагаанд оролцох, асуулт тавих, хэргийн материалтай танилцсаны үндсэн дээр тодорхой санал тавих зэрэг болно. Үүнээс үзвэл өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх ажиллагаа нь шүүхийн өмнөх шатанд, эрх ашиг сонирхлыг хамгаалах ажиллагаа нь шүүхийн шатанд илүүтэйгээр, нэн ялангуяа шүүхийн мэтгэлцээнээр илрэн гардаг гэж дүгнэмээр санагдана. Үйлчлүүлэгчийн ашиг сонирхолыг хамгаалан үр дүнтэй мэтгэлцэхийн тулд цагаатгах болон хөнгөрүүлэх баримт сэлтийг шүүхийн өмнө гарган тавьж түүний цагаатгах ач холбогдолыг хэргийн байдал болон хуулийн шаардлагатай уяалдуулан үнэмшүүлэх нөгөөтэйгүүр яллах нотлох баримтын яллагааны ач холбогдлыг бууруулах, үгүйсгэх, няцаах үндэслэлийг шүүхэд гарган тавих замаар өмгөөлөгч шүүхэд мэтгэлцэнэ. Өмгөөлөгч шүүх хуралдааны мэтгэлцээнд оролцож хуулиар олгогдсон боломжоо бүрэн гүйцэд ашиглах нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхолтой шууд хамааралтай. Өмгөөлөгч нь өмгөөлж байгаа этгээдийн болон өөрийн хүсэлтээр хийгдэж байгаа байцаан шийтгэх ажиллагаанд түүнчлэн байцаан шийтгэх ажиллагааны зарим оролцогчдыг байцаахад оролцох, тэдгээрт асуулт тавих зэрэг эрх хэрэглэж чадвал маш өргөн боломжийг бий болгох учиртай. Харамсалтай нь байцаан шийтгэх ажиллагаа хэрэгжүүлж буй зарим албан тушаалтнаас өмгөөлөгчийн дурьдсан эрхийг эдлүүлэхэд хойрго хандах, хязгаарлах, зөрчих асуудал гарсаар байна. Онцгой байдлын сайд С.Отгонбаярын гэх эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын шатанд түүний өмгөөлөгчөөс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41.3.3 болон 41.3.4 дугаар зүйлүүдэд заасан эрхийн дагуу зарим оролцогчдоос байцаалт авахад нь оролцох хүсэлт гаргахад "...байцаан шийтгэх ажиллагаанд саад болж болзошгүй..." гэх үндэслэлээр хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон нь хуульд огт байхгүй үндэслэл бөгөөд байцаан шийтгэх ажиллагаа явуулах журмыг ноцтой зөрчсон, өмгөөлөгчийн эрхийг бүдүүлгээр хязгаарласан хууль бус үйлдлийн жишээ юм. Мөн өмгөөлөгчийн мэдлэг, туршлагын дулимаг байдал, зарим эрх бүхий албан тушаалтнуудын хүнд суртлаас халшрах, залхахаас үүдэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын "аманд багтах" явдал байгаа нь ч нууц биш. Зүй нь өмгөөлөгч эсрэгээрээ хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчийг "залхаах" нь үйлчлүүлэгчийн эрх ашигт илүү нийцтэй юм.

Эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагаат мэтгэлцээний үндсэн дээр явуулахаар хуульчилсан заалтаас үзвэл анхан шатны шүүхэд мэтгэлцэх зарчим үйлчлэх, хяналтын шатны шүүхэд үйлчлэхгүй нь туйлын тодорхой. Харин давж заалдах шатны шүүхэд хэрхэх нь тун бүрхэг ажээ. Иймд мэтгэлцэх зарчмыг давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаатай уялдуулан авч үзэх нь зүйтэй. Эрүүгийн хэргийн шүүхийн мэтгэлцээн нь харилцан эсрэг сонирхол бүхий яллах болон өмгөөлөх талуудын хооронд өрнөж хэргийн бодит байдлыг тогтооход оршдог. Эсрэг сонирхол бүхий талууд хуралдаанд заавал оролцож үндэслэлээ дэвшүүлэх нь мэтгэлцээний урьдач нөхцөл. Үндэслэлд, хэрэгт ач холбогдолтой гэж үзсэн бүхий л баримт сэлтийг талууд шинээр гаргах, түүнд тулгуурлаж нотолгоо хийхийг зөвшөөрдөг.

Мэтгэлцэх зарчим шүүхийн гүйцэтгэх үүргийг тодорхойлдог гэж дээр дурьдсан. Тухайлбал, эрх тэгш байдлыг мэтгэлцээний нөхцөлд хангаж байх үүргийг шүүх хариуцна. Түүнийг хэрэгжүүлэх үндсэн арга нь шүүх хуралдааны дэгийг сахиулах, хуулиар тогтоосон хуралдааны журмыг баримтлах, хуралдаанд оролцогчдын эрхийг бодитой эдлүүлэх нөхцлийг бүрдүүлэх явдлаар илэрнэ. Гэвч эрх тэгш байдлыг тэгш эрхээс заагласан үзэх нь зөв болов уу? Учир нь эрүүгийн хэргийн хувьд эрх тэгш байдал нь шүүхийн төдийгүй шүүхийн өмнөх шатнаас тодруулбал, гэмт хэрэгт сэжиглэгдсэн үеэс нотлох баримт бүрдүүлэх, байцаан шийтгэх тодорхой ажиллаганд оролцох, санал, гомдол гаргах зэргээр байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдоос Эрүүгийн байцаан

шийтгэх хууль төдийгүй үндсэн хууль бусад холбогдох хуулиар олгогдсон боломжоо хэрхэн бодитой хэрэгжүүлж байснаар хэмжигддэг өргөн хүрээтэй цогцолбор асуудал. Тэгш эрхийг явцуу утгаар нь тодорхой байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эдэлж буй эрх гэж үзвэл, Жишээ нь шүүх хуралдаанд яллах болон өмгөөлөх талууд нь нотлох баримтыг шинжлэн судлах, яллах болон цагаатгах талын баримтыг танилцуулах, гаргаж тавих, эсрэг баримтыг үгүйсгэх зэргээр мэтгэлцэх, үг хэлэх, санал гаргахдаа хэн нэгнээсээ ялгаварлагдахгүй ижил нөхцөл эдэлж байгаагаар тодорхойлогдох учиртай. Үндсэндээ эрх тэгш байдал нь тэгш эрхийг ямагт агуулж байдаг өргөн хүрээтэй ойлголт. Товчдоо "эрх тэгш байдал нь он цаг, орон зайн адилсал, боломж бололцоо, бодит үйлдлийн ижилсэл" хэмээн хэлхэж болом.

Давж заалдах шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ шүүхийн тогтоол хууль ёсны болон үндэслэлтэй эсэхийг хэрэгт авагдсан баримтын хүрээнд хянадаг нь тус шүүх нь эрүүгийн хэргийг бус анхан шатны шүүхийн шийдвэрийг авч үздэгийг харуулна. Үүнээс үзвэл анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны эсэхийг хянах ажиллагаанд яллах болон өмгөөлөх талууд заавал мэтгэлцээний тал болон орохыг шаардахгүй тул давж заалдах шатны шүүхэд улсын яллагч, өмгөөлөгч оролцох эсэх нь хэрэг дээрээ сайн дурын асуудал болдог. Иймд давж заалдах шатны шүүхэд яллах болон өмгөөлөх талуудын хооронд эрүүгийн хэргийн гэм буруугийн асуудлаар мэтгэлцээн явагдахгүй. Давах болон хяналтын шатны шүүх хуралдаанд талууд оролцохыг хуулиар хориглоогүй бөгөөд тэднээс тухайн шатны шүүхэд гарган тавьж буй асуудал нь эрүүгийн хэргийн бодит байдал гэм буруугийн асуудлаар бус гагцхүү анхан шатны шүүхийн дүгнэлт, үйл ажиллагааны талаар санал бодлоо танилцуулж буй хэлбэр юм. Учир нь давж заалдах шатны шүүхийн хянан хэлэлцэж, шийдвэр гаргах эрх хэмжээг хуулиар хязгаарлан тогтоож[7] өгсөн гол оролцож буй талууд зөвхөн тэр хүрээнд л асуудал дэвшүүлэх эрхтэй. Иймд давж заалдах шатны шүүх хуралд тэдгээр талуулыг яллах болон өмгөөлөх тал гэж үзэх нь утгагүй болдог тул эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд мэтгэлцэж буй арга хэлбэрийг давж заалдах шатны шүүхэд байдаг мэтээр төөрөлдөх нь зохимжгүй юм.

Анхан шатны шүүхээс эрүүгийн хэргийг хянан хэлэлцсэний эцэст шүүхийн шийдвэр шийтгэх болон цагаатгах тогтоол хэлбэрээр гарна. Хэргийг хянан хэлэлцэх явцад гэмт хэрэг гараагүй, гэмт хэргийн бүрэлдхүүнгүй, шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй бол шүүх цагаатгах тогтоол гаргана. Шүүх цагаатгах шийдвэртээ шүүгдэгчийг яллах үндэслэл болж байсан баримт хэрхэн няцаагдсан, цагаатгах үндэслэл болж байгаа нөхцөл байдал юугаар нотлогдож байгаа зэргийг тодорхой ойлгомжтой бичих шаардлагатай. Олон улсын гэрээ хэлэлцээр болон дотоодын хууль тогтоомжноо гэм буруугүйн зарчмыг олонтоо тодорхойлсон.[8] Гэм буруугүйд тооцох зарчмын үүднээс шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хэнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй гэж үздэг. Үүнээс үзвэл гэм буруу зөвхөн шүүхээр тогтоогдох, гэм буруу шийтгэх тогтоолд тусгагдахыг нотолж байна. Цагаатгах тогтоолын талаар "Шүүгдэгчийн гэм буруугүй болохыг нотолсон шүүхийн шийдэл"[8] гэж тодорхойлжээ. Цагаатгах гэх томъёолол нь буруутай гэх эргэлзэлгүй буруугүй болохыг тодорхойлсон тэр тусмаа ЭБШ ажиллагааны хувьд албан ёсоор буруутай гэж үзэгдсэн эргэлзэлгүй албан ёсоор буруугүй болохыг тодорхойлсон процессын хэлбэр болно. Үүнээс үзвэл гэм буруу нь зөвхөн шүүхээр тогтоогдсон гэсэн атлаа анхан шатны шүүхээс цагаатгах тогтоол гарна гэдэг нь тун ойлгомж муутай байгаа хууль тогтоогчид цаашид анхааралдаа авах нь зөв биз. Учир юу гэвэл шүүхийн өмнөх шатанд гэм буруу тогтоогдоогүй атал чухам юуг цагаатгаад байгаа нь тодорхойгүй. Зүй нь анхан шатны шүүхээр шүүгдэгч гэмт хэрэгт холбогдолгүй болох нь тогтоогдвол зөвхөн хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргах нь гэм буруугүйд тооцох зарчимд илүү нийцтэй санагдана. Харин давах, хяналтын шатны шүүхээр болон шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас анхан шатны шүүхээр хэргийг дахин хянан хэлэлцээд гэмт хэрэг болох нь тогтоогдоогүй бол цагаатгах шийдвэрт хүрэх нь цагаатгалын жинхэнэ мөн чанарыг агуулах биз. Энэ мэтчилэн санал болгох, хуваалцах олон зүйл бий хэдий ч эцэст нь шүүхийн гүйцэтгэх үүрэг мэтгэлцэх зарчим болон гүүнийг тодорхойлоход, нөгөө талаас мэтгэлцэх зарчим нь шүүхийн үүргийг тодорхой болгоход ач холбогдолтой юм гэдгийг л ойлгож үлдсэнээ хуваалцъя.

НӨАТ-ЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАВ

2009 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан боллоо. Энэхүү хуралдаанаар Иргэний хуулийн "Эдийн болон эдийн бус баялгийн эрх" дэд хэсгийн 10, 11, 12 дугаар бүлгүүдийн зарим, зүйл заалтыг тайлбарлалаа.

Иргэний хуулийн 10,11 дүгээр бүлгүүдэд эдийн болон эдийн бус баялгийн эзэмшлийн харилцаа, 12 дугаар бүлэгт өмчийн харилцааны нийтлэг үндэслэл болон өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох, түүнчлэн гэр бүлийн хөрөнгийн эрхийг зохицуулсан байдаг аж.

Иргэний хууль 2002 онд шинэчлэгдэн батлагдсанаас хойш албан ёсны тайлбар хараахан гараагүй байсан. Энэ тайлбар нь дээрх хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Мөн дээрх хуралдаанаас НӨАТ-ын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлав.

www.legalinfo.mn сайтаас

7. Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 317, 318, 319, 320 дугаар зүйл.
8. С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг". УБ., 2007 он, 575 дахь тал.

ХЭН ДОР ЭРХ БАЙНА, ТҮҮН ДОР ХИЛЭНЦ БИЙ

Монгол улсад анхны дагнасан шүүх болох Захиргааны хэргийн шүүх байгуулагдаад даруй 5 жил болсон байх ба энэ шүүх байгуулагдсан үйл явц нь эрх мэдэл хуваарилах, хууль дээдлэх зарчимтай шууд холбоотойг хэлэхэд илүүдэхгүй байх. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар төр, иргэн хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байна гэсэн заалтыг амьдралд хэрэгжүүлэх үндсэн зохицуулалт нь захиргааны хэргийн шүүхээр дамжин биелэлээ олох учиртай.

Захиргааны байгууллага бол зөвхөн сонгуулиар биш Захиргааны хэргийн шүүхээр, эрх зүйн үүднээс, хуулийн шалгуураар үнэлүүлдэг шинэ үе шатанд бид нэгэнт ирээд байна.

"Захиргааны хэргийн шүүхээр төр өөрийн сэтгэл зүрхээ иргэндээ нээдэг" гэж Германы нэрт эрдэмтэн доктор, профессор Ю.Харбих хэлснийг иш татахад таатай байна.

Захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллага, албан тушаалтны нэр хаягаар ирж байгаа өргөдөл, гомдол, шүүмжлэлтэй дуу нийлүүлэн хавтгайд нь буруутгах санаа агуулаагүй, агуулах ч үгүй. Хуулийн дагуу шударгаар үүргээ гүйцэтгэж байгаа хэн боловч шийдвэр үйл ажиллагаа нь захиргааны шүүхээр баталгаажиж, хууль зөрчсөн албан тушаалтан нь зохих хариуцлага хүлээж, бусдын зөрчигдсөн эрхийг сэргээж байх нь шударга ёсонд нийцсэн үйл ажиллагаа юм.

Нийтийн засаглалын байгууллага, түүний албан тушаалтнууд үнэхээр хууль зүйн дагуу үйл ажиллагаа явуулсан бол Захиргааны хэргийн шүүхээр асуудлаа шийдвэрлүүлэхэд эмзэглэх зүйл байхгүй.

Өвөрхангай аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч П.Соёл-Эрдэнэ

Гэтэл өнөөгийн байдалд шүүх дуудлаа гэж бухимдаж, дахин дахин дуудуулж чирэгдэл учруулдаг, шүүхийг үл хүндэтгэж, иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг шүүрэн авч хэрэг үүсгэлээ гэж захиргааны шүүхийг ямар ч хуулийн үндэслэлгүйгээр буруутгадаг, иргэн өргөдөл, гомдол гаргах эрхийг өөрийн хувийн араншингаар ойлгодог, өөрийн нэр төр, алдар хүнд, хувийн ашиг сонирхлыг нэгдүгээрт тавьдаг ухамсаргүй байдал гаргадаг албан тушаалтнууд цөөнгүй байна.

Иргэд захиргааны байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх, шүүхэд нэхэмжлэл гаргах нь эрх зүйт төрд байдаг л хэвийн үзэгдэл гэдгийг яс махандаа шингэтэл ойлгож, хүлээн зөвшөөрөх нь чухал байна.

Түүнчлэн захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргалаа гэж иргэнийг заналхийлж, утсаар болон биечлэн дуудаж, тэр захиргааны шүүхээрээ хийлгэхгүй юу, тэр хамгаалдаг шүүхээсээ ав гэх мэтээр аашилж загнаж, заналхийллэг, өш хонзон санадаг эрх мэдэлтнүүд байна. Ийм үйлдэлтэй захиргааны хэргийн шүүх огт эвлэрэхгүй бөгөөд эдгээр албан тушаалтанд хуулийн хариуцлага хүлээлгэх эрх бидэнд бас байгаа гэдгийг анхааруулъя.

Сүхбаатар жанжныхаа "Төрөлхийн араншингаар байж болохгүй шүү. Төрийн нэрийн өмнөөс ажилла" гэсэн үгийг захиргааны байгууллага, албан тушаалтнууд санадаг л байлгүй.

Төрийн албаны мөн чанар нь ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээр захиргааны байгууллага, албан тушаалтны хуулийн дагуу гаргасан шийдвэр, үйл ажиллагаа нь баталгаажиж байдаг гэдгийг дахин дурьдмаар байна.

Захиргааны байгууллага, албан тушаалтнууд нь орон нутгийн хөгжлийг өөрчилж чадах, бүтээлч үйл ажиллагаа явуулах боломж бололцоотой байдаг, тийм ч байх ёстой. Тухайлбал хог хаягдалгүй орчинд амьдрах, байгаль орчныг хамгаалах, хүүхдүүд нь сайн багшаар хичээл заалгаж, сурсан эрдмээр аль ч улсын иргэдээс дутахгүй байх, сайн эмчээр эмчлүүлэх, эмчлүүлж байгаа эмчийнхээ мэдлэг чадварт итгэх зэрэг сэтгэл ханамжийн олон асуудлыг шийдэх эрх, бололцоо та бүхэнд байна.

Гагцхүү энэ олон талт үйл ажиллагаа явуулахдаа гаргаж буй шийдвэр, үйл ажиллагаа тань хуульд нийцсэн байхаас гадна хийх ёстой зүйлээ зохих ёсоор хийж гүйцэтгэх нь төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим, хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлэх гол нөхцөл нь болох юм.

Захиргааны хэргийн шүүхийн хувьд аливаа маргааныг шийдэхдээ гол баримталлаг зүйл бол төрийн албаны үндсэн зарчмыг хэрхэн

хэрэгжүүлсэн тухай шалгадаг.

Шүүхийн практикаас харахад Захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргаж байгаа түгээмэл алдаа нь төрийн албаны үндсэн зарчмыг зөрчсөнтэй шууд холбоотой байх ба цаашид энэ алдааг давтахгүй байх үүднээс эдгээр алдааны талаар товч дурьдья.

Хууль дээдлэх, тэгш хандах, төрийн алба тогтвортой байх, залгамж холбоотой байх, мэдэгдэх ба сонгох, шийдвэр үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод байх зэрэг зарчмыг алдагдуулдаг үйлдэл их байна.

Аливаа шийдвэр гаргахдаа хуулийн заалтыг үл харгалзах, түүнчлэн адилхан эрхтэй иргэдэд заримд нь үндэслэлгүйгээр давуу эрх олгож, дэмжин туслах, заримыг нь үндэслэлгүйгээр эрхийг нь хязгаарлах алдааг санаатай буюу санамсаргүй гаргадаг явдал нилээд байна.

Төрийн албыг хэн хашиж байгаагаас үл хамаараан төрийн алба нь тогтвортой, залгамж шинж чанартай байхад түүнийг үл мэдэн, эрх залгамжлан авсан этгээд буюу шинээр ажилд томилогдсон хүн нь би энэ асуудлыг хариуцахгүй, өмнө нь ажиллаж байсан хүний ажил гэж андуу ташаа бодож, хүнийг чирэгдүүлдэг, гүйцэтгэх ёстой үүрэгээ хэрэгжүүлдэггүй эс үйлдэхүй байсаар байна.

Мөн мэдэгдэх ба сонгох зарчмыг захиргааны байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэхгүй байна. Аливаа шийдвэр гаргахаас өмнө эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдэд энэ тухай мэдэгдэх, түүнд өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах боломж олгох, түүний дараа хэрхэн яаж шийдсэнээ эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдэд мэдэгдэх үйлдлийг тогтмол хийж хэвшээгүй байна. Энэ асуудал нь ялимгүй зүйл гэж зарим албан тушаалтан бодож болох ч үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэдийн эрхээ эдлэх боломжийг олгох чухал нөхцөл болох бөгөөд хүний эрхийг дээдлэх, цаашилбал иргэдээс төрд итгэх итгэлийг төрүүлдэг юм.

Төрийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх нь олон нийтэд захиргааны байгууллага өөрийн ажлыг хэрхэн явуулж буйг ажиглах боломжийг олгодог. Гэтэл явуулж буй үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрээ олон нийтэд мэдээлдэггүй, зөвхөн албан тушаалын хүрээнд явцуу хандлагатай, хэл ам ихтэй хүн гээд ялгаж харьцдаг дутагдал түгээмэл байгаагаас гаргасан шийдвэрийн үндэслэлийг буруу ойлгож, захиргааны шүүхэд хандах явдал ажиглагдаж байна.

Түүнчлэн иргэд, өргөдөл гомдлоо амаар болон бичгээр, цаашилбал цахим сүлжээгээр дамжуулан гаргах эрхтэй хуулийн заалт байсаар байтал амаар гаргасан өргөдлийг шийдэггүй, зүгээр л сонсоод өнгөрдөг, тусгай бүртгэлд бүртгэдэггүй, "нэг тийм мэрхүү зүйл амаар яриад байсан, надад албан ёсоор өргөдөл гаргаагүй" гэж хуульд байхгүй шаардлага тавьж, амаар гаргасан өргөдлийг өргөдөл биш гэж үздэг томоохон дутагдал байна.

Төрийн эрх мэдлийг ёс зүй, улс төрийн хувьд шалгарсан мэргэжлийн хүмүүс л хэрэгжүүлнэ. Төрийн албыг төрийн хэргийн мэдлэг мэргэшилтэй, хэсэг бүлэг биш ард түмний нийтлэг эрх ашгийг хамгаалдаг, өндөр нэр хүнд, ёс суртахуунтай, албан хаагч л хэрэгжүүлнэ. Иймд захиргааны байгууллага, албан тушаалтнууд эрх зүйн ухамсар, өөрийн мэдлэг, мэргэшлээ тавигдаж буй шаардлагыг хангахуйц хэмжээнд хүргэж ажиллах явдал маш чухал байна.

"Хэн дор эрх байна, түүн дор хилэнц бий" гэдэг ардын зүйр үгийг санацгаая. Хүний эрх, эрх чөлөөг бусад иргэд, эсхүл төр зөрчдөг. Гэхдээ бусад иргэдийн хувьд хүний эрхийг зөрчих орон зай нь хязгаарлагдмал байдаг бол төрийн хувьд энэ орон зай маш өргөн байдаг бөгөөд төр нь эрх мэдэлтэй байдгаараа иргэдээс ялгаатай. Иймч учраас төрийн болон захиргааны албан тушаалтан хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулах ёстой бөгөөд хуулиар зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглосон байдгийг ямагт санаж явах ёстой.

Төрийн албан хаагч нарт зөвшөөрөгдсөнөөс бусдыг хориглоно. Иргэний хувьд хуулиар хориглоогүй болгоныг зөвшөөрнө гэсэн эрх зүйн үндсэн онолоор иргэн ба захиргааны байгууллагын харилцан хамаарал тодорхойлогддог.

Захиргааны хэргийн шүүхээс иргэдээс гаргасан гомдлыг хэрхэн шийдсэн талаарх 2008 оны улсын хэмжээний тоон мэдээллийг хүргэвэл нийт нэхэмжлэлийн 37%-ийн нэхэмжлэлийг хангаж, захиргааны актыг хүчингүй болгосон, 24%-ийн нэхэмжлэлийг хангаж, захиргааны байгууллагаас гаргасан актыг илт хууль бус гэдгийг хүлээн зөвшөөрсөн, 32%-ийн нэхэмжлэлийг хангаж, хийх ёстой үүргээ биелүүлээгүй болохыг тогтоож, гаргавал зохих захиргааны акт гаргахыг даалгасан, 7%-ийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, захиргааны шийдвэр хууль зүйн үндэслэлтэй байна гэсэн шийдвэр гаргасан байна. Үүнээс үзэхэд төрийн албан тушаалтнуудын гаргаж буй шийдвэр үйл ажиллагаа тухай бүр хуульд нийцэхгүй, иргэдийн эрх, ашиг сонирхлыг ямар нэг хэлбэрээр зөрчиж байна гэж үнэлэлт өгөхөөс өөр аргагүй байгаад цаашид анхаарч ажиллахыг сануулмаар байна.

Иргэд олон түмэндээ үйлчлэх нь юугаар ч сольшгүй эрхэм нандин зүйл билээ. Хууль дээдлэх, хуулийг сахин хэрэгжүүлэх явдал нь төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагын үндэсэн шалгуур байх ёстой.

ӨМЧЛӨХ ЭРХ БА ӨМЧИЙН МӨН ЧАНАРЫН АСУУДАЛД

Пензийн улсын багшийн их сургуулийн эрх зүй, төрийн онолын тэнхимийн профессор, хууль зүйн шинжлэх ухааны дэд эрдэмтэн Борис Николаевич Алейников

Өмч болон өмчлөх эрх нь нийгэм болоод хувь хүний амьдрал, үйл ажиллагаанд онцгой байр суурь эзэлдэг нь нийгмийн шинжлэх ухааны төлөөлөгчдөд ердийн ойлгогддог ба маргаан үүсгэх нь ховор байдаг. Гэхдээ энэ нь эдгээр категорийн шинж гол чанарын тухай ойлголт олон янз байдагтай холбоотойгоор янз бүрээр тайлбарлагдана. Иймээс бид ч гэсэн өмчлөх эрх ба өмчийн мөн чанарын асуудалд хандая. Зөвлөлт засгийн үед марксист-ленинист онолд үндсэлсэн эрх зүйн шинжлэх ухаан нь өмчийг эдийн засгийн категори гэж уламжлал ёсоор үзэж байсан. Эдийн засгийн детерминизмийн үзэл санаа нь тодорхой хэмжээгээр оросын иргэний эрх зүй дэх өмчийн тухай номлолыг хөгжүүлсэн иргэний эрх зүйчдийн байр суурийг тодорхойлж байсан юм.

Өнөө үед ч ихэнхи эрдэмтэд өмчлөх эрхийг задлан шинжлэхдээ өмчийг эдийн засгийн уг гарал дээр үндэслэдэг. Энэ учраас Ю.К.Толстойн хэлснээр "Өмчлөх эрхийг зохицуулж буй эдийн засгийн харилцааг тодруулахгүйгээр өмчийн мөн чанарын асуудал шийдвэрлэгдэхгүй. Эрдэмтэн энэхүү байр суурыа В.П.Шкредовтой мэтгэлцэн <<Өмчийн эрх зүйн тухай номлолд>> гэсэн бүтээлдээ хожим нь бататгасан байдаг. Мөн Е.А.Суханов өмчийг тодорхойлхдоо "Энэ бол эрх зүйн ухагдахуунд багтах эдийн засгийн тодорхой харилцаа юм" гэж бичсэн байдаг. Харин В.П.Камишанский өмчийг тодорхойлхдоо "Энэ нь аливаа этгээд өөрийн гэж үзэж байгаа материаллаг баялагийг өөрийн болгосон, мөн эдгээрийг бусдад шилжүүлэхэд (отчуждение) чиглэсэн эд зүйлсийн талаарх субьектуудийн хоорондох нийгмийн харилцаа юм. Өмчийн эдийн засгийн харилцаа аль ч нийгмийн материаллаг үндсийг бүрдүүлж байдаг" гэж үздэг. "Өмч нь олон талт нийгмийн харилцааны нэг бөгөөд иргэний эрх зүйн зохицуулалтад ордог. Түүний харилцааны үндэс нь иргэний эрх зүйн субьект эд зүйлст өөрийн гэсэн хандлагатай байхад оршино" эж Л.В.Щенникова тэмдэглэсэн байдаг. Бусад цивилистууд ч гэсэн ижил байр суурьтай байдаг. Үндсэн хуулийн эрх зүйд өмчийн мөн чанарын асуудал анхаарал тавьсаар байна. Тухайлбал, В.Д.Мазаев үндсэн хууль болон өмчийн ойлголтыг авч үзэхдээ, өмчийг эдийн засгийн харилцаа гэж ойлгон тайлбарласан байдаг. Өмчийг материалаг баялагийг өөрийн болгох, шилжүүлэх нийгмийн харилцаа болох эдийн засгийн өвөрмөц үзэгдэл гэсэн ойлголт эдийн засгийн ном зохиолд зонхилох байр суурийг эзэлдэг. Харин сөрөг үзлийг В.П.Шкредов "Өмчийг нээх гэсэн эдийн засагчдийн оролдлого нь эрх зүйн үзэгдлийг эдийн засгийн үзэгдэлд хүргэж байна" гэж нэгэнтээ үнэмшилтэйгээр харуулсан байдаг. Эрх зүйч эрдэмтдийн хоёр дахь бүлэг нь өмчийн мөн чанарын талаарх зарчмын өөр байр суурьтай байдаг. Тэнд С.С.Алексеев, В.П.Павлов, К.И.Скловский нар багтдаг.

С.С.Алексеев өмчийн мөн чанарыг <<Өмч нь өөрийн эхлэл мөн чанараараа хүний хувьд "өөрийн", "хувийн" бөгөөд хүн эд зүйлсэд өөртэйгөө адилхан ханддаг>> гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, эд зүйлс дэх хүний үргэлжлэл, түүний орших байгалын болон бусад ашиг сонирхлын бэрхийг даван туулах нөхцөл хүчин зүйлс болж буй гадаад эд юмсыг захирах хувийн ноёрхол, туйлын болон онцгой эрх мэдлийн үргэлжлэл мэт ойлгодог. Хамгийн гол нь бас нэг хүчирхэг "гараараа" эсхүл "хүний биеийн хэсгүүдээр", түүний ахуй (зүйрлэж хэлбэл "түүнйи биеийн") илүү тодруулбал, шаардлагатай нөхцөл бүрэлдсэн тохиолдолд түүний биеийн боломжийн хэрэгсэл, оюун ухаан, ур чадвар, идэвхи, чадварын үргэлжлэл мэт юм>>.

Энэхүү тодорхойлолт нь бидний үзэж байгаагаар эдийн засагчид, хуульчдын уламжлалт үзэл баримтлалаас ялгагдаж байгаа үндсэн зүйл бол өмчийг эд зүйлс дэх хүний үргэлжлэл гэдэг тодорхойлолт юм.

К.И.Скловский нь: өмч (өмчлөх эрх) нь эдийн засгийн харилцааг шууд тусгадаггүй (сүүлчийнх байгаа ч гэсэн) гэж үздэг. Түүнийхээр өмч ба өмчлөх эрх нь ижил ойлголт, өмчид хувь хүний шинж чанарууд илрэлээ олдог ба өмч нь эд зүйлс дэх хувь хүний бүрэн биелэл юм.

В.П.Павлов: "Эрхийг субьектив утгаар нь хуульчид амьдралын баялагт хамааруулдаг. Өмчийн чухал шинж чанарыг

түүний тээгчийн (носитель) хувийн шинж чанарт хайж, түүнийг тодорхой өмчийн шинж тэмдэгээр тодорхойлогддог эд зүйлстэй харьцах тодорхой хүний арга барил, дадлын цогц юм" гэжээ. Зохиогч өмчийг хувь хүний салшгүй тодорхойлолт болох амьдрал, нэр төр, алдар хүндтэй адил тодорхойлж байна. Эрх зүйн үйлчлэлд өмч өөрөө биш, харин тодорхой эд зүйлстэй харьцах өмчлөгчийн үйлдэл хэлбэрээр илэрсэн илрэл ордог. Ингэхээр өмчийн илрэл нь эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг өмчлөгчийн эд зүйлтэй харьцаж байгаа бодит үйлдэл юм. Эдгээрийг В.П.Павловын тодорхойлсноор эд зүйлсийн бүрэлдэхүүн гэж нэрлэдэг. Эзэмших, ашиглах, захирамжлах болон тэдгээрийн хослуулалт нь "хэсгийн өмчлөгчийг нэгтгэх хэлбэр болон үүнээс гадна эд юмст хамаарах "хэсэгчилсэн эрх" эзэмшигч этгээдүүийг нэгтгэх хэлбэр гэж тодорхойлдог. Энэ шалтгаанаар хувийн, төрийн, орон нутгийн өмчийн олон төрлийн эрх зүйн дэглэм нь өмчийн хэлбэрийн талаар өгүүлж байна гэж үзэж болохгүй. Зохиогчийн дурдснаар өмчийн илрэлийн хэлбэр дор тодорхой эд зүйлсийн талаарх үйл ажиллагаанд этгээд тус бүрийн тодорхой оролцоогоор тодорхой үйл ажиллагаанд олж авсан дадлын үндсэн дээр тодорхойлогддог ба бүх оролцогчид үүнийгээ гэрээгээр баталгаажуулсан байна.

В.К.Андреев, К.И.Скловский, В.П.Павлов нар дээрх байр суурийг шүүмжилж "ОХУ-ын Үндсэн хуульд заасан улсын, орон нутгийн өмчийн хэлбэрээс бусад хэлбэрүүд байдгийг тооцоолоогүй байна гэжээ. Түүний саналаар бол эд зүйлсэд хувь хүний туйлын үргэлжлэл бүюу улсын (орон нутгийн) ба хуулийн этгээдийн өмчид хэрэглэх хувь хүний салшгүй шинж чанарыг талаар ярьж болох уу. Мөн арга зүйн хандлага ч түүний дургүйцлийг хүргэж байна.

"Гүн ухааны болон сэтгэл зүйн категоруудыг ашиглаж болно. Гэхдээ зөвхөн эрх зүйн үйл ажиллагаа-хууль тогтоомжийг танин мэдэх түвшинд байна. Өмчлөх эрх ба түүний хэлбэрүүд нь угтаа гусгай, бие даасан үйл явц юм" гэж В.И.Андреев үзжээ.

Бидний үзэж байгаагаар В.И.Андреевын дээрх шүүмжлэл нь бүрэн үндэслэлтэй биш юм. К.И.Скловский, В.П.Павлов нар өмчийн мөн чанарыг илрүүлэхдээ өмчийг ерөнхийд нь түүний онцгой шинж чанарыг бүрэн хэмжээгээр нь авч үзэж байна. Энэ нь хувийн өмч шүүдээ. Ном зохиолд энэ талаар "өмчийн аль ч төрөл хэлбэр тодорхой нөхцөлд нийгэмчлэлийн түвшин ямар өндөр байсан ч...хэн нэгэн нь үй двэрлэлийн нөхцөл, бүтээгдэхүүнд өөрийн юм шиг хандах, хэн нэгэн нь хүний юм шиг хандах нөхцөлд оршин тогтнох билээ" гэж зүй ёсоор тэмдэглэжээ. Үүнгүйгээр өмч гэж байхгүй. Энэ байр сууринаас бол өмчийн аль ч хэлбэр нь хувийн юм".

Өмчийн мөн чанарыг ойлгох манай хандлага "өмч" ба "хувийн өмч" гэдэг нь утга ижил гэдэг дээр үндэслэсэн.

"Үүний хамт хувийн гэж тайлбарлагдаж буй өмчийн бусад хэлбэрээс төрийн өмч онцгойрон ялгарч байдаг" гэж С.С.Алексеев үндэслэлтэйгээр бичсэн байдаг. Энэ нь ерөнхийдөө өмчийн (зөвхөн бус хэмжээгээр) тодорхой шинж чанарыг хачирхалтайгаар төрийн засаглал "өмч" гэдэг нэрийн дор эзэрхэг ноёрхлыг тогтоох боломжтой нэгддэг шалтгаанаар онцгой байр суурийг эзэлдэг. Бусад өмчийн хувирал, салбарлалын хувьд (хуулийн этгээдийн өмч, орон нутгийн өмч) тэдгээр нь дээр дурдсан хоёр төрөлд хуваагддаг" гэж зүй ёсоор тэмдэглэсэн байна.

В.К.Андреевын өмчийн судалгаанд гүн ухааны категоруудыг хэрэглэж болохгүй гэсэн байр суурийн хувьд К.И.Скловский учир шалтгааныг "Хөгжөөгүй эрх зүй, өөртөө болон өөрийн үндсэнд итгэлгүй учраас оюун санаанд хандах болдог ба өөрийн чадалд үнэмшихийн тулд тогтоогүй хязгаараас гарах явдал юм" гэсэн нь үнэн юм. Орчин үеийн байдал олон асуудлыг авч үзэхэд хэсэг хугацааанд шаардлагатай байх эрх зүйн гүн ухааны ач холбогдлыг урьдаас тогтоож байна" гэжээ. Эрх зүйн болон эдийн засгийн ном зохиолд өмч нь эдийн засгийн харилцаа гэсэн уламжлалт ойлголтын дагуу хуульч эрдэмтдийн байр суурь ч өмчлөх эрхийн утга учрыг өмчийн эдийн засгийн харилцааг баталгаажуулах эрх зүйн хэлбэр гэж үздэг. Ингэхлээр дээрх байр суурийн дагуу өмчийн мөн чанар ба өмчлөх эрх нь өөр өөр мөн чанартай юм.

А.Е.Черноморец эдгээр ойлголтыг салгах нь зүйтэй гэж үзэж байна. В.П.Павловын саналаар энэ нь үндэслэлтэй гэжээ.

Зарчмын өөр байр суурийг К.И.Скловский баримталдаг. Тэрээр өмч ба өмчлөх эрх нь нэг мөн чанартай, энэ нь бие хүний шинж чанарт ордог бөгөөд чухам энэ нь бусад эрх зүйн категоруудаас өмчийн тэргүүлэх үүргийг тодорхойлдог.

Авч үзэж байгаа асуудлын судалгаанд С.А.Зинченко, И.С.Бондарь нар бүтээлдээ "өмч", "эрх чөлөө", "эрх зүйн" категоруудыг үзэл баримтлалын үүднээс, тэдгээрийн хооронд түүхийн, генетикийн, учир зүй-бүтцийн холбоо тогтоож авч үзсэн нь сонирхолтой хандлага байгаа юм. Зохиогчид өмчийг эд

зүйлсийн хэлбэрээс хүнийг аажмаар чөлөөлөх, түүнийг (хүнийг) эдийн засгийн, нийгмийн, оюуны эрх чөлөөний (оюуны үйлдвэрлэл, иргэний эрх чөлөө, нийгмийн баялаг) системд хамааралтай болгох шилжүүлэх механизмаар харуулсан байна.

Өмч нь хүний амьдрал, эрх чөлөө, эд хөрөнгийг багтаасан үнэт зүйлс, эрх чөлөөт хүн өмчийн үндсийг бүрдүүлдэг үзэл санаа гэсэн Джон Локкын хандлагын үндсэн дээр эрдэмтэд томъёолол гаргаж, үүний дагуу хүмүүс өмчийн эзэн болж, байгалийн юмсыг эзэмшиж, тэд хөдөлмөрийн эд зүйлсийн үр дүнг өөрийн болгох чадвартай. "Яагаад гэвэл тэд эрх чөлөөтэй (хүсэл зоригийн эрх чөлөөтэй) үүнийн үндсэн дээр тэд өөрийн амьдралын, өөрийн хувь хүний эзэн юм" гэсэн дүрэм боловсруулжээ. Өмчийн мөн чанар болсон өмчлөх эрхийн талаар яригдсан төрөл бүрийн санаануудад дүн шинжилгээ хийж үзэхэд эдгээр нь ямар нэг хэмжээгээр нааштай хувь нэмрийг авч үзэж буй асуудлын судалгааND оруулсан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Гэхдээ аль нэгийг нь бүрэн хүлээн зөвшөөрч болохгүй.

Бидний үзэж байгаагаар "өмч", "өмчлөх эрх" гэдэг категоруудын мөн чанарыг хувь хүний шинж чанарт хайх хэрэгтэй гэсэн хандлага нь илүү үндэслэлтэй юм. Энэ хэсэгт К.И.Скловский, В.П.Павлов нарын байр суурийг бид дэмжиж байна. К.И.Скловский "Хэрвээ өмч нь эдийн засгийн утгаараа хамгийн гүн, хамгийн нуугдмал үндсэн, суурь харилцааны хувьд болон тийм байдлаар оршиж буй бол тэрээр хэзээ ч хууль зүйн дүрээрээ, эсхүл бидний өмнө бие даан бий болохгүй ба хэн ч урьд өмнө нь ямар нэгэн эдийн засгийн юмс үзэгдэл, эсхүл зохицолыг илруулж, түүнийг өмчийн үзэгдэл үзэгдэл болгон таниж чадаагүй" гэж бичжээ.

Цааш нь "Хэрвээ өмчийн мөн чанарыг өмчлөгчийн (гурамсан) эрх мэдэлд хайх нь утгагүй бол өөр зүйлд хандах нь зүйтэй"

В.П.Павлов мөн "Хэдийгээр өмч нь үүргийн хувьд материаллаг бус шинж чанартай, түүнчлэн баялагийн нэг төрөл болохын хувьд субьектив эрхийн гадуур оршдог учир энэ категорийн онцгой шинж чанарыг түүний тээгчийн хувийн шинж чанарт хайх хэрэгтэй" гэж баталсан байна.

Хууль зүйн ном зохиолд нэг бус удаа өмчлөх эрхийн мөн чанарыг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийн цогц гэж үзэж болохгүй гэж тэмдэглэсэн байдгийг анхаарах хэрэгтэй.

Үүнийг зөвшөөрөхгүй байх хэцүү. Учир нь, өмчлөгчийн буслад шилжүүлсэн эрх нь өөр эрх болдог. Аристотелийн хэлсэн эр өөртөө "өөрийн хэсэгт" эд зүйлсийн харилцааг яаж шилжүүлэх вэ. Мэдээж, ийм харилцааг зарчмын хувьд шилжүүлэх боломжгүй. Өмчлөгчийн хэрэгжүүлж байгаа эзэмшлийн хувьд янз бүрийн учир шалтгаан, зан үйлийн улмаас эзэмшил нь тухайлбал түрээслэгч юм уу хадгалагчаас тэс өөр юм.

Өмчийн мөн чанарыг илруулэх, хүний шинж чанартай холбон үзэх асуудалд оросын гүн ухаан ихээхэн хувь нэмэр оруулсан юм. "Өмч нь эд зүйлс дэх хувь хүний маш зохистой үргэлжлэл юм". "Өмчийн үндэслэл, зориулалт нь тодорхой хувь хүнд байдаг". "Нарийвчлан хэлбэл өмч нь зарим талаараа хувь хүний өөрийн шинж тэмдэг юм".

Гегелийнхээр бол хүн "өөрийн хүсэл зоригийг эд зүйлсэд оруулж, тэгснээр түүнийг өөрийн болгож өмчилдөг. Хүн бол "эрх чөлөөт, бүх нийтийн, хязгааргүй" юм. Цаашид энэ маягаар бодож "эрх чөлөө бол бурханы жишиг, дүр төрхөөр бүтээгдсэн аливаа нийгмийн үндсэн дотоод шинж чанар юм гэж үзвэл "өмчийн мөн чанар бол нийгмийн гишүүн-бие хүний үндсэн шинж чанарыг бүрдүүлэгч эрх чөлөө юм" гэсэн дүгнэлтэд хүрнэ.

Джон Локк: "Хүн бүр өөрийн өмчийг хамгаалах, өөрөөр хэлбэл, өөрийн амьдрал, эрх чөлөө, эд хөрөнгийг хамгаалах эрх мэдэлтэй байдаг. Эрх чөлөө бол бусад бүх юмны үндэс" гэж бичиж байсан. Гегель "Хийсвэр үлдэхгүйн тулд чөлөөт хүсэл зориг юуны өмнө өөртөө бэлэн ахуйг (наличное бытие) өгөх ёстой. Энэхүү ахуйн анхны мэдрэхүйн материал бол эд зүйлсийн мөн чанар, өөрөөр хэлбэл, эд зүйлс байх ёстой. Энэхүү эрх чөлөөний анхны төрлийг бид өмч гэж танина. Энэ утгаааа өмч бол "эд зүйлст хүсэл зоригоо шингээсэн явдал бөгөөд үүгээрээ хүн "өөрийн эрх чөлөөний гаднах байдлыг бий болгодог". И.А.Ильин өмчийн мөн чанарыг илэрхийлэхдээ "Хүн өөрийн амьдралаа эд зүйлсийн амьдралд оруулах (вкладывать) шаардлагатай. Энэ нь байгалиас зайлшгүй бөгөөд оюуны харилцаанд үнэ цэнэтэй. Хүний эзэмшил гол нь бус, харин түүний сэтгэл зүрх, хүсэл зориг болон түүний дотоод ертөнцөөс гарч буй ажил хэрэг" гэж бичсэн байна.

Эрх чөлөө болон өмчийн холбоог дүгнэн шинжлэнгээ Б.Н.Чичерин: "Хүрээлэн буй дэлхийд эрх чөлөөний анхны илрэл нь өмч юм" гэж батлан хэлсэн байдаг.

Манай орчин үеийнхний дунд өмчийн мөн чанар бол эрх чөлөө гэдэг байр суурийг баримтлагчдын дотроос эхний ээлжинд С.С.Алексеевыг нэрлэх хэрэгтэй. Тэрээр хүн төрөлхтөний үүсэл хөгжилд

өмчийн гүйцэтгэх үүргийг судлах явцдаа:"Энд гарааны үе бол өмчийн мөн чанар юм. Өмч-эрх чөлөө (идэвхтэй бүтээлч хэлбэрээрээ) хүний амьдралын шийдвэрлэх хэсэгт, эдийн засагт, мөн өдөр тутмын ажил хэрэг, амьдрал үйл ажиллагаанд оршдог гэж бичжээ.

Өмчийн мөн чанарыг идэвхтэй, бүтээлч хэлбэртэй эрх чөлөөгөөр дамжуулан тодорхойлохдоо, эрдэмтэн өмчийн шинж чанарын хэмжээнд дэвшилтэт зүйлээс гадна сөрөг тал болох: шунахай сэтгэл, хувиа хичээх, хуримтлалтай болох сонирхол болон бусад "адгуусны" төрөлд хамаарах зүйлүүд байдаг.

С.А.Зинченко, Н.С.Бондарь нар: "Өмч, эрх чөлөөг түүхэн үзэгдэл гэж үзэн, эрх чөлөөг өмчийн гол шинж, үндэс" гэж тодорхойлсон.

"Эрх чөлөө" гэдэг үгийн гарвал зүйг авч үзвэл "сво" гэдэг үг нь эртний энэтхэг, европийн үгийн үндэс юм. Энэ нь оросын "свобода"-эрх чөлөө гэдэг үгийн үндэс гэдэг нь ойлгомжтой. Энэ үгнээс "свой"(өөрийн) гэдэг үг гардаг. Эртний славян хэлэнд (XI зуунаас эртний орос) "собьство" гэдэг үг бий. Үгийн энэ үндсээс свойство (шинж чанар), сущность (мөн чанар), существо (гол утга), общность (нэгдэл), собственность (өмч) гэдэг үгнүүд гарсан. "Өмч", "эрх чөлөө" гэдэг үгнүүд нь нэг үндэстэй гэдгийг В.В.Колесов тэмдэглэсэн байдаг.

В.П.Павловын байр суурийн хувьд өмч нь эргэлзээгүй тодорхой этгээдийн хувь хүний тодорхойлолт болсон эд зүйлтэй харьцах арга барил (приём), арга (способ), (дадал)-ын цогц юм. Гэхдээ л өмчийн мөн чанарын хувьд дурдагдсан чанарууд нь хоёрдогч ба үүсмэл юм. Хэрэв Аристотелийнхоор өмчийг (эрх чөлөөг) хэдэн мөн чанар гэж авч үзвэл, "мөн чанар нь байгалийн хувьд харилцаанаас анхдагч, харилцаа нь болит байдлын хоёрдогч шинж чанар салаа мөчиртэй адил" болно.

Өмчлох эрхийн мөн чанарыг нээн илэрүүлэхээс өмнө хуулийн ном зохиолд өмч ба өмчлөх эрхийг ижил ойлголт гэж хүлээн зөвшөөрсөн байр суурь дурдагдсан байдгийг зайлшгүй тэмдэглэх хэрэгтэй.

Өмч болон өмчлөх эрхийн адилтгалын тухай К.И.Скловскийн байр суурийг бид урьд нь авч үзсэн. Энэ талаар С.С.Алексеев бичихдээ "Өмч нь харилцааг багтааж байдаг утгаараа өмчлөх эрх юм. Өмчлөх эрхгүйгээр болон бусад ямарч эрхгүй өмч нь аливаа оршин тогтнох утга агуулга, үндсээ алдана. Үүнтэй холбоотой, үндсэн бүрдэлтэй (эд зүйлс, түүнийг бүрэн эзэмших, эд зүйлстэй өөрийн мэт харилцах) зэрэгцэн багагүй ач холбогдолтой бас нэг үндсэн хэсэг нь түүний эрх зүйн бүрдүүлбэр юм.

Бидний харж байгаагаар "өмч" ба "өмчлөх эрх" гэсэн хоёр категорийг нэгтгэгч чанар болсон эрх чөлөө нь мөн чанарын шинж чанар, тодруулбал, хэрэв яг ийм эрх чөлөө нь өмчийн мөн чанарыг бүрдүүлж байгаа бол өмчлөх эрхийн мөн чанар нь эрх чөлөөний эрх зүйн хэлбэр, гуравдагч этгээдийн ашиг сонирхол эрх чөлөөнөөс хязгаарласан утга санааг хэрэгжүүлэх (хангах, баталгаажуулах) хэлбэрээр оршдог.

Энд Гегелийн "Чөлөөт хүсэл зориг нь эрхийн эхлэл цэг болдог. Тийм учраас эрх чөлөө нь түүний субстанци, тодорхойлолтыг бүрдүүлдэг ба эрх зүйн тогтолцоо бол хэрэгжсэн эрх чөлөөний (осуществленная свобода) ноёрхол" гэснийг хэлэх нь зохистой.

Иргэний эрх зүйн ном зохиолд ч эрх чөлөөг өмчлөх эрхийн мөн чанар гэж тэмдэглэсэн байдаг. Тэгэхээр М.В.Власова калифорнийн их сургуулийн профессор Дж.Гордлигийн өмчлөх эрх нь хүн өөрийн үйлдэл, эрх чөлөөгөөрөө өөрөө өөртөө эрх мэдэлтэй байхтай адилтгах санааг тайлбарлан: "өмчлөх эрхийг хамгаалах нь эрх чөлөөг хамгаалах, өмчлөх эрхийг хязгаарлах нь эрх чөлөөг хязгаарлахтай адил. Энэ зарчмыг тодотгон Оросын нийгэм улс төрийн түүхэн үйл явдлыг жишээ болгож болно. Хүмүүсийн өмчийг булааж байхад түүнтэй хамт эрх чөлөөг нь булааж авсан. Хүмүүс дахин хувийн өмчийн эрхээ олж авахад тэдэнд эрх чөлөө бий болж байлаа. Октябрийн хувсгалын дараа болон 20 дугаар зууны 90-ээд онд Орос оронд ийм байлаа. Өмчлөх эрхийг хууль зүйн харилцаа болохын хувьд эрх чөлөөтэй адилтган үзэх нь түүний оншлох чухал тодорхойлолт юм" гэж бичжээ.

В.П.Павлов энэ тухай "өмчлөх эрхийн тодорхойлолтоор түүний эзэмшигчид бусад этгээдтэй харьцуулахад үйлчилж буй хуулийн хүрээнд эд зүйлстэй харьцах дээд зэргийн эрх чөлөөг хангаж байдаг. Хэдийгээр өмчлөх эрх нь бусад обьектив эрхийн адилаар зохих этгээдийн үйл ажиллагааны эрх чөлөөг хязгаарлагч болдог боловч өмчийн субьектив эрхийн үнэт зүйлс нь хууль тогтоомжоор бусад этгээдийн дээрх эд юмсын хүрээнд бусад эрхийн болон үүрэгчлэлийн эрхийн хувьд гавигдах хязгаарлалттай харьцуулахад эдгээр эрхийг эзэмшигчийн үйл ажиллагааны хязгаарлалтын доод хэмжээнд оршдог. Ийм маягаар өмчийн субьектив эрх нь тодорхой эд зүйлтэй харьцах хамгийн бага

хоригийн давуу талыг өөртөө агуулж байдаг" гэж зөв зүйтэй баталсан байдаг.

В.П.Камышанский өмчлөх эрхийн хязгаар ба хязгаарлалтын асуудлыг судлахдаа, хангалттай үнэмшилтэйгээр "өмчлөх эрх нь өөртөө бие хүний болон нийгмийн элементийг агуулж байдаг. Нэг талаас өмчлөх эрх нь эрх зүйн институт болохын хувьд нийтийн эрх ашгийн өмнөөс өмчлөгчийн эрх чөлөөг хязгаарлаж байдаг. Нөгөө талаас энэ нь нийгмийн бусад гишүүд халдах ёсгүй өмчлөх эрх, эрх чөлөөний тодорхой хүрээг субьектэд илэрхийлж байдаг" хэмээн баталсан байдаг. Эрдэмтний хэлсэн үндэслэлд өмчлөх эрхийг дараах байдлаар харж болно.

1. Өмчлөгчийн эрх чөлөөг хязгаарласан, илэрхийлсэн эрх зүйн хэм хэмжээний цогц;

2. Эрх зүйн хэм хэмжээгээр илэрхийлэгдсэн, хязгаарлагдсан эрх чөлөө.

Нэгдүгээр тохиолдолд, өмчлөх эрхийн тухай асуудал нь обьектив утгаараа (тодруулбал өмчлөх эрхийн институт), хоёрдугаарт, өмчлөх эрх нь субьектив утгаараа (тодруулбал өмчийн эрх зүйн харилцааны элемент) хөндөгдөж байна.

Хэдийгээр бид бусад эрх зүйн категоруудийн дунд гол байр суурь эзэлдэг өмчлөх эрхийн мөн чанарыг илрүүлэх оролдлогуудыг хийсэн ч эрх зүйн ерөнхий онолд анхаарлаа хандуулах шаардлагатай. Үүнтэй холбоотойгоор 70-80 онуудын маргааны явцад тухайн үед хүлээн зөвшөөрөгдөж байсан эрх чөлөө, тэгш эрх, шударга ёсны биелэлийн эрх зүйн ойлголтын эсрэг сөргүүлэн тавьсан "хуульд өргөмжлөгдсөн ноёрхогч ангийн хүсэл зориг (буюу бүх ард түмний)" гэсэн тодорхойлолтын ойлголтыг зайлшгүй цохон тэмдэглэх хэрэгтэй. Эрхийг эрх чөлөө шиг үзэх тухай үзэл баримтлал үүсэхээс өмнө түүнийг идэвхтэй хэлэлцэж байхад болон одоо үед ч эрхийг эрх чөлөөний хэмжүүр гэж тодорхойлж байсан ба тодорхойлдог гэх хандлага (точка зрения) байсан, одоо ч байсаар байгааг хэлэх нь зүйтэй.

О.Э.Лейстийн бодлоор эрх чөлөөгөө хэрэгжүүлэх гэсэн эрхийн тухай ойлголт нь нэлээд эргэлзээг төрүүлж байдаг гэж үздэг. Түүний үзэж байгаагаар "энэ ойлголт нь нийгмийн эрх зүйн ухамсарт буй бөгөөд, хуулийн төслийг үнэлэх, хууль тогтоомжийн санал боловсруулах, хуучирсан хуулийг хүчингүй болгох, өөрчлөх зэрэгт нөлөө үзүүлдэг жам ёсны гэж нэрлэгдэх тодорхойлолтод тохирно" гэж үздэг. Нэгэнтээ одоо үйлчилж буй (позитив) эрх зүйн мөн чанарын тодорхойлолтод дээрх тодорхойлолт тохирохгүй. О.Э.Лейст өөрийн байр суур ї үндэслэн бичихдээ: Нэгдүгээрт, ийм эрх зүйн ойлголтоос үүдэн одоо үйлчилж буй эрх зүйн түүх нь зөвхөн бүх нийтийн тэгш байдал ба эрх чөлөөний санаануудыг эрх зүйд дэвшүүлж биелэлээ олсон 17-18 дугаар зуунаас эхэлдэг. Харин үүнээс өмнөх бүх эрх зүй нь эрх зүй гэж тооцогдохгүй. Үүний зэрэгцээ эрх зүйн философи нь нийгмийн философийн хэсгийн хувьд обьектоороо хүн төрөлхтөний түүхийг бүхэлд нь тооцдог. Иймд өөрийн дүгнэлт, ойлголт болон категордоо аль болох судалгааны зүйлд түүний оршин байх хугацааны турш үнэхээр нийтлэг, бодитоор агуулагдах зүйлсийг тусган илэрхийлэхийг тэмүүлэх ёстой.

Ийм учраас эрх зүйн философи нь эрх зүйн боломж, сайн тал түүнчлэн саар тал, аюулыг урьдчилан хэлэх чадвартай байдаг. Хоёрдугаарт хэрэв эрх зүй нь эрх чөлөөний биелэл (ахуй) бол хичнээн их эрх зүй байна төдий чинээ эрх чөлөөтэй байна гэсэн дүгнэлт нь зүйд нийцнэ (логично). Нэгэнтээ эрх зүйн тогтолцоо нь хэдий чинээ нийгмийн амьдралын бүх хүрээг ягштал (дотошно) тодорхойлсон нь хүмүүсийн чөлөөт үзэмжид бараг л зай үлдээгүй нь түүхээс харагддаг. Бүх нийтийн харилцааны түгээмэл зохицуулалт ба (гол!) шинэтгэлтийн огтлолцол нь хэд хэдэн улс төр-эрх зүйн номлолуудаар идеалчлагдсан байдаг. Эрдэмтэн, эрх зүйн гол зорилго нь журам ба нийгмийн тогтвортой байдал ба түүнийг "тогтвортой байдлын арга ба нийтийн харилцааны нөхөн үйлдвэрлэл (эрх зүйн бүрэлдэхүүнийг тодорхойлох чадвартай нийгмийн хэсгийн ашиг сонирхлын давуу талыг харгалзсан)" байдаг гэж үздэг байна.

Дээрх байр суурийг зөвшөөрхөд хэцүү. Өөрийн санааг хэлэхээс өмнө эрхийн ойлголтын хандлагыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай нь мэдээжийн хэрэг юм. Урьдах эрх зүйн хэм хэмжээний актын дагуу түүний үр дагавар нь бус шалтгааны үзэгдэл нь эрх зүйн ойлголтын хувьд бидэнд ойр. Эрх нь нийгмийн хөгжлийн бүтээгдэхүүн, хүмүүсийн хоорондоо буй болсон харилцааны тусгал ба бэхжүүлэлт. Нийтээр заавал дагаж мөрдөх хэм хэмжээг эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны эсрэг үндэслэл гэж үзэж болох ч энэ тохиолдолд энэ нь эрх биш дур зорго болно. Эрх зүйн хэм хэмжээний акт тэр дундаа эхний ээлжинд хууль нь илүү тодорхой илүү бүрэн дүүрэн эрхийн илэрхийлэл. Дээрх нийтлэг журмыг үндэслэн харах юм бол эрх нь гарцаагүй нийтлэг, хүн төрөлхтөний бий болсон бүх л цаг хугацааны судалгааны зүйл болсон обьектив жам ёсны зүйл

юм. Философич, эрх зүй судлаач Е.Н.Трубецкой бичихдээ **(эрх зүйн ойлголтын ач холбогдлын улмаас):** " эрх нь хэм хэмжээгээр илэрхийлэгдсэн болон хязгаарлгадсан гадаад эрх чөлөө юм. Энэ тодорхойолт нь бидний үзсэн бусад тодорхойолтод байхгүй тэр л гол шинжүүдийг агуулдаг гэдгийг ойлгоход бэрх биш. Эдгээрээс ихэнхи тодорхойлолтоор төрөөс бий болгож хүлээн зөвшөөрч байдаг нь эрхийн гол онцлог гэж тооцдог. Гэвч бид эрхийг төрөөс ангид байж чаддагийг мөн төрөөс урьдчилж, түүнийг нөхцөлдүүлж байдгийг харсан. Үүний адилаар эрхийг ямар нэгэн байдлаар дэвэргэн шүтэх нь түүний шинж огт биш харин ч, тэр нь өөрөө аливаа нэр хүндийг нөхцөлдүүлж байдаг.

Бусад тодорхойлолтууд эрх зүйн ойлголтуудийн гол чухал шинж тэмдэгүүд нь албадлага, хүч, ашиг сонирхол, энх тайвныг тогтоох, эрх зүйн хэм хэмжээний ёс суртахууны агуулга гэж үздэг. Гэвч эрх зүйн эдгээр гол бус (несущественность) шинжүүд нь ямар ч албадлага болон хүчирхийлэлгүйгээр ашиг сонирхол илэрхийлээгүй, энх тайвныг тогтооход чиглээгүй ба эцэст нь ёс суртахууныг агуулаагүй эрх зүйн хэм хэмжээ байдаг нь эрх хаа сайгүй оршиж байдгийг баталдаг. Дурдсан бүх эрх зүйн шинж тэмдгүүдийг дарсан ч гэсэн эрх байхаа болихгүй. Дээрх ойлголтыг устгаж байгаа шинж тэмдэгүүдийг түүний гол шинж тэмдэгүүд гэж ойлгож болно. Энэ өнцгөөс харахад курсын эхэнд томьёологдсон тодорхойлолтод эрхийн тэрхүү гол шинж тэмдэгүүд өгөгдсөн байгааг төвөггүй харж болно. Гадаад эрх чөлөөгүй байх нь эрхгүй байхтай утга адил: гадаад эрх чөлөөгөө хасуулсан этгээд бол ямарч эрхгүй этгээд. Ийм учраас гадаад эрх чөлөө нь эрхийн зайлшгүй гол шинж тэмдэг байдаг.

Эрх зүй судлаач А.П.Кунишин 200 гаруй жилийн өмнө эрхийн мөн чанарыг тодорхойлж байхдаа "Хүн ба эрхийн тухай" бүтээлийнхээ "Эрхийн суурь чанарын тухай" бүлэгт "Хэн ч тулгарсан ямар ч тохиолдолд эрхийг эрх бусаас ялгаж чадаж байхын тулд эрхийн суурь чанарыг тодорхойлдог учир тэр нь (суурь чанар) бүх л эрхийн зүйлд харьцангуй хамаарах ёстой байх ба нэг эрхэд бусад бүх эрхэд хамаарах шинж агуулагдаж байх ёстой, харин нэг л шинж агуулаагүй бол түүнийг эрхэд үл тооцох ёстой. Ухамсрын түвшинд зайлшгүй шаардлагатай (хэрэгцээтэй) шинжээр нь эрхийг хүлээн авах ба үгүй бол хүн болгон түүнтэй адил зүйл болгоныг эрхэд тооцно. "Хэдийгээр эрхийн шууд илрэх зүйл нь хүний гаднах эрх чөлөө учир түүний гол хэлбэрийн суурь нь дараах маягаар илэрч болно. Хүн ухамсрын ерөнхий хуулиар бусдын эрх чөлөө хамгаалагдсан үед ямарч үйлдэл хийх, ямарч байдалд байх эрхтэй. Хэдийгээр бид эрх чөлөөг зөрчиж аяндаа хүмүүсийн хүсэл зоригын эсрэг, тэднийг өөрийн зорилгодоо энгийн зэвсэг болгон ашиглаж тэднийг үл хүндэтгэдгээ баталдаг. Тиймээс эрхийн гол эхлэл нь мөн эсрэг аргаар илэрч болно. Өөрийн зорилгодоо бусдийг эд зүйл мэт бүү ашигла".

О.А.Лейстын хоёр дахь үндэслэлийн тухайд эрдэмтний "Эрх хэдий чинээ их байна эрх чөлөө үргэлж төдий хэмжээгээр байдаггүй" гэсэн дүгнэлт нь бидний эрх зүйн ойлголтоос урган гарсан шалтгаан, үр дагаврын төрлийн хамаарлын хүрээнд багтахгүй байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Биднийн үзэж байгаагаар В.С.Нерсесянцийн боловсруулсан эрхийн мөн чанарын үзэл баримтлал, түүний өмчлөх эрхтэй холбогдох байдал нь илүү нийцтэй бас үндэслэлтэй байна.

Түүний үзэж байгаагаар "Эрх бол эрх чөлөөний илэрхийллийн хэм хэмжээний хэлбэр". <<Эрх нь зүгээр нийтлэг хэмжээ (хүрээ, хязгаар) ба тэгш хэмжүүр төдий биш, харин юуны өмнө хувь этгээдүүдийн эрх чөлөөний нийтлэг хэмжээ, хязгаар, тэгш хэмжүүр юм. Чөлөөт хувь этгээдүүд нь эрхийн "матери", гээгч, учир шалтгаан, утга учир юм>>. Эрдэмтний үзэж байгаагаар энэ байдалууд нь үйлдвэрлэл ба эдийн засаг, бүх нийтийн өмчийн харилцаа шиг нийгмийн амьдрал үйл ажиллагааны гол хүрээнд бүрэн хэмжээгээр хамааралтай байдаг. Байгаа боломж нь өөрөө хувь хүний эд хөрөнгийн харилцаан дахь (ийм учир эрх чөлөө, хараат бус байдал, бие даасан байдал) эрх зүйн чадварыг хүлээн зөвшөөрөхтэй холбогдон нийгмийн эдийн засгийн хүрээн дэх хүмүүсийн тэгш байдал, эрхийн эрх зүйн чөлөөг эхлүүлсэн. Өөрөөр хэлбэл, хувь хүний эд зүйл үйлдвэрлэлийн (баялаг бүтээх гэсэн санаа байж магадгүй) өмчлөх эрхийн субьект байх чадварыг хүлээн зөвшөөрөх юм. Энд гагцхүү эд зүйл үйлдвэрлэлийн харилцаа нь эдийн засгийн харилцааны утга, агуулга, гол чанарыг бий болгож байгаа тэр нөхцөл байдлыг онцгой анхаарах хэрэгтэй. Хаана эдийн засгийн харилцааны эрх зүйн хэлбэрүүд бүрэлдэн тогтсон буюу үйлчилж байна, үйлдвэрлэлийн эд зүйл дэх хувь хүний өмчлөх эрх хэрэгждэгийг хүлээн зөвшөөрнө, тэнд (хувийн хэрэгцээний зүйлсийг оруулаад) бусад (үйлдвэрлэлийн бус) обьектуудыг өмчлөх эрхийн харилцааны хүрээнд хамаарууллаг ба өмчлөх эрхийн

обьект болдог. Гэвч өмч нь хэрэгцээний зүйлийн хувьд, тохирох нийгэмд эд зүйл үйлдвэрлэл дэх хувь хүний өмчлөх эрх байгаа үгүй, хүлээн зөвшөөрөх эс зөвшөөрөхөөс хамааранд үүсмэл, хоёрдогч шинжтэй байдаг.

Эрх зүй судлаач бичихдээ "Эрх нь бүхэлдээ- эрх чөлөө нь тэгш эрхийн хэлбэрээрээ энэ бол нийгмийн амьдралын хувь хүн болон бусад субьектүүдын эрх чөлөө. Энд эрх чөлөө нь эд зүйл үйлдвэрлэлийн харилцаа шиг нийгмийн амьдралын гол хүрээнд бол бүхэлдээ эдийн засаг гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй" гэжээ. Цааш нь:"Өмч нь зөвхөн хүний эрх, эрх чөлөөг илэрхийлэх чиглэл, хэлбэр биш юм. Өмч нь өөрөө эрх, эрх чөлөөний хөгжлийн (цивилизованный) суурийг бий болгож байдаг. Хаана аж үйлдвэрлэл, хувийн өмчийн эрх үгүйсгэгдэж байна, тэнд эрх чөлөө, эрх байхгүй бөгөөд зарчмын хувьд боломжгүй юм.

Энэхүү ажлын зорилгын хувьд хувь хүний эрх чөлөө болон хүсэл зоригийн эрх чөлөө нь ижил ойлголт гэж тэмдэглэх хэрэгтэй. Гэвч эрх чөлөө үзэгдэж буй нь энгийн боловч-ойлгоход хэцүү зүйл. Тэр тусмаа хэлбэрийн, хэм хэмжээний, институтийн, процедурын болон нийгмийн амьдарлын харилцааны практикт хэрэгжүүлэхэд Ш.Л.Монтескье "Хуулийн амин сүнс" бүтээлдээ "Эрх чөлөө" гэсэн үгийн олон утгыг тэмдэглэн бичихдээ "Эрх чөлөө гэдэг үг шиг олон янзын утга илэрхийлдэг, оюун ухаанд янз бүрийн сэтгэгдэл төрүүлж байдаг үг байхгүй. Нэг хэсэг нь эрх чөлөөг харгис эрх мэдэлтнүүдийг түлхэн унагах хөнгөн боломж гэдэг бол бусад нь өөрийн захирагдах хүнээ сонгох эрх, гуравдах хэсэг нь зэвсэг үүрэх, хүчирхийлэл үйлдэх эрх, дөрөв дэх хэсэг нь эрх чөлөөг, өөрийн үндэстний хүний удирдлага дор бүрэлдэн тогтох онцгой эрх буюу өөрсдийнхөө хуульд захирагдах гэж хардаг. Зарим ард түмэн удаан хугацаанд эрх чөлөөг урт сахал зүүх заншил гэж үзэж байсан. Зарим нь энэ үгийг засаглалын алдартай хэлбэртэй хослуулан бусдыг нь үгүйсгэдэг.

Өмнөх эрх чөлөөгүй байдлын (несвободы) дарлал ас чөлөөлөгдсөн хүмүүст эрх чөлөө нь сэтгэл зүрхнээсээ хүссэн бүхнийг барьж болох зөөлөн дуулгавартай материал, хүсэл зориг шиг санагддаг. Гэвч яг үнэндээ эрх чөлөө нь дэлхий дээр үл үзэгдэх байдалтай байдаг боловч эрхийг бат бөх хүрээлж байдгаар батлагддаг. В.С.Нерсесянц үүнтэй холбоотойгоор: "Хүн төрөлхтөн одоо болтол хүмүүсийн нийгмийн амьдралд эрх зүйн эрх чөлөөнөөс өөр эрх чөлөөний орших хэлбэр, илэрхийллийг зохиогоогүй байна. Тиймээс энэ нь логикын хувьд ч, практикын хувьд ч боломжгүй юм" гэж шударгаар баталсан байдаг.

Ийм маягаар эрх чөлөөний эрх зүйн хэлбэр нь өмчлөх эрхийн мөн чанарын шинж шиг мөн адил эрх чөлөөний хэлбэр шиг эрхийн ерөнхий тодорхойлолтоор нөхцөлддөг. Энд мөн логик нь тодорхой өмчлөх эрх нь түүнд байдаг эрх чөлөөний мөн чанарын шинжтэй гэдгээрээ бусад эрхийн категоруудаас гол, төв байр суурийг эзэлж байгаа бол, түүнд эрхийн гол эхлэл оршино.

Дээр өгүүлсэн зүйлийн үндсэн дээр дараах дүгнэлтийг хийж болно.

1. Өмчийн мөн чанар-хувь хүний идэвхтэй, бүтээлч хэлбэр түүний үндсэн чанар болох эрх чөлөө;

2. Өмчлөх эрхийн мөн чанар-эрх чөлөө нь эрх зүйн хэлбэрээрээ эрх чөлөөг олгосон (бататгасан, хангасан) болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолыг хязгаарласан утга;

3. Өмчлөх эрх нь обьектив утгаараа-өмчлөгчийн эрх чөлөөг олгохын хамт хязгаарлаж байдаг эрх зүйн хэм хэмжээний цогц;

4. Өмчлөх эрх нь субьектив утгаараа-эрх зүйн хэм хэмжээгээр зөвшөөрөгдсөн болон хязгаарлагдсан эрх чөлөө.

☙ ☙ ☙

ЗАЛРУУЛГА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан байсан О.Отгонтуяа нь судалгааны ажлынхаа зарим материалд түшиглэн "Гэр бүлийн эрх зүйн зарим төрлийн харилцаа" сэдвээр бичсэн өгүүллээ "Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн 2008 оны №4-ийн 16-20 дахь талд нийтлүүлсэн бөгөөд уг сэтгүүлийн 18 дахь талын сүүлийн өгүүлбэрт Иргэний бүрттгэл, мэдээллийн улсын төвөөс авсан тоо баримтыг дурдахдаа "Гадаадын иргэн, харьяатын албаиаас авсан тоогоор 407 хүүхэд . . ." гэж андуурч бичсэнийг "Иргэний бүрттгэл, мэдээллийн улсын төвөөс авсан тоогоор 407 хүүхэд . . ." гэж залруулан уншина уу.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНД ШҮҮМЖЛЭЛТЭЙ ХАНДАХ НЬ

Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн профессор, хууль зүйн доктор Б.Уранцэцэг

Төрийн албан хаагчдын тэр дундаа төрийн жинхэнэ албан хаагчдын хөдөлмөрийн харилцаа, түүний зохицуулалтын талаар хийсэн судалгаа, энэ талаар бичигдсэн бүтээл эдүгээ бараг үгүй билээ. Нэгэнт судлагдаагүй, танигдаагүйтэйгээ уялдан төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулахаар зохих журмаар тогтоогдон үйлчилж буй хууль тогтоомжууд нь ч тэр хэрээр ихээхэн учир дутагдалтай байх ажээ. Ер нь судлагдаж, мөн чанар, онцлог, шинж төрх нь шинжлэх ухаанд танигдахын хэрээр уг үзэгдэлд зөв хандах хандлага ойлголт чиг баримжаа ч үндэстэй, оновчтой тогтож бүрддэг.

Өмнөх тогтолцооны үед улсын үйлдвэр, албан газар, байгууллагад ажиллаж байгаа хүн бүр ажлчин албан хаагч гэсэн нэр томьёоны дотор багтан бүгд л хөдөлмөрийн гэрээний үндсэнд тухайн ажил үүргээ эрхлэн гүйцэтгэж байв. Тухайн үед Хүнс хөдөө аж ахуйн нэгдэлийг эс тооцвол, төр дангаар ажил олгогч байсан бөгөөд Үндсэн хуульд тусгагдсанаар хөдөлмөрийн чадвартай иргэн бүр улс орны социалист бүтээн байгуулалтад заавал оролцох, заавал хөдөлмөрлөх үүргээ улсын аль нэг үйлдвэр, албан газар, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах цор ганц аргаар биелүүлж байсан. Харин зах зээлийн тогтолцоонд шилжих үеэс нийгмийн үйл ажиллагааны өвөрмөц төрөл болох төрийн алба нь төрийн зорилго, зорилт, чиг үүргийг хангаж хэрэгжүүлэх үндсэн арга болж шинээр бүрэлдэх үйл явц эхэлсэн билээ. Үүнтэй уялдан 1994 онд "Төрийн албаны тухай хууль" батлагдан үйлчлэх болсон. Гэхдээ энэхүү хуулиар зохицуулагдах харилцаа, уг албыг хэрэгжүүлэх албан хаагчдын хөдөлмөрийг тухайлан нарийвчилж судлах судалгаа ихээхэн хоцрогдонгуй байна. Төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг судлаачид төрийн албаны үйл ажиллагаатай холих, нэг ойлголт мэт үзэх нь ч ажиглагдах боллоо.

Төрийн албаны хүрээнд нэг талаас төрийн албан тушаалд иргэд орж ажиллахтай холбогдсон, нөгөө талаас төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд чиглэгдсэн гэсэн хоёр төрлийн харилцаа үүсч хэрэгждэг байна. Үүнээс сүүлийнх нь нэгэнт төрийн тодорхой албан тушаал эрхлэх нөхцөл шаардлагыг хангаж томилогдсон албан хаагч төрийн тодорхой зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төрийн албаны харилцаа юм. Харин иргэн алба хашихын тулд төрийн тодорхой албан тушаалд орж төрд ажиллах, алба хаших явцад өөр ажилд шилжих, сэлгүүлэх, цалин хөлс авах, албанаас халагдах чөлөөлөгдөх зэрэг нь төр гэдэг ажил олгогч ба түүнд ажиллах хүчээ хөлслүүлж буй албан хаагчийн хооронд үүсч буй хөдөлмөрийн харилцаа билээ. Эндээс төрийн албаны хүрээнд төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, төрийн албан хаагч алба хаших харилцаа гэсэн хоёр өөр төрлийн, гэхдээ өөр хоорондоо салшгүй холбоо бүхий харилцаа үүсдэг болох нь ойлгогдоно. Энэхүү ангилалтаас үзвэл лурдсан харилцаанууд хэдийгээр төрийн албаны хүрээнд үүсч буй хэдий ч тус тусын онцлог, мөн чанарын хувьд нэг хуулиар зохицуулагдах, эрх зүйн салбарын нэг шинжлэх ухаанаар судлагдах бололцоогүй юм. Төрийн албан хаагчдаас хэрэгжүүлдэг албаны үйл ажиллагаа нь төрийн зорилт, чиг үүрэг тус бүрийн оншлогтой шууд холбоотой, жишээ нь, шүүн таслах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, татвар, гааль, мэргэжлийн хяналт зэрэг нь төрийн гэхдээ өөр хоорондоо ялгаатай үйл ажиллагаа гуд эдгээрийг хэрэгжүүлэх харилцаа гус бүр өөр өөр хууль тогтоомжоор зохицуулагддаг. Харин шүүгч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, татвар, гааль, мэргэжлийн хяналтын байцаагч гэсэн албан тушаал нь төрийн албан тушаал, тэдгээрт иргэд орж ажиллах үед болон ажиллах явцад төрийн албан хаагчийн хувьд тавигдах нийтлэг шаардлага, мөрдөх нийтлэг зарчим байдаг. Иймд эдгээр нийтлэгт тохирсон зохицуулалтыг Төрийн албаны тухай хуулиар тогтоон өгсөн гэж үзэж болох юм. Төрийн албаны тухай хууль (2002 он)-д байгаа нийт 41 зүйлээс төрийн албаны зарчим, төрийн албаны удирдлагатай холбогдсоноос бусад 28 зүйл нь үндсэндээ төрийн албан хаагчдын түүн дотроо төрийн жинхэнэ албан хаагчдын хөдөлмөрийн харилцааны зохицуулалт тогтоосон байх ажээ. Эдгээр заалтыг агуулгаар нь төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулсан, төрийн жинхэнэ албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулсан гэж ангилж болох юм. Төрийн албан тушаалд тавих шаардлага, төрийн албан хаагчийн баталгаа, ажиллах нөхцөл, олгох нөхөн төлбөр, тусламжийг тогтоосон зүйл, заалтууд нь төрийн нийт албан хаагчид, харин төрийн

жинхэнэ албан тушаал эрхлэх болзол журмыг зохицуулж буй IV бүлэг, түүний 11 зүйлийн заалтууд нь гагцхүү төрийн жинхэнэ албан хаагчдын хөдөлмөрийн харилцаанд тус тус хамаарч үйлчилж байна. Эндээс, Төрийн албаны тухай хууль нь нийгэм дэх хөдөлмөрийн харилцааны өвөрмөц төрөл болох төрийн албан хаагчдын нийтлэг харилцааг болон түүний нэг бүрэлдэхүүн-төрийн жинхэнэ албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг журамлан зохицуулах гол эх сурвалж гэж дүгнэж болно. Иймд Төрийн албаны тухай хууль бол хөдөлмөрийн эрх зүйн нэг эх сурвалж, төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн эрх зүйн салбар шинжлэх ухааны судалгааны объект юм.

Төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуулиудаар зохицуулдаг билээ. Албан тушаалын эрх зүйн статусаас хамаарч төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг Хөдөлмөрийн тухай хуулиар, харин төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг Төрийн албаны тухай хуулиар зохицуулж байна. Ингэхдээ төрийн албан хаагчдын хөдөлмөрийн нийтлэг шинжид тулгуурлах нэгдсэн зохицуулалтыг Төрийн албаны тухай хуулиар тогтоодог бол төрийн жинхэнэ албан хаагчдын хөдөлмөрийн харилцаанаас уг хуулиар зохицуулагдаагүй үлдсэн хэсгийг нь Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулж байна.

Эндээс тухайн хуулийн хооронд утга агуулгын шүтэлцээ холбоо зайлшгүй байх шаардлага урган гарч байна. Харамсалтай нь энэхүү шаардлага өнөөгийн байдлаар огт хангагдахгүй байгаа ажээ.

Төрийн үйлчилгээний албан хаагч ба төрийн жинхэнэ албан хаагч аль аль нь төрийн албан хаагч болоч тэдний төрд алба хаших хөдөлмөрийн харилцаа нь зарчмын эрс ялгаатай түвшинд хуульчлагдан зохицуулагдаж байна. Энэ ялгаа нь тэдний эрх зүйн статустай огт холбоогүй, зөвхөн хууль тогтоогчийн үзэмжээр бий болсон гэж дүгнэж болно.

Төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг ажил олгогч (төрийн байгуллага)-ийн санаачлагаар 9 үндэслэлээр дуусгавар болдог. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд тусгагджээ. Харин төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг захиргаа санаачлан, халах 3 үндэслэлийг л Төрийн албаны тухай хуульд тусгасан. Хэрвээ төрийн үйлчилгээний албан хаагч хүлээсэн үүргээ үл биелүүлэх зэрэг сахилгын ямар нэг зөрчил гаргах, эрхэлсэн ажил албан тушаалдаа мэргэжил ур чадвараар тэнцэхгүй бол халагддаг (Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2, 1.4). Харин төрийн жинхэнэ албан хаагч нь албан тушаал (ажлын байр)-ын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь төрийн тухайн албан тушаал эрхлэх шаардлага хангахгүй болсон бол төрийн албанаас халагдах, чөлөөлөгдөх бус харин захиргааны санаачлагаар албан тушаал буурдаг. (Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.2) Энэ нь төрийн үйлчилгээний албан хаагч ба төрийн жинхэнэ албан хаагч хоёрын хувьд яг адил утга бүхий үндэслэлүүд дурдагдаж хэрэглэгдэхдээ өөр өөр үр дагаврыг бий болгож байгаа хэрэг юм. Цаашилбал, төрийн үйлчилгээний албан хаагч ба төрийн жинхэнэ албан хаагч хоёрын аль нь төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд, төрийн засаглах зохион байгуулах чиг үүргийг биелүүлэхэд илүү их үүрэгтэй вэ? гэдэг асуулт тавихад төрийн жинхэнэ албан хаагч гэх нь ойлгомжтой. Эндээс төрийн жинхэнэ албан хаагчид төрийн нүүр царайг, төрийн нэр хүндийг авч явах гол субъект учраас тэдэнд нийгмийн, ард түмний зүгээс тавих шаардлага, тэдний хүлээх хариуцлага нь төрийн үйлчилгээний албан хаагчдынхаас өндөр, илүү түвшинд байх ёстой. Гэтэл төрийн жинхэнэ албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хуульд энэхүү өндөр үүрэг, хариуцлага, шаардлагыг харгалзсан түүнд тохирсон зохицуулалт тогтоогоогүй, харин ч төрийн жинхэнэ албан тушаалд чадваргүй, албан үүргээ биелүүлдэггүй хүн орчих, орсон хойноо албан тушаалдаа бүгж төрийн албаны нэр хүндийг унагах бололцоог хуульчлан тогтоож байна.

Төрийн жинхэнэ албан хаагчдын хөдөлмөрийн харилцаа бол нийгэм дэх хөдөлмөрийн нэгэн өвөрмөц төрөл хэсэг, бусад төрлийн хөдөлмөртэй түүн дотроо төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөртэй нийтлэг шинжүүдийг агуулдаг билээ. Энэ талаас нь авч үзсэн ч Төрийн албаны тухай хууль ба Хөдөлмөрийн тухай хуулийн агуулга, хэлбэрийг ойролцоо болгох, жигдлэх шаардлагатайг давхар нотлож байна.

Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийг агуулга, хэлбэрийн хувьд жигдлэх, ойролцоо болгох гэдэг нь өөр хоорондоо ялгаатай ойлголт юм. Жигдлэх гэдэг нь эдгээр хуульд тусгагдсан төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцаанд хэрэглэгдэх эрх зүйн зохицуулалтын хэлбэрүүдийг адил агуулгатай, адил үндэслэлээр хэрэглэгддэг, адил үр дагаврыг бий болгодог болгох явдал юм.

Хөдөлмөрийн тухай хуульд ажилтныг өөр ажилд шилжүүлэх гэсэн зохицуулалтын хэлбэр Төрийн албаны тухай хуульд буй төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх зохицуулалттай адил агуулгаар тусгагдах ёстой. Хэдийгээр эрх зүйн статус нь өөр ч аль аль нь төрийн албан хаагч, зохицуулалт нь "өөр ажил, албан тушаалд шилжүүлэх" гэж нэг л ойлголт юм. Гэтэл

Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар төрийн үйлчилгээний албан хаагч нь ажлын зайлшгүй шаардлага, сул зогсолт, эрүүл мэнд доройтсон гэсэн гурван үндэслэлийн аль нэгээр өөр ажилд шилждэг (Хөдөлмөрийн тухай хуулийн 32-34 дүгээр зүйлүүд, харин Төрийн албаны тухай хуулиар төрийн жинхэнэ албан хаагч нь байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар орон тоо нь хасагдсан бол цалин хөлсийг бууруулахгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжих (Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.3) зохицуулалт үйлчилж байна. Гэтэл Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр ажил, албан тушаалд шилжүүлэх үндэслэл болсон дээрхи гурван шалтгаан нь төрийн үйлчилгээний албан хаагчийн хувьд ажил олгогчийн санаачлагаар түүний хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болж Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-д тусгагджээ. Зөвхөн энэ зохицуулалтын хэлбэрээс авч үзэхэд хууль зүйн нэг хэлбэрийн зохицуулалт төрийн албан хаагчдад хоёр өөр агуулгаар тогтоогдон хэрэгжиж байна. Хөдөлмөрийн тухай хуульд албан тушаал бууруулах зохицуулалт огт байхгүй. 1991 онд Хөдөлмөрийн тухай хууль шинээр батлагдах үед сахилгын шийтгэлийн хэлбэрээр өмнөх хуульд тусгагдан хэрэглэгдэж байсан ажил, албан тушаал бууруулах зохицуулалтыг хуулиас хассан билээ. Энэ нь онол практикийн зохих үндэслэгээтэй байсан юм. Ажил олгогч хуулийн этгээдийн бүтцэд сахилгагүй ажилтанд зориулж ямар нэг ажлын байр, орон тоо хадгалж, сул байлгах ёстой гэсэн агуулгыг уг зохицуулалт агуулж байсан тул хуулиас хассан билээ. Гэтэл өнөөдөр Төрийн албаны тухай хуульд чадваргүй, ажил үүргээ биелүүлдэггүй албан хаагчаа хаацайлж эрхлүүлсэн агуулгатай ийм зохицуулалт байгаа нь онол-арга зүйн талаасаа ч, төрийн алба мэргэшсэн, ард түмэнд үйлчлэх зарчмын дагуу хэрэгжих шаардлагын талаасаа ч нийцэхгүй ажээ.

Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль хоёрыг агуулга, хэлбэрийн хувьд ойролцоо болгох гэдэг нь эдгээр хуулийн доторх зүйл, заалт, түүгээр тогтоогдож буй зохицуулалтууд яг адил агуулгатай байх гэсэн үг бус, төрийн үйлчилгээний албан хаагч ба төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг зохицуулахдаа төрөөс адил зарчим баримталж, аль болох ойролцоо үр дагаврыг бий болгох зохицуулалт тогтоох ёстой. Төрийн үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагаар халах, төрийн жинхэнэ албан хаагчийг захиргааны санаачлагаар халах гэсэн зохицуулалт Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн аль алинд нь байгаа ч мөн л эрс ялгаатай үндэслэл, журам тогтоож эндээс төрийн албан хаагчдад өөр өөр үр дагаврыг бий болгож байна.

Төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хуулиуд, дагалдах хуульчилсан актуудын хүрээнд хууль зүйн нэр томьёоны талаас анхаарвал зохих асуудал олон байна.

Ардын багш, гавъяат хуульч, доктор, профессор Б.Чимид эрх зүйн шинэтгэлийн үе шатуудын дотор хуульд цэвэрлэгээ хийх үе тулгарч байгааг онолын хувьд баталж тэмдэглэжээ. Үүний нэг хэсэг нь хууль зүйн ямар нэг ойлголтыг илэрхийлэх хууль зүйн нэр томьёог оновчтой болгох, жигдлэх явдал билээ. Б. Чимид: "Манай хууль хоорондоо зөрчилдөж буй нэг шалтгаан нь нэг үзэгдлийг олон янзаар нэрлэж байгаад оршино"[1] гэжээ. Төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулдаг хууль тогтоомжийн дотор нэр томьёог оновчтой оноож өгөөгүй, эсхүл нэг ойлголт олон янзаар нэрлэгдэж гусгасан зэргээс хэрэгжүүлэх явцад ойлголтыг нэр мөр, нэг утгаар бус өөр өөрөөр ойлгоход хүргэж, эндээс өөр өөрөөр биелүүлэхэд нөхцөл бүрдэж байгаа явдал цөөнгүй илэрч байна. Хууль зүйн нэг ойлголтыг нэг л нэр томьёогоор илэрхийлэн хууль тогтоомжуудад жигд хэрэглэх нь хуулийг нэр мөр ойлгож нэгдмэл байдлаар сахин хангахад гол утга нь орших "хууль ёсыг сахин биелүүлэх зарчим"-ын хэрэгжилтийн гол нөхцөл ажээ.

Төрийн албаны хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон төрийн албаны тодорхой салбар, чиглэлийн хүрээнд үүсэх харилцааг зохицуулдаг салбарын олон хуулиудад "төрийн албан хаагч", "ажилтан", "ажилд томилох", "ажилд авах", "хөдөлмөрийн гэрээ байгуулах", "халах", "чөлөөлөх" гэх мэт хууль зүйн тодорхой ойлголтыг илэрхийлдэг нэр томьёонууд нь оновчгүй байдлаар тусгагдан хэрэглэгдэж байна. Иймд юуны өмнө нийгмийн нэг төрлийн харилцааг тал бүрээс нь иж бүрнээр зохицуулах зорилгоор тогтоож байгаа хууль тогтоомжид нэр томьёог жигдлэх, оновчтой томьёолж тусгах асуудлыг даруй шийдэх ёстой болж байна. Төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулдаг хуулиуд болон хуульчилсан актуудад нэр томьёо жигд бус, оновчтой бус байгаа, үүнээс үүдэх сөрөг үр дагаврын талаар дараагийн удаа дэлгэрэнгүй тодорхой хөндөж өгүүлэх болно.

1. Б. Чимид. "Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг асуудал". УБ., 2004 он, 280 дахь тал

ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗОХИЦУУЛАЛТ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, докторант С.Болормаа

Монгол Улсын Үндсэн хуулийн гарванзургадугаар зүйлд зааснаар "Монгол Улсын иргэн хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах" эрхтэй ба иргэдийн хууль заасан энэхүү эрхээ эдлэхэд нь ажил олгогч хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангах үүргийг хүлээдэг.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль батлагдан гарч мөрдөгдсөнөөс хойш хуулийг зөв хэрэглэж хэвшүүлэх шаардлага ажил олгогчдод зайлшгүй тавигдаж байна. Тиймээс хөдөлмөрийн харилцааны зохицуулалт дахь хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар анхаарвал зохих зарим асуудлын талаар судлан авч үзсэн болно.

Хөдөлмөр хамгаалал гэдэг нь хөдөлмөрийн эрх зүйн үндсэн институтын нэг бөгөөд хөдөлмөрийн үйл ажиллагааны явцад ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах эрх зүй, нийгэм-эдийн засаг, зохион байгуулалт-техникийн, ариун цэвэр-эрүүл ахуйн, эмчилгээ-урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх болон бусад арга хэмжээг баталсан тогтолцоог хэлнэ.[1]

Хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалалын асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар бүлгээр зохицуулж байсан ба Улсын Их Хурлаас "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль" (Төрийн мэдээлэл)-ийг 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр батлан гаргаснаар дээрх асуудлыг бие даасан хуулиар зохицуулах болсон. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль зааснаар:

• "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл аюулгүй нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрслэлээс хамгаалах үйл ажиллагаат;

• "Хөдөлмөрийн аюулгүй байдал" гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байхыг;

• "Хөдөлмөрийн эрүүл ахуй" гэж хөдөлмөрлөх явцад химий, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан хүний бие махбодь, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэлнэ хэмээн хуульчилсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хуульчилснаар хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтнуудын хөдөлмөр хамгааллыг бэхжүүлэх, улмаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх урьдчилсан нөхцлийг бүрдүүлж өгсөн хэдий ч амьдрал дээр ажилтнууд хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллах, улмаар үйлдвэрлэлийн осолд өртөн хөдөлмөрийн чадвараа алдах, амь насаа ч алдах байдал багагүй байна.

Хөдөлмөр хамгааллын институтын агуулгыг схемлэн үзвэл:[2] *(схем 1-ийг үзнэ үү)*

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг ажил олгогч шууд хариуцах ба дээрх үүргээ биелүүлэхгүйгээс үүдэн гарах үр дагаврыг (хор уршиг, хохирол г.м) мөн шууд хариуцлагаараа онцлогтой.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн дагуу ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг ажиллуулах үүрэгтэй бөгөөд иногдлэх:

• Энэ чиглэлийн мэргэжил эзэмшсэн;

• Эсвэл мэргэшсэн хүнийг авч

1. С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" (Анхны хэвлэл). 523 дах тал.

2. Л.Баасан, Г.Баярмаа "Монгол улсын Хөдөлмөрийн эрх зүй" (тайлбар схем). УБ. 2009 он, 74 дэх тал.

Схем-1



ажиллуулах ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь ажил олгочийн шууд удирдлага дор ажиллаж, түүний өмнө ажлаа бүрэн хариуцна.

Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан **зөвлөл** болон **орон тооны ажилтан** ажиллуулахад баримтлах норматив, зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм, ажилтны ажлын байрны тодорхойлолтын загварыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоодгоороо онцлогтой.

Ажил олгогч хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах хуульд заасан үүргээ биелүүлээгүйгээс ажилтан хөдөлмөрийн чадвараа алдах, бие эрхтэндээ гэмтэл авах улмаар амь насаа алдах зэрэг таагүй явдал амьдралд цөөнгүй тохиолддог.

Эдгээр тохиолдлуудад дээр дурьдсанчлан хариуцлага хүлээх субьект нь зөвхөн ажил олгогч эсвэл хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан байна. Тиймээс ч шинээр батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд **үл хамаарах** ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглосон. Ингэснээр хөдөлмөрийн харилцааны бүхий л салбарт хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болно.

Аж ахуйн нэгж байгууллагуудад хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт (захиргааны хяналт)-ыг хэрэгжүүлдэг.

Захиргааны хяналт гэдэг нь хууль тогтоомж болон түүнийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас удирдлагын тодорхой салбар хүрээнд байгууллага, аж ахуйн нэгж иргэдэд нийтээр дагаж мөрдүүлэх тусгай журмын биелэлтэд хуулиар тусгайлан эрх олгогдсон мэргэжлийн байгууллага, алба хяналт хийх үйл ажиллагаа юм. Энэ ч утгаараа хяналтыг хэрэгжүүлж байгаа болон мөн түүнчлэн төрийн албанд ажиллагсдын хөдөлмөрийн харилцаатай холбогдуулан улс орнуудад "Хөдөлмөрийн эрх зүй"-г нийтийн болон хувийн эрх зүйд хамааралгүйгээр "*Холимог эрх зүй*"-д хамааруулан судалдаг байна.[3] (схем 2-ийг үзнэ үү)

Улсын Мэргэжлийн Хяналтын албаны нийтлэг дүрмийн 2.7-д заасаар хөдөлмөрийн улсын хяналтыг **хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлын зохион байгуулалт, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл болон техникийн аюулгүй ажиллагаа нь улсын стандартын шаардлагад нийцэж байгаа байдал, ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт, судалгааны талаарх шийдвэрийн хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлдэг байна.**

Хэдийгээр хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудлыг хууль тогтоомжоор хуульчилж зохицуулсан хэдий ч практикт ажил олгогч нар хуулийн дээрх зааллыг дагаж мөрдөхгүй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүй ажлын байранд иргэдийг ажиллуулснаар иргэд үйлдэрлэлийн осолд орох, гэдний эрхийг хохироох явдал ч цөөнгүй гарч байна.

Ямар нөхцөл байдалд гарсан ослыг үйлдвэрлэлийн осолд тооцох талаар Засгийн газрын 2000 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг судлан бүртгэх комисс"-ын дүрмээр зохицуулдаг байсан ба Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль батлагдан гарснаар дээрх тогтоол хүчингүй болж Засгийн газрын 2009 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийн дагуу зохицуулагдах болсон.[4]

Уг тогтоолд заасны дагуу дараах нөхцөл байдалд гарсан ослыг үйлдвэрлэлийн осолд оруулан тооцохоор заасан. Үүнд:

1. Ажилтан ажлын үндсэн болон туслах байранд , эсхүл гэрээ хэлэлцээр, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу албан томилолт, дайчилгаагаар бусад газарт ажил үүргээ гүйцэтгэж байхдаа;

2. Ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хоорондоо байнга явж

3. Кристофер Осакие. "Харьцуулсан эрх зүй судлал" (ерөнхий ба тусгай анги) . УБ., 2005 он, 24 дэх тал.

4. НХХЯ, УМХГ, ОУХБ, НҮБХХ "Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчдын гарын авлага". УБ., 2009 он, 35 дахь тал.

Схем-2



ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтан ажлын цагаар бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед;

3. Ажлын байраа орхих боломжгүй ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтан ажлын байрандаа амарч байх, ажил эхлэхийн өмнө болон ажил дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхлэн цэгцлэх, хувцсаа солих, усанд орох, ажил хүлээлцэх үед;

4. Ажилдаа ирэх буцах замдаа аливаа тээврийн хэрэгслээр буюу явган явж байхдаа (энэхүү ослыг тогтоохдоо тухайн ажилты гэр, ажлын байр хоорондын чиглэл, цаг хугацааг үндэс болгоно);

5. Үндсэн ажил үүргээ гүйцэтгэх үедээ байгаль цаг уур, гал, ус гэнэтийн аюул, цацраг идэвхит болон химийн хорт бодисын нөлөөлөл, биологийн гаралтай өвчин үүсгэгчийн гэнэтийн аюулд өртсөн;

6. Тухайн байгууллагад ашиглаж байгаа түүхий эд, материал болон бусад технологийн процессод ашигладаг химийн бодис, биологийн гаралтай боҳирдуулагчийн улмаас үүссэн өвчин, хордлогод өртсөн;

7. Байгалийн гэнэтийн аюул, гамшиг, хөнөөх хэрэгслийн болон гоц халдварт өвчний голомт, сүйрэл, дэлбэрэлтийн үед;

8. Ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ зам тээврийн осолд орсон тохиолдолд ослыг замын цагдаагийн байгууллагын дүгнэлтийн дагуу хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч судалж баталгаажуулна.

Ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа үйлдвэрлэлийн осолд орох улмаар хөдөлмөрийн чадвараа алдах тохиолдолд ажил олгогчоос төлөх нөхөн төлбөрийн асуудал хуульчлагдсан ба энэ нь хөдөлмөрийн эрх зүй дэх ажил олгогчийн хүлээх эд хөрөнгийн хариуцлагын нэг хэлбэр юм.

Даяарчлалын эрин үед хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөн буюу гадаалад ажиллах явдал улам нэмэгдэх болсон ба үүнтэй уялдуулан хөдөлмөрийн харилцаан дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал нь аль ч улс орны төрийн бодлогын хэмжээнд авч үзэх асуудал болсон. Хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөний үндсэн дээр Монгол Улсын иргэд Солонгос Улсад гэрээгээр болон бусад хэлбэрээр хөдөлмөр эрхлэх явдал маш их байдаг.Үүнээс үүдэн Солонгос Улсад хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдлын зохицуулалт хэрхэн байдаг болон энэ асуудлыг төрийн бодлогын хэмжээнд хэрхэн авч үздэг талаар авч үзье.

Солонгост хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хамгаалах бодлого нь[3]:

- Хөдөлмөрийн яам (Үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хамгаалах хэлтэс);
- Засгийн газрын байгууллага болох Солонгосын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хамгаалах агентлаг;
- Ослоос урьдчилан

хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

байгууллагууд тус тус үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Солонгосын үйлдвэрлэлийн ослын тоон үзүүлэлтийг үзүүлбэл:
(хүснэгт 1-ийг харна уу)

Хүснэгт 1

	1970	1980	1990	2000	2006	2007	2008
Ослын хувь	4,85	3,02	1,76	0,73	0,77	0,72	0,71
Ажлын байр ба үйлдвэр аж ахуйн нэгжийн тоо	-	63,100	129,687	706,231	1,292,696	1,429,885	1,594,793
Ажилчдын тоо	779,053	3,752,975	7,542,752	9,485,557	11,688,797	12,528,879	13,489,986
Осолд өртөгсдийн тоо	37,752	113,375	132,893	68,976	89,910	90,910	95,806
Өвчлөгсдийн тоо	-	1,183	1,1638	2,937	9,114	2,406	2,422

Дээрх тоон үзүүлэлтээс үзэхэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ахуйн асуудлыг төрийн бодлогын хэмжээнд тусгайлан авч үзсэнээр үйлдвэрлэлийн ослын хувь хэмжээ буурсан дүн харагдаж байна.

Монгол улс 1969 онд НҮБ-ын төрөлжсөн байгууллага болох Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагад гишүүнээр элссэн бөгөөд хөдөлмөрийн харилцааны салбарт олон гэрээ конвенцийг холбогдох зөвлөмжийн хамтаар соёрхон батлаад байна. Үүнээс хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалалтай холбоотой конвенц, зөвлөмжүүдэд:

1. Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай 59 дүгээр конвенц;

2. Газар дор буюу уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай 123 дугаар конвенц;

3. Газрын дор буюу уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай 123 дугаар конвенцийн 124 дүгээр зөвлөмж;

4. Үйлдвэрийн газарт ажилчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах болон тэдэнд олгогдох бололцооны тухай 135 дугаар конвенц;

5. Үйлдвэрийн газарт ажилчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах болон тэдэнд олгогдох бололцооны тухай 135 дугаар конвенцийн 143 дугаар зөвлөмж;

6. Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенц;

7. Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцийн 146 дугаар зөвлөмж;

8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 155 дугаар конвенц;

9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 155 дугаар конвенцийн 164 дүгээр зөвлөмж;

10. Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дүгээр конвенц;

11. Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дүгээр конвенцийн 168 дугаар зөвлөмж;

12. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хөдөлмөрийг устсгах тухай 182 дугаар конвенц тус тус болно[6].

Хэдийгээр хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн зохицуулалт нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон үндэсний хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа хэдий ч хөдөлмөрийн харилцаанд хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдах улмаар иргэд үйлдвэрлэлийн осолд орж хөдөлмөрийн чадвараа алдах, цаашлаад амь насаа ч алдах байдал өмнө дурьдсан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хийсэн шалгалтын дүнгээс тодорхой байна.

Тиймээс хөдөлмөр хамгааллын стандартад тавигдсан шаардлага (норм, норматив) хэм хэмжээг өнөөгийн нөхцөл байдалд тохируулан тодорхой болгох, гүүнчлэн эрх бүхий байгууллагаас ажлын байрны аттестачлалыг тогтмол хийж байх, аж ахуйн нэгж байгууллага бүр шинээр батлагдан гарсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нийцүүлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан **ажилтныг** ажиллуулах, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх бүхий л нөхцөл бололцоог хангаж ажиллах (ажлын байрны болон хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг зохих журмын дагуу хийлгэх), мөн ажилтнууд хөдөлмөрийн харилцаанд оролцон ажиллахдаа хууль дүрмийн дагуу үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж ажилласнаар Монгол Улсын Үндсэн хуулиар тунхаглагдсан "**иргэд хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах**" эрхийн баталгаа хангагдах болно.

5. Korea Occupational Safety& Health Agency, "Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй", 2009 он.
6. Төрийн мэдээлэл (Тусгай дугаар), Монгол Улсын Олон Улсын Гэрээ (I боть). УБ., 2004 он.

ХҮЧИН ТӨГӨЛДӨР БУС ГЭРЭЭНЭЭС ҮҮСЭХ ҮР ДАГАВАР

Иргэний эрх зүйн харилцаанд хэлцлийг хүчингүйд тооцох болон хэлцэл хүчингүйд тооцогдох зохицуулалт байх бөгөөд эдгээр нь хэлцлийг хүчингүй гэж үзэх үндэслэлээрээ ялгагдахаас гадна иргэний эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгож байгаагийн хувьд эрх зүйн мөн чанарыг тодорхойлоход хамгийн гол асуудал нь тэдгээрийн үр дагаврын хувьд ялгаа байдаг эсэх тухай асуулт урган гардаг. Хэрэв хүчингүй байх гэдгийг байгуулсан гэрээний хүрээнд бий болсон болон цаашид бий болох эрх зүйн үр дагаврыг үгүйсгэх явдал гэж ойлговол дээрх хэлцлийн хувьд зарчмын хувьд ялгаатай зүйл байхгүй мэт ойлгогдоно.

Хэлцлийн хүчинтэй ба хүчин төгөлдөр бус болох асуудал:

"а. Хэлцэл, гэрээг байгуулсан субьект, түүний эрх зүйн чадамж, мөн тэдгээрийн хүсэл зоригийн илэрхийлэл, хэлцлийн хэлбэр ;

б. Хүчин төгөлдөр бус ба бусад тооцуулах хэлцлийн хамаарал;

в. Хүчин төгөлдөр бус болсноос үүсч байгаа үр дагавар гэсэн хүрээг хамруулан багтаасан ойлголт байна".[1]

Гэтэл үр дагаврыг хэрхэн тооцох, хохирлыг хэрхэн барагдуулах гэдэг асуудал нь хэлцлийг байгуулсан үндэслэл, ямар төрлийн хэлцлээс хамааран өөр өөр байдаг. Хэлцэл гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцохдоо, ямар үндэслэлээр тухайн гэрээ хүчингүй болж байгаа болохыг нягтлах, тухайлбал, хэлцлийг байгуулсан талууд санаатайгаар хууль тогтоомжийг зөрчиж гэрээ, хэлцэл байгуулсан бол хохирол барагдуулах асуудал яригдахгүй байх боломжтой байдаг.

Хэлцэл хүчингүйд тооцогдож

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант Ц.Давхарбаяр

байгаа бол хэлцлийн аль нэг тал өөрийн эрх ашиг зөрчигдөж байгааг тухайн үед мэдээгүй, мэдэх боломжгүй байдаттай холбоотой гэрээг ирээдүйд хүчингүй болгуулахаар хандах тохиолдол байдаг учраас хохирлыг зөвхөн нэг тал буюу буруутай тал барагдуулна. Гэхдээ хүчингүйд тооцох болон хүчингүйд тооцогдох хэлцлийн ялгаг:

1. Гэрээ байгуулсан үеэс өөрийн хууль зүйн хүчин чадлаа алдаж байдаг (хүчингүйд тооцох хэлцлийн үр дагавар);

2. Хуулийн хүчин чадлаа ирээдүйд алддаг. (энэ үр дагавар хэлцлийн бүх төрөл хамаарахгүй)

Ирээдүйд буюу тодорхой хугацааны дараа хэлцэл, гэрээг хүчингүйд тооцуулах асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэх бөгөөд хүчингүйд тооцуулах гэрээний "хүчинтэй байх" асуудал маргааны гол сэдэв, үндэслэл болж шийдвэрлэгдэнэ. Гэрээг хүчингүйд тооцуулж, хүлээн зөвшөөрснөөр, "хоёрдмол" харилцаа буюу нэгдүгээрт, хүчин төгөлдөр гэрээ анхнаасаа хүчин төгөлдөр бус болж "хувирах", хоёрдугаарт, түүний одоогийн болон ирээдүйн үйлчлэл дуусгавар болно.

Иймээс байгуулсан хэлцэл анхнаасаа хүчин төгөлдөр бус байх тохиолдлын үр дагаврын асуудлыг авч үзсэнээр түүнээс уламжлан хүчин төгөлдөр бусад тооцуулах хэлцлийн үр дагавар ч шийдвэрлэгдэх боломжтой тул эхлээд хэлцэл хүчин төгөлдөр байснаас үүсэх үр дагаварт анхаарлаа хандуулья.

Иргэний хуульд зааснаар хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон үед үр дагаврыг Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д зааснаар гэрээгээр шилжүүлэн авсан зүйлийг талууд харилцан буцаан өгөх, биетээр буцаан өгөх боломжгүй болсон тохиолдолд (эд хөрөнгийг ашиглах, ажил гүйцэтгэл, үйлчилгээ үзүүлэх) үнэ өртгийг мөнгөн хэлбэрээр олгох ёстой гэж ойлгодог.

Хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцоход анхнаасаа хууль зүйн үр дагавар үүсгэхгүй буюу үүргийн ба эд хөрөнгийн эрхийн үр дагавар агуулаагүй гэж үздэг. Учир нь гэрээ байгуулсан талуудад, гэрээнээс үүсэх гарах ямар ч эрх, үүрэг үүсэхгүй гэж үздэг. Тухайлбал, худалдах, худалдан авах гэрээг хүчингүй болгоход худалдан авагчид бараа шилжүүлэхийг шаардах эрх үүсэхгүйн адил худалдагчийн талаас төлбөр шаардах эрх үүсэхгүйн үндэслэл бол талуудад үүргийн эрх зүйн харилцаа талуудын худалдах, худалдан авах гэрээ байгуулах үед үүсэхгүйтэй холбоотой.

Гэхдээ хэдийд, ямар хугацаанд хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцож байгаа нь ч үр дагаврыг тодорхойлоход ач холбогдолтой. Хэрэв гэрээ биелэгдээгүй, талууд

1.А.Жилинский, А.Рёрихт, "Введение в немецкое право". М, 2001 г, С.324.

хэлцэл байгуулсан хүссэн үрдүн бий болж амжаагүй байхад хүчин төгөлдөр бус гэж үзсэн бол нэгэнт гэрээ, хэлцлийн дагуу үүргээ биелүүлээгүй байдаг учраас анхны байдалд оруулах шаардлагагүй байдаг бол талууд үүргээ биелүүлсэн байх, хэсэгчлэн биелүүлсэн байх зэрэг үед анхны байдалд оруулахын тулд хууль зүйн нэмэлт зохицуулалт шаардагдаж эхэлнэ. Гэтэл шилжүүлэн авсан эд хөрөнгийн ангилал, төрлөөс хамаарч, тодруулбал, төрлийн шинжээр тодорхойлогдох хөрөнгө байх тохиолдолд эд зүйлийн эзэмшигч[2] байдаг.

Иймээс шүүхээр хэлцэл, гэрээг хүчин төгөлдөр бусад тооцохдоо, байгуулсан цагаас нь хүчин төгөлдөр бус гэж тооцох ба харин гэрээг нэгэнт хүчингүй болсонтой уялдан, анх гэрээг байгуулах үед ямар байдалтай байсан тэр байдалд оруулах (Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 5 дахь заалт) үүднээс талуудын шилжүүлсэн зүйлийг буцаан олгох, ийм боломжгүй, ялангуяа дээр өгүүлснээр, шилжүүлсэн хөрөнгийн шинж байдлаас хамаарч, хохирлыг нөхөн төлүүлэх асуудал гарах ба улмаар Иргэний хуулийн бусад үндэслэлүүд үүсч болох юм. Тухайлбал, гүйцэтгэл хийгдсэн худалдах, худалдан авах хүчин төгөлдөр бус гэрээний (гэрээний зүйл нь төрлийн шинжээр тодорхойлогдох хөрөнгө байгаа тохиолдолд) худалдан авагч нь гэрээний зүйлийг шилжүүлэн авах эрх зүйн үндэслэлгүй байх бөгөөд худалдагч нь мөнгөний эзэн гэж тооцогдох боловч мөн л мөнгө–үнийг авах эрхгүй байдгаараа үндэслэлгүй хөрөнгөжсөн этгээд байх болно. Дээр дурдсан нөхцөл байдлыг хуулийн дагуу зохицуулахын тулд, хууль бус эзэмшигчээс гэрээний зүйлийг өмчлөгчид шилжүүлэх шаардлагатай болдог.

Хэрэв талууд хүчин төгөлдөр бус худалдах, худаллан авах гэрээгээр гүйцэтгэлээ хийсэн байвал тухайн тохиолдолд эдийн болон элийн бус баялгийн харилцааны үндэслэл үүсээгүй боловч худалдан авагч шилжүүлсэн эд зүйлст өмчлөгч болох ба худалдагч нь төлбөрийн (мөнгөний) хувьд нэгэнт төрлийн шинжээр тодорхойлогдох зүйлийн хувьд эзэмшигч болохын зэрэгцээ үндэслэлгүйгээр хөрөнгөжих харилцааг үүсгэх нөхцөлийг бүрдүүлнэ. Иймээс гэрээг байгуулсан цагаас эхлэн хүчин төгөлдөр бус гэж тооцох асуудлыг гэрээ үйлчилж эхлэхээс өмнө тооцох тул гэрээний талууд нь үүргийн харилцаагаар тодорхойлогдсон эрх эдлэхгүй. Өөрөөр хэлбэл, талууд харилцан тохиролцсон эрх үүргээ шаардах эрх үүсэхгүй бөгөөд зохих үүрэг гүйцэтгэх асуудал гарахгүй. Энэ нь араасаа ямар нэгэн нэмэлт иргэний эрхийн объект шилжүүлэх гэсэн үр дагавар дагуулахгүй.

Харин хүчин төгөлдөр бус гэрээг хэсэгчлэн гүйцэтгэсэн бол нэгэнт үүрэг гүйцэтгэх эрх хэрэгжсэн байх тул иргэний эрхийн объектыг шилжүүлэх, түүний дагуу эрх үүргийг хэрэгжүүлсэн байх зэргээр үр дагавар агуулагдсан байдаг. Энэ тохиолдол нь иргэний эрх зүйн харилцааны зохих ёсны үндэслэл бүрдээгүй байдаг гэдгээр хүчин төгөлдөр бус гэрээ, хэлцэлд хамрагдах боловч өмнө өгүүлсэн (эрх, үүргээ хэрэгжүүлээгүй байх) нөхцөл байдлаас ялгатдах нь үүргийг хэсэгчлэн буюу бүрэн биелүүлснээр хөрөнгийг шилжүүлж авсан талууд эрх зүйн ямар нөхцөл байдалд байгаа, эд хөрөнгөө буцаан авах шаардлагын үндэслэл нь юу байх зэргийг тодорхойлох асуудлыг үүсгэж байдгаараа онцлог. Гэрээг хүчин төгөлдөр бус болгох буюу тухайн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулахаас өмнөх байдалд оруулах гэдэг нь иргэний маргаан болохын хувьд шийдвэрлэх шаардлагатай зүйл нь:

1. Талууд байгуулсан гэрээ, үүргээр холбоотой байх, мөн гуравдагч этгээд үүссэн үр дагавраар дамжин гэрээний галуудтай холбогдсон болохыг тогтоох;

2. Эд хөрөнгөө буцаан авч байгаа этгээд нь хөрөнгөө буцаан авахын тулд гэрээг хүчин төгөлдөр бус болохыг нотлох үүрэг хүлээсэн байхыг шаардана.

Монгол Улсын иргэний хууль тогтоомжийн хөгжлөөс сөхөн үзвэл, 1926 оны Иргэний хуульд "Аливаа хүчин төгөлдөр бус гэрээ хэлэлцээний тухай" заагаад үр дагаврыг "Хүчин төгөлдөр бус гэрээ хэлэлцээг гүйцэтгэсэн этгээд уул төлсөн зүйл буюу гүйцэтгэсэн үүргийн үнэ хөлсийг бүрнээ эргүүлэн авахаас гадна хамаг сүйтгэлийг нэхэмжилж болох"-ыг 191, 192, 193 дугаар зүйлүүдэд заасан байдаг нь зөвхөн ерөнхий ангийн хүрээнд зохицуулж байсан ба түүнээс гадна үр дагаврыг нь, зөвхөн хохирлыг барагдуулах байдлаар зохицуулжээ.

Харин 1952 оны Иргэний хуульд "хуульд заасан шаардлагыг хангаагүй бол хэлэлцээ хүчин төгөлдөргүй болох"-ыг заагаад үр дагаврыг хэрхэн зохицуулах нь тусгагдаагүй байна. 1963, 1994, 2002 оны Иргэний хуульд хүчин төгөлдөр бус болон бусад тооцуулж болох хэлцлийг ангилан, ерөнхий үр дагаварыг зохицуулсан (талууд гэрээгээр авсан зүйлээ харилцан буцаах, боломжгүй бол үнийг мөнгөн хэлбэрээр төлөх) зохицуулалт буюу хохирлыг барагдуулах, түүнээс гадна гэрээний зүйл, төрлөөс хамааран үр дагаврыг өөр байдлаар зохицуулах боломжийг ч хангасан байна.

2."Эд зүйл эзэмших эрх шилжих асуудал төрлийн шинжээр тодорхойлогдох хөрөнгийн хувьд бодитойгоор эзэмшигчид шилжинэ. Эзэмшигчийн мэдэлд байгаа мөнгө, үнэт цаас зэрэг төрлийн шинжээр тодорхойлогдох хөрөнгийн бусдаас ялгагдах хувийн шинж нь алдагддаг тул энэхүү тодорхойгуй байдал нь олж авсан этгээдийн өмчлөлийг үүсгэн, тэдгээрийн өмнөх өмчлөгчийн хувьд өмчлөх эрх нь дуусгавар болно." Под.ред. Е.А.Суханов, "Гражданское право". М, 2000г., С.447.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар хоёр талын болон ер нь хохирол барагдуулах асуудал иргэний хуулийн оролцогсодын эрхийн хамгаалалтын нэг хэлбэр. Түүнчлэн хохирол барагдуулах нь (**реституц**) эд хөрөнгийг шаардах эрх (**виндикац**), үндэслэлгүй хөрөнгөжих (**кондикц**) асуудалтай нэг эгнээнд байдаг нь, аль аль нь иргэний эрхийн хамгаалалтын шинжтэй хэм хэмжээ байдаг, нөгөө талаар аль аль нь хөрөнгийг бусдад шилжүүлж байгаа үед **хууль бус, үндэслэлгүйгээр** шилжих тохиолдолд хамгаалах хамгаалалыг үүсгэж байдгаараа холбогддог юм. Бид гэрээг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлагаар эдгээр ойлголтыг хамруулж багтаах, хөндөх нь цөөнгүй байдаг.

Эдгээр асуудал хоорондоо ямар хамааралтай байдаг талаар эрдэмтэн, судлаачид цөөнгүй тэмдэглэсэн байдаг.

1. Хохирол барагдуулах нь үндэслэлгүй хөрөнгөжихтэй нэг утгаар хэрэглэгдэнэ гэж үздэг. "Хэрэв аль нэг этгээд гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэхийг шаардаж байгаа бол энэ нь гэрээ байгуулсны үндсэнд өөрт оногдох эзэмшлийн эрхийг үндэслэлгүй хассан, эсвэл зохих ёсны үндэслэл байхгүй байхад үүргийг гүйцэтгэсэн, хэсэгчлэн гүйцэтгэсэн нөхцөл байдал бий болсон байдаг тул эдгээрийг үндэслэн сонирхогч этгээдийн хувьд (нэхэмжлэгч) эрхээ сэргээлгэх (үндэслэлгүй хөрөнгөжсөн байх), үүргээс чөлөөлөгдөх (гэрээний дагуу эрх үүрэг үүссэн байх) асуудал зэрэгцэн гарч ирдэг учраас энэ хоёр асуудлыг хамтад нь шийдвэрлэхийг шаардаг". Мөн "гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэх үед эд хөрөнгийг буцаан гаргуулах үндэслэл бол тухайн эд хөрөнгийн шинжээс (нэг бүрийн болон төрлийн шинж) үл хамаарч, үндэслэлгүйгээр бий болгосон буюу эзэмшсэн нөхцөл байдал байдаг"[3] гэж дээрх ойлголтыг адилтган үзсэн байна.

2. Нөгөө талаас, хохирол барагдуулахаар шаардах нь үндэслэлгүй хөрөнгөжих, эд хөрөнгийг эзэмшлээс гаргуулахаар шаардах эрхийн аль алинд хамаарч болно. "Хүчин төгөлдөр бус гэрээний олон төрөл, үндэслэлүүдийн ялгаа нь эд хөрөнгийг буцаан шаардах эрхийн үндэслэлд (тухайлбал, эд юмсын эрх зүйн үндсэнд гаргаж байгаа эд хөрөнгийг шаардах нэхэмжлэл) үүргийн эрх зүйн харилцааг үндэслэн гаргах үндэслэлгүй хөрөнгөжихөд оршино".

Эдгээр ойлголтоос үндэслэн хуулиа эргэн харья. Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д "хөрөнгө олж авсан этгээд болон үүрэг гүйцэтгэгч этгээдийн хооронд үүрэг үүсээгүй, эсхүл үүрэг нь хожим дуусгавар болсон буюу хүчин төгөлдөр бус болсон". Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.1-д "өмчлөгч хөрөн өө бусдын хууль бус эзэмшлээс шаардах эрхтэй" гэсэн заалтын агуулга нь хэлцэл, гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох нь гэрээг байгуулаагүй буюу гэрээ байгуулахаас өмнөх байдалд сэргээн оруулах явдал байх бөгөөд өмчлөгчийн хүсэл зоригоос гадуур эд хөрөнгө хууль бус эзэмшигчид шилжсэн, бусдын хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авсан буюу эзэмшсэн бол өмчлөгч, эрх бүхий этгээдэд буцаан олгох нь зайлшгүй болох нь харагдаж байна.

Виндикац буюу эд хөрөнгө шаардах нэхэмжлэлийг, гэрээгээр нэг тал нөгөө талаас хохирлыг барагдуулахаар шаардлага гаргасан үед гаргах нь агуулгын шинжээрээ зарим үед зорчилдөх ба учир нь эдгээр нэхэмжлэлийн шаардлагууд эд зүйлийн шинжээс хамааран өөр өөрийн онцлог шинжийг агуулж байдагтай холбоотой. Нөгөө талаар эд хөрөнгө гаргуулах нэхэмжлэлийг өмчийг шударга, шударга бусаар эзэмшиж байгаа этгээд ямар нэгэн үндэслэлээр сөрөг нэхэмжлэл гаргах боломжгүй байх тохиолдолд хэрэглэгддэг. "Нэг бүрийн шинжээр тодорхойлогдож байгаа эд хөрөнгийг буцаан шаардах эд хөрөнгийн нэхэмжлэлийн гол шинж нь хүчин төгөлдөр бус гэрээгээр шилжсэн хөрөнгө тухайн этгээдийн өмчлөлийн зүйл болохыг нотлох үүрэг хүлээх бөгөөд учир нь нэг бүрийн шинжээр тодорхойлогдох хөрөнгө хүчин төгөлдөр бус гэрээний оролцогч талд өмчлөгчөөс шууд шилжих үндэслэлгүй ба харин уг өмчлөлийн зүйлийг өөр этгээдэд эхэлж шилжүүлсэн байх, эсвэл өөр нөхцлөөр шилжүүлсэн байх нь илүү тохиолддог. Тухайлбал, хохирол барагдуулах асуудал нь ямар нэгэн эрхэд үндэслэгдээгүй, өмч эзэмших бодит байдалд тулгуурласан хамгаалалтын арга гэж үзэх нь виндикацийн субъектив эрхэд суурилан, эрхийг хамгаалдагтай холбогдож байгаа нь хоорондоо хамааралтай байх нөхцлийг бүрдүүлэн, улмаар үүнийг нотолсон нотолгоо шаардаг"[4].

Бидний үзэл бодолд хамгийн дөхүүтэй нь виндикацаар шаардах эрх эд зүйлийг биетээр олгосон нөхцөлд гарна. Гэхдээ тухайн зүйлийг буцаан өгөх боломжгүй байгаа тохиолдолд энд нөхөн төлбөр шаардахыг үгүйсгэхгүй, ингэхдээ эд хөрөнгө шаардах нэхэмжлэлийн үндсэнд бус, эд хөрөнгийн нэхэмжлэлээс үүрэг-эрх зүйн чанартай шаардлагад шилжих, үндэслэлгүй хөрөнгөжих байдлаас зарим тохиолдолд хохирол учруулах байдалд шилжих замаар нөхөн төлбөр хийхийг үгүйсгэхгүй бөгөөд нэг бүрийн шинжээр тодорхойлогдох эд зүйлийг мөнгөн хэлбэрээр орлуулан шаардаж болно гэдэг нь хуульд заасны дагуу нэг нэхэмжлэлийн хүрээнд гаргах шаардлагыг өөрчлөх боломжтой гэсэн үг. Өөрөөр хэлбэл, нэг

3. Ф.С.Хайфец, "Недействительность сделок по российском гражданскому праву". М, 1999г.,

4. Д.О.Тузов, "Реституция в гражданском праве". М, 1999г., (дам ишлэл)

бүрийн шинжээр тодорхойлогдох эд зүйлтэй холбоотой гэрээг хүчин төгөлдөр бус болгуулахаар нэхэмжлэл гаргасан бол эхлээд гэрээг хүчин төгөлдөр бус болгох улмаар эд хөрөнгө гаргуулахаар (энд виндикацийн асуудал хөндөгдөнө) шаардах ба хөрөнгө байхгүй болсон бол нэхэмжлэлийн шаардлага үндэслэлгүй хөрөнгөжсөн тухай шаардлагад шилжин, мөнгөн хэлбэрээр эргэн төлөх асуудал болж хувирдаг. Мөнгөн хэлбэрээр шаардахдаа тухайн хүчин төгөлдөр гэрээгээр нөгөө талд шилжүүлэн өгөх үеийн үнэ буюу зах зээлийн ханшаар тодорхойлно.

Харин хүчин төгөлдөр бус гэрээгээр төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгийг шилжүүлсэн бол хохирол барагдуулахаар шаардаж байгаа шаардлага үндэслэлгүй хөрөнгөжсөн шаардлага болж хувирах тохиолдол байдаг.

Тэгэхээр гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцоход нэхэмжлэгч нь хохирлыг барагдуулах, үүнээс гадна виндикац болон үндэслэлгүй хөрөнгөжих үндэслэлийг хамт хэрэглэх, эсвэл аль нэгийг нь сонгон хэрэглэх буюу хохирлыг барагдуулах, эсвэл эд хөрөнгө шаардах гэх зэргээр хэрэглэж байна. Эдгээр хамгаалалтын аргуудыг нэхэмжлэл гаргахдаа ямар нөхцөлд хэрэглэх, ямар хэмжээнд байх асуудал чухал. Иймд дээр өгүүлсэн болон практикаас дараах гурван өөр байдал байж болмоор байна. Үүнд:

• Хохирол гаргуулахаар шаардах нь (реституц) хамгаалалтын шаардлага болон тавигдах боловч бие даасан, эрхийн хамгаалалт болохгүй тул эд хөрөнгө гаргуулах (виндикац) болон үндэслэлгүй хөрөнгөжих (кондикц) хэм хэмжээний зохицуулалт, шаардах эрхийг араасаа дагуулах боломжтой;

• Хэлцэл, гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцоход хохирол барагдуулах нь нөгөө талаар бие даасан арга гэж үзэх ба буцаан авахаар шаардаж байгаа эд хөрөнгийг шинжээс нь хамааран эд хөрөнгө гаргуулах шаардлагаар солигдох магадлал байдаг. Гэрээний талуудад шилжүүлсэн хөрөнгө гэрээ байгуулсны дараа гуравдагч этгээдэд шилжин очсон бол Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.10-д зааснаар "хүчин төгөлдөр бус хэлцлийн үндсэн дээр хийсэн хэлцэл" нэгэнт өмнө байгуулсан, үндэслэл болж байгаа хэлцэл хүчин төгөлдөр бус болсон бол, үүнийг үндэслэн байгуулсан хэлцэл ч хүчин төгөлдөр бус болох тул эд хөрөнгөө хууль бус эзэмшлээс гаргуулах, эсвэл хүчин төгөлдөр бус гэрээтэй холбоотой нэхэмжлэл ба шаардлага гаргах боломжтой. Гэхдээ анхаарах зүйл нь хохирол барагдуулахдаа шударга ба шударга бус эзэмшигчээс эд хөрөнгө гаргуулахаар шаардаж болохгүй бөгөөд учир нь эд хөрөнгө гаргуулах нэхэмжлэл нь хууль бус эзэмшигчийн эрх ашгийг хөндөж бол хохирол гаргуулах нь түүнийг анхдагч байдалд оруулна;

• Хохирол барагдуулах нь бие даасан шаардлага байх ба бусад иргэний эрх зүйн хамгаалалтын бие даасан аргыг (эд хөрөнгийн нэхэмжлэл болон үндэслэлгүй хөрөнгөжих) маш тодорхой нөхцөл байдалд хэрэглэх боломжтой байдаг. Энэ талаар "...практикт эдгээр ойлголтыг хутган ойлгох, түүний дотор гэрээний шаардлагыг эд хөрөнгийн нэхэмжлэлээр чөлөөтэй солихыг зөвшөөрөх, эсвэл эд хөрөнгийн нэхэмжлэлийг гухайн гэрээг хүчингүйд тооцуулах нэхэмжлэлд шилжүүлэх гэх мэт онолын үндэс суурийг нэхэмжлэгчийн зүгээс чөлөөтэй сонгон авах байдал байна. Энэ нь шинжлэх ухааны үндэслэлгүй бөгөөд сөрөг үр дагавраас өөр зүйл эцсийн үр дүнд гаргаж чадахгүй"[5] гэжээ.

Эндээс дүгнэвэл гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцоход, эд зүйлийг эргүүлэн авах талаарх шаардлага нь зөвхөн реституцийн буюу хохирол барагдуулах л шаардлага байх бөгөөд харин гуравдагч этгээдэд эд хөрөнгө шилжсэн байвал, энэ тохиолдолд эд хөрөнгө гаргуулах шаардлага гарна. Иймд эд хөрөнгө гаргуулахаар шаардлага гаргах үндэслэл нь шаардах эрх бүхий этгээд нь өмчлөгч байх ёстой. Гэрээ байгуулсан талууд, тухайлбал, нэг гал нөгөөдөө хөрөнгө, эрхийг шилжүүлж байгаа үед шилжүүлж байгаа этгээд өмчлөгч буюу эсвэл эрх бүхий этгээд байх, түүнчлэн гэрээ байгуулсны дараа өмчлөх эрх гэрээний нөгөө талд бүрэн шилжсэн байх ч боломжтойг хууль зохицуулсан ба хэрэв өмчлөгч биш бол эд хөрөнгө гаргуулахаар шаардах эрхгүй. Харин нэгэнт гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол эд хөрөнгө шилжүүлэн авсан этгээд үндэслэлгүй хөрөнгөжсөн этгээд байх үндэслэл эндээс гарч ирдэг байна.

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОНО

Хөдөлмөрийн тухай хуульд 2010 онд нэмэлт, өөрчлөлт оруулах болжээ. Тиймээс дээрх хуульд ямар өөрчлөлт оруулах талаар байр сууриа илэрхийлэх зорилгоор Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос Нидерландын ажил олгогч эздийн байгууллагатай хамтран дугуй ширээний ярилцлага зохион байгуулла. "Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн шинэчлэл ажил олгогчдын байр суурь" сэдвийн дор болсон дээрх уулзалтад 30 гаруй байгууллагын хуулийн зөвлөх оролцов.

Уулзалтаар хөдөлмөрийн хамтын харилцаа, маргааны зохицуулалтыг хэрхэн боловсронгуй болгох талаар зөвлөлдөжээ. Мөн компанийн түвшинд хамтын гэрээгээр цалин хөлсний асуудлыг зохицуулах, Хөдөлмөрийн гухай хуулиар хүний эрх чөлөө болон минимум стандартыг хангах талаар ярилцсан байна.

(www.legalinfo.mn сайтаас)

5. Под.ред.А.П.Сергеева, Ю.К.Толстый "Гражданское право. Учебник. Часть 1". М, 1998., С.445.

ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА БА ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Монгол Улсын Үндсэн хууль болон хөдөлмөрийн хуульд иргэдийн хөдөлмөрийн харилцааг зохицуулж байгаа бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг нийцүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол болон орон нутгийн шинжтэй зарим актууд нь хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хуулийн үндсэн зарчим, заалтуудтай зөрчилдөх, давхарддаг зөрэг байдлууд үүсч байна. Энэ нь эргээд иргэдийн эрх ашгийг хохироох, иргэдийн хөдөлмөрлөх эрхийг зөрчих нөхцөл байдлуудыг үүсгэж байна.

Энэ нь нийгэм өдөр бүр хөгжиж, даяарчлагдаж буйтай холбоотой. Ялангуяа хөдөлмөрийн хууль тогтоомжийн энэхүү мэдэгдэхүйц өөрчлөлт хөдөлмөрийн эрх зүйн эх сурвалжийн тоон болон чанарын өөрчлөлтийг араасаа дагуулж байна[1].

Нийгэм, эдийн засгийн харилцааны шинэ хэлбэрүүд нь хөдөлмөрийн эрх зүйг шинжлэх ухаан болохынх нь хувьд түүний олон институтыг өөрчлөх, боловсронгуй болгох, түүгээр ч барахгүй шинэ хуулиудыг батлан гаргахыг шаардаж байна.

Иймээс зах зээлийн хөдөлмөрийн харилцаанд хөдөлмөрийн эрх зүйн эх сурвалжийн асуудал чухалд тооцогдож байна[2].

Манай улсын хувьд зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсон шилжилтийн жилүүдэд

ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэн-бизнесийн эрх зүйн тэнхмийн багш Г.Жаргал

нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар багагүй ажил хийгдэж байгаа билээ. Хөдөлмөрийн харилцааг дан ганц Хөдөлмөрийн хуулиас гадна бусад хуулиудаар зохицуулж байдаг. Энэхүү хуулиуд нь бүхэлдээ хөдөлмөрийн харилцааг зохицуулах агуулгатай, эсвэл зарим хэсэг, зүйл нь зохицуулах агуулгатай байдаг.

Эдгээр хуулиуд нь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан эх сурвалж бөгөөд хуулийн бүхий л заалтууд нь хөдөлмөрийн харилцаанд хамааралтай байна. Үүнээс гадна хуулиудын зарим зүйл, заалт нь хамаарал бүхий хөдөлмөрийн эрх зүйн эх сурвалжид хамаарагдах хэм хэмжээ байдаг. Судалбал тус хуулиудаар ихэвчлэн тодорхой асуудлыг тухайлбал:

- Цалин хөлсний зохицуулалт;
- Ажил, амралтын цаг;
- Нийгмийн хамгаалал зэрэг асуудлуудыг зохицуулсан байна.

Улсын Их Хурлаас батлан гаргах хуулийн нэгэн адил хүчинтэй актын нэг бол Улсын Их Хурлын тогтоол юм. Жишээ нь, Улсын Их Хурлын 2001 оны 55 дугаар тогтоолоор Хөдөлмөрийн арбитрын дүрэм баталжээ.

Төрийн захиргааны байгууллагаас батлан гаргасан эх сурвалжийг Монгол Улсын Засгийн газраас батлан гаргасан, яамдуудаас батлан гаргасан хэмээн ангилж болно.

Түүнчлэн **яамдаас** батлан гаргасан хэм хэмжээг Монгол Улсын Хөдөлмөрийн эрх зүйн эх сурвалжид хамааруулна. Энэ нь яамны сайдын тушаалын хэлбэрээр хэрэгждэг. Үүнд:

- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 213 дугаар тушаалын хавсралт: Хөдөлмөрийн дотоод журам боловсруулах загвар;
- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны 204 дүгаар тушаалын 1 дүгээр хавсралт: Эмэгтэй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт;
- Байгаль орчны сайдын 1998 оны 84 дүгээр тушаал: Химийн хортой, тэсрэх, болон цацраг идэвхитэй бодистой хамтран ажиллах, тээвэрлэх журам гэх мэт байж болно.

Монгол Улсын Хөдөлмөрийн эрх зүйн эх сурвалжийн төрөлд орон нутгийн, захиргааны болон ажил олгогчоос өөр өөрсдийн эрх хэмжээний дотор гаргасан актууд

1. Гусов К.Н, Курилин М.Н, "Международно-правовое регулирование труда", М, 1992г., С. 96.
2. Бугров Л.Ю, "Проблемы свободы труда в трудовом праве", Пермь, 1992г.

багтдаг байна. Орон нутгийн байгууллагаас батлан гаргасан эх сурвалжийг дотор нь:

• Ажил олгогчоос;

• Засаг даргаас хэмээн ангилж авч үздэг.

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас батлан гаргасан хэм хэмжээ хөдөлмөрийн эрх зүйн эх сурвалжид тооцогдоно.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас 188 зөвлөмж, 185 конвенци батлан гаргасны 16-д нь Монгол Улс нэгдэн орсон бөгөөд энэ нэгдэн орсон гэрээ конвенци нь бол Монгол Улсын эх сурвалжийн нэгэн адил хүчинтэй акт бөгөөд хөдөлмөрийн эрх зүйн эх сурвалж мөн.

Монгол Улсын хувьд хөдөлмөрийн хүрээний суурь зарчмууд ба үндсэн эрхүүдийг хангахаар Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын суурь конвенциудад нэгдэн орсон ба Олон улсын хөдөлмөрийн стандартыг хөдөлмөрийн харилцаанд удирдлага болгон хэрэгжүүлж байгаа билээ. Монгол Улс 2005 онд Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 29, 105 дугаар конвенцид нэгдэн орсоноор суурь 8 конвенцийг соёрхон баталсан орны нэг болсон юм.

Эндээс үзвэл Монгол Улсын хувьд багагүй конвенцид нэгдэн орсон нь сайшаалтай боловч дараах асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзэж байна. Тухайлбал:

• Конвенцид нэгдэн орсоноор л тухайн харилцаа зөрчигдөхгүй гэж өрөөсгөлөөр хандах бус нэгдсэн конвенцийг хэрэгжүүлэх, зөрчихгүй байх нь чухал байна;

• Нийгмийн харилцаа шинэчлэгдэж, хөдөлмөрийн олон шинж бүхий шинэ харилцаа бий болж байгаатай холбогдуулан олон улсын зарим конвенцид яаралтай нэгдэн орох шаардлагатай байна.

Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсон шилжилтийн жилүүдэд зах зээлийн үеийн хөдөлмөрийн харилцааг боловсронгуй болгох талаар хэд хэдэн чиглэлд анхаарлаа хандуулан ажиллаж байгаа билээ. Тухайлбал:

• Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн шаардлагатай хууль батлан гаргах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

• Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас батлан гаргасан конвенциудад нэгдэн орох;

• Олон улсын хөдөлмөрийн стандарт, зарчим, конвенцийн үзэл санаанд нийцүүлэн үндэсний хууль тогтоомжоо өөрчлөх, гөгөлдөржүүлэх зэргийг дурьдаж болно.

Мон үүнээс гадна хууль батлан гаргах, нэмэлт, өөрчлөлт оруулахаас гадна тулгамдсан асуудлын нэг нь нэг харилцааг зохицуулж буй хуулиуд хоорондын уялдаа холбоо юм.

Учир нь батлагдан гарсан хуулиуд нь өөр хоорондоо зөрүүтэй ялгаатай ойлголтуудаар гусгагдсан, нэг ойлголтыг хоёр өөр агуулгаар илэрхийлсэн зэрэг байгааг үгүйсгэхгүй.

Хөгжлийн явцад дэлхий нийтийн хөгжилд даяарчлалтай холбоотой шинэ нөхцөл байдал, шинэ ойлголт бий болж, хүний эрхэд суурилсан хандлагуудыг хэрэгжүүлэх шаардалага зүй ёсоор гарч байна. Ингэснээр зах зээлийн хөдөлмөрийн харилцаанд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, хөдөлмөрлөх таатай орчин бүрдүүлэх бодлогыг олон улсын төвшинд баримтлах боллоо.

Зах зээлийн үеийн хөдөлмөрийн харилцааны онцлог нь өөрийн төлөө хөдөлмөрлөх, эрх ашгаа хамгаалах, эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэх замаар илэрч байна. Энэ чиглэлийн хөдөлмөрийн харилцааг боловсронгуй болгохын тулд хэд хэдэн чиглэлийн хүрээнд анхаарлаа хандуулах шаардлагатай гэж үзлээ.

Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход дараах чиглэлээр анхаарах нь зүйтэй байна. Ялангуяа нэг харилцааг олон хуулиар зохицуулж байгаа манай өнөөгийн нөхцөл хуулиуд хоорондын уялдаа холбоог нийцүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь нэг ойлголтыг хуулиудад өөр өөр утга агуулгаар зохицуулсан, хоёрдмол агуулгыг бий болгосон зэрэг нөхцөл байдлууд байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудын уялдаа холбоо, өөр хоорондын зөрүүтэй тусгагдсан зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарах нь чухал асуудлуудын нэг юм. Энэ нь Хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй холбогдох хэм хэмжээг Хөдөлмөрийн хуульд нийцүүлэх замаар боловсронгуй болгоно. Энд зөвхөн Төрийн албаны хуулийг тухайлан авч үзсэн болно.

Төрийн албаны хуулийг Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд нийцүүлэхэд анхаарах нь.

Төрийн албаны хуульд хөдөлмөрлөх үйл ажиллагаатай холбогдсон зохицуулалтыг тусгахдаа Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд тусгадсанаас дараах байдлаар зөрүүтэй тусгажээ. Үүнд:

Нэр томъёоны хувьд, нэг зохицуулалтыг өөр өөр зөрүүтэй агуулгаар тусгасан зэрэг байдлууд байна. Эдгээрийг Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд нийцүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Дараах асуудал хуульд ялгаатай байдлаар тусгагджээ. Үүнд:

• ***Туршилтын хугацаа;***

• ***Өөр ажилд тур шилжүүлэх;***

• ***Тэтгэвэр авах эрх үүсэх;***

• ***Сахилгын шийтгэл ногдуулсан гомдолыг шүүхээр хянан шийдвэрлэх;***

• ***Хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хянан шийдвэрлэх уе шатууд*** зэрэг болно. Энэхүү өөр тусгагдсан зохицуулалтын заримыг нь авч үзвэл:

1. Төрийн албаны хуулийн 22 дугаар зүйлд "Төрийн жинхэнэ албан хаагчийг *өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах*" талаар тусгажээ. Харин судлан буй асуудлыг Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 32 дугаар зүйлд "Ажлын зайлшгүй шаардлагаар *өөр ажилд тур шилжүүлэх*" гэсэн нэр томъёогоор тусгажээ. Төрийн албаны хуулийн 22 дугаар зүйлийн агуулгыг авч үзвэл ажлын зайлшгүй шаардлагаар өөр ажилд тур хугацаагаар ажил олгогчийн зүгээс шилжүүлэх ойлголтыг илэрхийлсэн байна. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 32 дугаар зүйлд дээрх асуудлыг "*Өөр ажилд тур шилжүүлэх*" гэсэн нэр томъёогоор тусгасан байна. Иймд хөдөлмөрийн хуулийн дээрх нэр томъёог хэрэглэх нь зүйтэй гэж үзэж байна.

Учир нь "Өөр ажилд шилжүүлэх", "Ажлын байрыг солих (сэлгэх) нь ялгаатай ойлголтууд юм";

Харин Төрийн албаны хуулийн зохицуулалтаас үзвэл ажилтны зөвшөөрлийн үндсэн дээр төрийн байгууллага хооронд тодорхой чиглэлээр сэлгэн ажиллуулахыг заасан байна. Гэтэл энэ агуулгаас үзвэл сэлгэн ажиллуулах бус харин "Өөр ажилд тур шилжүүлэх" гэсэн агуулгыг шууд илэрхийлж байгаа учир Хөдөлмөрийн хуулийн дээрх зохицуулалттай нийцүүлэх нь зүйтэй болов уу;

2. Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд "*Олговор*"-ын зохицуулалтыг тусгажээ. Энэхүү зохицуулалтыг Төрийн албаны хуулийн 29 дүгээр зүйлд "төрийн албан хаагчид олгох *нөхөх төлбөр*" гэсэн нэр томъёогоор тусгасан байна;

3. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 128 дугаар зүйлд "Шүүхээр хянан шийдвэрлэх маргаан"-ы талаар тусгажээ. Хуулийн 128.1.7-д "*Сахилгын шийтгэл ногдуулсан гомдлыг шүүхээр хянан шийдвэрлэх*"-ээр заажээ. Гэтэл Төрийн албаны хуулийн 26.8-д "...сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор *төрийн дээд шатны байгууллага*, эсхүл шүүхэд гаргаж болно" гэжээ.[3] Үүнээс үзэхэд Төрийн албаны хуульд эхлээд төрийн дээд шатны байгууллага, мөн шүүх гэсэн 2 үндсэн шатыг дамжих агуулгыг илэрхийлсэн байна. Үүнийг Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд тусгагдсан байдлаар нийцүүлэн зохицуулах шаардлагатай болов уу;

4. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 40.1.3-д "ажилтан *60 нас хүрч* тэтгэвэр авах эрх үүсэх" талаар зохицуулсан байхад Төрийн албаны хуулийн 24.3.-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь *65 нас байна*" гэжээ[4]. Ингэж хөдөлмөрийн харилцааны субъектын хөдөлмөр эрхлэх насны хязгаарыг зөрүүтэй тогтоожээ;

5. Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хянан шийдвэрлэх уе шатуудыг тодорхой тусгасан байдаг.

Харин Төрийн албаны хуулийн 39 дүгээр зүйлд "Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх" талаар гусгажээ. Гэтэл тус хуульд маргааныг:

• Төрийн албаны төв байгууллага;

• Төрийн албаны салбар зөвлөл;

• Шүүх зэрэг шатуудыг дамжихаар зохицуулсан нь Хөдөлмөрийн хуулиас өөрөөр зохицуулагджээ. Үүнийг Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд нийцүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Ер нь нэг харилцааг зохицуулсан зохицуулалт нь олон хуулиудад тусгайлсан зохицуулж болох боловч гол хуулиндаа буюу Хөдөлмөрийн хуулийн үзэл санаа, зохицуулалтанд нийцэх нь зүйтэй болов уу гэж үзлээ.

Мөн дээрхээс гадна:

• Хөдөлмөрийн хуульд нийцүүлэн гаргасан төвлөрсөн бус зохицуулалт буюу орон нутгийн шинжтэй хэм хэмжээг Хөдөлмөрийн хуулийн үзэл, хандлага, зохицуулалтанд нийцүүлэх шаардлагатай байна. Учир нь хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээ, дотоод журам, ажлын байрны тодорхойлолт нь Хөдөлмөрийн хуульд нийцээгүй, хөдөлмөрлөх эрхийг нь зөрчсөн, хуулиар тусгагдсан эрхүүдийг нь тусгаагүй, эрхийг нь дордуулсан хэм хэмжээнүүд хөдөлмөрийн харилцаанд үйлчилсээр байна. Үүнийг хөдөлмөрийн харилцаанд зайлшгүй анхааран үзэж, хуульд нийцүүлэх шаардлагатай гэж үзэж байна;

• Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас батлан гаргасан конвенциудад нэгдэн орох шаардлагатай гэж үзэж байна.

3. Төрийн албаны хууль

4. Төрийн албаны хууль

МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Мэдээлэл бол эрхээ хэрэгжүүлэх хэрэгсэл мөн

Мэдээллийн эрх чөлөөний тухай ярихын өмнө **мэдээлэл** гэж чухам юу болох?, **эрх чөлөө** гэж юуг ойлгох тухай ярих нь чухал.

Мэдээлэл гэдэг нь мэдлэг олж авах хэрэгсэл төдийгүй зарим үед худалдах худалдан авах харилцаанд орж болдогоороо **эд барааа** буюу Монгол Улсын иргэний хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д Эдийн болон эдийн бус эрх, үйлдэл, эс үйлдэхүй, **мэдээлэл** иргэний эрх зүйн харилцааны объект байж болно гэж заасны дагуу мэдээлэл нь **иргэний эрх зүйн харилцааны объект** юм. (иргэд болон албан тушаалтан ямар нэг нэр хүнд бүхий хүн, хуулийн этгээд, нэртэй одууд, олны танил хүмүүсийн тухай мэдээллийг сэтгүүлчдэд болон тухайн мэдээллийг олны хүртээл болгох эрх бүхий хувь хүн, байгууллага, мэдээлэл түгээгч нарт худалдаж ашиг олох тохиолдол байдаг.)

Мэдээлэлтэй хүн мэдлэгтэй байна, мэдлэгтэй хүн нийгэмд тодорхой хэмжээгээр байр суурьа эзэлсэн байна. Өөрийн байр суурьтай хүн зорилготой, ирээдүйдээ итгэлтэй, өөрийгөө хөгжүүлэх чин эрмэлзэлтэй байна. Мэдээллийн ачаар хүмүүс улс төр, нийгэм, эдийн засгийн үйл явдлын талаар тодорхой ойлголттой болж, нийгмийн амьдрал, үйл явдалд идэвхитэй оролцож Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 3-ын 1-д: Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгодож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэнэ гэсэн заалтын дагуу уг эрхээ эдлэх боломж нь бүрдэх юм.

Ингэж нийгэмд шударга ёсыг

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Солонго

тогтоох төрийн үйл хэрэгт оролцох, үйл ажиллагаанд нь хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгөх зэрэгт мэдээлэл чухал ач холбогдолтой юм. Мэдээллийн хамгийн гол мөн чанар нь цаг хугацаа. Цаг хугацаа алдсан (хуучирсан) мэдээлэл нь ач холбогдлоо алдна. Жишээ нь: ямар нэг хүнд өвчин туссан байгаа үед өөрийн өвчинд тустай эмийн тухай мэдээллийг олж авсан боловч тухайн эмийг хэрэглэхэд тохиромжтой цаг хугацаа хожимдсон байвал өөрөөр хэлбэл: тухайн эмийг өвчний эрт үед хэрэглэхэд өвчин бүрэн төгс эдгэрдэг байж болно энэ тохиолдолд тэр мэдээллийг олж авсны ашиг тус гарахгүй. Үүний нэгэн адил ямар нэг лекц болсон тухай мэдээлэл байж болно, уг нь тэр лекцэнд очсоноор тухайн хүн өөрт хэрэгтэй маш их мэдээллийг авч болох байсан боловч лекц болох тухай мэдээллийг лекц болж өнгөрсний дараа авсан тохиолдолд тухайн лекц болсон тухай мэдээллийн ач холбогдол байхгүй болно.

Эрх чөлөө гэж хүний эдлэх ёстой бөгөөд хүнээс хаалт хэрэм босгон салгаж үл болох боломж. Үүгээрээ эрх чөлөө нь хүний салшгүй эрх болж илэрдэг.

Эрх чөлөө нь маш өргөн ойлголт боловч уг таа бол хоёрхон төрлийн эрх чөлөө байна.

1. Иттэл үнэмшлийн эрх чөлөө;
2. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө.

Хүн бүсдыг хайрлаж жигших, шүтэж биширч сүсэглэж байгаа нь иттэл үнэмшлийн эрх чөлөө. Жагсаж, эвлэлдэн нэгдэж үг хэлэх, хэвлэн нийтлэх нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө[1] юм. Эрх чөлөө хүний салшгүй эрх гэж үзвэл хүний эрхээ эдлэх боломжийг мэдээлэл бий болгодог гэж хэлж болно. Мэдээлэлгүйгээр хариуцлага үгүй. Мэдээлэл бол эрх мэдлээ хадгалж байх хэрэгсэл юм. Мэдээллийг олон хүн эзэмших гусам эрх мэдэл тэр хэмжээгээрээ тархдаг. Ард түмэн мэдээлэл олж авах бололцоотой байна гэдэг бол улс үндэстэндээ итгэлтэй байх нэгэн тулгуур зарчим болдог. Олон нийтэд мэдээлэл хүргэх зарчмын гол хэрэгсэл нь хараат бус, чөлөөт хэвлэл мэдээлэл юм[2].

Та төлсөн татвараа хэн нэгэн албан тушаалтнаар үрэн таран хийлгэхгүйн тулд хяналт тавих үүрэгтэй. Хяналт тавихын тулд танд тухайн албан тушаалтантай холбоотой мэдээлэл цуглуулах хэрэг гарна. Жишээ нь: таны хүүхэд сургуулийн сурагч. Уг таа та сургуулийг татвараараа санхүүжүүлж байгаа. Гэтэл сургуулийн захиргаа төсөв хүрэлцэхгүй гэдэг шалтгаанаар засвар, сурах бичиг, хичээлийн танхим тохижуулах нэрээр эцэг, эхээс байнга мөнгө шаардана. Та тухайн сургуулийн санхүүгийн үйл ажиллагаатай танилцах эрхтэй. Үүндээ бусад эцэг эхийг татан оролцуулж, хамтран ажиллах явцад танай хүүхдийн багш, эсвэл

1. Б.Батбаяр. "Баабар ингэж өгүүлэв". УБ., 2007 он, 122 дахь тал.
2. Д.Золжаргал. "Хэвлэл мэдээллийн эрх чөлөө", УБ., Хууль дээдлэх ёс. УБ., 2008 он, №4. 8 дахь тал.

сургуулийн захирал төсвийн хөрөнгийг зохисгүй зарцуулж эсвэл хувьдаа ашигласныг олж мэдэв. Иймээс иргэн та төрийн үйл хэрэгт шууд оролцох эрхтэй. Энэ бол таны эрх төдийгүй үүрэг юм[3].

Дээрхээс дүгнэж үзвэл мэдээлэл гэдэг нь хүнд мэдлэг олж авах хэрэгсэл төдийгүй, мөнгө олох эд **бараа** зарим тохиолдолд хүнийг эрхээ эдлэхэд нь туслах **боломж**, нөгөө талаар **хариуцлага** юм. Жишээ нь: мэдээллийг ашиглан хүн мэдлэгтэй болж болно, мэдээллийг худалдаж мөнгөтэй болж болно, мэдээллийн тусламжтайгаар өөрт хуулиар олгогдсон эрхээ эдлэж болно, хүнийг гутгэж, өөрт байгаа мэдээллээ хууль бусаар ашигласан тохиолдолд хариуцлага хүлээж болно гэсэн үг юм.

Мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн үндэс

1924 оны Үндсэн хуулиар "хэвлэн нийтлэх" эрх чөлөөг тунхагласан боловч Үндэсний ардчилсан хувьсгалын дараахнаас хэвлэл мэдээллийн бүх хэрэгсэл эрх баригч намын хяналт, төрийн мэдэлд орж, өнгөрсөн зууны 90-ээд он хүртэл намын дайчин зэвсэг гэгдэн нэгэн үзэл суртлын ноёрхлоос гарч чадаагүй байсан. "Монгол Улсад социализмын үед хүний эрхийг зөрчиж байсан хамгийн гол хэлбэр нь "тэрс үзэлтэнтэй" эвлэршгүй тэмцэл явуулдаг байсанд оршино. Тэр үед эрх баригч хүчний бодлого, явуулж байгаа арга хэмжээнд шүүмжлэлтэй хандсан хүнийг "сэхээтний төөрөгдөл", "намын эсрэг бүлэг" мэтийн нэр томъёо өгч ажил албанаас халж, захиргааны журмаар нутаг зааж цөлөх, мэргэжлийн ажил эрхлэх болон улс төрийн амьдралд оролцох эрхийг нь хасах зэргээр хэлмэгдүүлж байснаар барахгүй төрийн эсрэг ... онц хүнд гэмт хэрэг болгон хуульчилсан билээ[4].

Ардчилсан хувьсгалын явцад монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн тогтолцоо үндсээрээ өөрчлөгдөж, олон хэвшлийн мэдээллийн хэрэгслүүд бодит зүйл болсон ба 1992 оны Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ; 8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална; 16/итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно гэж баталгаажуулсан нь энэ эрхийг бодитоор хэрэгжих үндэслэл болсон ба өнөө үед олон нийт чөлөөт хэвлэлийн амтанд орж, хараат бус мэдээллийн үнэ цэнийг улам бүр мэдэрсээр байна.

Монгол Улсын иргэний үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь НҮБ-ыс баталсан Хүний эрхийн түгээлт тунхаглалын 19 дүгээр зүйлд "Хүн бүр өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ илэрхийлэх эрхтэй...", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 18 дугаар зүйлийн 1-д "Хүн бүр чөлөөтэй бодож, сэтгэх... эрхтэй", 18.2-т "Өөрийн ...үзэл бодолтой байх, сонгож авах гэсэн хэний ч эрх чөлөөг хязгаарлан хавчиж болохгүй", 19 дүгээр зүйлийн 2-т "Хүн бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэ эрх нь төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр эсхүл уран сайхны хэлбэрээр, түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөөг багтаана" гэж заан баталгаажуулсан ба энэ нь иргэдэд үг хэлэх, хэвлэн нийтлэх зэрэг улс төрийн эрх, эрх чөлөөгөө хэрэгжүүлэх боломж олгоход оршино.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д иргэд: "Төр түүний байгуллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нуущад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй" гэж заажээ.

2000 онд хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль гаргасан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах хууль зүйн баталгааг сайжруулахад чухал ач холбогдолтой болсон юм. Хүний эрхийн үндэсний комиссийн тухай хуулийн дагуу байгуулагдсан комиссыг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, чөлөөлөн дэмжих байгуллага гэж тодорхойлоод 9 дүгээр зүйлийн 1-д хүн өөрийнх нь эрх, эрх чөлөө зөрчигдсөн гэж үзвэл комисст хандах эрхийг баталгаажуулсан нь нааштай алхам юм. Монгол Улс Үндсэн хуулийнхаа 10 дугаар зүйлийн 2-т "Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударга сахин биелүүлнэ", мөн зүйлийн 3-т "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэсэн нь одоогоор Монгол Улсын хуульд ороогүй байгаа хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаархи Монгол Улсын олон улсын гэрээний заалтууд манай хуулийн хийдлийг нөхөж байгаагийн илрэл юм. Иймээс ч Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т иргэд "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах" эрхтэй гэжээ.

Манай улс "Хүний эрхийн түгээмэл тунхаглал"-ын үзэл санааг хүлээн зөвшөөрдөг бөгөөд

3. www.globeinter.org.mn.

4. Г.Совд. "Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх"(харшуулсан эрх зүй) УБ., 1999 он, 139 дэх тал.

1974 онд "Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт", мөн "Хүний эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай Олон улсын Пакт"-д нэгдэн орсон юм. Үүгээрээ Монгол Улс дээрх чухал баримт бичгийн хүний эрх, мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой заалтуудыг дагаж мөрдөнө гэдгээ хүлээн зөвшөөрсөн байна.

Хүний эрхийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд "түгээмэл"-ээр тусгасан байдаг. "Хүний эрхийн түгээмэл тунхаглалын" 19 дүгээр зүйлд: "Хүн бүр өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, үүнд үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах, аливаа үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан боломжтой арга замаар эрж сурвалжлах, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх эрх багтана" гэсэн байдаг. Манай Улсын Үндсэн хуульд иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд заасанчлан "хэвлэл мэдээллээр болон хил хязгаар үл хамааран хангах тухай хамгийн чухал заалт орхигдсон боловч Үндсэн хуулийн дээр дурьдсан 10 дугаар зүйлийн 2.3 болон 16 дугаар зүйлийн 14 дэх заалтаар нөхөгдөх боломжтой. Харин иргэдийн мэдээлэл хайх эрхийг хангах механизм үгүйлэгдсээр байгаа бөгөөд мэдээлэлд нэвтрэх эрх баталгаажаагүй байна. "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын дагуу хүний эрхийн хорооны хүлээх үүрэгт хязгаарлалтыг гаргахдаа 3 дугаар зүйлийн "а","б"-д заасан зорилгоор тогтоож болох бөгөөд "зайлшгүй хуульчилсан байх шаардлагатай" гэжээ. Манай улс Үндсэн хуулийнхаа 16 дугаар зүйлийн 16-д "Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор залруулж үл болох, төр, байгууллага, хувь хүний нуугыг хуулиар тогтоон хамгаална гэж хуульчилсан нь дээрхи шаардлагад нийцнэ. Гэвч хуулиар юуг нуух гэж тогтоох нь анхаарал татаж байгаа юм.

Дээр дурьдсанчлан манай улс нэгэнт гарын үсэг зурж, нэгдэн орсон эдгээр олон улсын баримт бичгийн заалтуудыг мөрдөх ёстой бөгөөд иргэдийнхээ суурь эрхийн талаар гаргахгүй нарийн чанд, зайлшгүй л хязгаарлалт тавьж болох юм. Монгол Улсын зарим хуульд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн эрхэлж буй албан тушаалтантай уялдан "хүндэтгэлтэй хандах" тухай заажээ. Эдгээрт цагдаагийн албан хаагч, шүүгч, прокурор, хүний эрхийн үндэсний комиссын гишүүн хамрагдаж байна. Мөн албан тушаалтны жишээлбэл засгийн газрын гишүүдийн үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөг "Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 4-т "Ерөнхий сайдтай зөвшилцөнө" гэсэн байна. Мөн төрийн ажилтны ёс зүйн кодод "төрийн албан хаагч удирдах даргынхаа зөвшөөрөлгүйгээр мэдээлэл өгч болохгүй" тухай заажээ. Монгол Улсын Үндсэн хууль 10 дугаар зүйлийн 4-д "Монгол улс үндсэн хуулиндаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй" гэсэн заалт нь олон улсын хэм хэмжээний хүрээнд хүлээсэн үүргээ хязгаарласан байна гэж үзэж байна[5].

Ардчилсан нийгэмд мэдээлэл чөлөөтэй, ил тод байх ёстой гэсэн зарчим баримталдаг. Эрх чөлөөт байдлыг хангахын тулд иргэд мэдээлэл хайх, олж авах, хүлээн авах, түгээх эрхтэй байх ёстой. Энэ бүлэг эрхийг **мэдээллийн эрх чөлөө** гэнэ.

Дарангуйллын нийгэмд улс орны үнэн бодит байдлын тухай мэдээлэл хаалттай байдаг. Тийм нийгмийн иргэд төр засгийн хяналт, мэдээлд байдаг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дээрээс тулгасан мэдээллийг хүлээн авдаг. Тэгвэл ардчилсан чөлөөт нийгэмд мэдээлэл бол хүчил төрөгч юм. Мэдээлэл олж авах нь ардчилсан нийгэмд амьдарч буй иргэн таны үндсэн эрхийн нэг бөгөөд иргэдийнхээ мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулах нь ардчилсан төрийн үүрэг юм.[6]

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухайд

Хүний эрхийг заяамал, олдмол гэж ангилах нь буй. "Итгэл үнэмшилтэй байх" нь хүний заяамал буюу салшгүй эрх мөнийг Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд хүлээн зөвшөөрч, түүнийг хэн ч, ямар ч нөхцөлд тур дундаа онц болон дайны байдалд ч хязгаарлахыг хориглосон юм. Сүсэглэхээс өргөн агуулгатай хүний хувийн энэхүү салшгүй эрх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг дээр иш татсан "**хэвлэл мэдээллийн эрх чөлөө**" гэх бүлэгт багтах нийгэм, улс төрийн бусад эрх, эрх чөлөөний **тулах цэг**, суурь дэвсгэр нь хэмээн үзэж болох байх аа. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх бол хэвлэн нийтлэх зэрэг энэ бүлгийн бусад эрх, эрх чөлөөний үйлчлэлтэй хамсан байж засаг төрийн үйл ажиллагаанд нийгэмшсэн хяналт тавьж хууль бус, шударга бус, бурангуй дур зоргын үйлдэл явдлыг олны сонорт хүргэж төр нийгмийн ажил үйлсийг зөв гольдролоор нь оруулах шалгарсан хүчтэй боломж юм. Хэвлэл мэдээллийн гэж хураангуйлж болох бүлэг эрх, эрх чөлөө тус тусын агуулгатай, тодорхой хүрээтэй, хэрэгжих өөр өөрийн механизмтай билээ[7].

1999 онд Хууль зүй, дотоод хэргийн яаманд 1130 мэдээллийн хэрэгсэл бүртгэлтэй байснаас 190

5. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө. УБ., 2001 он, 53 дахь тал.

6. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Анхдугаар чуулга уулзалтын 59 дүгээр тогтоолоос.

7. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө. УБ., 2001 он, 10 дахь тал.

орчим нь тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан. Энэ тоо 2008 оны эхний улиралд 398-д хүрч даруй 2 дахин өссөн байна. Тогтмол ажиллаж буй хэвлэл мэдээллийн байгууллагаас 168 нь сонин, 77 нь сэтгүүл, 57 нь телевиз, 77 нь радио, /үүнээс ФМ радио 69/, 19 нь кабелийн телевиз байна. Эдгээрээс 354 нь буюу 89 хувь нь мониторонгийн судалгаанд оролцож мэдээллээ ирүүлсэн, сонин, телевиз, радиогийн мэдээллийн бүрдэлт 90-94 хувьтай байгаа бол сэтгүүл 73 хувь байна. Сүүлийн 8 жилийн турш Монгол дахь мэдээллийн хэрэгслийн тоо тогтмол өсөж байгаа бөгөөд энэ нь мэдээллийн хэрэгслийн бүх төрөлд хамаарч байна. Тухайлбал, 1999 онд өдөр тутмын 5 сонин гарч байсан бол 2008 онд өдөр тутмын 12 сонинтой болж, нийслэлд үйл ажиллагаа явуулдаг таван телевиз 18 болсон. Түүнчлэн орон даяар нэвтрүүлгээ цацдаг телевизийн тоо нэг байсан бол зургаа болж, нийслэлийн ФМ радио долоогоос 20 болтлоо өсжээ[8].

Манай зарим сэтгүүлч хүнийг хувийн сонирхлоор гүтгэх, бодит баримттай мэдээлэл бус дам сонссон зүйлээ болсон мэт болгож хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүний нэр төрийг гутааж байгаагаа Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д: төр, түүний байгууллагаас хууль ёсоор гусгайлан хамгаалбал зохих нуущал хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх хүлээн авах эрхтэй, энэ бол мэдээллийн эрх чөлөө гэдгээр өөрийгөө хамгаалахыг ороолдог боловч мэдээллийн эрх чөлөө гэдэг бол өөрийн эзэмшсэн мэргэжил, өөрт олгогдсон боломжийг ашиглан бусдын нэр төр, алдар хүндийг гутааж болно гэсэн үг биш юм. Тухайн сэтгүүлчид өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх эрх байгаа боловч Хүний эрхий түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлийн 29.2-т Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх ёстой гэсэн заалтыг бас бодож байх учиртай. Өөрөөр хэлбэл сэтгүүлч таны хэвлэл мэдээллийн эрх чөлөө бусдын эрх, эрх чөлөөтөөр хязгаарлагдах юм.

1. "Монголын хэвлэл мэдээлэл, өнөөдөр" УБ, 2008 он., 5 дахь тал.



МОНГОЛ УЛСЫН НОТАРИАТЫН ХӨГЖИЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Нэг. Түүхэн хөгжил

Монгол Улсын нотариатын түүхийг эзэн Чингисийн үеэс улбаатай гэж үзэн судалгаа хийж болох талтай ч өнөөгийн нотариатын утга агуулгаар судлах гэвэл энэ нь боломжгүй зүйл юм.

Манай улсын нотариатын хөгжлийн тухай асуудлыг судлаачид бакалавр, магистрын дипломын ажил, ном зохиолдоо өөр өөрийнхөөрөө бичиж тэмдэглэсэн байдаг бөгөөд энэ нь үе үеийн эрх зүйн баримт бичиг болох дүрэм, журам, хуулийн бүтцийг бичиж, тэмдэглэхээс хэтрэхгүй байв. Харин энэ асуудлыг МУИС-ийн тэргүүлэх профессор, Хууль зүйн шинжлэх ухааны доктор Т.Сэнгэдорж 2005 онд нотариатын байгууллагын түүхт 80 жилийн ойн арга хэмжээнд зориулсан онол-практикийн бага хуралд "Монголын нотариатын түүхэн хөгжил, нийгэмд гүйцэтгэсэн үүрэг" сэдвээр тавьсан илтгэлдээ 4 үндсэн үед хуваж авч үзэж, тайлбарласан нь судлаачдад шинэ боломжийг нээж өгсөн юм. Тэрээр нотариатын байгууллагын хөгжлийн үе шатыг дараахь байдлаар ангилжээ. Үүнд:

Нэгдүгээрт, 1925-1964 он хүртэл. Энэ үед Нотариатын байгууллагын үндэс тавигдан, эрх зүйн байдал тогтоогдож, үйл ажиллагаа нь төлөвшсөн;

Хоёрдугаарт, 1964-1985 он хүртэл. Нотариатын байгууллага зохион байгуулалтын хувьд бэхжиж, иргэдэд эрх зүйн үйлчилгээ, туслалцааг тогтмол үзүүлэх болсон;

Гуравдугаарт, 1985-1997 он хүртэл. Нотариатын байгууллага бие даасан хуультай болж, эрх зүйн зохицуулалт сайжран, ардчилал шинэчлэлийн нөхцөлд үйл ажиллагаагаа шинэлэг арга барилаар хэрэгжүүлэх болсон;

Сүхбаатар дүүргийн нотариатч Р.Онончимэг

Дөрөвдүгээрт, 1997-2005 он хүртэл. Нотариатын байгууллага тус улсад зах зээлийн эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, хууль цаазат төрийг төлөвшүүлэх, эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн идэвхжүүлэх болсон гэжээ.

Энэ ангилалт нь мөн дээр өгүүлсэнчлэн дүрэм, хуультай холбон авч үзсэн боловч түүнийхээ учир шалтгааныг дэлгэрүүлж өгсөнөрөө бид бүхний цаашдын судалгааны ажилд дөхөм болох юм.

Мөн үүнтэй төстэйгээр "Отгонтэнгэр" их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Х.Цогзолмаа "Нотариатын түүхэн хөгжлийг харьцуулан судлах нь" сэдвээр "Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн 2009 оны №1–д бичсэн нийтлэлдээ нотариатын түүхэн хөгжлийг 5 үечлэлд хуваж авч үзсэн нь түүхчлэн харьцуулан судлахад дөхөмтэй байдлыг бий болгожээ.

Үүнээс гадна нотариатын хөгжлийг төрийн тогтолцооных нь байдлаар хуваж үзэж болох юм.

Нэгдүгээрт: 1925-1990 он хүртэл буюу социалист системтэй байх үеийн нотариат

Энэ үед үндсэндээ хувийн өмч хэмээх ойлголт сонгодог утгаар байгаагүй юм. Иймээс өнөөгийнх шиг иргэн хүн өмчөө хамгаалах, шилжүүлэхээр нотариатад хандах гухай асуудал байгаагүй. Учир нь манай улсад эрх зүйн тогтолцоог нийтийн ба хувийн эрх зүй гэж дэд тогтолцоонд ангилах уламжлал огт байгаагүй бөгөөд энэ нь нэг талаас хувийн өмчийн төрлийг хууль зүйн хувьд үгүйсгэж байсантай, нөгөө талаас зөвлөлт маягийн эрх зүйг баримжаа болгосонтой холбоотой. Судлаач З.Сүхбаатар нь социалист тогтолцоо нь хувийн өмчийг үгүйсгэдэг байсан бөгөөд манай улс нь 1921 оны 5 дугаар сарын 21-ний Ардын Засгийн газраас "Газрыг хувийн өмч болгохыг усгах тухай" тогтоол гаргаж байсан, 1958 онд хувиараа аж үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний худалдаа эрхлэхийг хориглож, 1960 оны Үндсэн хуулиар "хувийн өмчийг үүрд устгасан" гэж заан хуульчилснаар хувийн өмчийн үзэл сэтгэлгээ үгүйсгэгдсэнийг тэмдэглэсэн байна.

Энэ сэтгэлгээг үндэс болговол нотариатын байгууллагын үе үеийн дүрэмд аливаа гэрээ хэлцлийг гэрчилж болох тухай заасан ч энэ нь хэлбэрийн төдий зүйл байсан гэдгийг харж болохоор байна. Харин 1963 оны Иргэний хуулийн 59 дүгээр зүйлд "өмчийн төрлийг социалист өмч, амины өмч гэж ялгана" гэж зааснаар амины өмчийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч амины өмч нь хувийн өмчтэй харьцуулахад туйлын шинж чанар байхгүй, эдийн засгийн эргэлтэд эрох боломж хязгаарлагдмал байсан тул харьцангуй шинж чанартай байжээ. Иймээс "civil law" буюу эх газрын эрх зүйн тогтолцоотой улсуудад өнөөгийн утгаараа хөгжөөд хэдэн зуун жил болсон нотариатын байгууллага нь манай улсын төрийн тогтолцооноос хамааараад шүүхэд нотлох баримт бүрдүүлэх, зөрчигдсөн эрхийг хамгаалах шүүхийн ажилд туслах төдийгөөр

хязгаарлагдаж, түүний харьяанд ажиллаж байв.

1985 онд БНМАУ-ын Нотариатын хууль батлагдан гарснаар иргэн, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нотариатын үүргийг анх удаа хуульчилж өгсөн дэвшил байлаа;

Хоёрдугаарт: 1990 оноос одоог хүртэл буюу ардчилсан системтэй болсон үеийн нотариат

1990 оны ардчилсан өөрчлөлтийн нөлөөгөөр 1963 оны иргэний хуулийн 59 дүгээр зүйлд "өмчийн төрлийг социалист өмч, амины өмч гэж ялгана" гэж зааж байсныг "БНМАУ-д хувийн, нийтийн өмч байна" хэмээн хувийн өмчийн төрлийг хүлээн зөвшөөрсөн[1]. Улмаар 1992 оны Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" гэж зааснаар иргэд хувийн өмчтэй байх бүрэн эрхийг хуульчилж өгчээ.

Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгаат бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасан байдаг бөгөөд түүний "хууль зүйн баталгааг бүрдүүлэх" төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх субъектын нэг нь салбарын яамны хяналтанд төрийн бус байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байгаа нотариатчид юм.

1990-ээд оны эхээр нотариатын байгууллагын бүтцэд шинэчлэл хийх эхлэл тавигдсан юм. Хууль зүйн сайдын 1992 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 242 дугаар тушаалаар "Хувийн нотариатын үйл ажиллагааны түр журам"-ыг батлаж мөрдүүлснээр Улаанбаатар хотод Улсын нотариатын конторын зэрэгцээ хэд хэдэн хувийн нотариатч ажиллах болсон нь тухайн үедээ шинэ зүйл байлаа[2].

Шинэ Үндсэн хуулийн үзэл санааны дагуу 1992-1994 онд шүүх, прокурор, өмгөөлөл, цагдаа, хорих байгууллагуудын хуулиуд шинэчлэгдэн тэдний эрх зүйн байдал тодорхойлогдсон бөгөөд мөн үүнтэй уялдан 1997 онд Нотариатын байгууллагын тухай хууль батлагдан барууны орнуудын төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд төрийн үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх болсон цоо шинэ хэлбэрийн эхлэлийг тавьсан байна. 1998 онд УИХ-аас батлагдсан Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд дээрх хуулиудыг дахин шинэчлэн найруулах шаардлага гарч 1999 онд Газрын тухай хууль, 2002 онд Монгол Улсын иргэ д газар өмчлүүлэх тухай хуу ,, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Өмгөөлөлийн тухай хууль, Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд тус тус батлагдан гарснаар иргэний өмчлөх эрхийг бодитойгоор хэрэгжүүлэх эрх зүйн боломж бүрдэж, хэрэгжсээр өнөөг хүрч байна.

1998 оны "хөтөлбөр"-ийн дагуух шинэтгэл нь өөрийнхөө үндсэн дээр анх тутам бүрэлдсэн тогтолцоог боловсонгуй болгож Үндсэн хуульт байгууллагыг цаашид бэхжүүлэхэд оршиж байв. Энэ нь хөтөлбөрийн агуулгаас ойлгогдож байна[3].

Хоёр. Өнөөгийн байдал

1997 онд батлагдсан Нотариатын тухай хууль нь ардчилсан Үндсэн хуулийн хүрээнд хийгдсэн томоохон өөрчлөлт байсан бөгөөд 2002 онд Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан нь шинэтгэлийн хүрээнд хийгдсэн дараагийн алхмын нэг байсан гэдгийг дээр дурдсан.

Одоо манайд шинэ Үндсэн хуулийн хүрээнд хийгдэж буй эрх зүйн шинэтгэлийн хоёрдугаар шат эхэлснийг Ардын багш, гавъяат хуульч, доктор, процессор Б.Чимидийн 2008 оны "Монгол Улс дахь хууль тогтоох үйл ажиллагаа ба эрх зүйн шинэтгэл" сэдэвт илтгэлд тэмдэглэсэн бөгөөд тэрээр "улсынхаа бүх хуулийг бухэлд нь шинжлэх ухааны тогтолцооных нь гүвшинд хянан үзэж чанарын өөрчлөлт хийх буюу боловсронгуй болгох зорилго тавьж ажиллахыг засаг төрд санал болгож байна. Үүнийгээ шинэтгэлийн хоёр дахь шат гэж нэрлэж байгаа ч уггаа боловсронгуй болгох гэдэг нь илүү оновчтой болов уу" гэж шинэтгэлийн дараагийн шатыг тодорхойлсон байна. Мөн тэрээр шинэтгэлийн энэ шатны эхний үед хуулиудыг харьцуулан судалж оносон, алдсаныг цэгнэн ололтоо бататган, алдаж эндсэнээ арилгах "их цэвэрлэгээ" хийвэл зохино гээд хуулийн цэвэрлэгээ гэдгээ юуны өмнө алдаа, зөрчил, давхардал, бүрхэгдэл, хийдлийг илрүүлж арилгаж бүхэлд нь уялдуулахыг хэлнэ гэжээ.

Энэ шинэтгэлийн хүрээнд бид бүхэн Нотариатын тухай шинэчлэн найруулсан хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн

1.З.Сүхбаатар."Нийтийн ба хувийн эрх зүйн тухайд", УБ., "Хууль дээдлэх ёс". УБ., 2005 он, №1, 56 дахь тал.

2.А.Оюунчимэг. "Монгол улсад Нотариатын байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойд зориулсан баярын хуралд тавьсан илтгэл". 2005 он.

3.Б.Чимид. "Монгол Улс дахь хууль тогтоох үйл ажиллагаа ба хууль тогтоомжийн шинэтгэл". УБ., "Хууль дээдлэх ёс" УБ., 2008 он, №2, 10 дахь тал.

барихаар болоод байгаа билээ. Иймээс энэ хуульд гол анхаарлаа хандуулж ижил төрлийн харилцаат зохицуулдаг хуулиудтай уялдуулан, зөрчил, давхардал, бүрхэгдэл, хийдэлгүйгээр болзошгүй тосгуулан өргөн хүрээг хамран зохицуулахаар бодолцож хуулийн төслөө боловсруулах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Мөн Ардын багш, гавъяат хууль, доктор, процессор Б.Чимидийн процессын журамгүй хууль бол хоосон тунхаг лоозон болж хоцроод тэр зайг нь тогтоол, заавраар орлуулан нөхөж, хуулиа завхруулдаг нь социализмын үеийн хуулийн сул тал гэж шүүмжилсэнийг ч бодолцож заавраас хуульд шилжих нь эрх зүйт ёсонд шилжих нэг гол арга зам мөн гэдэгтэй саналаа нэгтгэх хэрэгтэй байна.

1997 оноос өмнө нотариатын чиг үүргийг төрийн байгууллага хэрэгжүүлж байсан бөгөөд Нотариатын шинэ хууль батлагдсанаас хойш төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх болсон энэ шийдэл нь дэлхий нийтийн жишиг буюу Ром-Германы эрх зүйн тогтолцоотой улсуудын нотариатын байгууллагын тогтолцоотой уялдуулах гэсэн чухал ач холбогдолтой шийдвэр болсон юм. Гэхдээ манай улсын нотариатын байгууллагын хөгжлийн түвшин тухайн улс орнуудын түвшинд хүрэх болоогүй байгаа нь нэг талаас өндөр хөгжилтэй улсуудын нотариатын байгууллагын хэдэн зуун жилийн түүхтэй харьцуулахад цаг хугацааны хувьд богино байсан нөгөө талаас дөнгөж шинээр бий болсон төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллах тогтолцоог санхүүгийн хувьд бэхжүүлэх, хүний нөөцийн бодлогыг төлөвшүүлэх, хамтран ажиллах байгууллагуудтайгаа харилцах харилцаа зэрэгт гол бодлогоо чиглүүлж байсантай холбоотой юм.

Монголын Нотариатчдын танхим нь 1997 онд батлагдсан Нотариатын тухай хуулийн дагуу төрийн чиг үүргийг гүйцэтгэдэг төрийн бус байгууллагын зохион байгуулалтад орж улмаар 1998 оны эрх зүйн шинэтгэлийн зорилтын хүрээнд тус улсад хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилтыг биелүүлэх үүднээс Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санааны дагуу . . . нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд өөрийн хувь нэмрийг бүрэн дайчлан ажиллаж, иргэдэд эрх зүйн ухамсар төлөвшүүлэх, туслалцаа үзүүлэх ажлыг хийж тэдний иргэний харилцаан дахь эрх зүйн баталгааг бүрдүүлэх үүргээ амжилттай гүйцэтгэж ирлээ.

Монголын Нотариатчдын танхимын 1997-2009 он хүртэл хийсэн ажлуудыг тоймлон авч үзвэл:

1. Нотариатчдын танхимын удирдлагын зүгээс боловсон хүчний асуудалд байнга анхаарлаа хандуулж, хуулийн байгууллагуудад ажиллаж байсан үе үеийн чадварлаг хуульчдаар эгнээгээ жил бүр нэмэгдүүлж байв. Энэ нь манай байгууллагад гавъяат хууль 2, алтан гадас одонгоор 4, Хөдөлмөрийн хүндэт медалиар 6, Засгийн газрын хүндэт жуух бичгээр 1, хууль зүйн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр 22, Хууль зүйн яамны хүндэт жуух бичгээр 2, хууль тогтоох байгууллагад ажиллаж байсан мэргэшсэн хуульч, их, дээд сургуулиудын эрдэмтэн багш нар мөн МЗХ-ны тэргүүний залуу алтан медаль, хүндэт тэмдгээр шагнагдсан залуу боловсон хүчнүүд ард иргэдийнхээ иргэний эрх зүйн баталгааг хангахын төлөө нэгэн хүсэл тэмүүлэлтэйгээр ажиллаж байгаагаар илэрч байна;

2. 1997 онд батлагдсан Нотариатын тухай хуулийн дагуу ажиллаж, улмаар эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд 2002 онд Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлуулан ажиллаж ирлээ;

3. Жил бүр дотоодоо мэргэшүүлэх сургалтыг дангаараа болон Хууль зүйн үндэсний төв, төслийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж улмаар хамтран ажиллаж байдаг Шүүх, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар, Үнэт цаасны хороо, Хөрөнгийн бирж, банк гэх мэт байгууллагуудтай хамтарсан семинаруудыг тухай бүр зохион байгуулж ажиллаж ирлээ;

4. Нотариатын эрх зүйг онолын түвшинд судлахад дөхөм болох үүднээс хууль зүйн их, дээд сургуулиудад эрх зүйн үйлчилгээ, нотариатын эрх зүй хичээлүүдийг хөтөлбөрт хичээл болгон оруулж, тэднээс зохион байгуулж буй эрдэм шинжилгээний хурал, лекц, семинарт оролцож ирлээ;

5. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар 2003 онд шинэчилэн баталсан Нотариатын үйлчилгээний хөлс, зардлыг жишигт өндөр үнээр гэрчилдэг гэрээ, хэлцлийн үнийг бууруулсан нь иргэд, байгууллагуудад учрах үйлчилгээний хөлсний дарамтыг багасгасан сайшаалтай үр дүнг авчирсан байна;

6. 2005 онд Нотариатын байгууллагын түүхт 80 жилийн ойг тэмдэглэн өнөөгүүлэх ажлын хүрээнд онол-практикийн бага хурал, нотариатын ач холбогдлыг иргэдэд сурталчлах үүднээс радио телевизэд ярилцлага хийлгэх, эрх зүйч-багш, хуулийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын дунд уралдаан тэмцээн зохиох зэрэг олон олон ажлуудыг хийж түүхэн замнал, одоогийн байр суурьа сурталчилж өгсөн төдийгүй өөрсдийн хүч хөрөнгөөр хуулийн байгууллагууд дотроос анх удаа Нотариатчдын танхим ажлын байртай болсон бахдам амжилттай ажилласан байна;

7. Иргэн, байгууллагад үзүүлэх үйлчилгээг чанартай, соёлтой, тав тухтай болгох үүднээс

нотариатчиддаа чиглэсэн ажлын байр, үйлчилгээний талаархи шалгалтыг жил бүр зохион байгуулж ирсэний дүнд иргэд, байгууллагын энэ талаархи гомдол мэдэгдэхүйц буурсан үзүүлэлттэй байна;

8. Нотариатын байгууллагын гадаад харилцааг хөгжүүлэх ажлын хүрээнд гадаад харилцааны яамны консулын хэлтэстэй хамтран ажиллах санамж бичиг гарын үсэг зуралцан ажлаа эхэлсэн байна. Мөн ОХУ-ын нотариатын байгууллага, ЛНОУХ-той хамтран ажиллах эхлэл суурийг тавих үүднээс ажил хэргийн уулзалтуудыг зохион байгуулж ирлээ;

9. Өдөр тутмын сонин болох Зууны мэдээ, Өнөөдөр зэрэг сонингуудад нотариатын мэдээллийн булан ажиллуулж, радио телевизэд цаг үеийн нөхцөл байдлын талаархи ярилцлага, мэдээллийг тухай бүр хийх замаар хэвлэл мэдээллийн салбартай хамтран ажиллаж ирлээ.

Гурав. Цаашдын чиг хандлага

Монгол Улсын Нотариатын байгууллага нь иргэдийнхээ Үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь эдлүүлж, үүргийг нь ойлгуулах түүнд үйлчилдэг төрийн болон иргэний нийгмийн бусад байгууллагуудтай хэрхэн эрх зүйн дагуу уялдаа холбоотой түргэн шуурхай ажиллаж ямар үйлчилгээг авч болохыг мэргэжлийн түвшинд уялдуулж иргэний эрх зүйн мэдлэг түгээж байдгийнхаа хувьд төр иргэн хоёрын зохистой харилцааг тодорхойлж, даяаршилтай хөл нийлүүлэх нь зүй ёсны асуудал болсон билээ. Иймээс өөрийн орны эрх зүйн тогтолцоотой ижил улс орнуудын нотариатын эрх зүйг судлах, улмаар хамтран ажиллах шаардлагын үүднээс тэднийг эгнээндээ нэгтгэсэн Латин Нотариатын олон улсын холбоо (ЛНОУХ)-ны гишүүн орон болох явдал чухал болоод байна.

Учир юу гэвээс 1998 онд хэлэлцсэн "Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо" сэдэвт олон улсын симпозиумын төгсгөлийн баримт бичигт үндэсний эрх зүйн тогтолцооны үндсэн шалгуур нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлд заасан "хууль дээдлэх ёс" байна. Тус улсын эрх зүйн тогтолцоо нь иргэншсэн эрх зүйн бүл (Civil law)-ийг баримжаалан хөгжинө"[4] гэдгийг АНУ, Монгол улс, ОХУ, ХБНГУ-ын эрдэмтэн судлаачид хүлээн зөвшөөрсөн байна.

Мөн энэ тухай гавъяат хууль ч Б.Чимид нь ямар ч нөхцөлд эх орныхоо "есөн зүйлийн" хэрэгцээ, уугуул орчинд нийцэхүйц эрх зүйн бүлийг баримжаалж, зөвхөн тэр хүрээнд харшлахааргүй бусад бүлийн жишгийг авах гээх ін үүднээс харгалзан үзэх нь тогтолцоот, тогтвортой хандлагын нэг шаардлага мөнийг дурдсан байна.

Иймээс манай улсын нотариатын байгууллага нь эх газрын эрх зүйн тогтолцоог үндэс болгодог ЛНОУХ-нд элссэнээр улам бүр даяаршилд татагдан орж байгаагийн хувьд, гадаадад болон өөрийн улсдаа байгаа иргэддээ тус холбооны гишүүн орнуудын үзүүлж буй эрх зүйн өндөр түвшний үйлчилгээг үзүүлэх, энэ чиглэлд хамтран хөгжих боломж бүрдэх юм.

ЛНОУХ-ны хүндэт Ерөнхийлөгч Дикьано 2002 онд манай улсад Хууль зүй, дотоод хэргийн сайдын урилгаар ирэхдээ "ЛНОУХ-ны гишүүн орон болохын тулд юуны өмнө тэдний шаардлагад нийцүүлэн батлагдсан хууль ёстой" гэдгийг сануулсан бөгөөд энэ санааг 2005 онд дахиж ирэхдээ бататгаж өгсөн юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайд энэ асуудлыг анхааралдаа авч Нотариатын тухай хуулийг латин нотариатын хэв маягийг дагуу боловсруулах бодлого барьж байгаа тухайгаа албан ёсоор илэрхийлсэн нь бодлого барьж буй яамны зүгээс нотариатын байгууллагын хөгжлийг цаашид зөв бодлогоор хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж байгаагийн нэг илрэл гэж хүлээн авч байна.

Гэхдээ нотариатын тухай хууль батлуулах, ЛНОУХ-нд элсэх гэсэн дан ганц баригдмал сэтгэлгээг үндэс болгох бус байгууллагыг хөгжүүлэх, боловсон хүчнээ чадваржуулах, тэдний нийгмийн асуудлыг цогцоор нь авч үзэх байгууллагын хөгжлийн стратегийг хэрэгжих хугацаатайгаар нь багцалж гаргах нь зорилго, зорилттой хөгжих боломжийг бүрдүүлэх юм.

Хөгжил нь өмнөхөө үгүйсгэх шүүмжлэх бус хөгжил дэвшилтэй нь хамтаар илүү далайцтайгаар сэтгэж, түүнийгээ хэрэгжүүлж, даяаршилтай хөл нийлүүлэх гэж тэмүүлж буйгаараа ач холбогдолтой билээ.

Нотариатын байгууллагын хөгжлийн чиг хандлагыг боловсронгуй болгохын тулд гадаад харилцаагаа өргөжүүлэх, ингэхийн тулд ЛНОУХ-нд элсэх, элсэхийн тулд латин нотариатын хэв маягийн дагуу нотариатын тухай хуулиа шинэчлэх, шинэчлэхийн тулд хуулийн төслийг бодлого барьж буй яамтайгаа хамтран боловсруулж Улсын Их Хуралд өргөн барих явдал юм гэж энэ тэргүүний зорилттой холбож байна.

4.Эмхэтгэн хэвлүүлсэн Ханс-Зайделийн сан. "Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо" УБ., 2000 он, 188 дахь тал.

ХҮҮХЭД ХӨДӨЛМӨРЛӨХ ЁСТОЙ ЮУ?

Хүүхэд хөдөлмөрлөх эсэх тухай ярихаас өмнө "хүүхдийн хөдөлмөр" гэж юу болохыг товч хөндөн өгүүлэх нь зүйтэй болов уу. "Хүүхдийн хөдөлмөр" гэдгийг бид хүүхдүүдийг байнга болон түр хугацаагаар ажил хийлгэх явдал гэж ойлгодог. Харин эл үйлдлийг олон улсын зонхилох байгууллагууд мөлжлөгийн нэг хэлбэр хэмээн үзэж, ихэнх улс орнуудад хууль бус үйл ажиллагаанд тооцдог байна.

Хүн төрөлхтний түүхийн хуудсыг сөхөн үзвэл, 1837-1901 онд амьдарч байсан Английн хатан хаан Викториагийн эрин үед хүүхдүүд үйлдвэр, уурхайд маш олноор ажиллаж, яндан хөөлөгч хүүхдүүд хотоор дүүрч байжээ.[1] Эдийн засгийн хүнд нөхцөл байдлын улмаас хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүд Аж үйлдвэрийн хувьсгалд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Английн алдарт зохиолч Чарльз Дикенс хүртэл өрийн дарамтаас гарахаар гэр бүлийн гишүүдийн хамт 12 настайгаасаа үйлдвэрт ажиллаж байсан гэдэг. Ядуу хүүхдүүд гэр бүлийн төсөвт хувь нэмэр оруулахаар бага цалинтай, маш хүнд, аюултай нөхцөлд удаан хугацаагаар ажилладаг байв. Шалмаг, овсгоотой хүүхдийг яндан хөөлөгчөөр, жижиг биетэй хүүхдийг үйлдвэрийн даавууны дамар солиулах, мөн уурхайн нарийхан цооногоор чулуун нүүрс гаргуулах, захиа хүргэх, хивс гүвэх, гутал тослох, шүдэнз, цэцэг зэрэг хямдхан бараа заруулдаг байжээ.[2] Зарим хүүхдийг худалдаа, барилга дээр, мөн гэрийн зарцаар

Хуульч Д.Солонго

ажиллуулдаг байсан бөгөөд XVIII зууны дунд үед Лондон хотод 120,000 гэрийн зарц байжээ. Ажлын цаг маш удаан, зуны цагт барилгачид долоо хоногт 64 цаг, өвлийн цагт 52 цаг, гэрийн зарц нар долоо хоногт 80 цаг ажилладаг. Мөн хүүхдийн биеийг үнэлүүлэх явдал газар авсан байжээ.[3] Ихэвчлэн хүүхдийг гурван настайгаас ажилд авах болов уурхайд таван настайгаас авч, харин ажилчин хүүхэд 25 нас хүрэлгүй нас бардаг байв.[4] Ерөнхийдөө XVIII зууны сүүлч XIX зууны эхээр хүүхдийг дөрвөн настайгаас нь аюултай, амь насанд заналхийлсэн нөхцөл байдал бүхий үйлдвэрт ажиллуулдаг байв[5]. Тиймээс хүүхдийн хөдөлмөрийн эсрэг хамгийн анхны эрх зүйн зохицуулалт бүхий "Үйлдвэрийн тухай хууль"-ийг Их Британид XIX зууны эхний хагаст батлан гаргажээ. Тухайн үед ихэнх хүүхэд насанд хүрсэн хүний нэгэн адил өдөрт 16 цаг ажиллаж байсныг 1802, 1819 онд баталсан "Үйлдвэрийн тухай хууль"-иар есөн насанд хүрээгүй хүүхдийг ажилд авч болохгүй, 18 насанд хүрээгүй хүүхдийн нэг өдрийн ажлын цагийг 12-оос хэтрүүлэхгүй байлгахаар тогтоожээ[6]. Гэсэн хэдий ч энэ нь тодорхой үр нөлөө үзүүлээгүй учир 1833 онд байгуулсан хааны хорооноос 11-18 насанд хүрсэн хүүхэд 12 цаг, 9-11 насанд хүрсэн хүүхэд 8 цаг, 9 насанд хүрээгүй хүүхэд ажиллах ёсгүй гэж тогтоожээ. Хэдийгээр энэ хэм хэмжээ зөвхөн үйлдвэрийн газруудад хэрэгжсэн боловч 1847 онд насанд хүрсэн хүн болон хүүхэд өдөрт 10 цагаас илүү ажиллаж болохгүй тухай өөр хуулийг батлан гаргахад нөлөөлсөн юм.

Аж үйлдвэрийн хувьсгалаас өмнө бүх хүүхэд ямар нэгэн хэлбэрээр ажил эрхэлж байсан. Харин Аж үйлдвэрийн хувьсгалын үеэр олон хүүхэд хөдөө аж ахуйгаас үйлдвэрийн газарт ажиллах болж, улмаар эцэг эх хүүхдээ үйлдвэр рүү биш сургуульд явуулдаг болсон нь хууль тогтоомжоос гадна орлого нэмэгдэж эхэлсэнтэй холбоотой. Нөгөө талаас хүүхдийн хөдөлмөрийг дэмждэг эрдэмтэд, хүнд хүчир ажилд нухчин дарлагдаж байсан хүүхдүүд орчин нөхцөл сайтай үйлдвэрийн газарт ажиллах болсноор нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулсан гэж үнэлдэг. Гэхдээ хүн төрөлхтний хойч ирээдүй болсон хүүхдийн бие махбодийн хүч хөдөлмөрөөр хөгжлийг тодорхойлох нь орчин цагт өрөөсгөл бөгөөд хөдөлмөрийн зах зээл болон аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөрийг салгаж ойлгох шаардлагыг эрдэмтэд тавьсаар байна. Ер нь эрт дээр үеэс олон төрөл хэлбэрээр хүүхдийн

1. Laura Del Col, West Virginia University, The Life of the Industrial Worker in Nineteenth-Century England
2. Barbara Daniels, Poverty and Families in the Victorian Era
3. Labor David Cody, Hartwick College http://victorianweb.org/history/hist8.html
4. http://hiddenlives.org.uk/articles/poverty.html
5. E. P. Thompson, *The Making of the English Working Class*, (Penguin, 1968), P.366-7.
6. Laura Del Col, *The Life of the Industrial Worker in Ninteenth-Century England* West Virginia University

хөдөлмөрийг ашиглаж ирсэн боловч аж үйлдвэржилтийн үр дүнд хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдөж, ажилтны болон хүүхдийн эрхийн тухай ухагдахуун бий болсноор нийгмийн энэхүү маргаант байдал бий болжээ. Гэсэн хэдий ч одоо хүртэл дэлхийн зарим хэсэгт хүүхдийн хөдөлмөр энгийн үзэгдэлд тооцогдож, хүүхдийг үйлдвэр, уурхай, газар тариаланд ажиллуулах, насанд хүрэгчдийн хийхээс зайлсхийдэг бохир заваан ажил хийлгэх, биеийг нь үнэлүүлэх, гар дээрээс худалдаа хийлгэх, ачаа зөөлгөх зэргээр эцэг эх нь өөрсдийн аж амьдралд туслуулсаар байна. Зарим хүүхэд жуулчдад хөтөч болох, тэдний дэлгүүр, зоогийн газар аваачих, үйлчлэх зэрэг ажил эрхэлдэг бол зарим нь нударган зодоон хийх, гутал тослох, дэлгүүрийн бараа бүтээгдэхүүнийг зөөх, цэвэрлэх зэрэг хүнд хүчир ажлыг шахалтаар гүйцэтгэдэг. Ер нь бодит амьдрал дээр хүүхдүүд хууль хяналтын байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслээс далдуур гудамжинд худалдаа, наймаа хийх, тариалангийн ажилд зүтгэх, эсвэл орон байранд нууц байдлаар ажиллах зэрэг хууль бус явдал түгээмэл байна. Түүгээр ч үл барам тэднээр тухайн ажлыг жилийн турш амралтгүйгээр хийлгээд зогсохгүй хамгийн бага хөлс өгдөг ажээ.

Ер нь гэр бүл нь ядуу зүдүү бол хүүхэд хүссэн, хүсээгүй хөдөлмөр эрхэлсээр байгаа билээ[8]. Ядуу гэр бүлийн хувьд, амь зуухын тулд хүүхдээ хөдөлмөр эрхлүүлдэг, зарим тохиолдолд хүүхэд нь цорын ганц орлогын эх үүсвэр болох явдал ч бий. 1998 оны Америкийн эдийн засгийн тойм сэтгүүлийн "Хүүхдийн хөдөлмөрийн эдийн засаг" нийтлэлд судлаач Каушик Басу, Фам Хоанг Ван нар хүүхдийн хөдөлмөрийн үндсэн шалтгааныг эцэг эхийн ядуу байдал хэмээн годорхойлсон байна. Түүнчлэн тэд хүүхдийн хөдөлмөрийн эсрэг хууль тогтоомжоор хорио, хязгаарлалт тавьснаар эерэг үр дүнд хүрэх боломжгүйг анхааруулаад, хүүхдийн хөдөлмөрийн эсрэг хорио нь зөвхөн насанд хүрсэн этгээдийн цалин орлогыг нэмэгдүүлж, ядуу хүүхдүүдийн гэр бүлд нөхөн олговор олгох нөхцөл бүрдсэн тохиолдолд хэрэгжиж болох юм гэжээ. Одоо хүртэл Энэтхэг, Бангладеш зэрэг улсуудад хүүхдийн хөдөлмөр өргөн тархсан хэвээр байна. Судалгаагаар Энэтхэг улсад 70-80 сая хөдөлмөр эрхлэгч хүүхэд байгааг тогтоожээ.[9] Мөн зарим улс оронд 14 насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулж болохгүй хэмээн үндэсний хуулиндаа тусгасан боловч түүнийгээ биелүүлдэггүй тохиолдол их бөгөөд тухайлбал 11 настай хүүхдүүд өдөрт 20 аг ажиллаж, дэлхийд алдартай дэлгүүрийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоогоор 1 цент авдаг үзэгдэл эрх чөлөөний орон гэгдэх АНУ-д байсаар байна. Хүүхдүүдийг насанд хүрсэн хүнээс хямд цалин хөлсөөр ажиллуулж болдог тул компаниуд илүү их орлого олох зорилгоор тэднийг гутал, хувцас зэрэг их хэмжээгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг газарт хүүхдүүдийг байнга ажиллуулдаг ажээ.

Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн харьцаа улс орон бүрт харилцан адилгүйгээс гадна бүс нутгаас шалтгаалан өөр өөр байдаг. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн тоо, хувь хэмжээг тивээр ангилан үзвэл, Ази тивд 61%, Африк тивд 32%, Өмнөд Америкт 6%, Хойд Америк, Европ тивд 1% оногдож байх ба Ази тивийн ажиллах хүчний 22 хувийг, Өмнөд Америкийн ажиллах хүчний 17 хувийг хүүхэд эзэлж байна.

Энэ мэтээр хүүхдийн хөдөлмөрийг ашиглах явдлыг орчин цагт хөгжилтэй улс орнууд хүний эрхийн зөрчилд тооцож, хууль бус хэмээн үздэг боловч буурай орнуудад энэхүү зөрчил оршсоор байна. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх зорилгоор цагдаагийн байгууллага хүүхэд ажилладаг хэмээн сэжиглэсэн үйлдвэрүүдийг байнга шалгадаг ажээ.[10]

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн сангийн зүгээс эдүгээ дэлхий дээр 5-14 насны 158 сая хүүхэд ил болон далд хэлбэрээр хөдөлмөр эрхэлж байгааг мэдэгджээ.[11] Тэрчлэн судалгааны баримтаар өдгөө дэлхий дахинд 2-18 насны 250 сая хүүхэд хөдөлмөрлөж байгаа ажээ.[12] НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 32 дугаар зүйлд: "Оролцогч улсууд эдийн засгийн мөлжлөгөөс хамгаалуулах, хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, сэтгэл санаа, ёс суртахуун, нийгмийн хөгжилд аюултай боловсрол эзэмшихэд нь саад болох ажил эрхлэхээс хамгаалуулах эрхийг хүлээн зөвшөөрнө" гэж заасныг хүүхдийн хөдөлмөрийг ашиглах, мөлжих боломжтой гэж үзэж ойлгох явдал ч байна.[13]

1990-ээд оноос АНУ, Сомалиас

7. "Child labour in Kyrgyz coal mines". BBC News. http://news.bbc.co.uk/2/hi/asia-pacific/6955202.stm. Retrieved on 2007-08-25.

8. "The State of the World's Children 1997". UNICEF.

9. http://www.boloji.com/society/0035.htm

10. Morendy Octora - Central Of Manpower Data & Information, 2008; Aditya Agroebie - ILO, 2008)

11. http://www.unicef.org/ceecis/pub_beyond_en.pdf

12. "Worst Forms of Child labor Recommendation, 1999". International labor Organization. http://www.ilo.org/ilolex/cgi-lex/convde.pl?R190. Retrieved on 2006-10-05.

13. "Convention on the Rights of the Child". United Nations. http://www.ohchr.org/english/law/crc.htm. Retrieved on 2006-10-05.

бусад бүх НҮБ-ын гишүүн орнууд Хүүхдийн эрхийн тухай конвенцид гарын үсэг зурсан билээ. НҮБ-ын Сангийн (The United Nations Foundation) мэдэгдсэнээр, Сомали Улс 2002 онд гарын үсэг зурах үйл явц удаашралтай байгааг төрийн эрх барих байгууллага байхгүй байсантай холбон тайлбарладаг байна.[14] Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хууль бус хүүхдийн хөдөлмөрийг хориглосон хамгийн үр нөлөөтэй олон улсын эрх зүйн эх сурвалж мөн боловч чухамдаа хүүхдийн хөдөлмөрийг хууль бус гэж шууд тодорхойлоогүй муу талтай. Нөгөөтэйгүүр хүүхдийн эрхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг зарим бүлэг, хүүхдэд хэрэгтэй гэх үүднээс хүүхдийн хөдөлмөрийг хориглох нь хүүхдүүдийн ахархан хугацаанд олох орлого, амьдралын итгэл найдварыг давхар үгүй хийж байна, "хуулинд заасан насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөрийг хориглох нь хүний эрхийг зөрчиж, хүүхдийн боломж бололцоог бууруулж байгаа үзэгдэл. Хүүхэд зөвхөн мөнгө гэдэг зүйлийг хүсэж мөрөөдөхөөс өөр зүйл чадахгүй боллоо" гэж өөрсдийн байр суурийг илэрхийлэх явдал ч бий.

Юутай ч хөгжингүй улс орнууд хүүхэд хөдөлмөр эрхлэх насанд хүрээгүй тохиолдолд гэрийн болон сургуулийн ажлаас бусад ажил эрхлэх явдлыг тохиромжтой бус буюу мөлжиж байгаа хэлбэр гэж үздэг, ажил олгогч насанд хүрээгүй хүүхэд ажилд авахыг хориглодог[15] билээ. Ер нь ажил эрхлэх доод насыг улс орон бүр харилцан адилгүй тогтоосон байдаг бөгөөд "Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль"-нд 16 насанд хүрсэн хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрнаас бусад ажилд 14 насанд хүрсэн хүнийг мэргэжлийн баримжаа, ажлын даллага олгох зорилгоор эцэг эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр ажиллуулж болохыг заажээ.

1998 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр эхэлсэн "Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхий дахины аян"-ы уриалга эрчимтэй өрнөн дэлхийн өнцөг булан бүрт хүрч, олон нийтийн анхаарлыг татан, өргөн хүрээг хамарч, хүүхдийн хөдөлмөрийн эсрэг уриаг олон мянган хүн дэмжсэн юм. Энэхүү аян үргэлжилсээр Швейцарь Улсын Женев хотод болсон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын бага хурлаар өндөрлөсөн билээ. Аянд оролцогчдын дуу хоолой Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай конвенцийн төсөл боловсруулагч нарт хүрч, тэдний үзэл бодлыг конвенцийн төсөлд тусгаж, улмаар жилийн дараа тус конвенцийг ямар ч саналын зөрөлдөөнгүй батлсан ажгуу. Өдгөө дэлхийн 169 улс уг конвенцийг соёрхон батлснаас гадна Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын түүхэнд хамгийн богино хугацаанд батлсан конвенц болж оржээ. Үүнд аянд оролцсон гишүүн улсууд голлох үүрэг гүйцэтгэснийг дэлхий нийт талархан тэмдэглэдэг бөлгөө.

Монгол Улсын хувьд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас батлсан "Алагчилахгүй байх (Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай" олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц, "Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай" олон улсын хөдөлмөрийн байгууллагын 59 дүгээр конвенц (хянаж өөрчлөсөн), "Газар доор буюу уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай" олон улсын хөдөлмөрийн байгууллагын 123 дугаар конвенци, "Тэгш шан хөлс олгох тухай" олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц, "Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай" олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенци, "Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай" олон улсын хөдөлмөрийн байгууллагын 122 дугаар конвенциудад нэгдэн орж, соёрхон баталсны дээр холбогдох харилцааг зохицуулсан үндэсний хууль тогтоомжийн зохицуулалтыг тодорхой хэмжээнд нийцүүлэн өөрчилсөн болович нийгэмд хүүхдийн хөдөлмөр оршсоор байна. Учир нь эдийн засгийн баталгаа, амьжиргааны түвшинтэй энэ нь шууд холбоотой тавигддаг асуудал билээ.

Хэдий тийм боловч технологийн болон эдийн засгийн өөрчлөлт нь хүүхдийг ажлын байрнаас шахаж, сургуульд явах боломжийг бүрдүүлж байна. Ингэснээр хүүхдүүд чадварлаг иргэн болон төлөвшиж, эрүүл амьдарч, урт наслах болно. Гэсэн хэдий ч дэлхийн ядуу буурай улс орнуудад XIX зуунаас өвлөн авсан хүүхдийн хөдөлмөрийг олон гэр бүл өөрийн амь зуух хэрэгсэл болгож байна. Иймээс хүүхдийн хөдөлмөрийг дуусгавар болгохын тулд дан ганц хуулиар хүчлэн хориглох бус, нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлыг харгалзан, эрэг өөрчлөлтийг хийх замаар буюу үр нөлөөтэй арга замыг сонгон ажиллах шаардлагатай байна.

Эцэст нь, АНУ-ын "Уурхайчдын барууны холбоо"-ны тэргүүн, "Дэлхийн аж үйлдвэрийн ажилчид" байгууллагыг үндэслэгч, тэргүүн Билл Хейвудын хүүхдийн хөдөлмөрийг эсэргүүцэж хэлсэн алдарт үгээр бичвэрээ өндөрлөе. "Хамгийн өөдгүй хулгай бол хүүхдийн тоглох цагаас хулгайлах явдал"[16] гэдгийг санана уу.

14. http://www.unwire.org/unwire/20020510/26300_story.asp

15. "Ratification of the Convention on the Rights of the Child". Office of the United Nations High Commissioner for Human Rights. http://www.ohchr.org/english/countries/ratification/11.htm.

16. Wobblies! A Graphic History of the Industrial Workers of the world edited by Paul Buhle and Nicole Schulman p.294.

АНУ-ЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС ДАХЬ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА (II хэсэг)

Америкийн нэгдсэн улсын эрүүгийн процесс дахь гэм буруугаа хүлээн зөвшөөрөх талаар хэлцэл хийх тухай хэлэлцээр (ял наймаалцах ажиллагаа) талаарх ерөнхий ойлголт, яллах болон өмгөөлөх талуудын үүрэг, оролцоог өмнөх дугаарт дэлгэрэнгүй толилуулсан билээ. Нийтлэлийн дараачийн хэсэгт яллах болон өмгөөлөх талуудын хооронд хийгддэг тохиролцооны хэлбэр, төрөл, хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шүүхийн гүйцэтгэх үүргийг авч үзье.

Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч, докторант Ч.Хосбаяр

Гэм буруугаа хүлээн зөвшөөрөх талаар хийсэн хэлцлийн үр дүн (The Product of plea bargaining)

Ялын хэлцэл яллагдагчийг шүүхэд шилжүүлэхээс өмнө, хэрэг шүүхэд шилжсэнээс хойш ч явагдаж болно. Үр дүнд нь талуud дараах нөхцөлүүдийн аль нэг дээр эсвэл аль алинаар нь ч тохиролцоонд хүрсэн байж болно. Үүнд:

а. Шүүгдэгч өөрийгөө эрүүгийн хууль тогтоомжийн (US Code гэж эрх бүхий байгууллагаас баталж АНУ-д хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй бүх хуулийг дугаарлаж бичмэл байдлаар кодолж эмхтгэсэн баримт) арай хөнгөн ангилал, зүйл, хэсэгт хамаарах гэмт хэргийг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрөхөөр босоо чиглэлд зүйлчлэлийг хөнгөрүүлж;

б. Шүүгдэгч илүү цөөн үйлдэлд гэм буруутайгаа хүлээхээр буюу хэвтээ чиглэлд тохиролцох;

в. Шүүгдэгч прокурорын ялласан хэрэгт гэм буруутайгаа бүрэн хүлээж арай хөнгөн ял авахаар тохирч буюу ял дээр тохирох гэсэн байдлаар талуud тохиргоодог. Тодруулбал:

- Зүйлчлэл хөнгөрүүлж тохирох (Pleas to Lesser Charges)

Энэ нь шүүгдэгч прокурорын яллах дүгнэлтэд буй эсвэл ялла: ір төлөвлөж буй хэрэгтэй нэг бүлэгт хамаарах боловч нийгмийн хор аюулаар бага, илүү хөнгөн ял шийтгэлтэй хэрэгт өөрийгөө гэм буруутай болохоо хүлээн зөвшөөрөхөөр, зөвшөөрснөөс үүсэх үр дагаврыг бүрэн ойлгож хийсэн хэлцэл юм. Илүү хөнгөн хэрэг гэдэгт гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд анхны ялласан хэрэгтэй нэг бүлэгт хамаарах боловч бүрэлдэхүүний зарим нэг шинж (criminal elements) дутуу хэргийг оруулдаг. АНУ-ын эрүүгийн эрх зүйд энэ талын сонгодог жишээ бол нэгдүгээр зэргийн аллага (first-degree murder), хоёрдугаар зэргийн аллага (second-degree murder) гэж томъёологддог хүнийг шууд санаатай болон шууд бус санаагаар, эсвэл болгоомжгүй алах хэргүүд юм. Хүнийг алах хэрэгт хамаардаг боловч болгоомжгүй бусдыг алах, санаа сэтгэл хүчтэй цочрон давчидсаны улмаас бусдыг алах, мөн хувийн таарамжгүй харьцааны улмаас алах зорилгогүйгээр зодолдох явцдаа хүнийг алах хэргүүдийг илүү хөнгөн хэрэг хоёрдугаар зэргийн аллагад тооцдог. Эдгээр хэргүүдийг хохирогч нас барсан байдгаар нь нэг бүлэгт багтаасан боловч сүүлд дурьдсан хэргүүдийг санаатай гэмт хэрэг гэж үздэггүй ажээ.

Мөн орон байрт нэвтэрч бусдын эд зүйл хулгайлсан хэргийг (burglary) бусдын орон байрт хууль бусаар нэвтрэх хэрэг (trespass), их хэмжээний хохиролтой хулгайн хэргийг (grand theft) жижиг хулгай (petty theft) болгон хөнгөрүүлэхээр тохиролцох нь олонтаа. Энэ тохиролцоо нь улсын яллагчийн хувьд илүү хүнд хэрэгт үр дүнтэй яллаж чадах нь эргэлзээтэйгээс арай хөнгөн хэрэгт баттай ял шийтгүүлэх, шүүгдэгчийн хувьд мөн эрсдэлгүйгээр илүү хөнгөн хэрэгт богино хугацааны баривчлах, торгуулах ял шийтгүүлэх, эсвэл ялыг тэнсэн харгалзах боломж бий болж байгаараа талуудад ашигтай юм. Прокурорууд тохиролцооны энэ хэлбэрийг сонгон авах нь элбэг, учир нь хэргийн зүйлчлэлийн хувьд л тохирч ялын асуудлыг шүүхэд үлдээж байгаа учир ял тохирсон (гэм буруud нь) эсэх талаар аливаа асуудалд өртөх эрсдэлгүй гэж үздэг ажээ.

- Яллагдах үйлдлийн тоог цөөрүүлэх (Dropped Charges or Case)

Прокурор, өмгөөлөгч хоёр шүүгдэгчийн холбогдсон зарим үйлдэлд түүнийг яллахгүй байхаар тохиролцож болно. Прокурорын анх үйлдсэн яллах баримтад заасан үйлдлүүдийн заримд шүүгдэгч өөрийгөө гэм буруутайг хүлээн зовшөөрсөн тохиолдолд бусад үйлдэлд нь яллахгүйгээр

тохиролцоно гэсэн үг юм. Гэхдээ энэ нь нэг бүлэг эсвэл зүйлд хамаарах үйлдлүүдийн хувьд яригдахаас өөр бүлэг, зүйлд хамаарах бодит байдлаараа өмнөх хэргээс онц ялгаатай хэргийг орхигдуулахыг яллагч зөвшөөрдөггүй. Мөн хууль эдгээр үйлдлүүд нэг яллах баримтад (прокурорын баталсан яллагдагчаар татах тогтоол-indictment, яллах дүгнэлт-information) тусгагдсан байх, нэг шүүгдэгчид холбогдолтой байхыг шаарддаг.

Прокурорт шүүгдэгчийг гэмт хэрэгт яллахгүй байх боломжийг nolle prosecui (лат.) буюу товчоор nol pros гэх прокурор "яллах сонирхолгүй" гэсэн агуулга бүхий олон улсын эрүүгийн эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн зарчим олгодог бөгөөд энэ тохиолдолд прокурор яллахаас татгалзах мэдэгдлийг шүүхэд гаргадаг. Прокурор яллахаас татгалзах болсон үндэслэлээ ердөө л "шүүгдэгч гол үйлдлүүдээ хүлээн зөвшөөрсөн" тул гэж тайлбарласан нь шүүх түүнийг хүлээн авахад хангалттай байдаг. Үнэхээр ч шүүгдэгч хамгийн ноцтой үйлдлээ хүлээн зөвшөөрсөн байхад бусад түүнд багтах үйлдлүүд хууль зүйн үр дагавар үүсгэх ач холбогдол багатай байх нь олонтаа. Тэгээд ч АНУ-ын ихэнх мужид "багтаах яллагаа" буюу concurrent sentencing зарчим үйлчлэх бөгөөд энэ нь "үндсэн гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагдсан байхад түүнд багтах өөр үйлдлээр ялыг чангаруулахгүй" гэсэн (манай эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйд энэ зарчмыг зөвхөн ял оногдуулахад "хөнгөн ялыг хүндэд нь багтаах" хэлбэрээр хэрэглэдэг) агуулгатай. Өөрөөр хэлбэл талууд тохиролцоонд хүрч чадалгүй хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцсэн байсан ч шүүх үндсэн үйлдлүүдэд ял шийтгэхээс түүнд хамаарах бусад үйлдлийг хэлцэхгүй байх магадлалтай.

Нэг зүйлийг нэмж хэлэхэд энэ хэлбэрээр ял тохиролцсоноор шүүгдэгчид үйлдэл, холбогдлоос нь зарим нь хасагдаж ял хөнгөрөх мэт сэтгэгдэл төрдөг боловч энэ нь ач холбогдолгүй, шүүхээс бодит байдал дээр илүү ял оногдуулах боломжгүйг прокурор мэдэж харин энэ нөхцөл байдлыг ашиглаж шүүгдэгчээр хэргийг нь хүлээлгэсэн байх нь олонтаа. Харин хашир гуршлагатай өмгөөлөгч прокурорт хуурталгүйгээр гол үйлдлүүдээсээ хасуулж тоог нь цөөлснөөр зүйлчлэлд өөрчлөлт орж босоо чиглэлд хөнгөлөлт бий болгож чадвал үнэхээр шүүгдэгчид ашигтай хэлцэл байх нь ойлгомжтой. Практикт түгээмэл тохиолддог жишээ бол олон үйлдэлтэй хулгайн хэрэгт анх удаа холбогдсон шүүгдэгчийг хохирол ихтэй 2-3 үйлдэлд нь гэм буруутайг нь хүлээлгэж бусдад нь яллахгүйгээр тохирох боловч үнэндээ энэ хэрэгтээ авах ял нь бүх үйлдлээ шийтгүүлэх ялтай тэнцүү байх бөгөөд прокурорын энэ ов мэхийг олж харах нь шүүгдэгчийн өмгөөлөгчийн мэргэжлийн чадвараас хамаардаг.

- Ял дээр тохиролцох (sentence bargains)

Энэ нь яллагдагч, шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа бүрэн хүлээж хариуд нь хөнгөн ял шийтгүүлэх тухай хэлцэл юм. Прокурор өмгөөлөгчөөс шүүгдэгчийн ялыг хөнгөрүүлэх талаар шүүгчид гаргаж буй санал, тайлбар, нотолгоог эсэргүүцэхгүй, харин ч дэмжихээр тохиролцдог. Шүүгдэгчийн хувьд ял шийтгэл хөнгөн байх нь бүхнээс илүү чухал учир энэ баталгааг прокурор ямар нэг хэмжээгээр гаргасан тохиолдолд хэргээ ч хялбар хүлээдэг. Энэ хэлбэрийн тохиролцоо ихэвчлэн нэг үйлдэлтэй, эрүүгийн хуулийн хамгийн хөнгөн зүйл, хэсэгт хамаарах хөнгөн хэргүүд дээр явагддаг. Өөрөөр хэлбэл, өмнө яригдсан зүйлчлэл хөнгөрүүлэх, үйлдэл хасах боломжгүй хэргүүд дээр шүүгдэгчид оногдуулах ялыг багасгах дээр тохиролцох боломжтой гэж ойлгож болно.

Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхийг эсэргүүцэгчид ял нь нийтийн ашиг сонирхолд үйлчлэх ёстой бөгөөд гэмт хэрэг үйлдсэн тухайн этгээдэд оногдуулах ялын төрөл, хэмжээг хөндлөнгийн хараат бус субъект, тухайлбал шүүгч тогтоох ёстой, хэрэгт сонирхол бүхий талуud ялыг хуйвалдан тодорхойлсноор эрүүгийн хариуцлагын жинхэнэ зорилго, агуулга алдагдаж байна гэж шүүмжилдэг ажээ. Ер нь АНУ-д ял наймаалцах нь олон нийт, зарим эрдэмтэн судлаачдын зүгээс эрх зүйн тулгуур зарчмуудад харш гэсэн утгаар асар их шүүмжлэлд өртдөг, тийм ч цэвэр сэдэв биш бөгөөд энэ шалтгаанаар ч АНУ-д албан ёсоор хуульчлагдаагүй, гэвч хэрэглэхийг хориглоогүй, практикийн шинжтэй ойлголт юм. Иймээс АНУ-ын зарим муж улсын прокурорын байгууллагууд дээр дурдсан шалтгаан болон олон нийт, хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн өмнө ялын асуудлаар ямар нэг хариуцлага хүлээхгүй байх зорилгоор гэм буруугаа хүлээн зөвшөөрөх талаар хэлцэл хийх тухай хэлэлцээрийн (ял наймаалцах ажиллагаа) энэ хэлбэрийг хэрэглэхээс аль болохоор зайлсхийх чиг бодлого барих нь байх боловч ихэнх прокурор энэ журмыг үйл ажиллагаандаа урьдын адил өргөн хэрэглэсээр байна.

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шүүхийн хяналт
(Judicial review and acceptance of pleas)

Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрч шүүгдэгч, түүний өмгөөлөгч болон прокурорын гэм буруу, ялын асуудлаар харилцан тохирч хэргийг хялбаршуулсан

журмаар шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргасныг шүүх хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож хянаж үзсэний үндсэн дээр хүлээн авах эсэхийг дотоод итгэлээрээ шийднэ. Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж буй үед шүүхийн гүйцэтгэх гол үүрэг шүүгдэгчийн гэм буруугийн асуудлаар хийсэн талуудын тохироо хуульд нийцэж буй эсэх, хэрэг бодитой, шударга шийдвэрлэгдэж буй эсэхэд тавих хяналт юм. Энэ нь ял шүүгдэгчийн хувийн байдал, гэм буруугийн хэр хэмжээнд тохирч буй болон ял наймаацахдаа Америкийн Барын Холбооноос гаргасан стандарт болон АНУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дүрмийг (тухайлбал Флоридагийн дүрэм) баримталсан эсэхийг шалгана гэсэн үг юм.

Америкийн Барын Холбооны стандарт *(ABA standarts Related to Pleas of Guilty)*

1968 онд Америкийн Барын Холбооноос шүүгдэгчийн гэм буруугийн асуудлаар талуудхарилцан тохиролцоноор хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөлийг тогтоож өгсөн. Энэ нь зөвлөмжийн шинжтэй, ягштал мөрдөх албагүй боловч АНУ-ын бүх шүүх, шүүгчид удирдлага болгож ажилладаг. Уг стандартын гол нөхцөлүүдийг сийрүүлбэл:

Шүүх нь шүүгдэгчийн гэм буруу болон ялын асуудлаар талуудхарилцан тохиролцсон хэргийн тухайд энэ тухай хүсэлтийг хүлээн авч хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх нь нийтийн эрх ашиг, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт зарчимд харшлахгүй бөгөөд түүний шуурхай, оновчтой байдлыг хангахад тустай гэж үзвэл шүүгдэгчид тохиролцсон зүйлчлэл, ялыг хэрэглэж байх нь зүйтэй. Талуудын тохиролцоо дараах шалгуурыг хангасан байх ёстой. Үүнд:

-Шүүгдэгч үйлдсэнээ хүлээн зөвшөөрч буй хэрэгтээ ямар ял шийтгүүлэх боломжтойг ойлгож мэдсэн;

-Шүүгдэгч үйлдсэн хэрэгтээ гэмшсэн, гэм буруутай үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн;

-Хэлэлцэж тохирсон ял нь шударга, энэрэнгүй байх;

-Тухайн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх нь шүүгдэгчид үнэхээр давуу тал бий болгож буй, (үүнд илүү хөнгөн ял шийтгэгдэх боломжоос гадна хэрэг түргэн шуурхай шийдвэрлэгдэж буй хугацааны хүчин зүйлийн хөнгөлөлтийг бас харгалзана).

Шүүх талуудын тохиролцоо дээрх шалгуурыг хангасан эсэхийг шалгахаас гадна шүүгдэгч анх өөрийн гэм буруугаа хүлээж гаргасан мэдэгдэл хэр оновчтойг мөн нягталдаг. "Оновчт й" (accurate-англ., точный-ор :.) гэдэг нь АНУ-д хэрэглэж заншсан хууль зүйн нэр томъёо бөгөөд шүүгдэгч өөрийгөө тухайн гэмт хэрэгт гэм буруутай болохоо хүлээн зөвшөөрснөөр учирч болох үр дагаврыг сайтар ойлгож "сайн дурын үндсэн дээр" мэдэгдэл гаргасан, уг гэмт хэргийг үйлдсэн болох нь нотлох баримтаар хангалттай "тогтоогдсон байх"-ыг хэлдэг байна. Сайн дурын үндсэн дээр гэдгийг шүүгдэгч шахалт дарамт эсвэл хууран мэхлэлт, худал амлалтад автагдалгүй шийдвэр гаргасан байх гэж үздэг. Энэ нь харьцангуй ойлголт, учир нь шүүгдэгчид прокурорын зүгээс санал болгож буй нөхцөлүүд хэзээ ч бүгд тааламжтай байдаггүй, олон таатай биш сонголтоос арай боломжтой гэж үзсэнээ сонгохоос гадна үүнд шүүгдэгчид өмгөөлөгч нь ч шахалт үзүүлсэн байдаг тул шүүгдэгчийг зөвхөн өөрийн хүсэл зоригоор дээрх шийдвэрийг гаргадаг гэж үзэх нь учир дутагдалтай.

Шүүгч мэдэгдлийн оновчтой эсэхийг шүүгдэгчтэй ярилцлага хийснээр нягтлах бүрэн боломжтой. Ярилцлага нь техник хэрэгслээр бичлэг болон бэхждэг бөгөөд ял тохиролцох явцад гарсан аливаа асуудлаар шүүгдэгч хожим гомдол гаргавал эргэж сөхөгдөг. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх үед шүүгч галуудын хэлцэл зохих шалгуурыг хангасан эсэх, шүүгдэгчийн мэдэгдэл оновчтой эсэхийг шалгах журмыг **АНУ-ын Эрүүгийн процесс дахь Флоридагийн дүрэмд заажээ.** Уг дүрмийн 3.172 дугаарт;

1. Хүсэлтийг хүлээн авахын өмнө шүүгдэгч тодорхой гэмт хэрэгт гэм буруутай болохоо хүлээн зөвшөөрч гаргасан мэдэгдлийг шүүгдэгч сайн дураар гаргасан эсэх, уг мэдэгдэл нь хэр үндэслэлтэй болохыг заавал шалгана. Энэ үед шүүгчид өмгөөлөгч, прокурор нар шаардлагатай нотлох баримтыг гаргаж өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлнэ;

2. Шүүгдэгч өөрийн гэм буруугийн талаар мэдэгдлийг аль нэг нээлттэй шүүх хуралдаан дээр (урьдчилсан) гаргах бөгөөд зарим онцгой тохиолдолд цагдан хорих байранд гаргаж болно;

3. Шүүгдэгч мэдэгдлийг сайн дураар гаргасан эсэхийг шүүх шалгахдаа шүүгдэгчээс андгай авч дараах асуултуудыг асууж тодруулна. Үүнд:

3.1. Гэм буруутайгаа хүлээн зөвшөөрч буй уг гэм хэргийг үйлдсэний төлөө оногдуулж болох ялын төрөл, шинж чанар, ялын доод болон дээд хязгаарыг мэдэж буй эсэх;

3.2. Хэрэв шүүгдэгч өмгөөлөгч аваагүй бол байцаан шийтгэх ажиллагааны аль ч шатанд өмгөөлөгч авч болох, хэрэв өмгөөлөгч авах боломжгүй бол шүүхээс томилж болохыг мэдэж байгаа эсэх;

3.3. Мөн шүүгдэгч өөрийгөө гэм буруугүй гэсэн мэдэгдлийг гаргаж болох, нэгэнт гаргасан

мэдэгдлээ дэмжих, яллагдаж буй хэргээ тангарагтны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх, шүүх хуралдаан дээр өөрийгөө өмгөөлөх, тайлбар гаргах, өмгөөлөгчөөс туслалцаа авах, өөрийн хүсэлтээр гэрчүүдийг оролцуулах, тэдгээрт асуулт тавих, нүүрэлдэх, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг тайлбарласныг ойлгосон эсэх;

3.4. Мөн хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэж буй тохиолдолд тангарагтан оролцуулсан бүрэн хэмжээний шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэхгүй болохыг;

3.5. Улмаар хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн тохиолдолд шинээр илэрсэн нөхцөл байдлаас бусад шалтгаанаар хэрэг дахин хянагдахгүй болохыг (давж заалдах гомдол гаргахгүй) мэдэж буй эсэх;

3.6. Хялбаршуулсан хуралдаанд андгай өргөж мэдүүлэг өгнө, шүүгчийн асуултад үнэн зөв хариулах үүрэгтэй, худал мэдүүлсэн тохиолдолд гүнийх нь төлөө хариуцлага хүлээлгэж болохыг;

3.7. Дээрх нөхцөл байдлын улмаас шүүгдэгч талуудын тохиролцоогоор түүнд олгогдсон бүх хөнгөлөлт, давуу байдлаа алдах болохыг;

3.8. Хэрвээ гэм буруугийн мэдэгдэл хийж буй этгээд АНУ-ын иргэн биш бол АНУ-ын Харьяатын болон цагаачлалын хууль тогтоомжид зааснаар уг мэдэгдэл нь түүнийг АНУ-аас албадан гаргах үндэслэл болж болохыг шүүгч сануулна.

4. Шүүгч мэдэгдлийг хүлээн авахаас өмнө шүүгдэгч өөрийн гэм буруугаа хүлээж зөвшөөрч буй эсэх, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх нь түүний ашиг сонирхолд бүрэн нийцэж буйл итгэлтэй байгаа эсэхийг тогтооно;

5. Улмаар шүүгдэгч мэдүүлэг гаргаж буй процесс нь тэмдэглэгдэж улмаар нотлох баримтын чанартай цаашид ашиглагдаж болохыг;

6. Талууд шүүгдэгчийн гэм буруугийн асуудлаар тохиролцсоныг шүүгч энэ дүрэмд заасны дагуу хянаж магадлан хууль ёсны гэж үзэж хүлээн авахаас нааш энэ нь хуулийн хүчин төгөлдөр бус бөгөөд талуудын аль нь ч тохиролцооноос ямар нэг тайлбаргүйгээр татгалзаж болохыг;

7. Шүүгч тохироог хүлээж авахгүй байх, уг тохирооны заалтыг баримтлахаас татгалзаж болохыг;

8. Шүүгч тохиролцоог хүлээн аваагүй тохиолдолд шүүгдэгчийн өөрийн гэм буруугаа хүлээсэн мэдэгдлийг энэ шүүгдэгчийн эсрэг ямар нэгэн эрүү, иргэний хэрэгт нотлох баримтаар ашиглахгүй болохыг мэдэгдэнэ.

Үүний дараа шүүгч жижиг хэмжээний шүүх хурал хийж талуудын хамтран гаргасан хүсэлт, хэрэгт буй нотлох баримттай танилцаад тэдгээрийн тохиролцоог батлаж хэргийг шийдвэрлэдэг.

Хэдийгээр ял наймаалцах ажиллагаа нь АНУ-ын Үндсэн хуулийн 6 дугаар нэмэлтийн "..эрүүгийн хэрэгт холбогдсон иргэн тангарагтны шударга шүүхээр нийтийн өмнө шүүлгэх эрхтэй, улмаар өөрийгөө өмгөөлөх, төрөөс өөрийн гэм буруог нотлохыг шаардах, зөвхөн тангарагтнаар гэм буруутай эсэхээ тогтоолгох, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгч буй гэрчтэй нүүрэлдэх, өөрт ашигтай мэдүүлэг өгөх гэрчийг дуудан ирүүлэх эрхтэй, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг хэн нэгэн нь хүчээр хязгаарлах эрхгүй.." зэрэг олон заалтуудыг зөрчдөгөөс гадна эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үндсэн зарчмууд, эрүүгийн хариуцлагын зорилго, агуулгад харш гэх зэргээр зарим судлаач, эрдэмтдийн шүүмжлэлд байнга өртдөг боловч ямар ч байцаан шийтгэх ажиллагаанд хялбаршуулсан журам байх ёстой, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр уг журмыг хэрэглэх нь чухал гэж АНУ-д үздэг хэвээр бөгөөд Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх ажиллагааг хөгжүүлж боловсронгуй болгох асуудлыг хурцаар тавьдаг.

Энэхүү нийтлэлийг бичигчийн гол зорилго бол орчин үеийн төр, эх зүйн хөгжлийн нийтлэг, шилдэг зүй тогтолд өөрийн улс дахь эрх зүйн орчинг нийцүүлэн өөрчлөхөд өчүүхэн ч атугай нэмэр болох санаагаар Англи-Саксоны эрх зүйн бүлд хамаарах зарим улс орны эрүү, иргэн, процессын эрх зүйн зарим давуу талыг уншигчдад толилуулах явдал бөгөөд энэ удаа АНУ дахь Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх ажиллагаатай та бүхнийг товч танилцууллаа. Уншигч хуульч, сонирхогч хэн боловч энэ нийтлэлийн талаар, гухайлбал, ял наймаалцахыг манай эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлснээр ямар давуу болон сөрөг тал бий болж болох, энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн зарчмуудад хэр нийцэх талаар санал, хүсэлт байвал сэтгүүлийн хаягаар ирүүлнэ үү.

ХБНГУ ДАХЬ КОНЦЕРНИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш, докторант Э.Байгаль

Аж ахуйн нэгжийн төвлөрөл

Дэлхий даяар улам бүр хүчээ авч буй даяарчлал нь аж ахуйн нэгжүүдийг төвлөрсөн зохион байгуулалтад орохыг шаардаж байна. Өнөөдөр ХБНГУ-д үйл ажиллагаа явуулж буй ихэнх аж ахуйн нэгж нь концерн хэлбэрийн зохион байгуулалтад орсон байдаг. Харин концернийг бүртгэх тусгай бүртгэлийн журам байдаггүй бөгөөд худалдааны бүртгэлд бүртгүүлэхгүйгээр концерн бий болж болно. Концернийн хэлбэр ийнхүү хөгжиж байгаа нь аж ахуй эрхлэгч уян хатан байдлаар хэлбэрийг сонгох эдийн засгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа юм. Ийнхүү төвлөрсөн аж ахуйн нэгжүүд нь томоохон төслүүдийг гүйцэтгэх чадвартай болох бөгөөд, үүгээрээ техникийн дэвшил болон эдийн засгийн хөгжлийн шаардлагыг биелүүлэх хэрэгтэй болдог.

Концернийн хамгийн түгээмэл тохиолддог хэлбэр бол концернийн толгой нийгэмлэгийн эрх мэдлийг өөртөө төвлөрүүлсэн хэлбэр юм.

Хувьцааны тухай хуулийн 15-22 дугаар зүйлд Концернийн эрх зүйн ерөнхий зохицуулалт агуулагддаг бөгөөд энэ нь 15-19 дүгээр зүйлд концернийн эрх зүйн үндсэн нэр томъёог тодорхойлсон хэсэг, 20-22 дугаар зүйл нь концернд оролцогчдын үүргийг тодорхойлсон материаллаг концернийн эрх зүй хэмээх 2 хэсэгт хуваагддаг.

Хэдийгээр Худалдааны хууль (271 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг) болон Хувьцааны тухай хууль (15 дугаар зүйл)-д тус бүр холбоо бүхий аж ахуйн нэгжийн нэр томъёоны тодорхойлолтыг агуулдаг[1] боловч, эдгээр нь хоорондоо бас ялгаатай байдаг.

Хувьцааны тухай хуулийн дагуух холбоо бүхий аж ахуйн нэгжийн хувьд эрх зүйн хэлбэр нь төдийлөн ач холбогдолгүй байдаг. Энэхүү холбоонд багтаж буй аж ахуйн нэгжийн ядаж нэг нь Хувьцаат нийгэмлэг, эсвэл Хувьцаанд суурилсан коммандит нийгэмлэг байгаа үед л уг хуулийн дагуух эрх зүйн үр дагавар нь үүснэ. Харин эсрэгээр, Худалдааны хуулийн дагуух холбоо бүхий аж ахуйн нэгжийн эрх зүйн хэлбэрийн хувьд тусгайлан нарийвчилсан байдаг. Худалдааны эрх зүйн дагуух заалтууд нь ерөнхийдөө аж ахуйн нэгжийн холбоог ил болгох зорилгыг баримталдаг.

Нэр томъёо

1. Хараат байдлын талаархи нэр томъёо (Хувьцааны тухай хуулийн 17 дугаар зүйл)

Концернийн эрх зүйн түлхүүр нэр томъёоны нэг нь Хувьцааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хараат байдлын тухай нэр томъёо юм. Концернийн эрх зүйн гол эрх зүйн үр дагавар нь концерн хэмээх нэр томъёонд бус, харин хараат байдал хэмээх ойлголттой илүү холбогддог.[1] Энэ нь Хувьцааны тухай хуулийн 302 дугаар зүйлийн 1 дахь хэсэг, 305 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 311 болон түүнээс хойшхи хамаарах зүйлүүд дэх концернийн эрх зүйн хамгаалах заалтуудын хувьд, түүнчлэн концернийн орчны тухай хамгаалах заалтууд болох Хувьцааны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 2 ба 3, 71d- ийн 2 дахь өгүүлбэр, 100 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх өгүүлбэрийн 2 зэрэгт хамаарна.

17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь шууд ба шууд бус хараат байдлын тухай зохицуулдаг. Энд зааснаар, хэрэв эрх зүйн хувьд бие даасан аж ахуйн нэгж нь шууд буюу шууд бусаар ноёрхох нөлөөг үзүүлж байгаа бол хараат байдал байна гэж үзнэ. Өнөөдөр ноёрхож буй үзлээр бол, ийнхүү ноёрхож буй нөлөө нь нийгэмлэгийн эрх зүйн хувьд нийцсэн байх ёстой[2]. Ноёрхох нөлөө гэж үзэхийн тулд ердийн бодит хараат байдал нь эдийн засгийн хараат байдлын хэлбэрийн хувьд хангалтгүй[3]. Өөрөөр хэлбэл, ноёрхох нөлөөг бодитоор үзүүлж байгаагаас энэ нь хамаарахгүй.

2. Концернийн шинж

Концернийг Хувьцааны тухай хуулийн 18 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлсон байдаг: "Удирдаж буй, эсвэл удирдаж буй компанийн нэгдмэл удирдлага дор олон хамааралтай аж ахуйн нэгж нэгдсэн байвал энэ нь концернийг бүрдүүлэх бөгөөд, аж ахуйн нэгж тус бүр нь концернийн аж ахуйн нэгж болно. Тэдгээрийн хоорондоо нэг нь толгойлох тухай гэрээ байгуулсан, эсвэл тэдгээрийн нэг

1. ХБНГУ-ын Хувьцааны тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. 17 дугаар зүйл., 3, 5 дахь дугаар.
2. BGHZ 90, 381, 396; 121, 137, 146. Hueffer, AktG, 17 дугаар зүйл., 8 дахь дугаар.
3. BGHZ 90, 381, 396

нь нөгөөдөө багтаж байгаа бол тэдгээрийг нэгдмэл удирдлагатай гэж үзнэ. Нэгдмэл удирдлагад багтаж буй, гэхдээ нэг нь нөгөөгөөсөө үл хамаарах эрх зүйн хувьд бие даасан аж ахуйн нэгжүүд нь бас концернийг бий болгох боломж, аж ахуйн нэгж тус бүр нь концернийн аж ахуйн нэгж болно".

Дээрхээс үзэхэд концернийг хоёр төрөлд хуваах болохоор байна:

• Захирагдах хэлбэрийн концерн (Босоо концерн);

• Тэгш эрхтэй концерн (Хэвтээ концерн).

Захирагдах хэлбэрийн концернийн гол шинж нь "нэгдмэл удирдлага дор нэгдсэн" байх явдал юм. Харин нэгдмэл удирдлага гэдгийг хуульд тодорхойлоогүй байдаг тул аж ахуйн нэгж нь ямар тохиолдолд нэгдмэл удирдлагад нэгдсэн гэдгийг тодорхойлоход эргэлзээтэй юм.

Концернийн хамгийн явцуу утгын дагуу нэгдмэл удирдлага байхын тулд концернийн толгой нь аж ахуй эрхлэгчдийнхээ төв салбарын хувьд нэгдмэл төлөвлөгөөг боловсруулдаг, үүнийг нь концернийн аж ахуйн нэгж бие даасан байдлаа үл харгалзан хэрэгжүүлдэг эдийн засгийн нэгдмэл байдал гэдгийг шаардаг[4]. Энэ нь нэн ялангуяа санхүүгийн хувьд хамаарна.

Нэгдмэл удирдлага гэдгийн талаархи дэлгэрэнгүй тайлбарын дагуу хэрэв бусад төв аж ахуйн нэгжийн хүрээний хувьд, тухайлбал худалдаа, байгууллага, хүний нөөц зэргийн хувьд нэгдмэл төлөвлөгөө байгаа тохиолдолд хангалттай гэж үзсэн байна. Шүүхийн шийдвэрт ч энэхүү өргөн утгаар тайлбарыг илүүтэй харгалздаг.

Концерн нь гол төлөв, маш олон шаталсан бүтэцтэй байдаг бөгөөд түүний үндсэн загвар нь 3 шатлалт бүтэц болно: Толгой аж ахуйн нэгж, охин, охины охин аж ахуйн нэгж.

3. Захирагдах хэлбэрийн концерн

Захирагдах хэлбэрийн концернийн хувьд дараах шинжүүд бүрдсэн байх ёстой. Үүнд:

• Эрх зүйн хувьд бие даасан аж ахуйн нэгжүүд;

• Ноёрхох байдалтай нэг аж ахуйн нэгж;

• Хувьцааны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу толгойлох аж ахуйн нэгжээс хамааралтай (хараат) нэг буюу хэд хэдэн аж ахуйн нэгж;

• Толгойлох аж ахуйн нэгжийн нэгдмэл удирдлага дор багтсан байх.

Удирдлага гэдэг нь тухайн аж ахуйн нэгжийг удирдан явуулах талаархи аж ахуй эрхлэгчийн шийдвэр юм.

Нэгдмэл удирдлага гэдэг нь зарчмын хувьд маш олон хэлбэртэй байж болно. Нэг бол маш тогтмол, эсвэл чөлөөт нэгдэл ч байж болно. Боломжит хувилбарууд нь:

• Тогтмол холбоо харилцаа;

• Тогтмол өгөх чиглэмж;

• Хараат аж ахуйн нэгжийн удирдах этгээдийн үйл ажиллагаа нь гаргцхүү удирдаж буй байгууллага байдлаар.

Нэгдмэл удирдлага гэдэг нь концернийн аж ахуйн нэгжийг нэгдмэл утгаар удирдах гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл концернийг удирдаж буй этгээд нь танигдсан буюу туйлын байх гэсэн үг биш. Хэрэв ноёрхож буй аж ахуйн нэгж нь удирдлагыг хараат аж ахуйн нэгжийн эсрэг хэрэгжүүлж байгаа ба ингэснээр тэднийг өөрийн аж ахуйн нэгжид нэгтгэсэн, нэгдмэл хамтын төлөвлөгөөг урьдаа тавьсан нөхцөлд удирдлага нь нэгдмэл байна гэж хэлж болно[5].

Хувьцааны тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан утгаар нэгдмэл удирдлагатай байх боломж нь:

• Оролцож буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны бодлогыг чиглүүлэх, хянах удирдах байгууллагыг хамтран байгуулах. Ингэхийн тулд оролцож буй аж ахуйн нэгжүүд нь Иргэний хуульд заасан XXK буюу нийгэмлэг байгуулж болно;

• Захиргааны байгууллага дахь боловсон хүчний нэгдэл;

• Хамтарсан захиргааны зөвлөл байгуулах.

Захирагдах хэлбэр бүхий концерн нь түүнчлэн Хувьцааны тухай хуулийн 17 дугаар зүйлд хамаарах бөгөөд хараат ба удирдах аж ахуйн нэгжийн хувьд бүхий л заалтууд нь хэрэглэгдэх боломжтой.

4. Тэгш эрхтэй концерн

Энэ ангилалд хамаарах концернийн шинж нь:

• Концернд хамрагдаж буй аж ахуйн нэгжүүд нь эрх зүйн хувьд бие даасан бөгөөд нэг нэгнээсээ хараат бус,

• Концернийн шинж нь гаргцхүү нэгдмэл удирдлагаар л бүрэлдэн бий болсон байна.

Концернийн түгээмэл шинж болон нэгдмэл удирдлагыг ямар арга, хэлбэрээр бий болгож, хэрэгжүүлэх нь төдийлөн чухал биш юм.

5. Гэрээт концерн ба бодит концерн

Захирагдах хэлбэрийн болон тэгш эрхтэй концернуудыг гэрээт ба бодит концернийг ялгах хэрэгтэй. Гэрээт концерн нь гаргцхүү ноёрхох гэрээний үндсэн дээр үүсэн байгуулагдаг бөгөөд учир нь эндээс л жинхэнэ чиглүүлэх эрх нь үүсдэг. Концернийн бусад бүх хэлбэрүүд, жишээ нь оролцооны

4.Rehbinder, ZGR 1977, 581, 591.
5.Wuerdinger, 65 IV 1 d

үндсэн дээр бодитоор удирдах эрх мэдлийн үндсэн дээр үүсгэж байгаа бол түүнийг бодит концерн гэж нэрлэдэг.

Эрх зүйн үр дагавар

Хувьцааны тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан концернийн тухай нэр томъёоны дагуу захирагдах эрхтэй буюу тэгш эрхтэй концернийн аль алиных нь хувьд хэрэглэгдэх нилээдгүй олон заалт бий. Эдгээрээс хамгийн чухал нь:

- Концерн дахь тооцооны эрх зүйн зохицуулалтын талаархи заалтууд (Худалдааны тухай хуулийн 290 дүгээр зүйл);
- Онцгой эрхт болон хаалтын шалгачид холбоо бүхий аж ахуйн нэгжийн хооронд харилцан суурьшуулах эрх (Хувьцааны тухай хуулийн 145 дугаар зүйл болон Худалдааны тухай хуулийн 320 дугаар зүйлийн 3, 323.1 дэх хэсэг).

Концерн дахь тооцоог тайлагнах

Нягтлан бодох бүртгэлийн шинэ эрх зүй концернийн тооцоог тайлагнах явдлыг капитал нийгэмлэгийн нэгдмэл удирдлагад байдаг концернийн толгой буюу эх аж ахуйн нэгжийн хувьд тусгасан байдаг. Энэхүү тооцооны тайлан нь концернийн баланс, концернийн ашиг алдагдлын тооцоо болон концернийн хавсралтаас бүрдэх концернийн жилийн эцсийн тайлангийн хэлбэрээр хийгдэнэ (Худалдааны хуулийн 297 дугаар зүйл 1 дэх хэсэг). Үүний дараа Худалдааны хуулийн 315 дугаар зүйлд заасан арга хэмжээний дагуу Концернийн эдийн засгийн байдлын талаархи тайланг нийтлүүлдэг.

Концернийн жилийн эцсийн тайланд эх аж ахуйн нэгжээс гадна зарчмын хувьд бүхий л охин аж ахуйн нэгжүүд хамрагдах ёстой. Энэ нь түүний оршин байгаа газраас үл хамааран хэрэгждэг (Худалдааны тухай хууль 294.1). Иймээс ч уг тооцоог охин болон эх аж ахуйн нэгжийг нийтэд нь нэг л аж ахуйн нэгж байдлаар гаргадаг. Энэхүү зорилгод хүрэхийн тулд нэг аж ахуйн нэгжийн жилийн эцсийн тайлан тэнцлийг нь концернийн тайлан тэнцэлд шилжүүлэн суулгах нь хангалтгүй. Илүүтэйгээр, Худалдааны тухай хуулийн 300-307, 310-312 дугаар зүйлд тусгайлан заасан "Баталгаажуулах процесс" гэж нэрлэгдэх процесс юм.

Концернийн жилийн эцсийн тайлан тэнцлийг гаргаж өгөх үүргээс Худалдааны тухай хуулийн 293 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу жижиг концерн нь чөлөөлөгддөг. Концерн жижиг гэдэг ангилалд багтах эсэхийг нь Худалдааны хуулийн 293 дугаар зүйлд заасан шалгууруудын дагуу тодорхойлно.

Түүнчлэн олон шатлалт аж нэрлэгдэх концерн нь жил бүр тайлан тэнцлийг нийтлэх үүргээс чөлөөлөгддөг. Олон шатлалт гэдэг нь нэг аж ахуйн нэгж нь өөр аж ахуйн нэгжийн охин компани байхын зэрэгцээ өөрөө бас нэг охин компанитай байхыг ойлгоно. Олон шатлал бүхий тайлан тэнцлийг хөнгөвчлөхийн тулд Худалдааны хуулийн 291, 292 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангасан тохиолдолд өөрөө охин компани боловч дороо охин компанитай аж ахуйн нэгж нь хамгийн дээд удирдлагын түвшинд оршиж байгаа эх компани буюу аж ахуйн нэгжийн гаргасан жилийн тайлан тэнцлээр өөрөөр үүнийг гаргахаас чөлөөлөгддөг байна.

Монгол Улс дахь аж ахуйн нэгжийн эрх зүйн зохицуулалтаас харахад концерн гэж тодорхой хэлбэрийг зааж өгөөгүй ч Компанийн тухай хуулийн 6-р зүйл нь компани нь дээр дурдсан олон шатлалт концернийн бүтэц байж болохыг харуулж байна. Үйл ажиллагаа явуулж буй зарим аж ахуйн нэгж концерн, корпораци, холдинг гэх мэт хэлбэрийг нэрийнхээ ард дурдсан байдаг нь сонирхол татдаг. Хэдий концерн болон бусад нэгдэх боломжийг олгосон хэлбэрийг хуулиар тодорхойлоогүй ч компаниуд, ялангуяа өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулж буй томоохон компаниуд нь концернийн зохион байгуулалтад орж үйл ажиллагаа явуулж байгаа нь тодорхой харж болохоор байна. Иймээс хуульд тусгагдаагүй боловч практикт хэрэглэгдэж байгаа хуулийн этгээдийн нэгдлүүдийн талаархи бусад улс дахь эрх зүйн зохицуулалтын талаархи судалгаа чухал ач холбогдолтой юм.

☙ ☙ ☙

ХУУЛЬЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА

Хуульч сонгон шалгаруулах тухай Монгол Улсын хуулийн дагуу Хуульчийн сонгон шалгаруулалтыг 2009 оны 8 дугаар сарын 8, 9-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион явагдах гэж байна.

Энэхүү шалгаруулалтын үндсэн дээр шүүгчийн албан тушаал эрхлэх сонгон шалгаруулалтад оролцох, өмгөөллийн болон нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах мэргэшлийн шалгалтад оролцох, прокуророор ажиллах хуульчдаас мэргэжлийн хангалттай мэдлэг, чадварыг эзэмшсэн эсэхийг шалгаж гэрчилгээ олгоно.

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгч сонгон шалгаруулалтын хуваарь, газар, бүрдүүлэх материал зэрэг шаардлагатай бусад мэдээллийг www.legalinfo.mn сайтад хандаж авна уу.

☙ ☙ ☙

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖЛЫГ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн лабораторийн тасгийн дарга, биологийн ухааны доктор С.Ганболд

Аливаа албаны хөгжил дэвшил, ололт, амжилтын үндэс нь шинжлэх ухааны үндэслэлтэй эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тэргүүлэх чиглэлээ болгон ажиллах явдал байдаг. Энэ нь тухайн байгууллагын өмнөө тавьсан зорилго, зорилтоо амжилттай биелүүлэхийн үндсэн суурь нь болж өгдөг.

Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжлэх ухааны ололт амжилтыг цогцоор нь нэвтрүүлэх бодлого барьж ажиллах шаардлага өнөө үед нийгмийн амьдралаас урган гарч байна.

Ялангуяа шүүх эмнэлгийн үйл ажиллагаа нь хүссэн ч, эс хүссэн ч эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын хамгийн үнэтэй, бодит бааз мөн учраас энэ давуу талаа ашиглан мэргэжлийн их дээд сургуулиудтай хамтран сургалт зохион байгуулан ажиллах нь салбарын ирээдүйн өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх асуудлыг өөрсдийн бааз сууринд илүүтэйгээр тулгуурлан шийдэх боломжийг олгоно.

Ийм учраас эрдэм шинжилгээ судалгааны ажлыг зохион байгуулах, хэтийн бодлого төлөвлөлт, чиг хандлагаа тодорхойлох нь хамгийн чухал юм.

Шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтыг шүүхийн шинжилгээний байгууллагын олон салбарын практикт нэвтрүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг байгууллагын тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх бодлого барьж ажиллахгүйгээр "Эрүүгийн, эрүүгийн байцаан шийтгэх, захиргааны хариуцлагын, замын хөдөлгөөний аюулгүй байдлын болон бусад холбогдох хуулиудын зүйл ангийг зөрчин гэмт хэрэг үйлдэж нийгэм, иргэн, хүнийг хохироосон тохиолдол бүрт шинжлэх ухааны үндэслэлтэй, хөдөлгөөнгүй үнэн зөв нотлох баримт болох шинжээчийн дүгнэлт гарган өгөх" гэсэн үндсэн үйл ажиллагааны чиглэлээ хэзээ ч бүрэн дүүрэн хангаж чадахгүйд хүрнэ.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг шүүхийн шинжилгээний байгууллагын хүрээнд зохион байгуулах хэд хэдэн арга зам байгааг тэмдэглэж байна. Үүнд:

1. Улс, орнуудын шүүхийн шинжилгээний байгууллагын хөгжлийн түүхэн замналыг судлан үзэхэд шинжилгээний байгууллагынхаа өмнө тулгамдаж байгаа асуудлыг ээлж дараатай шийдвэрлэхийн тулд шийдвэрлэх асуудлынхаа жагсаалт гарган жилд 2-оос доошгүй удаа эрдэм шинжилгээ, онол практикийн хурал, сургалт семинар зохион байгуулах ажлыг тогтмол зохион байгуулан ажилладаг жишгийг судлан үзэж хэрэгжүүлэх;

2. Тулгамдаж байгаа асууллуудыг шийдвэрлэхийн тулд "Шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлийг боловсронгуй болгох, цаашдын хөгжлийг хурдасгах гэх мэтчилэн" харьяа яамны сайдын тушаалын төсөл боловсруулах, зарим тохиолдолд дээд газрын тогтоолын төсөл боловсруулах ажлын хэсэг, зөвлөл байгуулан ажиллах;

3. Шинжилгээний байгууллагад ажилладаг шинжээчдийн мэргэжлээр бакалаврийн зэрэг олгодог их, дээд сургуультай ажил төрлийн холбоотой ажиллаж 3 дугаар курсээс нь сургалтын тусгай хөтөлбөрийн дагуу сурган төгсгөж авах ажлыг зохион байгуулах;

4. Шинжээчдийг өөрийн болон гадаад улс оронд жил бүр зохион байгуулагддаг эрдэм шинжилгээ, онол практикийн хурал, семинар сургалтад оролцуулах ажлыг байнга зохион байгуулах, хуралд оролцохдоо өөрсдийн үйл ажиллагааны дагуу хийж байгаа ажлын сонирхолтой тохиолдол болон олон жил хийсэн ажилдаа судалгаа, дүн шинжилгээ хийж үр дүнгээр илтгэл, эрдэм

шинжилгээний өгүүлэл бичиж, асуудал дэвшүүлж оролцож байх;

5. Гадаад улс оронд хуралд оролцохдоо өөрсдийн байгууллагын өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлүүлэх үүднээс тэдний ололт амжилт, туршлагыг судалж нэвтрүүлэхэд гол анхаарлаа хандуулах, бид бүхэн өөрсдөө санаачлага гарган хамтын ажиллагааг тогтмолжуулах, хамтарсан эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хамтран хийх, арга зүй, технологиос нь суралцах, эзэмших, мэдээлэл олж авах зэрэг чиглэлээр эрчимтэй ажиллахыг биднээс шаардаж байна.

Өндөр хөгжилтэй орнуудын шинжилгээний байгууллагын бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг судлан үзэхэд, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг үйл ажиллагааны тэргүүн ээлжинд тавьж, техник технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх тал дээр нь онцгой анхааран ажилладаг нь ажиглагддаг.

Манай хүрээлэнгийн хувьд эрдмийн болон мэргэжлийн зөвлөл байгуулан үйл ажиллагааг байнгын болгох нь хамгийн чухал байна. Тухайлбал, шүүх эмнэлгийн чиглэлээр шинжээчийн анхны дүгнэлт давтан хийгдсэн үед, анхны дүгнэлтээс зөрж гардаг тохиолдол цөөнгүй байгаад мэргэжлийн дүн шинжилгээ хийж учир холбогдлыг нь тогтоох шаардлагатай байгаа юм.

Үүнд олон хүчин зүйл нөлөөлөх боловч аль нь илүүтэй нөлөөлж байгааг тогтоож тэр нөлөөллийг багасгах, давтан шинжилгээний тоог эрс бууруулах зорилт тавин ажиллах нь чухал байна.

Шинжилгээний байгууллагын ажлын чанар, үр ашгийг дээшлүүлэхийн тулд хуулийн хүрээнд шаардагдах бичиг баримтыг боловсронгуй болгох ажлыг улам идэвхижүүлэх хэрэгтэй мэт санагддаг.

Шинжээчийн дүгнэлт нь ямарч хувь хүний амьдралын асуудлыг шийдвэрлэхэд ялангуяа шүүх шийдвэрээ гаргахдаа шинжээчийн гаргаж өгсөн дүгнэлтийг нотлох баримт болгон гаргадаг учраас энэ нь нэг талаас хүнд ял завшуулах, нөгөө талаас хүнийг хэлмэгдүүлэх асуудал ч гарах эрсдэлтэй учир шинжээчдэд алдаатай дүгнэлт гарах эрх байхгүй.

Олон жилийн ажлын туршлага, амжилтад дүн шинжилгээ хийж алдаг нь засаж, ололттой талыг нь улам боловсронгуй болгон ажиллахын тулд судалгаа шинжилгээний ажлыг заавал явуулах шаардлагатай байна.

Цөөн болон олон жилийн ажлын явцад хуримтлуулсан туршлага дээр тулгуурлан хийсэн ажлынхаа үр дүнд дүн шинжилгээ, боловсруулалт хийж өгүүлэл, нийтлэл бичих, эрдэм шинжилгээ, онол-практикийн хуралд илтгэл тавьж хэлэлцүүлэх, бакалаварын диплом, магистр болон докторын диссертаци туурьвах нь шинжилгээний байгууллага тухайн салбарын хойч үеийнхэндээ мэдээлэл, онол арга зүйн гарын авлага, ажлынх нь зүг чиг, чиг хандлага нь болж өгдөг учиртай.

2007 онд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэд хэдэн салбар лабораториуд техникийн шинэчлэл хийсэн ба эдгээр тоног төхөөрөмжийн хүчин чадалыг бүрэн дүүрэн ашиглах, үр өгөөжтэй сургалт, судалгаа, туршилт-эрдэм шинжилгээ, практик шинжилгээний чиглэлээр ажиллуулах нь чухал байна. Энэхүү лабораторид ажиллах чадварлаг мэргэжилтэн, шинжээч, бусад боловсон хүчнийг богино хугацаанд сургах ажлыг цаг алдахгүй зохион байгуулах шаардлагатай байгаа юм. Шинээр суурилуулсан тоног төхөөрөмж дээр ажиллах арга аргачилал, технологийн заавар, стандартыг боловсруулж батлуулах ажлыг шуурхай зохион байгуулах нь зүйтэй юм.

Шинжилгээ судалгааны шаардагддаг урвалж бодис, дагалдах хэрэгсэл, ДНХ-ийн кит, хэрэглэгдэхүүн материалууд 1-2 жилийн хэрэглээний нөөцтэй байх нь шинжилгээг цаг хугацаанд нь гаргах чухал нөхцөл болдог.

Сүүлийн үеийн үйл ажиллагааны практикаас үзэхэд гэмт хэрэгт холбогдсон хүмүүс болон эд мөрийн баримтад ДНХ-ийн магадлан шинжилгээг үнэ төлбөргүй хийхэд манай хүрээлэнгийн төсөв хүндрэлтэй байгаа учраас шинжилгээ хийлгүүлж байгаа хууль хяналтын байгууллага нь өндөр өртөгтэй шинжилгээний зардлыг хаанаас гаргуулах талаар харилцан ярилцаж тохиролцож, шийдвэрлүүлэх нь чухал байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжилгээнд нэвтэрч байгаа сүүлийн үеийн дэвшилтэт технологи, арга зүй, текник хэрэгслийн талаар интернет болон бусад мэдээлэлийн эх сурвалжаас холбогдох мэргэжлийн шинжээчдээр судлуулж мэдээлэл цуглуулж манай хүрээлэнгийн хүрээнд нэвтрүүлж болохуйц арга технологийг эрэлхийлж, практикт нэвтрүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулах шаардлагатай байна.

Шинжлэх ухаан, мэдээлэл, технологи өндөр хурдацтай хөгжиж байгаа өнөө үед интернетыг ашиглахгүйгээр магадлан шинжилгээний ажилд мэдэгдэхүйц дэвшил гаргана гэж найдахын аргагүй юм.

Шинжлэх ухааны байгууллага эрдэмтэн, судлаачид, хүрээлэнд олон жил ажиллаж байгаа шинжээчдийн оюуны хүчээр шүүхийн шинжилгээний байгууллагад нэн шаардлагатай байгаа ажлын чиглэлийг гаргаж, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсгэвэрийг улсын төсөв, ШУТСангийн төсөл хэрэгжүүлэх, дотоод, гадаадын олон нийтийн байгууллага, сангаас дэмжлэг, тусламж авах замаар шийдвэрлэх арга замыг эрж хайх хэрэгтэй байна. Үүнд:

1. Шүүхийн шинжилгээний бүх чиглэлээр магистр, докторантурт суралцуулах ажлыг байгууллагын зүгээс хөхиүлэн дэмжиж, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой судалгааны сэдвүүдийг боловсруулж, холбогдох их, дээд сургуулиудад захиалга өгч өдөр тутмын хэвлэлээр зарлуулах ажлыг зохион байгуулах;

2. Лабораторийн чиглэлээр мэргэжлийн ур чадвар сайтай боловсон хүчнийг сонгон шалгаруулалтаар ажилд авах ба ирээдүйн боловсон хүчний нөөцийг бий болгох талаар бодлого барьж ажиллах;

3. Шүүхийн шинжилгээний бүх чиглэлээр шинжлэх ухаан танин мэдэхүйн, арга аргачилал, зөвлөмж, мэдээ мэдээлэл, туршилт судалгаа, эрдэм шинжилгээний ажлын тухай бичсэн нийтлэл, материалыг хэвлэн нийтэлсэн сэтгүүлийг жилд 2-оос доошгүй удаа гаргах;

4. Эрдэм шинжилгээ судалгааны ажлын ойрын болон хэтийн төлөвийн чиг хандлагыг тогтоох, шинжээчийн мэргэжил дээшлүүлэх, нарийн мэргэжил олгох курсын сургалтын программ боловсруулж, холбогдох их, дээд сургуультай хамтран сургалт зохион байгуулах эрх зүйн орчин, нөхцөлийг бий болгох зэрэг ажлыг зохион байгуулах нь ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэхэд онцгой ач холбогдолтой болно.

Дэлхий даяарчилагдаж байгаа өнөө үед монголын иргэд олон улс оронд алба, амины ажлаар зорьчих, ажиллах, амьдрах болсон өнөө үед Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн зарим лабораториудад олон улсын шаардлага стандартыг хангасан зөвшөөрөл авах, тус хүрээлэнгийн лабораторид хийсэн шинжилгээний хариуг дэлхийн бусад орны ижил төстэй лабораторид хийсэн шинжилгээний хариутай жишиж харьцуулж үзэхийг хүлээн зөвшөөрдөг төвшинд хүргэх шаардлага байна.

Тухайлбал, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн "Молекул-генетикийн лаборатори"-ийг олон улсын чанарын хяналтын International Society for Forensic Genetics (ISFG) болон International Qualifications Assessment Service (IQAS)-д элсэж холбогдох заалтын дагуу аттестачилалд хамрагдаж олон улсын сертификат авах зорилго тавин ажиллах хэрэгтэй байгаа юм.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын шүүхийн шинжилгээний байгууллагын үүсэл хөгжил, түүхэн замналын цаг хугацаа нь манай улсынхаас хамгийн багаар бодоход 2 дахин болон түүнээс ч олон жилийн хугацаанд оршин тогтнож ихээхэн туршлага хуримтлуулсан байгаа нь ойлгомжтой. Энэхүү бэлэн туршлага байхад түүнийг өөрийн орны нөхцөлд зөв зохистой авч үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлох нь тухайн албыг зөв чиг хандлагаар хөгжүүлэх, шинэ бүтцээр ажиллаж эхэлж байгаа энэ үед алдаа дутагдал гарах магадлал багасах үндэс болох юм.

Эдийн засгийн хямралтай, төсөв санхүү хүндэрсэн өнөө үед олон жилийн ажлын үзүүлэлт, ачаалалд дүн шинжилгээ хийсэний үндсэн дээр шаардлага багатай орон тоог эргэн харж, нэн шаардлагатай байгаа салбарын боловсон хүчнийг нэмэгдүүлэх, оновчтой бүтэц, орон тоогоор ажиллах нь чухал байгаа юм.

Оросын Холбооны Улсын шүүхийн шинжилгээний байгууллагын түүхэн хөгжлийг судалж үзэхэд эрдэм шинжилгээ судалгааны чиглэлийг түлхүү хөгжүүлэн ирсэн туршлага байнга ажиглагдаж байгаа юм.[1]

1. http://www.fbi.gov/hq/lab/html/codis1.htm. http://www.mvd.ru/struct/3842/3845/, -сайт МВД, Структура министерства Основные этапы формирования Экспертно-криминалистической службы

ОРЧИН ҮЕИЙН ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Орчин үеийн гэмт хэрэг үүдэн гарах болсон шалтгаан нөхцөл, криминологийн прогноз 1990 оноос хойшхи нийгмийн өөрчлөлтийг дагаж өөр болжээ. Гэмт явдал аяндаа урсгалаараа гарахаа больсон төдийгүй нийгмийн хор аюул нь улам бүр өсөн нэмэгдэж, тэдгээртэй тэмцэх арга, хэрэгсэл, урьдчилан сэргийлэх ажлыг шинэ тутам арга барилд шилжүүлэх цаг үе бидний өмнө тулгараад байна. 1990, 2000, 2005 онд хэрэглэж байсан бидний мэдэх ***"уламжлалт"*** гэх тэр арга, хэрэгсэл одоо үр дүнд хүрэх нь багасч, шинжлэх ухааны болон нийгмийн бусад салбаруудын мэдлэг, хамтын ажиллагаа илүү ихээр шаардагдах болсныг сүүлийн үед гараад байгаа онц ноцтой, албан тушаалын, банк санхүүгийн, шинэ төрлийн гэгдэх эрүүгийн хэргүүдээс харж болно.

Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус наймаа, мөнгө угаах, мөрийтэй тоглоом, ноуны өмчийн хулгай, кибер болон эко терроризм, хүний наймаа, хууль бус цагаачлал, алан хядах ажиллагаа гээд л эдгээр төрлийн гэмт хэргийн өсөлт хурдасч, дэлхий нийтийн улс орнуудыг бараг бүхэлд нь хамрах боллоо.[1]

Манай нийгэмд зорилго ухамсартай хийгдэх өөрчлөлт янз янзын хүрээтэйгээр цаашид өрнөх болно. Иймд болохоор алдаж онож байгаад хүрсэн үр дүндээ эргэн

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Оюунболд

шинжилгээ хийж цаашдын зорилгоо тодорхойлоход шинжлэх ухаанч байр суурьтай хандах ёстой. Юуны урьд хэлэхэд нийгмийн тогтолцоог ухамсар зорилготойгоор бүхэл бүтнээр нь хувирган хувьсгахыг нийгмийн өөрчлөлт гэх ба нийгмийн зохион байгуулалт, хүмүүсийн сэтгэлгээний дүр төрх, авир үйлдлийн байр байдалд гарч буй шинэчлэл хувирал юм. Эл үйл явц Монголын нийгэмд өрнөж байна, энэ үйл явц болоод өнгөрчихөөгүй байгаа.[2]

Чухам яагаад өнөөдөр нийгэмд айдас төрүүлэм харгис хэрцгий аллага, шунахай зорилготой их хэмжээний хохирол учруулсан хэргүүд гараад байгаа юм бэ? Насанд хүрээгүй хүүхдүүд яагаад гэмт хэрэг үйлдээд байгаа юм бэ? Тодорхойлох гээд оролдоод үзье.

Гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нөхцөлийг тогтоохдоо та бидний ***"байнга дурддаг"*** нийтлэг нөхцөл байдал болох ажилгүйдэл, ядуурал, архидалт, нийгмийн байдал гэх мэт ***"тодорхой бус"*** хүчин зүйлсийг дурдахаас татгалзах[3] бодлого баримталж, судалгааны тодорхой арга, арга зүйг, практик үйл ажиллагаатай хослуулах шаардлагатай байгааг сүүлийн үеийн судалгааны ажлын үр дүн харуулж байна.

Эдийн засгийн гэмт хэрэг:

Манай улсад тогтмол гарч, бүртгэгддэг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах (Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйл), бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах (Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйл) гэмт хэрэг нь 2002 оноос тодорхой хэмжээгээр буурч ирсэн боловч сүүлийн 2 жилд гарч байгаа энэ төрлийн гэмт хэргийн нийгэмд учруулж байгаа хор хохирол хэдэн зуун тэрбум төгрөгөөр хэмжигдэж, шинэ тутам арга хэрэгслээр үйлдэгдэх болжээ.[4]

Залилан мэхлэх, завших үрэгдүүлэх гэмт хэрэг нь онлайн, интернет хэлбэрээр бусдыг хуурч мэхлэх, хуурамч гүйлгээ хийх, хуурамч байгууллага бий болгох, гэмт хэргээ далдлахын тулд санаатайгаар болон зохиомлоор дампуурах, сүлжээний бизнес, гоо

1."Шинэ төрлийн гэмт хэрэг" ЦЕГ-ын Мэдээлэл дүн шинжилгээний төв, 2005 он.

2."Монголын нийгмийн өөрчлөлт" хамтын бүтээл, ред. Б.Даш-Ёндон, Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, УБ., 2008 он, 14 дэх тал.

3."2004-2007 онд шийдвэрлэгдсэн Эрүүгийн хуулийн 113, 124 дүгээр зүйлд заасан эрүүгийн хэргийн судалгааны тайлан" ХЗҮХ-ийн , ЭЭЗКСС-оос 2009 онд явуулсан судалгаа.

4."Шинэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл" эрдэм шинжилгээний өгүүлэл Г.Оюунболд, "Хууль дээдлэх ёс" сэтгүүл, 2008 он, №1.

5. Орхон аймгийн ТВ-ийн редакторыг 2006 онд 6 сард орон нутгийн телевизээр гаргасан нэвтрүүлэгтэй нь холбогдуулан үл мэдэгдэх хүмүүс утсаар заналхийлснээс гадна амь биед нь халдаж, гэмтэл учруулсан байна. "Монгол Улс дахь Хүний эрх чөлөөний байдлын илтгэл", 2008 он.

сайхны болон гадаад улсаас уран зураг, эм бэлдмэл оруулж ирэх зэргээр шатлал бүхий сүлжээ үүсгэж бусдыг их хэмжээгээр хохироох, бусдын дансыг ашиглах, албан тушаалын (сүүлийн үед банк санхүүгийн салбарт) давуу байдлаа ашиглах, байгууллагынхаа нууц код, тэмдэгтийг хэрэглэх, хуурамч гүйлгээ хийх замаар үйлдэгдэж байна. Эдийн засаг, банк санхүүгийн салбарын үйл ажиллагаанд тавих хяналт сул, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт дутмаг зэрэг нь эдгээр гэмт хэрэг гарах суурь шалтгаан (Хадгаламж зээлийн хоршоодын хэргийг шалгах явцад төрийн байгууллагын хяналт шалгалт, эрх зүйн зохицуулалт илт дутагдсан байдаг) болж байна. Зар сурталчилгаа, түүний хяналтгүй байдал, иргэдийн аж ахуй, үйлдвэрлэл эрхлэх боломж, эрх зүйн орчин байхгүй зэрэг нь хохирогчдыг энэ төрлийн гэмт хэрэгт ихээр өртөж хохироход хүргэж байгаа төдийгүй цаашид бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн нөхцөл болж байна.

Хуулиар хамгаалагдаагүй эрх ашгийн тухайд: Практикт иргэдийг "заналхийлсэн" хэргийг шийдвэрлэхэд ихээхэн хүндрэл учирч байна. Сүүлийн үед бусдын амь насанд заналхийлэх, айлган сүрдүүлэх, дарамтлах байдал нэлээдгүй гарах болсон. Тодорхой жишээ аваад үзье: Иргэдийг газраа, тодорхой объектоо зарахыг шаардах, хийсэн үйлдэл, эс үйлдэхүйтэй холбогдуулан дарамтлах, айлгах, мөнгө амлах, нэхэх зэрэг хэлбэрээр энэ гэмт хэрэг илүүтэй үйлдэгдэж байна[5]. Үүнтэй холбоотойгоор Эрүүгийн хуулийн 149 дүгээр зүйлд **"Бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх"** гэмт хэргийн бүрэлдэхүүнийг зааж өгсөн ч хуулийн энэ заалт иргэдийг ямар нэг заналхийлэл, айлган сүрдүүлгээс хамгаалж чадахгүй байна.[6] Өөрөөр хэлбэл: иргэнийг тодорхой үйлдэл хийлгэхээр, эсвэл түүнээс нь татгалзуулахаар дарамталсан, заналхийлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс байхгүй энэ нь гэмт этгээдүүд хариуцлагаас мултрах, ял завших боломжийг олгож байна.[7] Одоогийн дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуульд тодорхой эрх бүхий байгууллага албан тушаалтнаар тодорхой шийдвэр гаргуулах, гаргуулахаас татгалзуулахад чиглэсэн, заналхийлсэн үйлдлийг зандалчлах гэмт хэрэгт тооцохоор заасан байгаа юм.[8]

Компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг[9]: 2006, 2007 онд компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг гус бүр нэг удаа гарч бүртгэгдсэн нь тухайн гэмт хэрэг тогтвортой байгааг харуулж байна. Гэвч техник хөгжсөн өнөө үед манай улсын албан байгууллага болгон интернетэд холбогдож, тэр хэрээр байгууллага, иргэд кибер гэмт хэрэгт ихээр өртөж хохирч байна. Ялангуяа байгууллагын сүлжээнд байгаа мэдээллүүдийг устгах, ашиглах, хулгайлах, худалдаа үйлчилгээ хэлбэрээр, эсвэл аялал жуулчлалын салбар, банк санхүүгийн салбарт хуурамч гүйлгээ хийх, гадаалын орнуудын хуурамч байгууллага, гэмт хэрэгтнүүд гэж захиалга өгч хохироох, хууран мэхэлж эд зүйл, бэлэн бус мөнгийг шилжүүлэн авах гэмт хэргүүд гарсаар байна. Хохирсон байгууллага аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн мэдээллийг шалгаж үзээд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэж эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэж байгаа тохиолдол цөөнгүй гарсан нь анхаарал татаж байлаа. Манай улсын хувьд багахан хэмжээний санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгчид, жижиг нэгдэл нь кибер халдлагаас хамгаалах, хакеруудын дайралтыг зогсоох хөрөнгийн болон техник, технологийн боломжгүй, энэ талаар мэдлэг хангалттүй, хуулийн байгууллагаас гэмт хэрэг гэж үздэггүй, кибер гэмт хэргээс хамгаалах үндэсний хамгаалалттүй, гухайн гэмт хэрэгтэй тэмцэх талаар нарийвчилсан заалт, эрх зүйн орчин байхгүйгээс өөр төрлийн гэмт хэрэг гэж үзэн шийдвэрлэж байгаа нь энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг явуулахад сөргөөр нөлөөлж байна.

Мэдээлэл, сурталчилгаа:

Мэдээллийн хаалттай байсан нийгмээс ардчилалд шилжих явцад үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө нээгдэж, хаалттай байсан сэдвүүдээр чөлөөтэй ярьж, бичиж эхэлсэн бөгөөд үүнийг дагаж "мэдээллийн тэсрэлт" гарсан билээ.[10]

Судалгаанаас харахад[11] дотоод

6.*"Өмчлөгч, эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцаж буюу хамгаалж байгаа этгээдэд болон тэдний ойр дотны хүмүүст* ***хүч хэрэглэх, нэр хүндийг нь гутаасан мэдээ баримт тараах буюу эд хөрөнгийг нь устгахаар заналхийлж эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг шилжүүлэн өгөхийг шаардсан үйлдэл нь*** энэ гэмт хэргийн объектив тал.

7.Судлаачийн зүгээс "Зандалчлах" нь иргэдийн амь насанд халдах, айлган сүрдүүлэх замаар эд хөрөнгө, өмчлөх эрхийг авахаар, тодорхой үйлдэл, эс үйлдэхүй хийлгэхээр заналхийлсэн гэмт үйлдлийг тооцвол зохино гэж үзэж байна.

8."Онц байдал түүний эргэн тойронд" эрдэм шинжилгээний өгүүлэл, Г.Оюунболд, "Хууль дээдлэх ёс" сэтгүүл, 2008 он, №4.

9."Компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн криминологийн зарим асуудал" эрдэм шинжилгээний өгүүлэл, Г.Оюунболд "Хууль дээдлэх ёс" сэтгүүл, 2008 он, №2.

10."Монголын нийгмийн өөрчлөлт" хамтын бүтээл, ред. Б.Даш-Ёндон, Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, УБ., 2008 он, 76 дахь тал.

11.Монголын хэвлэлийн хүрээлэнгийн Мэдээлэл судалгааны албанаас сар тутам явуулдаг "Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн 52 дахь удаагийн судалгаа" 2008 оны сүүлээр явагдсан энэ судалгаанд сар тутам нийслэлийн 500 өрх өрх данхардахгүйгээр хамрагдаг бөгөөд одоогийн байдлаар нийт 25 мянган өрх оролцоод байгаа гэсэн статистик

мэдээлэл авдаг хамгийн чухал эх сурвалж нь телевиз хэвээрээ байгаа боловч урьд нь судалгаанд хамрагдагчдын 91,0 хувь нь телевизийн мэдээлэл авдаг байсан бол өдгөө 59,0 хувь болж буурчээ. Мэдээлэл авдаг дараагийн гол эх сурвалж нь 29,5 хувиар "найз нөхөд" байсан бол "4 оронтой лавлах"-аас гол мэдээлэл авдаг гэж судалгаанд оролцогчдын 2,6 хувь нь хариулжээ. Интернетээр мэдээлэл авагчдын тоо сар ирэх бүр нэмэгдсээр байгаа нь судалгаагаар батлагдсаар байна. Энэ тоо 2007 оны 11 сард 18.9 хувьтай байсан бол 2008 онд 28,9 хувьд хүрч гол мэдээллийн эх сурвалжийн 3 дугаарт жагсчээ. ***Дашрамд дурдахад нийслэлийн нийт өрхийн 47 хувь нь компьютертэй бөгөөд тэдгээрийн 10 хувь нь интернэтэд холбогдсон*** гэсэн судалгааны дүн гарчээ. Улаанбаатар хотын 12 ба түүнээс дээш настай хүн амын 54 хувь нь ямар нэгэн хэлбэрээр интернэт ашигладаг, тэдний 40 хувь нь өдөр дунджаар 2-3 цаг интернэт ашигладаг байна.

"Чаатын эмээгийн хэрэг", "Дарханы" гэгдэх хэд хэдэн хүн амины эсрэг гэмт хэргүүд шил шилээ даран гарах болсон нь ТВ чаатаар гарсан хууль бус зар, түүний хяналтгүй байдлаас шууд шалтгаалж байна. Өдөртөө зөвхөн ТВ чаатнаас хэдэн сая төгрөг олдог телевизүүд энэ санхүүгийн эх үүсвэрээ алдахыг хүсэхгүй байгаа нь хэнд ч ойлгомжтой төдийгүй цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах тал дээр хайнга хандаж, илт хууль бус үйлдэлд бусдыг уриалсан, садар самууныг сурталчилсан, уруу татсан гэх мэт нийгэмд гэмт хэрэг гарахад сэдэл өгч болох мессежүүдийг "замбараагүй цацаж" байна.

Өнөөдөр монголын мэдээллийн зах зээлд тогтмол, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн нийт хэрэгслэлийн 15 орчим хувийг телевиз эзэлж байна. 2001 оны эхний хагас жилийн байдлаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд нийт 24 телевиз, 9 кабелийн телевиз албан ёсоор бүртгэгдэн тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа ажээ. ***Одоогоор тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 241 мэдээллийн хэрэгсэлтэй, үүнээс: сонин 144, сэтгүүл 36, радио 27, телевиз 24, кабелийн телевиз 9, агентлаг 1 байгаа юм.***[12]

Телевизүүд гадаад, дотоодын телевизийн бүтээлийг тэр бүр худалдаж авах санхүүгийн чадавхи султай. Тиймээс программ солилцоо, худалдааны аргаар авдаг ганц нэг бүтээлийг эс тооцвол ихэнхдээ чанар муутай видео кино, эсвэл хулгайн замаар хуулж бичсэн зарим бүтээлийг орчуулан гаргах байдалтай (нийслэлд үзүүлж байгаа телевизүүдийн хөтөлбөрийн 25-57 хувь нь гадаадын телевизі н бүтээлийг орчуулан үзүүлдэг) байна. Судалгаагаар нийт гарч байгаа киноууд нь хүчирхийллийг шууд харуулсан, сурталчилсан, өөгшүүлэн дэмжсэн, хэдийд насны ангиллаар, онцлогоор яаж үзүүлэх талаар ямар нэг хязгаарлалтгүй байна.[13] Энэ нь бага болон өсөр насны хүүхдийн сэтгэхүйд гэмт зан төлөвийг бүрдүүлэх нэг нөхцөл болж байгааг ч үгүйсгэх аргагүй[14] юм.

Хүн худалдах гэмт хэргийн судалгаанаас үзэхэд[15] судлагдсан хэргийн хувьд гэмт хэрэг гарах болсон шалтгаан нөхцөл нь зар сурталчилгааны хяналтгүй байдлыг давуу талаа болгосон, хохирогч нарын сул талыг (ажил хайж байгаа гэх мэт) ашигласан, "гадаад улсад өндөр цалинтай ажилд зуучлана" гэх мэтээр хохирогч нарт сэдэл төрүүлэх, хууртагдах гол нөхцөлийг бүрдүүлсэн байна. Товчоор хэлэхэд зар хууль бус сурталчилгаа, мэдээллийн байдалд хяналт тавьж, аюулгүй байдлыг хянах чиг үүрэг бүхий байгууллага байхгүй нь гэмт хэрэг гарах хамгийн гол нөхцөл болж байна.

Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж буй гэмт хэрэг: Түүнчлэн техник, технологийн дэвшилтэт байдал нь өөрөө өсөөр үе залуучуудын гэмт хэрэг үйлдэх нэг шалтгаан болж байна. Жишээ аваад үзье л дээ. "памперс" өмсөөд "Компьютер тоглоомын газар" хонон өнжин тоглож байгаа өсөөр насны хүүхдүүд "тоглоомонд донтох сэтгэцийн эмгэг"-ийн улмаас жилдээ дунжаар 20 гарсан тоогоор хүрэгдлдэг, "Шар хадны эмнэлэг"-т тусгай тасаг нээх хүртлээ тийм хэмжээнд хүрч, PC тоглоом тоглох нэг цагийн мөнгө эцэг, эхээсээ нэхдэг байсан хүүхдүүд яваандаа нэгнээсээ мөнгө, гар утас зэрэг эд зүйл дээрэмдэх (өөрсдийнх нь хэлдгээр "бариа хийх"), хулгайлах, булаах, айлган сүрдүүлэх замаар мөнгө нэхэх зэрэг нуугдмал гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэх болсон байна.

Гэмт хэрэг үйлдсэн, холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн хувийн байдлыг аваад үзэхэд дийлэнхи нь урьд нь өөрөө гэмт хэргийн улмаас хохирч байсан нь ихээхэн сонирхол татаж байгаа төдийгүй насанд хүрээгүй хүмүүсийн дунд зохиох урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн бусад салбарын үйл ажиллагаатай хослуулах хэрэгцээтэй байгааг харуулж байна.

Судлаач би өөрийн биеэр БЗД-ийн 2 дугаар хороонд үйл ажиллагаа явуулж буй "Би чадна" хүүхдийн төв дээр 6 сар шахам ажиглалт,

гарчээ. http://zorigtsoc.wordpress.com/

12. Монголын хэвлэлийн хүрээлэнгээс явуулсан мониторингийн судалгаанд дурдснаар

13. "Монголын телевизийн өчигдөр өнөөдөр", дэд доктор Ю.Эрдэнэтуяа, http://zorigtsoc.wordpress.com/

14. "Өдрийн сонин", 2009 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн №112, "Телевиз аливаг даган дуурайх сэдэл, сэтгэхүйг төрүүлдэг" гэсэн ХИС-ын хэсэг оюутнуудын нэг өдрийн ажиллалтын аргаар хийсэн судалгаагаар үүнийг нотолсон байна.

15. 2004-2007 онд шийдвэрлэгдсэн ЭХ-ийн 113, 124 дүгээр зүйл заасан эрүүгийн хавтаст хэргийн судалгааны тайлан" ХЗҮХ, ЭЭЗКСС, 2009 он.

тандалт, ярилцлага хийхэд ийм чөлөөт цагаа өнгөрөөх газар байгуулах, боловсролын байгууллагаас гадуурхи номын сангийн болон бусад үйлчилгээг төрийн бус байгууллага, хүмүүнлэгийн тодорхой үйлсээр дамжуулан тэдэнд ойртуулах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг алхам болж байгаа үр дүн шууд мэдрэгдэж байсан юм.

Шашин, шүтлэг тэдгээрийн нөлөө: Мормоны, Мүүнийн шашин зэрэг христосийн урсгалын нэлээд гуйвуулагдсан урсгал сектүүд олноор орж ирснээр монголчуудын уламжлалт сэтгэлгээ, үнэлэмж амьдарлын хэв маяг, нийгмийн ёс суртахуун гэдэг ойлголт өөрчлөгдөхөд хүргэж өөрчлөх, нийгмийг илүү задгай байлгах чиглэлд илүү түлхүү үйлчилж байгаа нь ажиглагдаж, зарим төрлийн шашны хориотой хэлбэрүүд ч гэмт хэргийн сэдлийг "шүтэгч этгээдэд" төрүүлдэг, тархийг нь угаадаг байдлууд ч байсаар байна. Энэ нь эд хөрөнгөгүй байхыг шаардах, амиа хорлох, үүндээ бусдыг ятгах зэрэг нийгэмд харш зан үйлийг хөхүүлэн дэмжсэн, хаацайлсан[16] шинжтэй байна. Түүнчлэн зарим судлаачид санхүүгийн эх үүсвэр нь тодорхой бус шашны урсгалын ард мөнгө угаах гэмт хэрэг нуугдаж байдаг хэмээн үздэгийг ч дурдах хэрэгтэй болов уу.

Хар тамхи, мансууруулах бодис хууль бусаар авч явах, борлуулах, хадгалах гэмт хэрэг: Хар тамхитай холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал жилээс жилд хүндэрч байна. Олон төрлийн шалтгаан нөхцөл гэмт хэргийн гаралттай холбоотой нь ойлгомжтой юм. Улс орны нийгэм эдийн засаг, даяарчлалын нөлөөлөл, мэдээллийн хурд, шинэ эрин үеийн хүүхэд залуучуудын сэтгэхүй, хөгжлийн олон талын сөрөг нөлөөлөл гэх мэт олон хүчин зүйлүүд энд яригдах ёстой.

1995-2005 онд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой буюу мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тарих, хурааж авах үйлдлүүдтэй 63 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 152 хүн сэжигтэн, яллагдагчаар татагдсан байна. Эдгээр 63 гэмт хэргээс 60 холбогдогчтой 22 гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн ба шүүгдэгчдийн 42 нь хорих ял бусад нь хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн байна.

Мөн дээрх гэмт хэргүүдийг шалгах явцад 22,5 кг каннабис, 0,1 кг героин, 0,4 кг кокаин, 4 ширхэг амфетамин, 285 ампул морфин, 200 грам нунтаг морфин, 2500 ампул пормидол, 1475 ампул пентазоцин, 67 феназефам тус тус хураагдаж эд мөрийн баримтаар тогтоогдож байв. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бусад орны гэмт хэргийн статистиктай харьцуулахад харьцангуй цөөн юм. Гэвч гэмт хэргийн тоог 5 жилийн байдлаар ангилж үзвэл:

• 1995-2000 онд 17 гэмт хэрэгт 58 хүн;

• 2000-2005 онд 46 гэмт хэрэгт 93 хүн сэжигтэн, яллагдагчаар татагдсан байна.[17]

Эндээс харахад сүүлийн 5 жилд мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг өссөн дүнтэй байгаа нь хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлттэй холбоотой юу аль эсвэл энэ төрлийн гэмт хэргийн гаралт ихэссэнтэй холбоотой юу гэдэг асуудал сонирхол татаж байна. Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчийн тоо, өөрөөр хэлбэл ямар нэг шалтгааны улмаас мансууруулах бодис хэрэглэж үзэх сонирхолтой өсвөр насны залуучуудын тоо ихсэх хандлагатай байна.

Манай улсад өсвөр насны залуучууд зэрлэг олс каннабисыг түүж бэлтгэх, тариалах, хурааж авах гэмт үйлдлүүдийг хийж байгаа нь хууль зүйн факт боловч эрх зүйн тодорхой зохицуулалтгүй учир энэ нь гэмт хэргийн шийдвэрлэлтэд нөлөөлж байгаа юм.

Хэрэглэгчдийг дараах 4 ангилалд хамааруулан авч үзэж болох юм. Үүнд:

• Эхний бүлэгт чинээлэг айлын хүүхдүүд ордог ба тэд ихэвчлэн БНХАУ-ын хилээр хууль бусаар их хэмжээгээр нэвтрүүлэн оруулж ирдэг гашиш болон синтетик төрлийн хар тамхи, амфетамин, мансууруулах бодис хэрэглэж зуршсан байна;

• "Хип хоп" урсгалын дуу хөгжим сонсдог залуучууд, дуучид гашиш болон зэрлэг өвсийг хольж хэргэлдэг;

• Рок дуу, хөгжим сонирхдог залуучууд юм. Тэд нар бусад ангилалд байгаа хүмүүсийг бодвол хамгийн боломж муутай хэрэглэгч гэж тооцогддог тэд ихэвчлэн Монгол Улсын нутагт ургадаг хар тамхины төрлийн ургамлыг түүж, бэлтгэх, улмаар түүнийгээ хатааж боловсруулан татах байдлаар хэрэглэж мансуурсан тохиолдлууд цөөнгүй бүртгэгдсэн байдаг;

• Дөрөв дэх ангилалд Монгол Улсад түр болон удаан хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд орох бөгөөд тэд хоёрдугаар ангиллын хүмүүстэй адил хэрэглээтэй байдаг.

Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөлийг хэрхэн арилгах вэ?

■ **Олон талт хамтын ажиллагаа:**[18] Гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөн байцаагчдын зүгээс ерөнхийдөө хэрэглэдэггүй

16."Өдрийн сонин", 2009 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн №136/3213, "Сүмийн итгэгч бяцхан охиныг амттанаар хуурч, гэрийн хорионд байлгажээ" гэсэн эрэн сурвалжлах нийтлэлд "9 настай охиныг хүчирхийлсэн, бэлгийн мөлжлөгөд ашигласан гэмт хэрэг гарсан ба үүнийг нь тухайн Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн нэгэн ажилтан хаацайлсан утгатай ярилцлага өгчээ" гэсэн байна.

17."2000-2005 оны эхний 3 сарын байдлаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн судалгаа" УМБГ, ЭЦГ, 2006 он.

18."ХХГХ-тэй тэмцэх талаар цагдаагийн албан хаагчдыг чадавхижуулах сургалт" сургагч багшийн гарын

татварын, хөдөлмөрийн гэх мэт хууль тогтоомжийг ашигладаг бусад байцаагч, хуулийн ажилтнуудтай хамтран ажиллах тактикийг олон талт ажиллагаа гэдэг. Энэ ажиллагааны хамтрагчид нь:

• Нийгмийн хэв журам сахиулах олон нийтийн байцаагч;

• Хилийн болон гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн албаны ажилтан;

• Гаалийн ажилтан;

• Гадаад харилцаа, эрүүл мэнд, байгаль орчин, хөдөлмөрийн улсын байцаагч;

• Гал түймэртэй тэмцэх албаны ажилтан;

• Орон нутгийн байгаль орчны болон эрүүл мэндийн ажилтнууд;

• Нутгийн захиргааны байгууллагын ажилтан;

• Зам тээврийн байгуулагын ажилтан;

• Хохирогчид тусламж үзүүлэх ажилтан;

• Хэвлэл, мэдээллийн ажилтан нар байна.

Тухайн салбарын үйл ажиллагааг зохицуулж байдаг хууль тогтоомжийг судалж үзээд ямар байгууллагатай хамтран ажиллахаа сонгох хэрэгтэй. Тухайлбал: Татварын, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай, ашигт малтмалын, хөдөлмөрийн, бэлгийн мөлжлөгтэй холбоотой хэрэг дээр тухайн баар, цэнгээний газрын зөвшөөрлийг хураан авч үйл ажиллагааг нь зогсоох, ашгийн төлөө байгууллага эсэх, тийм бол татвараа үнэн зөвөөр мэдүүлж төлдөг эсэх. Хэрэв тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг бол тусгай зөвшөөрөл нь хууль ёсны эсэх, галын аюулгүй ажиллагааны дүрмийг зохих ёсоор мөрдөж байгаа эсэх, аюулгүйн гарцтай эсэх, гал унтраах багаж хэрэгсэлтэй, тэдгээр нь ажиллагаатай эсэх гэх мэтээр шалгалт явуулах нь үр дүнтэй.

Олон талт ажиллагааны хүрээнд хамтарч хийсэн шалгалт нь маш үр дүнтэй таслан зогсоох арга хэмжээ болж чаддаг. Галын болон байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд тухайн байгууллагын үйл ажиллагааг зогсоох боломжтой болдог. Дээр дурдсан бүх үйл ажиллагааны үр дүнд тодорхой хэмжээний санхүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд тухайн гэмт хэргийн объектыг (жишээлбэл, сауны газар, зочид буудал гэх мэт) зорилгоор ашиглах боломжуудыг хааж өгдөг. Ингэснээр гэмт хэрэг үйлдэх арга, хэрэгслийн өртөг өсөж, түүнээс олох ашиг буурдаг.

■ **Захиргааны арга хэмжээ авах**: Тодорхой үйлдэл нэг бүрийг шалган тогтоож, хянах чиг үүрэг бүхий ажилтнууд нь илэрсэн зөрчил бүрт тохирсон арга хэмжээ авч зохих хариуцлагыг хүлээлгэж байх, захиргааны зөрчлийн нэгдсэн сан байгуулах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын саналыг авч, энэ төрлийн мэдээллийн бааз, судалгааны байгууллагыг байгуулах чиглэлийг баримталж ажиллах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дараагийн алхам юм.[19] Монгол Улсын нутаг дэвсгэрт нэг этгээд хэдэн удаа захиргааны зөрчил гаргаж, арга хэмжээ авагдсаныг мэдэх арга байхгүй байгаа юм.

■ **Судалгаа, шинжилгээний үндсэн дээр нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авах:** Шинэ тутам арга хэрэгслээр үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь онцлог байдлаас шалтгаалан өөр өөр байдаг тул хууль сахиулах байгууллагын албан хаагч криминологийн судалгааны наад захын аргачлалуудыг хэрэглэж чаддаг чадвартай байх хэрэгтэй юм. Өнөөдөр хотын нөгөө захад хэрэглэж байгаа арга таны хариуцсан хороо нутаг дэвсгэрт өөр үр дүн үзүүлж болох тул энэхүү судалгааны аргуудыг эзэмших нь тун чухал. Наад зах нь "Цагдаагийн байгууллагын тухай хууль"-д заасан "объектын судалгаа" хийх явцдаа тодорхой ажиглалт, туршилт хийх (болгоомжтой хэрэглэвэл зохино), сар бүрийн нуугдмал болон бүртгэгдсэн хэрэг дээр хэрэглээний программ ашиглан прогноз гаргаж, түүнд тохирсон арга хэрэгслийг сонгон хэрэглэж сурах, зарим тохиолдолд иргэд олон нийтийн туслалцааг ашиглан анкетийн болон ярилцлагын судалгааг явуулж чаддаг байх хэрэгтэй юм. Эцэст нь хэлэхэд "шинэ төрлийн арга"-аар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь "шинэлэг хэлбэр"-т шилжсэн учраас хууль сахиулах байгуулагын албан хаагчид "шинэлэг арга барил"-аар ажиллахыг нөхцөл байдал харуулж байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

ПРОКУРОРЫН СУРГАГЧ БАГШ НАРЫН СУРГАЛТ БОЛОВ

2009 оны 6 дугаар сарын 8-наас 12-ны өдөр буюу нийт 5 хоногийн турш прокурорын сургагч багш нарын сургалт ХЗҮХ-нд болж өнгөрлөө. Сургалтад орон нутгийн 21 аймгийн сургагч багш нар хамрагдсан бөгөөд Үндсэн хуулийн эрх зүйг Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид, Хуульчийн ёс зүйг Н.Батчимэг, Ц.Ариунболд, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд дахь шижилгээг Э.Ганбат, Мэдээллийн аюулгүй байдал, кибер комп ьютер, криминалистикийн шинжилгээг Т.Халтар, Хүн худалдах, худалдан авах гэмт хэрэг сэдэвт сургалтыг Эрүүгийн цагдаагийн газрын хэлтсийн дарга Т.Дашням, Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Э.Сагсай, Нийслэлийн шүүхийн Эрүүгийн танхимийн тэргүүн Б.Сарантуяа нар тус тус удирдан явуулав. Сургагч багш нар тухайн орон нутагтаа очиж хичээл заах бөгөөд сургалтыг сонирхолтой, ач холбогдолтой, үр бүтээлтэй болж өндөрлөлөө гэж дүгнэлээ.

авлага, 2008 он.

19. ХЗҮХ-ийн ЭЭЗКС-оос явуулсан "Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын хуулийн харьцуулсан судалгаа", 2007 он.

МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙ ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХИЙХ ДҮГНЭЛТ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд[1] "...Төр нь нийтийн ба хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална... Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна." гэж заасан нь манай иргэдийн өмч хөрөнгө, ялангуяа малчин түмний амжиргааны гол эх үүсвэр болсон мал сүргийг хамгаалах, ашиг шимийг хүртэхэд төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээний эрх зүйн үндсийг тодорхойлсон хэрэг мөн.

Мал сүргийг гэмт халдлагаас хамгаалахад төрөөс олон чухал арга хэмжээ авч ирсний нэг илрэл нь "Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг"-ийн тухай Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл хэсгүүдийг 1993, 2002, 2004, 2008 онд шинэчлэн өөрчилж, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль 2004 онд гаргаж, 2008 онд түүнд зарим өөрчлөлт оруулж хэрэгжүүлсэн явдал юм. Үүний зэрэгцээ Монгол Улсын Засгийн газар болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2005 онд Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хөтөлбөрийг[2] батлан, эдгээр хууль, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нутгийн удирдлагын байгууллагууд болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймаг, сумдын зөвлөл (цаашид "ГХУСАЗЗ" гэх), хууль сахиулах байгууллагуудаас нэгдсэн зөвөлгөөн хийж бодлого зорилтоо тодорхойлон олон ажлыг зохион байгуулж ирэв.

Гэвч мал хулгайлах гэмт хэргийн тоо төвийн бүсийн аймгуудад туушгай буурахгүй, харин ч нэмэгдэж арга, хэлбэр нь улам нарийсч, хэрцгий шинж чанартай

Төв аймгийн шүүхийн шүүгч Д.Гансүх

болж байна. Түүний улмаас нийгэм, иргэдэд учирсан аюул, хохирол сүйтгэл нь жил бүр өсөн нэмэгдсэн байна.

Төв аймаг дахь сум дундын шүүхүүдийн мал хулгайлсан гэмт хэрэг шийдвэрлэсэн үзүүлэлт (гурван жилээр, хүснэгт 1)

Хүснэгт-1

Үзүүлэлт	Онууд			
	2006	2007	2008	Дүн
Нийт шийдвэрлэсэн хэргийн тоо	161	200	222	583
Ял шийтгүүлсэн	242	295	305	842
үүнээс хулгайн гэмт хэргийн тоо	57	72	72	201
Ял шийтгүүлсэн	112	120	126	358
үүнээс мал хулгайлсан гэмт хэрэг	34	36	42	112
Ял шийтгүүлсэн	70	69	83	222
Мал хулгайлсан гэмт хэргийн нийт хулгайн хэргийн дотор эзлэх хувь	59,6%	50,0%	58%	55,%

Тухайлбал, *тус аймаг дахь сум дундын шүүхүүдийн 2008 онд шийдвэрлэсэн эрүүгийн нийт 222 хэргийн 72 буюу 32.4 хувь нь хулгайн хэрэг, түүний 42 буюу 58,3 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг байв.*

Шүүхийн практик судалж үзэхэд Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн зарим зүйл, заалт амьдралд хэрэгжихгүй, улс, орон нутгийн хэмжээнд мал, мах бэлтгэх төвлөрсөн зах болон орон нутгийн цэг, ялангуяа ченж нарт тавих хяналт, шаардлага хангалтгүй байгаат далимдуулан нутгийн зарим иргэд "ченж" хэмээх бүлэг хүмүүс буюу "уутлагч"-тай ил, далд аргаар сулбэлдсэн, тэдний даалгавраар шахам ажилладаг "явуулын хулгайч" буюу "уургалагч" нартай хуйвалдан гэмт хэргийн сүлжээ үүсгэн гол усныхаа малчид, ах дүү, найз нөхдийнхөө амин зуулга болсон мал сүрэг рүү голчлон шөнийн цагаар, эсхүл бэлчээрт нь халддаг болжээ. Зарим тохиолдолд тэд гар утас, машин механизм ашиглан хулгайлж, нялх төлтэй, түүнчлэн хөгшин хөвөө, хурдан жороо алийг ч ялгалгүй буу зэвсэг, хутга жад, сүх ашиглан хайр найргүй олноор нь алан махалж төвлөрсөн зах болон орон нутаг дахь "ченж" хэмээх мах бэлтгэгч нарт нийлүүлэн амар хялбар аргаар ашиг хонжоо олж дадлагажин мэргэшсэн гэмт үйлтнүүдийн баримт цөөнгүй байна.

Тухайлбал, Нийслэлийн Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороонд эрхэлсэн тодорхой ажилгүй оршин суугч Х.С, Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороонд эрхэлсэн тодорхой ажилгүй оршин суугч, 1997 онд мал хулгайлсан гэмт хэрэг үйлдсэний

1."1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд". УБ., 2007 он.

2."Хамтын зүтгэл (Иргэдийн мэдлэгийн санд)". Зуунмод, 2005 он.

учир 1 жил хорих ял шийтгүүлэн тэнсэгдэж байсан А.Т, Төв аймгийн Лүн сумын үндсэн харьяат, Баянзүрх дүүргийн 20 дугаар хороонд эрхэлсэн тодорхой ажилгүй оршин суугч, 2001 онд мал хулгайлах хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэний учир 2 жил хорих ял шийтгүүлж, 2002 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 8 сар 3 хоногийн хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдаж байсан Ч.Ч, Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороонд гэмт хэрэг үйлдэхийн өмнө эрхэлсэн тодорхой ажилгүй оршин суугч, 2005 онд хулгайн хүнд гэмт хэрэг үйлдсэний учир 5 жил 6 сарын хорих ял шийтгүүлж, Хэнтий аймаг дахь хорих 419 дүгээрангид ял эдэлж байсан Ш.Б нар нь Төв аймгийн Сэргэлэн, Баянцогт, Аргалант, Баянчандмань сумын нутгаас 2003-2005 онд найман удаагийн үйлдлээр 48 адуу, үхэр буюу **олон тооны мал** хулгайлж нядлан Нийслэлийн төвлөрсөн захын наймаачдад худалдаж нийт 9 иргэнд 14.340.0 төгрөгийн их хэмжээний хохирол учруулжээ. Тэдгээрийн дотор:

1. Х.С таван удаагийн дангаар болон бүлэглэн үйлдлээр 41 адуу хулгайлж 8.730.0 төгрөгийн **их хэмжээний** хохирол бүсдад учруулсан;

2. А.Т хоёр удаагийн давтан үйлдлээр, бүлэглэн 46 адуу хулгайлж 8.590.0 төгрөгийн **их хэмжээний** хохирол бүсдад учруулсан нь тус тус **хүнд гэмт хэрэг** болно;

3. Ч.Ч ялтай байх хугацаандаа гурван удаагийн давтан үйлдлээр, бүлэглэн 26 буюу олон тооны адуу хулгайлж 5.590.0 төгрөгийн **үлэмж** хэмжээний хохирол бүсдад учруулсан **хүндэвтэр**;

4. Ялтан Ш.Б дангаар 1 үхэр хулгайлж 350.0 төгрөгийн **бага бус хэмжээний** хохирол бүсдад учруулсан **хөнгөн** гэмт хэрэг тус тус үйлдсэний учир Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.3 дахь хэсэгт зааснаар Х.С-г таван жил гурван сарын, А.Т-г таван жил нэг сарын, Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар Х.Ч-г хоёр жил нэг сарын, Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.1 дэх хэсэгт зааснаар Ш.Б-г хоёр сарын хугацаатай баривчлах ялаар тус тус шийтгэж, Х.С, А.Т, Ч.Ч нарт оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид тус тус эдлүүлэхээр шүүх хянан шийдвэрлэжээ.

Хууль зөрчин ашиг хонжоо олохын тулд зарим этгээд малыг зөвхөн олноор нь хулгайлж, махлахын зэрэгцээ малын эзэн болон бусад хүний бие махбодид гэмтэл учруулах, амь насанд нь халдахаас ч буцахааргүй болтлоо хэт улайран омогшсон авир төрх, ааш араншин гаргах болжээ.

Төв аймгийн Баянцогт сумын харьяат гурван иргэн, Нийслэлийн СХД-ийн 7 дугаар хороонд эрхэлсэн тодорхой ажилгүй оршин суугч Д.П, СХД-ийн 3 дугаар хороонд мал нядлагчаар ажиллаж байсан Э.А, мөн хаягт оршин суугч Э.А нар болон СХД-ийн 14 дүгээр хороонд эрхэлсэн тодорхой ажилгүй оршин суугч, 2006 онд мал хулгайлсан хүнд гэмт хэрэг үйлдсэний учир 5 жил 7 сарын хорих ял шийтгүүлж, Өрөө өл үзүүлэх тухай хуулиар хорих ялаас 2006 онд суллагдсан Н.Б нар хоёр удаагийн давтан үйлдлээр, бүлэглэн 2006 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Төв аймгийн Баянхангай сумын нутгаас иргэн А-ийн бэлчээрт явсан 2 адуу, Баянцогт сумын нутаг "Наньд" гэдэг газраас иргэн Б-ийн 13 адуу, нийт 15 адуу буюу **олон тооны малыг** хулгайлж, нядлан Чингэлтэй дүүрэг дэх "Хүчит шонхор" захын ченж С гэгчид худалдан борлуулж, Д.П нь 2006 оны 8 дугаар сарын 23-ны өдөр иргэн Д-ийн унаж явсан эмээл, хазаартай морийг дээрэмдэх зэргээр бусдад 5.990.0 төгрөгийн буюу **үлэмж хэмжээний** хохирол учруулсан байдаг. Түүгээр ч зогсохгүй Д.П, Э.А нар нь Б-ийн 13 тооны адууг хулгайлах үедээ тэдний үйлдлийг мэдсэн хохирогч Б-ийн хүү Ж-г тухайн хэргийг нуун далдлах зорилгоор, шунахайн сэдэлтээр, бүлэглэн боож алсан **онц хүнд, жигшүүрт** гэмт хэргийг тус тус үйлджээ. Үүний учир:

1. Төв аймгийн сум дундын 2 дугаар шүүхийн 2008 оны 86 тоот шийтгэх тогтоолоор Д.П-г Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.1, 91.2.6, 91.2.11 дэх хэсэгт зааснаар хорин гурван жил, Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар таван жил, 147 дугаар зүйлийн 147.1 дэх хэсэгт зааснаар дөрвөн жилийн хугацаагаар хорих ял шийтгэж, Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасныг журамлан хөнгөн ялыг хүндэд нь багтаах, заримыг нэмэх зэргээр хорин дөрвөн жил хорих ялаар;

2. Э.А-г Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.1, 91.2.6, 91.2.11 дэх хэсэгт зааснаар хорин таван жил, мөн Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар таван жилийн хугацаагаар хорих ял шийтгэж, Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасныг журамлан хөнгөн ялыг хүндэд нь багтааж хорин таван жилийн хугацаагаар хорих ялаар;

3. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар Н.Б-г гурван жил, Э.А-г гурван жил гурван сарын хугацаагаар тус тус хорих ялаар шийтгэж, Д.П-д оногдуулсан хорин дөрвөн жилийн хорих ялын зарим болох 4 жилийн ялыг гянданд, үлдэх 20 жилийн ялыг чанга дэглэмтэй хорих ангид, Э.А-д оногдуулсан хорих ялын зарим болох 5 жилийн ялыг гянданд, үлдэх 20 жилийн ялыг чанга дэглэмтэй хорих ангид, Н.Б, Э.А нарт оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид тус тус эдлүүлэхээр хянан шийдвэрлэжээ. Түүнчлэн эдгээр ялтнуудын хулгайн зарим үйлдэл нь өмнө дурдсан 48 адуу хулгайлж ял шийтгүүлсэн Х.С нартай ямар нэг байдлаар холбоотой болох нь хавтаст хэргүүдийг харьцуулан судалсан дүнгээс тодорхой харагдахын зэрэгцээ Нийслэлийн төвлөрсөн захын мал, махны зарим ченжүүдийн бусармаг үйл ажиллагааны дүр зураг ажиглагддаг.

Мал хулгайлах гэмт хэргийн дотроос "олон тооны мал хулгайлсан", ялангуяа "машин механизм ашиглан хулгайлсан" гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тусгайлан авч үзэх, хулгайлсан мал,

махыг ямар этгээд хаана, хэнд, хэрхэн борлуулж буй, аль сумын мал сүрэг голчлон хулгайд өртөж буй зэргийг судлан болвсруулах нь нутгийн удирдлагын байгууллагаас уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсох арга журам, бодлого зэргийг зөв тодорхойлоход дэмжлэг болох ач холбогдолтой.

Судалгааныг үзэхэд тус аймагт мал хулгайлсан гэмт хэргийн 25 хувийг "олон тооны мал хулгайлсан" хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг эзэлж байна. Олон тооны мал хулгайлах гэмт хэргийн гол онцлог нь үйлдлийн аргын хувьд ихэвчлэн бүлэглэж, олон удаагийн үйлдлээр давтан, зарим тохиолдолд машин механизм, буу зэвсэг ашиглан үйлдэгдэх төдийгүй, тухайн гэмт хэргийн улмаас бусдад учрах хохирол, нийгмийн хор аюулаар үлэмж их байдаг нь анхаарал татаж байна.

Тухайн гэмт хэргийг нөхцөлдүүлж буй гол шалтгаан нь хулгайн замаар ашиг олох зорилго бүхий субъектив шалтгаанаас гадна Төв аймаг, түүний харьяа олонхи сум монголын хамгийн том зах зээлд ойр хүрээлэн орших онцлог байрлалаас хамаарч Нийслэлийн зам тээврийн болон төвлөрсөн захын чеңжүүдэд тавих засаг захиргааны хяналт сул байдагт оршино. Энэ нөхцөл байдлыг ашиглан малыг хулгайлан махалж "шахаж" их хэмжээгээр ашиг хонжоо олох зорилгоор олноор нь хулгайлж нядлан, тээвэрлэх буюу тууварлан нийлүүлдэг болжээ. Иймээс нийслэлийн төвлөрсөн захууд, түүний харьяа төв, орон нутаг дахь "ченж" хэмээгдэх сүлжээний үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо, журмыг боловсронгуй болгох, энэ зориулалтаар зөвхөн нийслэлд төдийгүй, аймаг, сумдад тусгайлсан албадыг ажиллуулах шаардлагатай болжээ.

Нөгөөтэйгүүр, олон тооны мал хулгайлсан гэмт хэргийг мөрдөн шалгахдаа зөвхөн мал хулгайлсан этгээдэд ял төлөвлөх төдийхнөөр ажлаа хязгаарлах биш, тухайн хэргийг үйлдэхэд сүлжилдэн оролцсон хамаарал бүхий этгээдүүд, ялангуяа хямд төсөр үнээр мах олж авах шуналд хөтлөгдөн гарал үүслийн бичиггүй мал, мах худалдан авсан, тухайн гэмт хэргийг зохион байгуулсан төдийгүй, урьд өмнө тийм хэрэг үйлдсэн тогтворгүй этгээдийг гар хөлөө болгон ашиглаж гэмт хэргийн сүлжээ үүсгэж буй бэл чинээ ихтэй "ченж" нэртэй "боссууд"-ийн бусармаг үйлдлийг илрүүлэх, тэдэнд хариуцлага тооцох арга, журмын тогтолцоо үгүйлэгдэж байна. Тухайлбал, 2008 онд мал хулгайлах гэмт хэргийн галаар шүүхийн практик судлахад хулгайн мал, махны ихэнхийг төвийн болон орон нутгийн чеңжүүдэд нийлүүлсэн болох нь тогтоогдсон боловч Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйлийн 155.1 дэх хэсэгт заасан "Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах" гэмт хэрэгт ял төлөвлөгдсөн болон шүүхээр ял шийтгүүлсэн этгээд бараг үгүй байна. Түүгээр ч зогсохгүй гарал үүслийн бичиггүй хулгайн мал, мах худалдан авсан нь нэгэнт тогтоогдчихоод байхад "хулгайн мал гэдгийг мэдээгүй" гэж хэлсэн "ченж" гэгч этгээдийн мэдүүлэг төдийхнөөр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаат зогсоож, тэдний эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг нь туйлын зохисгүй практик юм. Бидний судалгаагаар мал хулгайлсан гэмт хэргийн 10 буюу 25.5 хувийг машин механизм ашиглан үйлдсэн гэмт хэрэг эзэлж буй боловч дөрвөн хэргийн ялын дүгнэлт болон шийтгэх тогтоолд "машин механизм хэрэглэсэн"-ийг тэмдэглээгүй орхисон, хоёроос бусдад нь "тухайн этгээд тээврийн хэрэгслийн жинхэнэ өмчлөгч буюу эзэмшигч биш" байснаас хулгайн үйлдэлдээ хэрэглэсэн машин механизмыг хураах боломжгүйд хүрчээ. Улсын Их Хурлаас 2008 оны 10 дугаар сарын 30-ны өдөр "Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"[3]-ийг батлан гаргасан нь малыг олон тоогоор хулгайлах, тухайн үйлдэлдээ машин механизм ашиглахыг таслан зогсоох болон мал, мах бэлтгэх, тууварлах, тээвэрлэхэд зөвхөн жолооч нарын төдийгүй нутгийн захиргааны байгууллагын удирдлагын үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн нь чухал ач холбогдолтой юм. Тухайлбал, тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Тээврийн хэрэгслийн жолооч нь мах бэлтгэлийн зориулалттай мал, махыг тээвэрлэхдээ гарал үүслийн гэрчилгээтэй эсэхийг шалгасны үндсэн дээр тээвэрлэнэ.". Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д "...хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол...мал, мах бэлтгэлийн зориулалтаар гарал үүслийн гэрчилгээгүй, мал тууварласан, тээвэрлэсэн, тусгайлан бэлтгэсэн төвлөрсөн цэгээс өөр газарт мал, мах бэлтгэсэн бол хууль бусаар тууварласан, тээвэрлэсэн, бэлтгэсэн мал, махыг болон зөрчил гаргахад ашигласан уналга, тээврийн хэрэгслийг хураан зөрчлийг илрүүлсэн орон нутгийн төсвийн орлого болгож, зөрчил гаргасан иргэнийг 50.0 төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллагыг 250.0 төгрөгөөр торгох... шийтгэл ногдуулна" гэж заажээ.

Иймхүү гарал үүслийн гэрчилгээгүй мал тууварласан, тээвэрлэсэн, тусгайлан бэлтгэсэн төвлөрсөн цэгээс өөр газарт мал, мах бэлтгэсэн бол ... тухайн этгээдэд эрүүгийн, эсхүл захиргааны хариуцлагын аль нэгийг сонгон хэрэглэж болохоор заасан нь мал сүргийг гэмт халдлагаас хамгаалахад нутгийн захиргааны хийгээд хууль сахиулах байгуулага, ажилтны эрх хэмжээг өргөтгөсөн онцлог зохицуулалт болжээ. Иймд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг сурталчлан таниулах,

3."Төрийн мэдээлэл" сэтгүүл, № 42. 2008 он.

холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх ажлыг эхнээс нь зөв, оновчтой зохион байгуулах явдал нутгийн захиргааны байгууллагуудын өмнө нэн тулгамдсан зорилт болон дэвшигдэж байна.

Мал хулгайлах гэмт хэрэгт урьд ял шийтгүүлж түүнийг гүйцэд эдэлж дууссан болон өршөөлөөр суллагдсан боловч ялгүйд тооцогдох хугацаа болоогүй, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан, хорих ялаас тэнсэгдэж хянан харгалзагдсан зэрэг этгээдэд сумын захиргаа, цагдаагийн байгууллагаас тавих хяналтын арга, журам хангалтгүй, зөвхөн судалгаа гарган бүртгэх төдийхнөөр ажлаа хязгаарлаж буй нь тухайн гэмт хэргийг дахин үйлдэх, бусдыг уруу татан оролцуулах шалтгаан нөхцөлийг ч бүрдүүлж болохоор байна. Тухайлбал, Төв аймгийн шүүхийн 2008 оны статистик мэдээгээр шүүх мал хулгайлсан 42 хэргийг хянан шийдвэрлэснээс 23 буюу 54.7 хувийг бүлэг, үүнээс 11 буюу 47.8 хувийг урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг, 13 буюу 30.9 хувийг давтан, үүнээс 7 буюу 53.8 хувийг ял шийтгэлтэй давтан хэрэг тус тус эзэлжээ.

Ял шийтгүүлэгчдийн байдлыг судалж үзвэл мал хулгайлсан гэмт хэрэгт 83 хүн ял шийтгүүлсний 34 буюу 40.9 хувь нь урьд ял шийтгүүлсэн, 27 буюу 32.5 хувь нь тухайн хэрэгт ял шийтгүүлсэн этгээд байгаагаас ялтайд тооцох хугацааны дотор гэмт хэрэг үйлдсэн 15, тэнсэж хянан харгалзах хугацааны дотор гэмт хэрэг үйлдсэн 3, хорих ялаас ... тэнсэн суллагдсан хугацаанд гэмт хэрэг үйлдсэн 1, Өршөөлөөр суллагдсаны дараа гэмт хэрэг үйлдсэн 5 хүн байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2002, 2008 оны хуульд Мал хулгайлах гэмт хэргийг Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн зүйл, заалтад нэгтгэсэн нь олон тооны мал хулгайлсан, тухайн хэргийг давтан үйлдсэн болон гэмт хэрэгт хамаарал бүхий этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын хэр хэмжээ зэрэг нь хөнгөрч одоо үйлчилж буй Эрүүгийн хуулиар нэгээс хоёр бод мал хулгайлсан болон "8 бод, эсхүл 25 бог, түүнээс дээш буюу **олон тооны мал**"[4] хулгайлсан, анх удаа болон олон удаагийн давтан үйлдлээр мал хулгайлсан этгээдийн аль алинд хүлээлгэх эрүүгийн ял шийтгэлийн төрөл, хэмжээ үндсэндээ адил түвшинд болсон нь шүүхийн ял шийтгэлийн бодлогод сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, мал бүхий иргэдийн хүсэн хүлээсэн шаардлагад төдийлөн нийцээгүй байна.

Тухайн гэмт хэргийг үйлдэгдсэн газар, цаг улирлаар нь судлан үзэхэд 2008 онд Өндөрширээт, Эрдэнэ суманд малын хулгай огт гараагүй бол Эрдэнэсант сумын нутгаас 16 бод, 38 бог буюу 54 толгой мал (хамгийн олон бог) гэмт халдлагад өртөж 8 хэрэгт 15 хүн ял шийтгүүлснээс 10 нь тухайн сумын уугуул иргэд байх бөгөөд ийнхүү тус суманд малын хулгайн гэмт хэрэг хамгийн олон үйлдэгдсэн нь ихэд анхаарал татаж байна. Түүнчлэн Алтанбулаг сумын нутгаас 70, Баянцогт сумын нутгаас 64, Сэргэлэн сумын нутгаас 33, Аргалант сумын нутгаас 31 толгой мал хулгайн гэмт халдлагад өртжээ.

Монголчууд бид эртнээс эдүгээ хүртэл амжиргааны эх үүсвэр болсон буянт мал сүргийнхээ дотроос адууг эрхэмлэн тахилга, сүлдэндээ мөнхөлж, хийморийн бэлгэдэл, "морин эрдэнэ, молор эрдэнэ" хэмээн дээдэлж, дуу, шүлэг, магтаал, найраглал, кино зэрэг зохиол бүтээлдээ яруу сайханаар дүрслэн илэрхийлж, магтан дуулж ирсэн нүүдлийн өвөрмөц соёл уламжлалтай улс билээ. 2008 оны судалгаагаар тус аймгийн нийт 111 иргэний 397 толгой мал гэмт халдлагад өртсөний 315 буюу 79.3 хувь нь адуу байгаа нь сэтгэл эмзэглүүлж байна.

Нэгэн баримт дурдахад Баянчандмань сумын Эрдэнэ багийн харьяат, СХД-ийн 15 дугаар хороонд түр оршин сууж байсан Д.Э нь Б.Т гэгчийн хамт 2005, 2006 онуудад Алтанбулаг, Баянхангай, Баянцогт, Баян-Өнжүүл, Баянчандмань, Баянцагаан, Борнуур, Жаргалант, Зуунмод, Сэргэлэн сумын болон нийслэлийн зарим дүүргийн нутгаас 15 иргэний 33 адуу, 5 үхэр буюу олон тооны малыг 13 удаагийн үйлдлээр **давтан** буюу **бүлэглэж**, "Аксент" болон "Портер" маркийн **машин ашиглан** хулгайлж, ТОЗ-8 маркийн калибрь буугаар **буудан алж** газар дээр нь орхих, арьс махыг нь төвлөрсөн захын ченжид худалдан борлуулах зэргээр бусдад 14.830.0 төгрөгийн буюу **онц их хэмжээний хохирол** учруулсны учир сум дундын 1 дүгээр шүүх 2008 оны 44 тоот шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлийн 55.1, 49 дугаар зүйлийн 49.1, 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсэгт зааснаар Д.Энхбатын хувь хөрөнгөөс зарим эд хөрөнгийг хурааж, түүнд 7 жил 6 сарын хорих ял шийтгэж, уг ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн байх ба харин яллагдагч Б.Т нь шүүхээс оргон зайлж ял завшсан учир эрэн сурвалжлагдаж байна.

Иймд мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах, тухайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Улсын Их Хурал, төв, орон нутгийн төр, захиргааны болон хууль сахиулах байгууллага, Гэмт хэрэгтэй тэмцэх, урьчилан сэргийлэх ажлыг зохицуулах төв, орон нутгийн Зөвлөлөөс дараах арга хэмжээг хойшлуулшгүй зохион байгуулах явдал тулгамдсан зорилт болж байна.Үүнд:

1. Эрүүгийн хууль, тогтоомжийг эргэн харж мал хулгайлсан гэмт хэргийн талаар 1993 оны Эрүүгийн хуулиар тусгайлсан зүйл, заалтууд оруулан тогтоож байсныг сэргээх, эсхүл олон тооны мал хулгайлсныг уг хөрөнгийн зөвхөн үнэ ханшаар нь биш ач холбогдлоор нь үнэлж хүндэвтэр гэмт хэргийн ангилалд байгааг хүнд гэмт хэргийн ангилалд

4. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоол. "Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл". УБ., 2008 он.

оруулан өөрчлөх, тухайн хэрэгт хоёрба түүнээс дээш удаа ял шийтгүүлсэн этгээдийг хүнд гэмт хэрэг үйлдсэнд тооцох, мал хулгайлах гэмт хэрэгт хамаарал бүхий этгээдэд хүлээлгэх ялын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйлийн 155.1 дэх хэсэгт "Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан..." гэсний дараа борлуулах, худалдах зориулалтаар гарал үүслийн гэрчилгээгүй мал, мах худалдан авсан бол" гэсэн нэмэлт заалт оруулж, тухайн гэмт хэргийг хөнгөн гэмт хэргийн ангилалд байгааг хүндэвтэр гэмт хэрэг болгон өөрчлөх, "Гэмт хэрэг ... үйлдэхэд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл унаа хөсөг ...-ийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураан" улсын орлого болгохоор тогтоосон Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсгийн заалтыг өөрчлөн харин ч тэдгээрийг эд хөрөнгө хураах ялын журмаар хураж, хохирол төлбөрт оруулан тооцохоор өөрчлөх зэрэг санал боловсруулж Улсын Их Хуралд уламжлах шаардлагатай байна. Хохирогчийн эрх хамгаалал талаас авч үзэхэд, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн хэрэгсэл, эд хөрөнгө буюу хөрөнгө хураах ялаас гадуур хураагдсан унаа хөсгийг тухайн хэргийн улмаас бусдад учирсан хохирол төлбөрт оруулан тооцохын оронд шүүхээс түүнийг улсын орлогод шилжүүлж байгаа хуулийн өнөөгийн зохицуулалт мал бүхий иргэдийн хүсэн хүлээсэн шаардлагад төдийлөн нийцэхээргүй байна;

2. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр болж мөрдөгдсөнөөс хойшхи таван жилийн хугацаанд биелэлээ олоогүй зарим заалт, тухайлбал, "бод малыг улсын хэмжээнд индексжүүлсэн тамгын сүлжээнд хамруулах ажлыг зохион байгуулах, ... төв суурин газар, хүйсний зах, махны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж зэрэг шаардлагатай газарт мал, мах бэлтгэх төвлөрсөн цэг тогтоож, мал, махны гарал үүсэлд хяналт тавих ... чиг үүргийг хэрэгжүүлэх" зэрэг нутгийн өөрөө удирдах болон захиргааны бүх шатны байгууллагын эрх хэмжээний гунхаг төдий болж үлдсэн нэлээд заалтыг сэргээн хэрэгжүүлэх, зөвхөн аймгийн төвд тедийгүй, зарим сумдад мал, мах бэлтгэх төвлөрсөн цэг шинээр байгуулах, мал нядлах тусгай цэгүүд бий болгох, тэдгээр цэг болон мал, махны гарал үүсэлд тавих хяналтын тогтолцоо, арга журмыг боловсронгуй болгох нь зүйтэй;

3. Бүхэл сүлжээ үүсгэн бүлэг зохион байгуулалттайгаар мал хулгайлсан болон тухайн гэмт хэрэгт хамаарал бүхий этгээдүүдийг бүрэн илрүүлэх, үйлдэл, хэргийн зүйлчлэлийг зөв тогтооход хууль сахиулах, ялангуяа, цагдаа, прокурорын байгууллагаас явуулах үйл ажиллагааг эрчимжүүлэн, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны чанарыг дээшлүүлж, шуурхай байдлыг хангах;

4. Хулгайн, ялангуяа мал хулгайлсан гэмт хэрэгт урьд ял шийтгүүлж суллагдсан, өршөөгдсөн боловч ялтайд тооцох хугацаа дуусаагүй, хорих ялаас тэнсэгдэж ялнан харгалзагдсан, мөн хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдүүдийн бүртгэл судалгааг нарийн тодорхой болгох, тэдэнтэй нэг бүрчлэн тулж ажиллах, хөдөлгөөн, засрал хүмүүжилд нь хяналт тавих хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд сумдын ГХУСАЗ зөвлөл болон цагдаагийн байгууллага, ажилтны хүч анхаарлыг хандуулах нь зүйтэй;

5. Мал хулгайлсан гэмт хэрэгт удаа дараа ял шийтгүүлсэн болон олон удаагийн давтан үйлдэлтэй, түүнчлэн олон тооны мал хулгайлсан зэрэг этгээдэд ялын цээрлүүлэх зорилгыг хангахуйц ял шийтгэлийн боллогыг шүүхээс хэрэгжүүлэх шаардлагатай;

6. Аймаг, сумын ГХУСАЗ зөвлөлөөс жил бүр зохион байгуулах ажлын төлөвлөлтийг боловсронгуй оновчтой болгох, ялангуяа тайлант жилд гарсан гэмт хэрэг, гүнний шалтгаан нөхцөлийг судалж, энэ талаар дүгнэлт гаргах, уг дүгнэлтэд түшиглэн дараагийн жилд гэмт хэргийг сааруулах, таслан зогсооход шууд нөлөө болохуйц бодит ажлыг оновчтой төлөвлөн зохион байгуулж, үр дүнг жил бүр тооцож байхад анхаарах хэрэгтэй;

7. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль (2004), түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2008), холбогдох бусад хууль, тогтоомжийг мал бүхий иргэд, ялангуяа тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд тайлбарлан таниулахад хэвлэл мэдээлийн хэрэгслийг өргөн ашиглах (орон нутгийн телевиз, сонин сэтгүүл зэрэг), энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулахад сум, багийн Засаг дарга, хууль, эрх зүйн ажилтнуудын хүч анхаарлыг чиглүүлэх шаардлагатай;

8. Мал хулгайлах гэмт хэрэг хамгийн олон гарсан сумыг онцгой объект болгон ажиллах, ингэхдээ зөвхөн тухайн сумдын төдийгүй аймгийн ГХУСАЗ зөвлөлийн анхаарлыг гэмт хэрэг дахин давтан гарахаас урьдчилан сэргийлэх, тухайн хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглүүлэх бодитой ажил хийх, хулгайн гэмт халдлагад мал нь олноор өртсөн зарим сум, багт мал хамгаалах "Малчид, мал бүхий иргэдийн бүлэг"-ийг байгуулан түүний журмыг баталж, сумдын салбар зөвлөлийн сангийн хөрөнгийн зарим хэсгийг түүнд зарцуулах явдал тулгамдсан зорилт болж байна.

КОМПЬЮТЕРИЙН ГЭМТ ХЭРЭГ

МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн ахлах багш, докторант Ц.Хүрэл-Очир

XXI зууны шинжлэх ухаан, технологийн эрчимтэй хөгжил нь мэдээллийн шинэ харилцаа, орчин, орон зайг бүрдүүлж, түүний олонтод тулгуурласан орчин үеийн өндөр хүчин чадал бүхий компьютер, мэдээлэл холбооны техник, хэрэгслийг нийгмийн бүхий л салбарын өдөр тутмын үйл ажиллагаанд түгээмэл хэрэглэх болсон хэдий ч нийгэмд өөрийн сөрөг талуудыг бий болгож, хулгай хийх, залилан мэхлэх, садар самууныг сурталчлах, тагнуул хийх зэрэг гэмт үйлдлийг *кибер орон зайн шинэ хэлбэрт оруулж*, "Компьютерийн гэмт хэрэг", "Кибер гэмт хэрэг", "Кибертерроризм" гэх мэт шинэ нэр томъёо, ойлголтыг хэрэглэх болов. Тухайлбал, орчин үеийн мэдээлэл, холбооны технологийн тусламжтайгаар аливаа террорист үйл ажиллагаа явуулахыг "Кибертерроризм" хэмээж, терроризмын энэхүү хэлбэр нь мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон дэд бүтэц, бусад салбар (тээвэр, атомын цахилгаан станц, усан цахилгаан станц, эрчим хүчний байгууламж г.м)-ын компьютерийн удирдах системд халдах байдлаар илэрдэг өвөрмөц онцлогтой. Өөрөөр хэлбэл, "Кибертерроризм" гэдэгт компьютер, компьютерийн систем болон сүлжээнд санаатайгаар халдсан улс, нийгмийн аюулгүй байдал, тусгаар тогтнол, хүний амь бие, эрүүл мэнд, ахуйд шууд заналхийлэх зорилготой, хууль зүйн сөрөг үр дагавар бүхий аливаа халдлагыг ойлгож болох юм.

Өнөө үед компьютерийн систем, түүний сүлжээний орчинд үйлдэгч шинэ төрлийн гэмт хэргүүд бий болсон нь хууль тогтоох, хууль сахиулах байгууллагын өмнө шинэ, өвөрмөц нөхцөл байдал үүсгэж, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөх, түүнээс урьдчилан сэргийлэх явдал хууль сахиулах байгууллагад нэлээд бэрхшээл учруулах боллоо. Өндөр хөгжилтэй, хөгжингүй орнуудын туршлагаас үзэхэд үндэсний мэргэшсэн кибер-мөрдөгчдийг бэлтгэх тусгай сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг төрийн оролцоотойгоор нэн даруй эхлүүлэхийг мэдээллийн технологийн олон талт харилцаа зүй ёсоор шаардаж байна. "Компьютерийн гэмт хэрэг" гэх гэмшэх асуудал судлаачдын дунд олон янзын үзэл бодол, маргаан, мэтгэлцээнийг өрнүүлж буй тул уг гэмт хэргийн талаар нэгдсэн ойлголттой болж, тулгарч буй бэрхшээлийг зөв тодорхойлж, шийдвэрлэх арга зам боловсруулан, нэгдсэн системчлэл бүрдүүлэх боломжийг шинжээчдэд олгох нь хууль зүйн практикт чухал ач холбогдолтой юм[1].

ОХУ-ын эрдэмтэн Ю.М.Батурин хууль, эрх зүйн утгаараа "Компьютерийн гэмт хэрэг"-ийн ангилалд хамаарах онцгой төрлийн гэмт хэрэг байхгүй гэж үзсэн бөгөөд "олон төрлийн уламжлалт гэмт хэрэг электрон тооцоолох техникээс шууд хамааралтайгаар хувирч, өөрчлөгдөж байгааг харгалзан эдгээр гэмт хэргийг тусад нь гэмт хэргийн ангилалд оруулалгүй, харин гэмт хэргийн компьютерийн аспектийн тухай ярих нь зүйтэй"[2] гэсэн саналыг дэвшүүлжээ. Ю.М.Батурин дээрх үзэл баримтлалыг дэмжиж буй хэсэг эрдэмтдийн (гол төлөв ОХУ-ын) үндсэн санааг удаан хугацааны туршид илэрхийлж буй бөгөөд тэрбээр бусад гэмт хэргийн компьютерийн аспектийн тухай асуудлыг олонтаа хөндсөн юм. Гэвч компьютерийн мэдээллийн хүрээн дэх нийгмийн харилцаанд халдаж буй "хакердалт", мэдээллийн аюулгүй байдалд хууль бусаар халдах зэрэг гэмт үйлдлүүд хууль тогтоогчдыг цочроосны үндсэн дээр ОХУ[3], Украин[4], Беларус[5] зэрэг улс орнууд дээрх төрлийн гэмт хэргийг үндэсний хууль тогтоомждоо хуульчилсан байна.

Зарим судлаач "Компьютерийн гэмт хэрэг" гэсэн тусгайлсан нэр томъёог хэрэглэхэд шүүмжлэлтэй хандаж байна. Тухайлбал, ОХУ-ын судлаач В.В.Крылов "Мэдээллийн гэмт хэрэг" гэж илүү өргөн хүрээтэй томъёолбол тодорхой техник хэрэгсээс салгаж хийсвэрлэх боломж олгоно[6] гэсэн санал дэвшүүлсэн нь анхаарч үзэх асуудал юм. Гэхдээ копьютерийн гэмт хэргийг мөрдөн байцаах аргачлал боловсруулахад техникийн тодорхой хэрэгслүүдээс салгаж хийсвэрлэх нь уг гэмт хэргийн криминалистик тодорхойлолтыг иж бүрэн байдлаар тодорхойлох боломж олгохгүй. Өөрөөр хэлбэл, криминалистикийн тодорхойлолт хэт нүсэр болохын хэрээр практик хэрэгслээ, шуурхай эрэн сурвалжлах, хянан шалгах, бусад процессийн (байцаан шийтгэх) ажиллагаа, мөрдөлтийн тактикийн онцлогыг судлахад багагүй хүндрэл учруулж болзошгүй. Түүнчлэн, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөхөд "тусгай мэдлэг" хэрэглэх тактикийн үндсэн зарчмуудыг хэтэрхий бүрхэг, барьцгүй болгож болох юм. Энэхүү шалтгаанаар

1. Ц.Хүрэл-Очир, "Компьютерийн гэмт хэрэг". Эрх зүй сэтгүүл, 2007(2-3), 100 дахь тал.
2. Ю.М.Батурин, "Проблемы компьютерного права". Юрид. лит., М, 1991г. С.129.
3. Эрүүгийн хуулийн XXVIII бүлэг, "Компьютерийн мэдээллийн хүрээн дэх гэмт хэрэг".
4. Эрүүгийн хуулийн XVI хэсэг, "Компьютер (ТЭМ), түүний систем ба компьютерийн сүлжээ ашиглалтын хүрээн дэх гэмт хэрэг".
5. Эрүүгийн хуулийн XXXI бүлэг, "Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг".
6. В.В.Крылов. "Информационные компьютерные преступление"-Инфра-М-Норма, М, 1997г. С.11.

"Кибер гэмт хэрэг", "өндөр технологийн орчин дахь гэмт хэрэг" гэсэн нэр томъёо хэлбэрийн хувьд оновчгүй, агуулгаа бүрэн илэрхийлж чадаагүй гэж үзэж болно. Судалгаанаас ажиглахад "Кибер гэмт хэрэг" гэдэг нь хэвлэл, нийтлэлийн шинжтэй томъёолол бол харин "өндөр технологийн орчин дахь гэмт хэрэг"-т шинжлэх ухаан (физик, хими, биологийн гэх мэт), техник, технологийн шинэ ололтыг ашиглаж үйлдсэн гэмт хэргийн томоохон бүлэг (түүний дотор компьютерийн гэмт хэрэг)-ийг хамааруулж ойлгох боломжтой.

Зарим судлаачид "Компьютерийн гэмт хэрэг"-т "мэдээлэл, тооцоолон бодох системийг ашиглаж, эсвэл тэдгээрт нөлөөлөх замаар үйлдэгдсэн нийгэмд аюултай, хууль бус үйлдэл"-ийг' хамааруулж үзжээ. Энэ нь "Компьютерийн гэмт хэрэг"-ийн криминологийн ойлголттой тохирох боловч криминологи, криминалистикийн шинжлэх ухааны судлагдахуун ялгаатай тул "Компьютерийн гэмт хэрэг" гэсэн нэр томъёоны криминалистик тодорхойлолтыг тодорхой болгох, цэгцлэх шаардлага хууль зүйн практикт зайлшгүй тулгарч байна.

Судлаачдын судалгааны үр дүнг анхаарч, бусад улсын эрх зүйн зохицуулалт "Компьютерийн гэмт хэрэг"-тэй тэмцэж буй туршлагыг харгалзаж, хууль зүйн онол, практикт ач холбогдолтой криминалистикийн "тусгай" аргачлал боловсруулах, хэрэгжүүлэх үүднээс авч үзвэл "Компьютерийн гэмт хэрэг"-т *компьютерийн мэдээлэл, түүний орчин дахь компьютерийн технологийг ашиглан үйлдэж буй гэмт хэргийг хамааруулах нь* зүйтэй юм. Энэ нь НҮБ-ын шинжээчдээс санал болгож буй үлгэрчилсэн зааварчлагатай нийцэх ба компьютерийн систем, түүний сүлжээний тусламжтай үйлдэгдэж болох, компьютерийн систем, сүлжээний орчинд гарч болох, компьютерийн систем, сүлжээний мэдээллийн аюулгүй байдлын эсрэг үйлдэж бүлох бүх төрлийн гэмт хэрэгт хамаарна.

Судалгаанаас ажиглахад "компьютерийн гэмт хэрэг"-ийг ангилахад ОХУ, Украины судлаачид багагүй хувь нэмэр оруулсан байна. Тэдгээрээс ОХУ-ын эрдэмтэн В.А.Нокомонов "Компьютерийн гэмт хэрэг"-ийн талаарх нөөнгүй судалгааг нэгтгэж, дараах байдлаар ангилжээ[8].

1. *Халдлагын обьектоор нь*:

- Эдийн засгийн "компьютерийн гэмт хэрэг";
- Хувийн халдашгүй орчин, хувь хүний эрхийн эсрэг "компьютерийн гэмт хэрэг";
- Нийгэм, төрийн ашиг сонирхлын эсрэг "компьютерийн гэмт хэрэг".

2. *Компьютер, компьютерийн системийг ашигласан шинж байдлаар нь*:

- Компьютер нь гэмт хэргийн арга хэрэгсэл (мэдээлэл устгах, мэдээллийг гэмтээх, мэдээллийг хууль бусаар зөвшөөрөлгүй олж авах г.м) болсон;
- Компьютер гэмт хэргийн "зэвсэг" (электрон залилан хийх, электрон хулгай хийх г.м) болсон;
- Компьютер "оюуны орчны үүрэг" гүйцэтгэсэн гэмт хэрэг (тухайлбал, Интернетэд садар самууныг сурталчилсан веб хуудас байрлуулах г.м) гэж төрөлжүүлж ангилсан.

2001 оны 11 дүгээр сард Америк, Европ тивийн гуч гаруй улс "Компьютерийн гэмт хэрэг"-тэй тэмцэх тухай Европын зөвлөлийн олон улсын конвенцид нэгдэн орсон бөгөөд энэхүү конвенцийн дагуу компьютерийн програм хангамж эвдэх, түүнийг хууль бусаар хуулбарлах, интернетийн сүлжээний орчинд залилан мэхлэх, шашны эсрэг суртал ухуулга хийх, арьс өнгөөр ялгаварласан мэдээлэл гүгээх, хүүхдийг садар самуунд уруу татах, ашиглах, сурталчлах зэрэг гэмт хэрэгтэй хамтран тэмцэх үүрэг хүлээсэн байна. Уг конвенцийн II бүлэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгах гэмт хэргийн төрөл, хэлбэрийг дараах байдлаар тодорхойлжээ.

1. Компьютерийн өгөгдөл, системийг хууль бусаар олж авах, гүүний бүрэн бүтэн байдал, нууцлалтын эсрэг гэмт хэрэг, өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг зөрчих, системийн ажиллагаанд саналаатайгаар саад учруулах, компьютерийн техник, хэрэгсэлийг хууль бусаар ашиглахтай холбоотой гэмт хэрэг;

2. Компьютерийг зүй бусаар ашиглах, компьютерийн тусламжтайгаар хуурамч баримт бүрдүүлэх, компьютер ашиглаж залилан мэхлэхтэй холбоотой гэмт хэрэг;

3. Өгөгдлийн агуулгатай холбоотой хууль зөрчих, хүүхдийн садар самуун бичлэг хийх, гараахтай холбогдсон гэмт хэрэг;

4. Зохиогчийн эрх, түүнтэй холбоотой бусад эрхийг зөрчсөн гэмт хэргийг багтаасан байна.

Хууль зүйн шинжлэх ухааны онол, практикт компьютер, мэдээллийн технологийн орчинд гарч буй нийгэмд аюултай сөрөг үзэгдлүүдийг гэмт хэргийн объектийн төрлөөр нь ангилан авч үзэхийг эрмэлзэж байна. Иймээс бүх төрлийн "Компьютерийн гэмт хэрэг"-ийг:

Нэгдүгээрт. Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (электрон мэдээлэл нь гэмт халдлагын хэрэгсэл болсон гэмт хэрэг);

Хоёрдугаарт. Аливаа электрон мэдээлэл нь бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх арга хэрэгсэл буюу урьдчилсан нөхцөл болсон гэмт хэрэг;

Гуравдугаарт. Компьютер, бусад электрон техник, хэрэгсэл ашиглан үйлдсэн гэмт хэрэг гэж гурван үндэсэн хэсэгт ангилах боломжтой гэсэн саналыг дэвшүүлж байна.

Дээр дурдсан хандлага, саналыг харгалзан үзэж хууль зүйн онол, практикт хэрэглэх нь компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, компьютерийн мэдээллийн аюулгүй байдлыг эрх зүйн хүрээнд хангах боломж олгох юм.

7. Н.Ф.Ахраменка, "Проблемы криминализации общественно-опасного поведения с использованием информационно-вычислительных систем". Автореф. дис. канд. юрид. наук: 12.00.08/белорусский государственный университет. Минск, 1996г.
8. В.А.Нокомонов, "Глобализация информационных процессов и преступность". 2001г.

ШИНЭ НОМ



Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухааны академаас эрхлэн хэвлүүлсэн монголчуудын хэрэглэж ирсэн үсэг бичгээр бүтээсэн Монгол Улсын Үндсэн хуулийг танд толилуулж байна.

"Монгол Улсын Үндсэн хууль"-ийн эхийг монголчуудын хэрэглэж ирсэн зургаан гол зүйл бичиг үсэг, арван зүйл тиг хэлбэрээр бүгээсэн болой.

Энэхүү номд монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсгийг дараах дараалаар оруулсан байна. Үүнд:

- Их Монгол Улсын үеийн монгол бичгийн тиг;
- Монгол бичгийн модон барын тиг;
- Монгол бичгийн бийрийн тиг;
- Монгол бичгийн эвхмэл тиг;
- Монгол бичгийн төмөр барын тиг;
- Монгол дөрвөлжин бичиг;
- Тод бичиг;
- Соёмбо бичиг;
- Латин бичиг;
- Монгол кирилл бичиг.

Худалдах үнэ: 25 000 төгрөг
Утас: 315736, 88007557

www.mongolyn.mn



"МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ"
4 БОТЬ ХЭВЛЭГДЭН ГАРЛАА.

Энэхүү 4 ботид Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх хуулийг 2008 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар нэмэлт, өөрчлөлтийг нь тусган эмхтгэн оруулаа.

Монгол Улсын хуулийн 4 боть эмхтгэлийг хэрэглэхэд хялбар, цаашид нэмэлт, өөрчлөлтийг оруулан сольж болохуйц суугалбар хуудас, төмөр цоожлогч бүхий хатуу хавтастайгаар хэвлэсэн болно.

Дээрхи 4 ботид цаашид орох өөрчлөлтийг улирал бүр нэг багц болгон хэвлэж, захиалгын дагуу түгээх болно.

1 багцын үнэ: 200.000 төгрөг (I, II, III, IV боть 1 багц болно.)

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
www.nli.gov.mn



БИЗНЕСИЙН ХОЛБОГДОЛТОЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
МОНГОЛ, АНГЛИ ХЭЛЭЭР 2 БОТИОР ХЭВЛЭГДЭН ГАРЛАА.

Бизнесийн үйл ажиллагаа эрхлэгч хэн бүхний гол хэрэглэгдэхүүн болох бизнесийн холбогдолтой Монгол Улсын 70 хуулийг эмхтгэн монгол, англи хэлээр 2 ботиор хэвлэн гаргалаа.

Энэхүү 2 ботийг хэрэглэхэд хялбар, суугалбар хуудас, төмөр цоожлогч бүхий хатуу хавтастайгаар хэвлэсэн болно.

Үнэ: 1. Бизнесийн холбогдолтой Монгол Улсын хууль (монгол хэлээр) 28.000 төг
2. Business Laws of Mongolia 45.000 төг

Та элгээр хуулийн эмхтгэлийг худалдан авахыг хүсвэл доорх хаяг, утсаар ханлана уу.

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг. Сүхбаатарын талбай 7,
Хууль зүйн үндэсний хүрээлэн Утас: 317494, 315735, 88007557, Факс: 315735